



**ЭРҮҮЛ  
МЭНДИЙН ЯАМ**



**НИЙГМИЙН ЭРҮҮЛ  
МЭНДИЙН ҮНДЭСНИЙ  
ТӨВ**

**ЭРТ ИЛРҮҮЛЭГ ҮЗЛЭГТ ХАМРАГДСАН НАСАНД ХҮРСЭН  
ХҮН АМЫН ДУНДАХ ХАЛДВАРТ БУС ӨВЧНИЙ  
ЭРСДЭЛИЙН ТАРХАЛТ**

**УЛААНБААТАР ХОТ**

**2024 он**

## ӨМНӨХ ҮГ



Монгол улсын Ерөнхийлөгчийн санаачлан хэрэгжүүлж байгаа 3 тулгуурт үндэсний хөдөлгөөний нэг нь “Эрүүл монгол хүн” үндэсний хөдөлгөөн юм. Үндэсний хөдөлгөөнийг “Эрүүл зөв хооллолт”, “Эрүүл зан үйл”, “Эрүүл мэндийн боловсрол”, “Нийтийн биеийн тамир” гэсэн 4 үндсэн бүрэлдэхүүнтэй зохион байгуулж иргэдийг өвчилсөн хойно нь эмчлэх бус, өвчлөхөөс урьдчилан сэргийлэх, өвчлөлийн шалтгааныг бий болгож буй хүчин зүйлсийг арилгах, эрүүл орчинд амьдрах нөхцөл бүрдүүлэх, эрүүл хүнсээр хангах, зөв дасгал хөдөлгөөн, зохистой амьдралын хэвшилтэй болгох, эрүүл мэндийн боловсрол олгоход анхаарч байна.

Монгол улсын Засгийн газраас 2022 оны 05 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн нийт хүн амыг нас, хүйс, эрүүл мэндийн эрсдэлд суурилсан зонхилон тохиолдох халдварт болон халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, шинжилгээ, оношилгоонд хамруулах шийдвэр гаргаж, урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, шинжилгээ, оношилгоог улс орон даяар зохион байгуулан ажиллаж байна.

Урьдчилан сэргийлэх эрт илрүүлэг нь өвчний эмгэг шинж тэмдэггүй, өөрийгөө эрүүл гэж тооцдог хүн амд урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээ, оношилгоог хийснээр эрсдэлт хүчин зүйл болон өвчин, эмгэгийг илрүүлэх эрүүл мэндийн тусламж үйлчилгээ юм. Эрт илрүүлгийн үр дүнд үндэслэн Халдварт бус өвчин(ХБӨ)-ий нийтлэг эрсдэлт хүчин зүйлсийн тархалтын түвшинг нотолгоонд тулгуурласан бодит тоо, баримтыг үндэслэн сумын түвшинд анх удаа боловсруулан гаргаснаар олон талт байгууллагын оролцоонд тулгуурлан ХБӨ-тэй тэмцэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээг бүс нутгийн ялгаатайгаар, нотолгоонд суурилан хэрэгжүүлэх боломжтой болж байна.

Монголчуудын нийт нас баралтын 77%-ийг ХБӨ эзэлж байгаагийн 32% нь 30-70 насныхан байна. Өвчлөлийн архагшсан, хожуу шатанд өртөг ихтэй оношилгоо, эмчилгээнд эрүүл мэндийн салбарын 70 гаруй хувийг зарцуулж байгааг багасгахын тулд өвчин эмгэгээс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх чиглэлд нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тогтолцоог улам бэхжүүлэх, иргэдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэн, эрүүл аж төрөх хэв маяг, эрүүл мэндээ хамгаалах зөв зан үйлийг төлөвшүүлэх замаар өвчин эмгэг үүсгэдэг эрсдэлт хүчин зүйл, учир шалтгааныг таслан зогсоох чиглэлд эрүүл мэндийн салбарын бодлого чиглэгдэж байна.

Халдварт бус өвчин, түүний нийтлэг эрсдэлийн далайц, тархалт, хор уршгийг ойлгож мэдсэнээр хүн бүр өөрөө болон хамт олноороо амьдралын эрүүл хэв маягт шилжих талаар зөв шийдэлд хүрч, бидэнтэй хамтран ажиллаж, амжилтад хүрнэ гэдэгт итгэлтэй байна.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ГИШҮҮН,  
УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН, ЭРҮҮЛ  
МЭНДИЙН САЙД

Т.МӨНХСАЙХАН

## Нэг. Ерөнхий үзүүлэлт

Эрт илрүүлэг үзлэгт хамрагдсан насанд хүрсэн хүн амын дундах халдварт бус өвчний эрсдэлийн тархалтыг тогтоосон энэхүү тайланд урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэг үзлэгт 2022-2023 оны хооронд Монгол улс(МУ)-ын 18 ба түүнээс дээш насны нийт 447.409 хүнийг хамруулсан бөгөөд тэдгээрийн 279.388 (62.4%) эмэгтэйчүүд, 168.021 (37.6%) эрэгтэйчүүд байв. Урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдсан насанд хүрэгчдийг оршин суугаа орон нутгаар харьцуулан үзвэл хамрагдалтын түвшин Улаанбаатар хот (n=247.795)-д илүү, аймаг орон нутаг (n=199.614)-т бага байна.

Урьдчилан сэргийлэх үзлэгт 18–102 насны хүмүүс хамрагдсан бөгөөд тэдгээрийн дундаж нас 44.7 жил байна. Насанд хүрэгчдийн гэрлэлтийн байдал нь байршлын хувьд төдийлөн ялгаатай бус, харин бэлбэсэн иргэдийн хувь Улаанбаатар хот (5.3%)-д, огт гэрлээгүй байдал орон нутаг (16.2%)-т ялимгүй өндөр байв.

Эрт илрүүлэг үзлэгт хамрагдсан насанд хүрэгчдийн 0.7% боловсролгүй, 3.2% бага, 1.9% суурь, 41.9% бүрэн дунд, 38.0% бакалавр, 6.2% мэргэжлийн болон техникийн, 4.6% дипломын, 5.3% магистр, докторын боловсрол эзэмшсэн байна. Боловсролын түвшинг байршлаар харьцуулан үзвэл боловсролгүй болон бага боловсролтой, бүрэн дунд боловсролтой хүн амын үзүүлэлт 0.5 ба 2.1, 12.6 хувиар аймаг орон нутагт Улаанбаатар хотоос тус тус илүү байв. Харин бакалаврын боловсрол 10.3, магистрын боловсрол 3.3 хувиар Улаанбаатар хотод тус тус илүү байна (Хүснэгт 1).

Хүснэгт 1. Эрт илрүүлэгт хамрагдсан насанд хүрэгчдийн ерөнхий үзүүлэлт

Ерөнхий үзүүлэлтүүд	Орон нутаг (N=198,714)		Улаанбаатар (N=247,696)		Нийт (N=446,410)		p value
	тоо	%	тоо	%	тоо	%	
Дундаж нас, жилээр	43.5		45.7		44.7		<0.001
<b>Хүйс</b>							
Эмэгтэй	121,383	61.1	157,339	63.5	278,722	62.4	<0.001
Эрэгтэй	77,331	38.9	90,357	36.5	167,688	37.6	
<b>Гэрлэлтийн байдал</b>							
Батлуулсан гэр бүлтэй	141167	79.3	176318	81.4	317485	80.4	<0.001
Бэлбэсэн	7998	4.5	11523	5.3	19521	4.9	
Огт гэрлээгүй	28935	16.2	11523	5.3	19521	4.9	
<b>Боловсролын төвшин</b>							
Боловсролгүй	1204	0.9	479	0.4	1683	0.7	<0.001
Бага	7099	5.4	1138	0.9	8237	3.2	
Суурь	6571	5.0	2920	2.4	9491	3.7	
Бүрэн дунд	102126	77.7	88468	72.5	190594	75.2	
Мэргэжлийн болон техникийн	10004	7.6	14479	11.9	24483	9.7	
Магистр	4340	3.3	13433	11.0	17773	7.0	
Доктор	85	0.1	1162	1.0	1247	0.5	

### Хоёр. ХБӨ-ний анхдагч эрсдэлт хүчин зүйлсийн тархалт

Халдварт бус өвчин (ХБӨ)-ий анхдагч эрсдэлт хүчин зүйлсэд нь хувь хүний амьдралын хэв маягтай холбоотой, зан үйлийн эрсдэлийг багтаадаг бөгөөд, эдгээрт тамхины хэрэглээ, архи, согтууруулах ундааны зохисгүй хэрэглээ, хөдөлгөөний хомсдол, жимс, хүнсний ногооны хангалтгүй хэрэглээг хамруулдаг.

#### 2.1 ХБӨ-ний анхдагч эрсдэлийн тархалт

Урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэг үзлэгт хамрагдсан хүн амын 18.4% тамхи татдаг, бөгөөд тамхины хэрэглээ орон нутаг (17.2%) болон Улаанбаатар хот (19.3%)-ын иргэдийн дунд төдийлөн ялгаатай бус байв. Өдөр бүр тамхи татдаг хүн амын тархалт 27.0% байгаа бөгөөд уг үзүүлэлт аймаг, орон нутагт (38.4%) харьцангуй илүү байна. Тамхи татаж эхэлсэн дундаж нас 22.4, аймаг орон нутгийн иргэд харьцангуй залуу насандаа тамхи татаж эхэлсэн байв (Хүснэгт 2).

Сүүлийн 30 хоногт архи, согтууруулах ундааг стандарт уултаас илүү хэмжээгээр үзлэг хамрагдсан иргэдийн 8.0% хэрэглэсэн ба байршлын ялгаа ажиглагдаагүй болно. Эрт илрүүлэг үзлэгт хамрагдсан иргэдийн 23.4% тогтмол, 23.7% хаяа долоо хоногт 5-аас цөөнгүй өдөр 30 минутаас багагүй хугацаагаар эрүүл мэндэд тустай идэвхтэй хөдөлгөөн хийдэг эсвэл өдөр бүр 10,000 алхдаг гэж хариулжээ. Идэвхтэй хөдөлгөөн тогтмол хийх дадал аймаг орон нутаг (24.5%), Улаанбаатар хотын (23.4%) иргэдийн дунд харьцангуй ижил түвшинд байв.

Шинэ жимс, хүнсний ногооны зохистой хэрэглээтэй хүн амын тархалт 29.7%, зохистой хэрэглээтэй иргэдийн үзүүлэлт аймаг, орон нутагт Улаанбаатар хотоос 8.8 хувиар бага байв. Өөрөөр хэлбэл жимс, хүнсний ногоог өдөрт 400 граммаас бага хэмжээгээр хэрэглэдэг иргэдийн хувь орон нутагт илүү байна (Хүснэгт 2).

Хүснэгт 2. ХБӨ-ний анхдагч эрсдэлт хүчин зүйлсийн тархалт, байршлаар

Ерөнхий үзүүлэлтүүд	Орон нутаг (N=198714)		Улаанбаатар (N=247696)		Бүгд (N=446,410)		p value
	тоо	%	тоо	%	тоо	%	
<b>Тамхины хэрэглээ</b>							
Тамхи татдаг	31975	16.7	43906	18.3	75881	17.6	<0.001
Нэг жилээс бага хугацаанд тамхи татсан	980	0.5	2494	1.0	3474	0.8	
Тамхи татаж эхэлсэн дундаж нас, жилээр	20.2		21.4		20.9		<0.001
Өдөр бүр тамхи татдаг (тамхи татдаг хүмүүсийн дунд)	29349	37.0	39915	24.6	69264	28.6	<0.001
<b>Архи, согтууруулах ундааны хэрэглээ</b>							
Сүүлийн 30 хоногт “Стандарт уулт”-аас илүү хэрэглэсэн	15817	8.5	18010	7.7	33827	8.0	<0.001
<b>Идэвхтэй хөдөлгөөн: 7 хоногийн <math>\geq 5</math> өдөр 30 минутаас багагүй хугацаанд хөдөлгөөн хийдэг</b>							
Тийм	33607	17.7	42604	17.8	76211	17.8	<0.001
Үгүй	122280	64.4	145318	60.8	267598	62.4	
Хааяа	33875	17.9	51132	21.4	85007	19.8	
<b>Жимс, ногооны хэрэглээ (Missing n=9,730)</b>							
Зохистой хэрэглээ ( $\geq 5$ нэгж=400г)	45893	24.2	80448	33.6	126341	29.4	<0.001
Хангалтгүй хэрэглэдэг (<5 нэгж=400г)	53523	28.2	74463	31.1	127986	29.8	
Өдөр бүр хэрэглэдэггүй	90598	47.7	84397	35.3	174995	40.8	

Эрт илрүүлэгт хамрагдсан эмэгтэйчүүдийн 5.2%, эрэгтэйчүүдийн 40.3% тамхи татдаг, тамхи татаж эхэлсэн дундаж нас эмэгтэйчүүдэд 26.3, эрэгтэйчүүд 19.8 байв. Эмэгтэйчүүдийн 4%, эрэгтэйчүүдийн 14.6% сүүлийн 30 хоногт архи, согтууруулах ундааг “стандарт уулт” хэмжээнээс хэтрүүлэн хэрэглэсэн байна. Мөн 7 хоногийн 5-аас цөөнгүй өдөрт 30 минутаас багагүй хугацаанд идэвхтэй хөдөлгөөн хийдэг эрэгтэйчүүдийн хувь эмэгтэйчүүдээс 4.1 хувиар илүү, харин жимс, хүнсний ногооны зохистой хэрэглээ эмэгтэйчүүдийн дунд ялимгүй өндөр байна (Хүснэгт 3).

Хүснэгт 3. ХБӨ-ний анхдагч эрсдэлт хүчин зүйлсийн тархалт, хүйсээр

Ерөнхий үзүүлэлтүүд	Эмэгтэй (N=278953)		Эрэгтэй (N=167850)		Бүгд (N=446803)		p value
	тоо	%	тоо	%	тоо	%	
<b>Тамхины хэрэглээ</b>							
Тамхи татдаг	12966	4.9	62988	38.7	75881	17.6	<0.001
Нэг жилээс бага хугацаанд тамхи татсан	892	0.3	2588	1.6	3474	0.8	
Тамхи татаж эхэлсэн дундаж нас	26.3		19.8		20.9		<0.001
Өдөр бүр тамхи татдаг (тамхи татдаг хүмүүсийн дунд)	11718	8.9	57618	52.0	69264	28.6	<0.001
<b>Архи, согтууруулах ундааны хэрэглээ</b>							
Сүүлийн 30 хоногт “Стандарт уулт”-аас илүү хэрэглэсэн	10537	4.0	23322	14.6	33859	8.0	<0.001
<b>Идэвхтэй хөдөлгөөн: 7 хоногийн <math>\geq 5</math> өдөр 30 минутаас багагүй хугацаанд хөдөлгөөн хийдэг</b>							
Тийм	43230	16.2	33046	20.3	76276	17.8	<0.001
Үгүй	169358	63.5	98445	60.6	267803	62.4	
Хааяа	54143	20.3	30937	19.0	85080	19.8	
<b>Жимс, ногооны хэрэглээ (Missing n=9,730)</b>							
Зохистой хэрэглээ ( $\geq 5$ нэгж=400г)	82856	31.1	43588	26.8	126444	29.5	<0.001
Хангалтгүй хэрэглэдэг (<5 нэгж=400г)	78046	29.2	50045	30.8	128091	29.7	
Өдөр бүр хэрэглэдэггүй	106143	39.7	68989	42.4	175132	40.8	

ХБӨ-ний анхдагч эрсдэлийн тархалтыг эрт илрүүлэг үзлэгт хамрагдсан иргэдийн насны бүлгээр харьцуулан үнэлэв. Ингэхдээ өдөрт 10,000 алхдаггүй эсвэл 7 хоногийн 5-аас цөөнгүй өдөрт 30 минутаас багагүй хугацаанд дасгал хөдөлгөөн хийдэггүй иргэдийн үзүүлэлтийг нэгтгэн “Идэвхтэй хөдөлгөөн тогтмол хийдэггүй” хэмээн бүлэглэн, үр дүнг тооцов. Мөн өдөр бүр шинэ жимс, ногоо хэрэглэдэггүй эсвэл өдөрт 400 граммаас бага

хэмжээгээр хэрэглэдэг иргэдийн хувийг нэгтгэн “Жимс, ногоо хангалтгүй хэрэглэдэг” хүн амын үзүүлэлтийг тооцон гаргасан болно.

Тамхины хэрэглээ үзлэгт хамрагдсан иргэдийн настай урвуу хамааралтай буюу нас ахих тутам тамхи татдаг хүн амын тархалт буурч байна. Сүүлийн 30 хоногт архи, согтууруулах унааг “стандарт уулт”-аас хэтрүүлэн хэрэглэсэн хүн амын тархалт 20-59 насны иргэдийн дунд харьцангуй өндөр байв. Эрт илрүүлэгт хамрагдсан насанд хүрэгчдийн дунд идэвхтэй хөдөлгөөн хийдэггүй, жимс, ногоог хангалтгүй хэрэглэх байдал түгээмэл байна. Тухайлбал, насанд хүрэгчдийн 71%-85% идэвхтэй хөдөлгөөнийг тогтмол хийдэггүй, 67.3%-74.0% жимс, хүнсний ногооны хангалтгүй хэрэглээтэй байв (Хүснэгт 4).

Хүснэгт 4. ХБӨ-ний анхдагч эрсдэлийн тархалт, насны бүлгээр

Насны бүлэг, жилээр	N	Тамхи татдаг		Сүүлийн 30 хоногт архи, согтууруулах ундааг хэтрүүлэн хэрэглэсэн		Идэвхтэй хөдөлгөөн тогтмол хийдэггүй		Жимс, ногоог хангалтгүй хэрэглэдэг	
		тоо	%	тоо	%	тоо	%	тоо	%
<19	15,277	3001	20.3	484	3.4	10469	71.1	11299	73.1
20-24	27,522	5557	21.0	2051	7.9	19652	74.7	19461	69.4
25-29	33,389	5786	18.2	3175	10.2	24473	77.6	23051	67.3
30-34	48,492	9490	20.2	4922	10.7	38568	82.1	31898	67.9
35-39	51,936	10491	20.7	4830	9.7	42453	84.0	34955	69.2
40-44	49,453	9801	20.4	4290	9.1	40657	75.1	33918	71.0
45-49	49,166	9136	20.3	3998	8.6	40146	85.0	33733	71.4
50-54	45,387	7634	17.4	3328	7.8	36699	84.4	31180	71.7
55-59	44,473	7363	17.2	2874	6.9	35541	83.2	30529	71.4
60-64	38,123	5966	16.3	2166	6.1	2991	82.2	26138	71.7
65-69	23,166	3109	14.0	1080	5.0	18141	82.0	16141	72.9
70-74	11,633	1359	12.2	424	3.9	9149	82.4	8140	73.1
≥ 75	8,789	741	8.8	237	2.9	7026	84.0	6207	74.0

ХБӨ-ний анхдагч эрсдэлийн тархалтыг эрт илрүүлэгт хамрагдсан иргэдийн оршин суугаа аймаг, дүүргээр харьцуулан 5 дугаар хүснэгтэд харуулав. Сэлэнгэ, Дархан–Уул, Говь-сүмбэр, Дорноговь, Дорнод аймгаас бусад орон нутгийн иргэдийн 70%–88.5% жимс, хүнсний ногоог хангалттай хэмжээгээр хэрэглэж чадахгүй байна. Жимс, хүнсний ногоог хангалтгүй хэрэглэдэг хүн амын үзүүлэлт Дархан–Уул аймагт хамгийн бага, харин Баянхонгор, Завхан, Хэнтий, Өвөрхангай, Увс аймагт хамгийн өндөр байв. Тамхины хэрэглээ Хөвсгөл аймгийн насанд хүрэгчдийн дунд хамгийн өндөр, харин Баян–Өлгийн аймагт харьцангуй бага буюу 10.2% байна. Сүүлийн 30 хоногт архи, согтууруулах ундааг хэтрүүлэн хэрэглэсэн иргэдийн хувь Говь-сүмбэр, Дорноговь, Хөвсгөл, Булган аймгийн насанд хүрэгчдийн дунд харьцангуй өндөр буюу 15.0–17.2 хувь, Баян–Өлгий (3.6%), Хэнтий (3.9%) аймагт хамгийн бага байв. Орон нутгийн иргэдийн 74.3–89.8 хувь хоногт 10,000 алхам эсвэл 7 хоногийн 5-аас цөөнгүй өдөрт 30 минутаас багагүй хугацаагаар эрүүл мэндэд тустай идэвхтэй хөдөлгөөн хийдэггүй байна (Хүснэгт 5).

Хүснэгт 5. ХБӨ-ний анхдагч эрсдэлийн тархалт, хүн амын байршлаар

Байршил	Тамхи татдаг		Сүүлийн 30 хоногт архи, согтууруулах ундааг хэрэглэсэн		Идэвхтэй хөдөлгөөн тогтмол хийдэггүй		Жимс, ногоог хангалтгүй хэрэглэдэг		
	тоо	%	тоо	%	тоо	%	тоо	%	
<b>Орон нутаг</b>									
Архангай	2253	18.7	853	6.9	10432	84.2	9561	77.0	
Баян-Өлгий	763	10.2	260	3.6	1443	89.8	6287	81.2	
Баянхонгор	1368	16.2	444	5.4	6847	81.5	7420	88.5	
Булган	1763	18.7	1408	15.0	7881	83.8	6905	73.4	
Говь-Алтай	1599	18.2	1022	12.2	7452	85.5	6832	78.0	
Говьсүмбэр	386	18.6	349	17.2	1677	81.5	1273	61.7	
Дархан-Уул	1989	17.4	766	6.9	8593	75.7	7070	62.2	
Дорноговь	1559	18.6	1285	15.6	6529	78.8	5335	64.0	
Дорнод	1592	17.9	469	5.4	7195	80.8	6052	68.1	

Дундговь	1186	17.0	736	10.7	5887	84.6	5420	77.8
Завхан	2352	17.6	776	5.8	11957	87.4	11750	88.0
Орхон	1806	18.0	1099	11.1	7455	74.6	6679	66.8
Өвөрхангай	2609	17.5	1609	11.0	11979	81.4	12720	85.4
Өмнөговь	983	18.3	371	7.0	3965	74.3	3666	68.4
Сүхбаатар	1265	16.0	620	8.0	6286	79.6	5055	67.0
Сэлэнгэ	994	13.6	252	4.1	5433	80.8	3707	55.0
Төв	2004	18.9	676	6.5	8624	81.5	7833	73.8
Увс	1267	15.5	388	4.9	6870	83.9	6900	84.2
Ховд	1817	17.3	579	5.8	8843	86.0	8321	80.9
Хөвсгөл	2230	21.9	1530	15.2	8001	78.6	870	79.2
Хэнтий	1094	13.0	325	3.9	7394	88.3	7265	86.8
<b>Улаанбаатар</b>								
Багануур	271	13.4	294	14.6	1519	75.6	1234	61.0
Багахангай	451	19.8	31	11.8	221	72.8	199	74.8
Баянгол	3447	18.8	1278	7.3	8250	82.0	13002	71.3
Баянзүрх	12685	19.9	5027	7.9	52272	81.8	41267	64.5
Налайх	1091	19.4	561	10.1	4588	81.7	4657	82.7
Сонгинохайрхан	7522	17.9	2636	6.4	36438	87.3	27967	66.7
Сүхбаатар	5588	22.6	2848	11.7	20103	81.5	17229	69.7
Хан-Уул	7074	18.6	221	6.1	30395	80.4	22884	60.3
Чингэлтэй	3762	22.3	1354	8.2	13133	88.0	10241	60.8

Тавдугаар хүснэгтээс харахад Улаанбаатар хотын Налайх, Багахангай дүүргийн насанд хүрэгчдийн дунд жимс, хүнсний ногооны бага хэрэглээ харьцангуй өндөр, харин Хан-Уул, Чингэлтэй дүүрэгт хамгийн бага буюу 60 орчим хувь байна. Багахангай, Багануур дүүргээс бусад дүүргийн насанд хүрэгчдийн 80 гаруй хувь нь эрүүл мэндэд тустай идэвхтэй хөдөлгөөн хийдэггүй байв. Мөн Багануур, Багахангай, Сүхбаатар дүүргийн насанд хүрсэн 10 хүн тутмын 1-ээс илүү нь сүүлийн 30 хоногт архи, согтууруулах ундааг “стандарт уулт” хэмжээнээс хэтрүүлэн хэрэглэж байна. Тамхины хэрэглээ Улаанбаатар хотын Чингэлтэй, Сүхбаатар дүүргийн иргэдийн дунд харьцангуй өндөр байв.

## 2.2 Хувь хүний эрсдэлийн тархалт

Эрт илрүүлэг үзлэг хамрагдсан иргэдийн 17.7% артерийн даралт (АД) бууруулах эмийг тогтмол, 10.4% цусны өөх тос бууруулах эм хэрэглэдэг бөгөөд эдгээр үзүүлэлт Улаанбаатар хот болон орон нутгийн иргэдийн дунд харьцангуй ижил түвшинд байв (Хүснэгт 7).

Урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдсан насанд хүрэгчдийн 13.2% гэр бүлийн хэн нэгэн хүн хавдраар өвчилж байсан гэж хариулсан бөгөөд Улаанбаатар хотод орон нутгийн үзүүлэлтээс 3.3 хувиар илүү байна. Урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдсан эмэгтэйчүүдийн 9.6% хөхөнд ямар нэгэн эмзэглэл, хатуурал, арьсны өнгө өөрчлөгдсөн гэж мэдээлсэн ба уг үзүүлэлт орон нутгийн иргэдийн дунд бага зэрэг илүү байв (Хүснэгт 6).

Хүснэгт 6. Хувь хүний эрсдэлийн тархалт, байршлаар

Ерөнхий үзүүлэлтүүд	Орон нутаг (N=198,714)		Улаанбаатар (N=247,696)		Нийт (N=446,410)		p value
	тоо	%	тоо	%	тоо	%	
АД бууруулах эм тогтмол хэрэглэдэг	33439	17.5	42667	17.9	76106	17.7	< 0.001
Чихрийн шижинтэй (эмээ, өвөө, нагац, авга)	3242	4.4	6807	4.0	10049	4.2	< 0.001
Чихрийн шижинтэй (эцэг, эх, ах, дүү, өөрийн хүүхэд)	8536	11.3	17735	10.4	26271	10.6	< 0.001
Хөхөнд эмзэглэл, хатуурал үүссэн, арьсны өнгө өөрчлөгдсөн	14587	10.6	16786	8.8	31373	9.6	< 0.001
Гэр бүлийн гишүүд хавдраар өвчилж байсан	21721	11.3	34951	14.6	56672	13.2	< 0.001
Өөх тос бууруулах эм хэрэглэж байгаа	18789	9.8	26005	10.9	44794	10.4	< 0.001
Жирэмсний чихрийн шижин оношлогдож байсан	10963	10.3	13166	9.6	24129	9.9	< 0.001

Гэр бүл, хамаатан садны хэн нэгэн хүн чихрийн шижингээр өвчилсөн эсэхийг тодруулахад эрт илрүүлэг үзлэгт хамрагдсан иргэдийн 4.2% эмээ, өвөө, нагац, авга нарын аль нэг, харин 10.6% эцэг, эх, ах дүү, өөрийн хүүхэд

нь чихрийн шижингээр өвчилсөн гэж хариулжээ. Мөн үзлэгт хамрагдсан эмэгтэйчүүдийн 9.9% жирэмсний чихрийн шижин оношлогдож байсан бөгөөд жирэмсний чихрийн шижин оношлогдсон тохиолдол аймаг орон нутаг (10.3%)-ийн эмэгтэйчүүдийн дунд ялимгүй илүү байна. Артерийн даралт бууруулах эмийг тогтмол, цусны өөх тос бууруулах эм хэрэглэж байгаа хэмээн хариулсан иргэдийн хувь эмэгтэйчүүдийн дунд харьцангуй өндөр байв. Мөн гэр бүлийн хэн нэгэн гишүүн чихрийн шижингээр өвчилж байсан гэж хариулсан эмэгтэйчүүдийн хувь эрэгтэйчүүдээс 0.6–2.2 хувиар илүү байна. Гэр бүлийн хэн нэгэн гишүүн хавдраар өвчилсөн гэсэн өгүүлэмжтэй эмэгтэйчүүдийн хувь эрэгтэйчүүдээс 4.0 хувиар илүү байв (Хүснэгт 7).

Хүснэгт 7. Хувь хүний эрсдэлийн тархалт, хүйсээр

Ерөнхий үзүүлэлтүүд	Эмэгтэй (N=278,953)		Эрэгтэй (N=167,850)		Нийт (N=446,803)		p value
	тоо	%	тоо	%	тоо	%	
АД бууруулах эм тогтмол хэрэглэдэг	50043	18.7	26131	16.1	76106	17.7	< 0.001
Чихрийн шижинтэй (эмээ, өвөө, нагац, авга)	6552	4.4	3504	3.8	10049	4.2	< 0.001
Чихрийн шижинтэй (эцэг, эх, ах, дүү, өөрийн хүүхэд)	17660	11.5	8634	9.3	26271	10.6	< 0.001
Хөхөнд эмзэглэл, хатуурал үүссэн, арьсны өнгө өөрчлөгдсөн	31373	9.6	-	-	31373	9.6	< 0.001
Гэр бүлийн гишүүд хавдраар өвчилж байсан	39362	14.7	17364	10.7	56672	13.2	< 0.001
Өөх тос бууруулах эм хэрэглэж байгаа	29677	11.1	15172	9.3	44794	10.4	< 0.001
Жирэмсний чихрийн шижин оношлогдож байсан	24129	9.5	-	-	24129	9.5	< 0.001

Эрт илрүүлэг үзлэгт хамрагдсан насанд хүрэгчдийн хувь хүний эрсдэлийн түвшинг тэдний насны бүлгээр харьцуулан үр дүнг 8 дугаар хүснэгтэд харуулав. Артерийн даралт бууруулах эм тогтмол хэрэглэх байдал нь иргэдийн наснаас шууд хамааралтай нэмэгдэж байна. Тухайлбал, 40–44 насны иргэдийн дунд АД бууруулах эмийг тогтмол хэрэглэдэг хүн амын үзүүлэлт 35–39 насныхны үзүүлэлтээс бараг 2 дахин нэмэгдэж байв. Мөн Артерийн гипертензитэй 50–59 насны 3 хүн тутмын 1, 60–69 насны 2 хүн тутмын 1 нь тус тус АД бууруулах эмийг тогтмол хэрэглэж байна.

“Гэр бүлийн хэн нэгэн хүн хавдраар өвчилсөн” гэж хариулсан иргэдийн хувь 40–59 насныхны дунд харьцангуй өндөр, харин 18–29 насны залуучуудын дунд бага байна. Эрт илрүүлэг үзлэг хамрагдсан иргэдээс гэр бүл, хамаатан садны хэн нэгэн нь чихрийн шижингээр өвчилсөн эсэхийг тодруулахад, 18–29 насны залуучуудын дунд “эмээ, өвөө, нагац, авга нь өвчилсөн”, харин “эцэг, эх, ах дүү, эсвэл өөрийн хүүхэд нь өвчилсөн” гэж хариулсан иргэдийн хувь 30–54 насны хүн амын дунд харьцангуй илүү байв. Цусны өөх тос бууруулах эмийн хэрэглээ 20–29 нас, 70 ба түүнээс дээш насны иргэдийн дунд харьцангуй илүү байна (Хүснэгт 8).

Хүснэгт 8. Хувь хүний эрсдэлийн тархалт, насны бүлгээр

Насны бүлэг, жилээр	N	АД бууруулах эм тогтмол хэрэглэдэг	Чихрийн шижинтэй (эмээ,өвөө, нагац, авга)	Чихрийн шижинтэй (эцэг, эх, ах, дүү, өөрийн хүүхэд)	Хөхөнд эмзэглэл, хатуурал үүссэн, арьсны өнгө өөрчлөгдсөн	Гэр бүлийн гишүүн хавдраар өвчилж байсан	Өөх тос бууруулах эм хэрэглэж байгаа	Жирэмсний чихрийн шижин оношлогдож байсан
		%	%	%	%	%	%	%
<19	15,277	0.5	12.6	10.3	14.9	6.9	13.5	14.9
20-24	27,522	1.0	11.3	10.6	15.0	9.4	14.5	15.5
25-29	33,389	2.0	8.0	10.1	17.1	10.2	16.8	19.3
30-34	48,492	3.0	5.6	11.0	9.3	12.0	8.1	9.1
35-39	51,936	4.9	4.2	11.8	8.0	13.8	7.2	8.2
40-44	49,453	9.6	3.3	12.1	8.4	15.1	7.8	8.3
45-49	49,166	16.1	2.9	11.7	8.1	16.1	8.3	7.9
50-54	45,387	23.9	2.3	11.1	7.8	15.3	9.3	8.1
55-59	44,473	31.8	1.9	10.1	8.2	14.9	10.9	9.1
60-64	38,123	39.4	2.0	8.8	8.3	12.9	11.8	9.3
65-69	23,166	45.9	1.8	8.2	8.4	12.0	12.7	10.2
70-74	11,633	51.5	1.8	8.1	9.6	10.7	14.2	11.7
≥ 75	8,789	55.8	1.6	7.3	9.3	9.8	14.1	11.1

Хувь хүний эрсдэлийн тархалтыг тэдний оршин суугаа аймаг, дүүргээр харьцуулан үр дүнг 9 дүгээр хүснэгтэд үзүүлээ. МУ-ын 21 аймаг, Улаанбаатар хотын 9 дүүргийн эрт илрүүлэг үзлэгт хамрагдсан иргэдийн тоо харилцан адилгүй, мөн статистикийн нарийвчилсан дүн шинжилгээ хийгээгүй тул дараах үзүүлэлтийг харьцуулан жишиж, үнэлгээ дүгнэлт өгөх боломжгүй байна (Хүснэгт 9).

Хүснэгт 9. Хувь хүний эрсдэлийн тархалт, байршлаар

Байршил	N	АД бууруулах эм тогтмол хэрэглэдэг	Чихрийн шижинтэй (эмээ,өвөө,наг ац, авга)	Чихрийн шижинтэй (эцэг, эх, ах, дүү, өөрийн хүүхэд)	Хөхөнд эмзэглэл, хатуурал үүссэн, арьсны өнгө өөрчлөгдсөн	Гэр бүлийн гишүүн хавдраар өвчилж байсан	Өөх тос бууруулах эм хэрэглэж байгаа	Жирэмсний чихрийн шижин оношлогдож байсан
		%	%	%	%	%	%	%
<i>Орон нутаг</i>								
Архангай	13,822	23.9	1.8	4.5	6.0	8.0	5.1	4.3
Баян-Өлгий	7,981	14.6	2.5	7.7	14.1	5.3	15.7	16.6
Баянхонгор	8,564	20.7	2.3	10.2	7.9	6.6	5.5	7.2



Булган	9,574	23.8	3.3	11.0	11.0	10.6	9.3	11.2
Говь-Алтай	9,065	18.0	18.1	37.5	16.8	22.5	13.1	16.4
Говь-сүмбэр	2,129	21.8	7.4	22.9	6.1	12.0	4.5	4.2
Дархан-Уул	9,867	17.5	5.7	14.4	10.4	14.7	13.6	9.2
Дорноговь	8,606	17.9	11.	22.8	16.1	16.9	16.2	16.1
Дорнод	9,235	16.3	8.4	33.1	9.1	15.2	8.0	7.3
Дундговь	7,175	19.8	12.1	31.9	18.0	16.0	16.1	18.9
Завхан	13,574	18.4	2.5	6.1	6.2	10.4	6.0	4.5
Орхон	10,129	16.2	7.9	12.9	10.4	16.5	10.5	5.4
Өвөрхангай	15,170	14.6	3.1	5.7	9.1	7.7	8.4	10.7
Өмнөговь	5,458	15.7	13.6	32.6	15.7	14.5	13.7	15.1
Сүхбаатар	8,068	15.7	6.1	21.3	9.4	9.4	8.4	9.7
Сэлэнгэ	7,628	7.7	4.6	9.9	14.6	6.1	12.2	15.2
Төв	10,962	23.6	2.9	12.3	11.1	11.8	12.0	11.8
Увс	8,642	14.5	3.9	12.4	10.9	7.4	9.0	11.4
Ховд	12,132	10.0	2.2	5.1	1.7	4.7	8.1	14.0
Хөвсгөл	10,449	22.7	3.7	7.4	7.3	19.7	5.8	4.6
Хэнтий	8,684	12.	4.5	12.1	11.6	6.0	9.5	11.1
<i>Улаанбаатар</i>								
Багануур	2,159	27.6	3.0	7.9	22.1	16.0	27.2	30.2
Багахангай	275	16.9	4.9	14.1	10.3	9.4	11.7	14.5
Баянгол	19,413	14.5	4.2	11.1	14.0	14.4	16.0	15.6
Баянзүрх	65,234	18.5	3.9	10.2	6.0	16.4	8.9	5.0
Налайх	5,811	20.9	8.1	21.6	20.5	9.0	25.4	21.9
Сонгинохайрхан	44,292	16.5	3.2	7.6	9.8	10.3	10.5	11.5
Сүхбаатар	25,366	20.5	5.2	11.0	6.3	18.4	9.8	5.6
Хан-Уул	38,602	15.5	4.0	11.0	7.1	14.4	8.2	8.4
Чингэлтэй	17,693	19.9	4.9	14.1	15.5	17.7	15.1	17.3


### 2.3 Биеийн жингийн эрсдэлийн үнэлгээ

Эрт илрүүлэг үзлэгт хамрагдсан насанд хүрэгчдийн 42.7% хэвийн жинтэй (БЖИ=18.5-24.9 кг/м<sup>2</sup>), 36.5% биеийн жингийн илүүдэлтэй (БЖИ=18.5-29.9 кг/м<sup>2</sup>), 20.8% тарган (БЖИ≥30.0 кг/м<sup>2</sup>) байна. Үзлэгт хамрагдсан насанд хүрэгчдийн дунд хоол тэжээлийн дуталтай буюу туранхай хүн илрээгүй болно. Улаанбаатар хотод оршин суугаа иргэдийн дунд жингийн илүүдэлтэй хүн амын үзүүлэлт орон нутгийн түвшнээс бага зэрэг илүү, харин орон нутгийн насанд хүрэгчдийн дунд таргалалтын тархалт ялимгүй илүү байв (Хүснэгт 10).

Хүснэгт 10. Насанд хүрсэн хүн амын биеийн жингийн үнэлгээ, байршлаар

Биеийн жингийн үнэлгээ	Орон нутаг (N=198,714)		Улаанбаатар (N=247,696)		Нийт (N=446,410)		p value
	тоо	%	тоо	%	тоо	%	
<b>Хэвийн жинтэй</b> (БЖИ=18.5-24.9 кг/м <sup>2</sup> )	76275	42.1	96959	43.3	173234	42.7	< 0.001
<b>Илүүдэл жинтэй</b> (БЖИ=18.5-29.9 кг/м <sup>2</sup> )	64858	35.8	82959	37.0	147817	36.5	
<b>Таргалалттай</b> (БЖИ≥30.0 кг/м <sup>2</sup> )	40025	22.1	44173	19.7	84198	20.8	

Урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдсан насан хүрэгчдийн биеийн жингийн үнэлгээг хүйсээр харьцуулан үнэлэхэд илүүдэл жинтэй эмэгтэйчүүдийн хувь эрэгтэйчүүдээс 4.2 хувиар илүү, харин хэвийн жинтэй эмэгтэйчүүдийн үзүүлэлт 3.9 хувиар бага байна. Насанд хүрэгчдийн дунд таргалалтын тархалтад хүйсийн ялгаа ажиглагдаагүй болно (Зураг 1).



Зураг 1. Насанд хүрэгчдийн биеийн жингийн индексийн үнэлгээ, хүйсээр

Эрт илрүүлэгт хамрагдсан иргэдийн биеийн жингийн эрсдэлийн үнэлгээг насны бүлгээр харьцуулан үнэлэхэд жингийн илүүдэл болон таргалалтын тархалт иргэдийн наснаас шууд хамаарч нэмэгдэх хандлага ажиглагдсан бөгөөд ойролцоогоор 40 ба түүнээс дээш насны 4 хүн тутмын 1 нь (22.0%-27.0%) таргалалттай байв. Мөн 20–39 насны иргэдийн дунд таргалалтын тархалт огцом нэмэгдэж, өмнөх насны бүлгийн насанд хүрэгчдийн үзүүлэлтээс даруй 2 дахин ихсэж байна (Хүснэгт 10).

Хүснэгт 11. Насанд хүрэгчдийн биеийн жингийн үнэлгээ, насны бүлгээр

Насны бүлэг, жилээр	N	Хэвийн жинтэй (БЖИ=18.5-24.9 кг/м <sup>2</sup> )		Жингийн илүүдэлтэй (БЖИ=25.0-29.9 кг/м <sup>2</sup> )		Таргалалт (БЖИ≥30 кг/м <sup>2</sup> )	
		тоо	%	тоо	%	тоо	%
<19	53,138	11788	86.4	1530	11.2	331	2.4
20-29	92,430	36803	69.3	11775	22.2	4560	8.6
30-39	90,507	43187	46.7	33016	35.7	16227	17.6
40-49	81,964	30786	34.0	37213	41.1	22508	24.9
50-59	55,635	25725	31.4	34122	41.6	22117	27.0
60-69	18,258	18182	32.7	22949	41.2	14504	26.1
≥ 70	53,138	6917	37.9	7329	40.1	4012	22.0

Эрт илрүүлэг үзлэгт хамрагдсан иргэд (N=426,593)-ийн хоол тэжээлийн байдлыг БЖИ-ээр үнэлсэн үр дүнг тэдний оршин суугаа аймаг, дүүргээр харьцуулан үр дүнг дараах хүснэгтэд харуулав (Хүснэгт 11).

Хүснэгт 12. Насанд хүрэгчдийн биеийн жингийн үнэлгээ, байршлаар

Байршил	N	Хэвийн жинтэй (БЖИ=18.5-24.9 кг/м <sup>2</sup> )		Жингийн илүүдэлтэй (БЖИ=25.0-29.9 кг/м <sup>2</sup> )		Таргалалт (БЖИ≥30 кг/м <sup>2</sup> )	
		тоо	%	тоо	%	тоо	%
<b>Орон нутаг</b>							
Архангай	12,090	5023	41.5	4651	38.5	2416	20.0
Баян-Өлгий	7,271	3475	47.8	2364	32.5	1432	19.7
Баянхонгор	8,086	2991	37.0	2881	35.6	2214	27.4
Булган	9,541	3119	32.7	3739	39.2	2683	28.1
Говь-Алтай	8,134	3843	47.2	2847	35.0	1444	17.8
Говьсүмбэр	2,038	742	36.4	772	37.9	524	25.7
Дархан-Уул	11,935	4509	37.8	4588	38.4	2838	23.8
Дорноговь	7,798	3176	40.7	2762	35.4	1860	23.9
Дорнод	8,705	3780	43.4	3054	35.1	1871	21.5
Дундговь	6,965	2926	42.0	2410	34.6	1629	23.4
Завхан	13,220	5618	42.5	4946	37.0	2656	20.1
Орхон	11,296	4644	41.1	4155	36.8	2497	22.1
Өвөрхангай	15,577	6826	43.8	5509	35.4	3242	20.8
Өмнөговь	5,075	2215	43.6	1833	36.1	1027	20.2
Сүхбаатар	7,370	2898	39.3	2554	34.7	1918	26.0
Сэлэнгэ	8,231	3825	46.5	2826	34.3	1580	19.2
Төв	9,878	3703	37.5	3652	37.0	2523	25.5
Увс	6,598	4125	50.3	2473	30.2	1601	19.5
Ховд	9,236	5290	57.3	2816	30.5	1130	12.2
Хөвсгөл	11,257	4261	37.9	4256	37.8	2740	24.3
Хэнтий	8,250	2870	34.8	2979	36.1	2401	29.1
<b>Улаанбаатар</b>							
Багануур	1,729	597	34.5	722	41.8	410	23.7
Багахангай	257	99	38.5	105	40.9	53	20.6
Баянгол	16,879	7746	45.9	6225	36.9	2908	17.2
Баянзүрх	63,538	26242	41.3	24188	38.1	13108	20.6
Налайх	5,356	1870	34.9	2106	39.3	1380	25.8
Сонгинохайрхан	42,361	20017	47.3	14450	34.1	7894	18.6
Сүхбаатар	24,432	10001	40.9	9357	38.3	5074	20.8
Хан-Уул	39,657	17253	43.5	14911	37.6	7493	18.9
Чингэлтэй	16,126	6542	40.6	5898	36.6	3686	22.9

МУ-ын 21 аймаг, Улаанбаатар хотын 9 дүүргээс эрт илрүүлэг үзлэгт хамрагдсан иргэдийн тоо харилцан адилгүй байгаа хэдий ч, зарим аймгийн иргэдийн дунд таргалалтын тархалт харьцангуй өндөр байв. Тодруулбал, Хэнтий, Баянхонгор, Булган, Сүхбаатар, Төв аймгийн насанд хүрэгчдийн 25.5–29.1 хувь таргалалтай байна (Хүснэгт 11). Харин Ховд, Говь–Алтай аймгийн иргэдийн дунд таргалалтын тархалт хамгийн бага байв ( $p < 0.001$ ).

Урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдсан насанд хүрэгчдийн биед агуулагдах усны дундаж хэмжээг тэдний хүйс болон байршлаар харьцуулан үнэлэв. Нийт эмэгтэйчүүдийн 87.9% биед агуулагдах усны хэмжээ хэвийн, 11.7% багассан, 0.4% ихэссэн байна. Эрэгтэйчүүдийн бие агуулагдах усны хэмжээг үнэлэхэд 11.3% багассан, 0.8% ихэссэн, 87.9% хэвийн байв. Биед агуулагдах усны хэмжээ ихэссэн Улаанбаатар хотын эмэгтэйчүүдийн хувь, орон нутгийн ижил хүйсийн иргэдийн үзүүлэлтээс 0.3 хувиар илүү байна. Харин хөдөө орон нутгийн эрэгтэйчүүдийн дунд бие дэх усны хэмжээ багасан иргэдийн хувь Улаанбаатар хотод оршин суугаа ижил хүйсийн хүн амын үзүүлэлтээс бага зэрэг өндөр байгааг дараах хүснэгтээс харж олно (Хүснэгт 12).

Хүснэгт 13. Иргэдийн биед агуулагдах усны хэмжээ, хүйс ба байршлаар


Бие дэх усны хэмжээ	Орон нутаг (N=198,714)		Улаанбаатар (N=247,696)		Нийт (N=446,410)		p value
	тоо	%	тоо	%	тоо	%	
<i>Эрэгтэй</i>							
Багассан	3,362	12.4	6,521	10.8	9,883	11.3	< 0.001
Ихэссэн	137	0.5	532	0.9	669	0.8	
Хэвийн	23,602	87.1	53,328	88.3	76,930	87.9	
<i>Эмэгтэй</i>							
Багассан	4,443	11.1	6,521	10.8	9,883	11.3	< 0.001
Ихэссэн	85	0.2	532	0.9	669	0.8	
Хэвийн	35,637	88.7	53,328	88.3	76,930	87.9	

#### 2.4 ХБӨ-ний эрсдэлт хүчин зүйлс хавсран илрэх тохиолдол

ХБӨ-ний зарим эрсдэлт хүчин зүйлс нэг хүнд хавсран илрэх тохиолдол хүн амын дунд түгээмэл байдаг. Тухайлбал дараах эрсдэлт хүчин зүйлс (ЭХЗ) хамгийн түгээмэл тохиолддог байна. Үүнд:

- Өдөр бүр тамхи татах
- Жимс, хүнсний ногоог өдөрт 5 нэгжээс бага хэрэглэх
- Хөдөлгөөний хомсдол
- Илүүдэл жин ба таргалалт (БЖИ  $\geq 25$ кг/м<sup>2</sup>)
- Артерийн даралт ихсэлтэй (СД $\geq 140$  эсвэл ДД $\geq 90$  мм МУБ) эсвэл даралт ихсэлтийн улмаас эм хэрэглэж байгаа тохиолдлыг багтаасан болно.

Урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдсан орон нутгийн болон Улаанбаатар хотын иргэдийн дунд ХБӨ-ний түгээмэл тохиолдох ЭХЗ-ийн тархалт төдийлөн ялгаатай бус, огт эрсдэлгүй хүн амын эзлэх хувь маш бага боловч, тэдний талаас илүү хувьд 3 ба түүнээс олон эрсдэлт хүчин зүйлс хавсран илэрч байна (Зураг 2).



Зураг 2. ХБӨ-ний нийтлэг эрсдэлт хүчин зүйлсийн тархалт, байршлаар

Эдгээр түгээмэл тохиолдох эрсдэлт хүчин зүйлсийн аль нэг нь илрээгүй бол ХБӨ-өөр өвчлөх эрсдэлгүй, 1-2 хүчин зүйл илэрвэл эрсдэлтэй, 3 ба түүнээс олон хүчин зүйлс хавсран илэрвэл тухайн хүнийг ХБӨ-өөр өвчлөх өндөр эрсдэлтэй хэмээн үнэлдэг. ХБӨ-ний нийтлэг эрсдэлт хүчин зүйлс хавсран илрэх тохиолдол Улаанбаатар хот болон орон нутгийн иргэдийн дунд төдийлөн ялгаатай бус байгаа хэдий ч, Улаанбаатар хотод ялимгүй илүү байна (Зураг 2).

Эрт илрүүлэг үзлэгт хамрагдсан насанд хүрсэн хүн амын 4.1% ямар нэг эрсдэлгүй, 22.2% ХБӨ-өөр өвчлөх эрсдэлтэй буюу 1-2 эрсдэлт хүчин зүйлс, 73.7% өндөр эрсдэлтэй буюу 3-5 эрсдэлт хүчин зүйлс хавсран илэрч байгаа нь анхаарал татаж байна (Хүснэгт 13).

Хүснэгт 14. ХБӨ-ний эрсдэлт хүчин зүйлс хавсран илэрсэн байдал

Хүйс	N	Эрсдэлгүй		Эрсдэлтэй (1-2)		Өндөр эрсдэлтэй (3-5)	
		тоо	%	тоо	%	тоо	%
<b>Байриллаар</b>							
Эмэгтэй	86,672	4390	5.1	23709	27.4	58573	67.6
Эрэгтэй	59,068	1619	2.7	8577	14.5	48872	82.7
<b>Бүгд</b>	<b>145,627</b>	<b>6006</b>	<b>4.1</b>	<b>32263</b>	<b>22.2</b>	<b>107358</b>	<b>73.7</b>

ХБӨ-өөр өвчлөх эрсдэлийн тархалтыг эрт илрүүлэг үзлэгт хамрагдсан насанд хүрэгчдийн хүйсээр харьцуулан судлахад өндөр эрсдэлтэй эрэгтэйчүүдийн үзүүлэлт эмэгтэйчүүдээс 15.1 хувиар илүү, харин огт эрсдэлгүй болон эрсдэлтэй эмэгтэйчүүдийн хувь эсрэг хүйсийн иргэдийн үзүүлэлтээс даруй 2 дахин илүү байгааг 13 дугаар хүснэгтээс харж болно.

ХБӨ-өөр өвчлөх эрсдэлийн тархалтыг эрт илрүүлэгт хамрагдсан иргэдийн насны бүлгээр харьцуулан үнэлэхэд ХБӨ-өөр өвчлөх өндөр эрсдэлийн тархалт хүн амын насжилттай шууд хамааралтайгаар ихсэж байна (Хүснэгт 14).

Хүснэгт 15. ХБӨ-өөр өвчлөх эрсдэлийн тархалт, насны бүлгээр

№	Насны бүлэг, жилээр	N	Эрсдэлгүй		Эрсдэлтэй (1-2)		Өндөр эрсдэлтэй (3-5)	
			тоо	%	тоо	%	тоо	%
1.	<19	5640	773	13.7	3064	54.3	1803	32.0
2.	20-29	19584	2067	10.6	9174	46.8	8343	42.6
3.	30-39	30695	1571	5.1	8787	28.6	20337	66.3
4.	40-49	30684	747	2.4	4877	15.9	25060	81.7
5.	50-59	30111	496	1.6	3417	11.3	26198	87.0
6.	60-69	21717	279	1.3	2224	10.2	19214	88.5
7.	≥ 70	7309	76	1.0	743	10.2	6490	88.8

ХБӨ-өөр өвчлөх эрсдэлгүй хүн амын тархалт 30 хүртэлх насны залуучуудын дунд 10.6-13.7 хувь байгаа бол, 30–39 болон 40–49 насанд тус тус 2 дахин буурч байгааг 14 дүгээр хүснэгтээс харж болно. ХБӨ-өөр өвчлөх нийтлэг эрсдэлт хүчин зүйлс огт илрээгүй хүн амын тархалт нас ахих тутам буурах хандлага ажиглагдсан бөгөөд 70 ба түүнээс дээш насны иргэдийн дөнгөж 1.0% ХБӨ-өөр өвчлөх эрсдэлгүй байна.

**Нэгдсэн дүгнэлт**


1. Урьдчилан сэргийлэх эрт илрүүлэг үзлэгт хамрагдсан насанд хүрсэн 10 хүн тутмын 7 нь жимс, хүнсний ногоог хангалтгүй буюу эрүүл хооллолтын зөвлөмжид заасан хэмжээнээс бага хэрэглэж байна. Жимс, хүнсний ногооны зохистой хэрэглээ эмэгтэйчүүдийн дунд эрэгтэйчүүдээс ялимгүй өндөр байв.
2. Эрт илрүүлэг үзлэгт хамрагдсан насанд хүрсэн хүн амын 18.4% тамхи татдаг, бөгөөд тамхины хэрэглээ Улаанбаатар хот (19.3%)-ын иргэдийн дунд ялимгүй илүү байв. Насанд хүрэгчдийн тамхи татаж эхэлсэн дундаж нас 22.4 жил, аймаг орон нутгийн иргэд харьцангуй залуу насандаа тамхи татаж эхэлсэн байна. Нийт эмэгтэйчүүдийн 5.1%, эрэгтэйчүүдийн 40.3% тамхи татдаг, тамхи татаж эхэлсэн нас дунджаар эмэгтэйчүүдэд 26.3, эрэгтэйчүүдэд 19.8 жил байв.
3. Насанд хүрэгчдийн 8.0% сүүлийн 30 хоногт архи, согтууруулах ундааг стандарт уулгаас хэтрүүлэн хэрэглэсэн байв. Сүүлийн 1 сард архи, согтууруулах ундааг хэтрүүлэн хэрэглэсэн иргэдийн хувь эрэгтэйчүүдийн дунд эмэгтэйчүүдээс 3.7 дахин өндөр байна.
4. Эрт илрүүлэг үзлэгт хамрагдсан насанд хүрэгчдийн 23.4% тогтмол, 23.7% хаяа долоо хоногийн 5-аас цөөнгүй өдөрт 30 минутаас багагүй хугацаагаар идэвхтэй хөдөлгөөн хийдэг эсвэл өдөр бүр 10,000 алхдаг байна. Долоо хоногийн 5-аас цөөнгүй өдөрт 30 минутаас багагүй хугацаанд идэвхтэй хөдөлгөөн хийдэг эрэгтэйчүүдийн үзүүлэлт эмэгтэйчүүдээс 4.1 хувиар илүү байв.
5. Урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдсан иргэдийн 17.7% артерийн даралт бууруулах эмийг тогтмол, 10.4% цусны өөх тос бууруулах эм хэрэглэдэг бөгөөд эдгээр үзүүлэлт Улаанбаатар хот болон орон нутгийн иргэдийн дунд харьцангуй ижил түвшинд байв. Үзлэгт хамрагдсан нийт иргэдийн 4.2% эмээ, өвөө, нагац, авга нарын аль нэг, харин 10.6% эцэг, эх, ах дүү, өөрийн хүүхдүүдийн хэн нэг нь чихрийн шижингээр өвчилсөн, эмэгтэйчүүдийн 9.9% жирэмсний чихрийн шижин оношлогдож байжээ. Насанд хүрэгчдийн 13.2% гэр бүлийн хэн нэгэн хүн хавдраар өвчилсөн, эмэгтэйчүүдийн 9.6% хөхөнд ямар нэгэн эмзэглэл, хатуурал, арьсны өнгө өөрчлөгдсөн гэж хариулсан байна.

6. Эрт илрүүлэг үзлэгт хамрагдсан насанд хүрэгчдийн 36.5% жингийн илүүдэлтэй, 20.8% тарган байв. Үзлэгт хамрагдсан иргэдийн дунд хоол тэжээлийн дуталтай буюу туранхай хүн илрээгүй болно. Таргалалтын тархалт орон нутгийн насанд хүрэгчдийн дунд Улаанбаатар хоттой харьцуулахад 2.4 хувиар илүү байв.
7. Эрт илрүүлэг үзлэгт хамрагдсан насанд хүрсэн 10 хүн тутмын 7 нь ХБӨ-өөр өвчлөх өндөр эрсдэлтэй, дөнгөж 4.1% ямар нэгэн эрсдэлгүй байна. ХБӨ-өөр өвчлөх өндөр эрсдэлтэй насанд хүрэгчдийн тархалт Улаанбаатар хотын иргэдийн дунд ялимгүй өндөр буюу орон нутгийн түвшнээс 3.2 хувиар илүү байв. ХБӨ-өөр өвчлөх өндөр эрсдэлтэй насанд хүрсэн эрэгтэйчүүдийн тархалт эсрэг хүйсийн хүн амын үзүүлэлтээс харьцангуй өндөр буюу 15.1 хувиар илүү байна.

### УЛААНБААТАР ХОТЫН НАСАНД ХҮРЭГЧДИЙН ДУНДАХ ХАЛДВАРТ БУС ӨВЧНИЙ ЭРСДЭЛТ ХҮЧИН ЗҮЙЛСИЙН ТАРХАЛТ

#### ТАНИЛЦУУЛГА

Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/248 дугаар тушаалыг хэрэгжүүлэх арга хэмжээний хүрээнд 2022 оны 5 дугаар сарын 3-ны өдрөөс 2023 оны 5 дугаар сарын 1 хүртэлх хугацаанд эрт илрүүлэг, урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдсан Улаанбаатар хотын 187,415 насанд хүрэгчдийн мэдээллийг нэгтгэн, хүн амын дунд түгээмэл тохиолдож буй Халдварт бус өвчин (ХБӨ)-ий эрсдэлт хүчин зүйлсийн тархалтын байдалд дүн шинжилгээ хийв (Зураг 3).



Зураг 3. Эрт илрүүлэг үзлэгт хамрагдсан насанд хүрэгчдийн тоо, дүүргээр

Эрт илрүүлэг, урьдчилан сэргийлэх үзлэгт Улаанбаатар хотын 18-102 насны нийт 187,415 хүн хамрагдсан бөгөөд тэдний 36.7% (n=68,792) эрэгтэйчүүд, 63.3% (n=118,623) эмэгтэйчүүд байв (Хүснэгт 1).

Хүснэгт 16. Эрт илрүүлэгт хамрагдсан насанд хүрэгчид, нас бүлэг ба хүйсээр

Насны бүлэг, жилээр	N	Эрэгтэй			Эмэгтэй		
		Тоо	Хувь	95% ИХ	Тоо	Хувь	95% ИХ
≤ 19	4,946	2,586	52.3	50.9-53.7	2,360	52.3	50.9-53.7
20 – 29	22,207	8,781	39.5	38.9-40.2	13,426	39.5	38.9-40.2
30 – 39	43,565	16,432	37.7	37.3-38.2	27,133	37.7	37.3-38.2
40 – 49	40,718	14,667	36.0	35.6-36.5	26,051	36.0	35.6-36.5
50 – 59	36,928	12,425	33.6	33.2-34.1	24,503	33.7	33.2-34.1
60 – 69	28,563	9,987	35.0	34.4-35.5	18,576	35.0	34.4-35.5
≥ 70	10,488	3,914	37.3	36.4-36.9	6,574	37.3	36.4-36.9
<b>Нийт</b>	<b>187,415</b>	<b>68,792</b>	<b>36.7</b>	<b>36.5-36.9</b>	<b>118,623</b>	<b>36.7</b>	<b>36.5-36.9</b>


Эрт илрүүлэг үзлэгт хамрагдсан Улаанбаатар хотын насанд хүрэгчдийн дундаж нас 45.8 (95%ИХ 45.7-45.9) жил, эмэгтэйчүүдийн дундаж нас эрэгтэйчүүдээс 1.3 жилээр илүү байна (дундаж нас: эр 45.0 жил, эм 46.3 жил).

## ХАЛДВАРТ БУС ӨВЧНИЙ НИЙТЛЭГ ЭРСДЭЛТ ХҮЧИН ЗҮЙЛС ХАВСРАН ИЛЭРСЭН ХҮН АМ

Хүснэгт 17. Халдварт бус өвчний нийтлэг эрсдэлт хүчин зүйлс хавсран илэрсэн хүн ам хүйсээр


Хүн амын дунд (95% ИХ)	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
<b>ХБӨ-ий нийтлэг эрсдэлт хүчин зүйлс</b>			
<ul style="list-style-type: none"> <li>Өдөр бүр тамхи татдаг</li> <li>Өдөрт 5 нэгжээс бага хэмжээгээр жимс, ногоо хэрэглэдэг</li> <li>Хөдөлгөөний хомсдолтой</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Илүүдэл жинтэй (БЖИ <math>\geq 25</math> кг/м<sup>2</sup>)</li> <li>Артерийн даралт ихсэлттэй (САД <math>\geq 140</math> ба/эсвэл ДАД <math>\geq 90</math> мм МУБ эсвэл даралт бууруулах эм хэрэглэж байгаа)*</li> </ul>		
Нийтлэг эрсдэлт хүчин зүйлс илрээгүй хүн амын хувь	<b>3.7</b> (3.6 – 3.8)	<b>2.5</b> (2.4 – 2.7)	<b>4.4</b> (4.3 – 4.5)
Нийтлэг эрсдэлт хүчин зүйлсээс 1-2 эрсдэл хавсран илэрсэн хүн амын хувь	<b>46.1</b> (45.9 – 46.4)	<b>37.7</b> (37.3 – 38.1)	<b>51.2</b> (50.9 – 51.5)
Нийтлэг эрсдэлт хүчин зүйлсээс 3 ба түүнээс олон эрсдэл хавсран илэрсэн хүн амын хувь	<b>50.2</b> (49.9 – 50.4)	<b>59.8</b> (59.4 – 60.2)	<b>44.4</b> (44.1 – 44.7)

\*ДЭМБ-ын үзүүлэлтийг баримтлав.



Зураг 4. Нийтлэг эрсдэлт хүчин зүйлсээс 3 ба түүнээс олон эрсдэл хавсран илэрсэн хүн амын хувь, хүйсээр

### ГОЛ МЭДЭЭЛЭЛ




Зураг 5. ХБӨ-өөр өвчлөх өндөр эрсдэлтэй хүн амын хувь, сумаар

- Улаанбаатар хотын насанд хүрсэн хүн амын ХБӨ-өөр өвчлөх эрсдэлгүй хүн амын тархалт дөнгөж 3.7% байна. Эрсдэлт хүчин зүйлс огт илрээгүй хүн амын тархалт хот суурин газарт хөдөө орон нутгаас харьцангуй өндөр байв.
- Насанд хүрсэн хүн амын 2 хүн тутмын 1 нь (50.2%) нийтлэг эрсдэлт хүчин зүйлсээс 3 ба түүнээс олон эрсдэл хавсран илэрсэн байна.
- ХБӨ-өөр өвчлөх өндөр эрсдэлтэй хүн амын тархалт эрэгтэйчүүдийн дунд эмэгтэйчүүдээс 1.8 дахин их байна. Энэ нь эрэгтэйчүүдийн дундаж наслалт болон тэдний амьдралын чанарт сөргөөр нөлөөлөх магадлалтай.
- Нас ахих тусам эрсдэлт хүчин зүйл хавсран илэрсэн хүн амын тоо өсөж байна.
- Налайх, Багахангай, Сонгинохайрхан, Багануур, Сүхбаатар, Баянзүрх дүүргүүдэд нийтлэг эрсдэлт хүчин зүйлсээс 3 ба түүнээс олон эрсдэл хавсран илэрсэн хүн амын хувь хотын дундаж (50.2%)-аас өндөр байна.

## ТАМХИНЫ ХЭРЭГЛЭЭ


Хүснэгт 18. Тамхины хэрэглээ хүйсээр

Насанд хүрсэн хүн амын дунд (95% ИХ)	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
Тамхи татдаг хүн амын хувь	<b>19.9</b> (19.7 – 20.8)	<b>40.5</b> (40.1 – 40.9)	<b>7.7</b> (7.5 – 7.9)
Өдөр бүр тамхи татдаг хүн амын хувь	<b>14.5</b> (14.3 – 14.6)	<b>30.7</b> (30.4 – 31.1)	<b>5.0</b> (4.9 – 5.2)
<i>Өдөр бүр тамхи татдаг хүн амын дунд:</i>			
Тамхи татаж эхэлсэн дундаж нас (жилээр)	<b>21.4</b> (21.3 – 21.5)	<b>19.9</b> (19.8 – 19.9)	<b>26.2</b> (26.0 – 26.4)



Зураг 6. Тамхи татдаг хүн ам, хүйс ба насны ангилал

## ГОЛ МЭДЭЭЛЭЛ



Зураг 7. Тамхи татдаг хүн амын тархалт, сумаар


1. Улаанбаатар хотын насанд хүрсэн хүн амын 5 хүн тутмын 1 нь (19,9%) тамхи татдаг бөгөөд эрэгтэйчүүдийн дунд тамхины хэрэглээ эмэгтэйчүүдээс 5.2 дахин их байна.
2. Өдөр бүр тамхи татдаг хүн амын хувь нийт тамхи татдаг хүмүүсийн 72.8%-ийг эзэлж байна.
3. Тамхи татаж эхэлсэн нас дунджаар 21.4 байна.
4. 20-59 нас хүртэлх бүх насны ангилалд тамхины хэрэглээ жигд өндөр байна.
5. Чингэлтэй, Багахангай, Сүхбаатар, Баянзүрх, Сонгинохайрхан дүүргүүдэд тамхи татдаг хүн амын хувь хотын дундаж (19.9%)-аас өндөр байна.




## АРХИ, СОГТУУРУУЛАХ УНДААНЫ ХЭРЭГЛЭЭ

Хүснэгт 19. Архи, согтууруулах ундааны хэрэглээ хүйсээр

Насанд хүрсэн хүн амын дунд (95% ИХ)	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
Сүүлийн 1 сард стандарт уултаас илүү архи, согтууруулах ундаа хэрэглэсэн хүн амын хувь	<b>8.6</b> (8.5 – 8.8)	<b>15.1</b> (14.8 – 15.3)	<b>4.9</b> (4.8 – 5.0)



Зураг 8. Сүүлийн 1 сард архи, согтууруулах ундаа хэрэглэсэн хүн ам, хүйс ба насны бүлгээр



Зураг 9. Сүүлийн 1 сард архи, согтууруулах ундаа хэрэглэсэн хүн ам, сумаар


### ГОЛ МЭДЭЭЛЭЛ

1. Улаанбаатар хотын насанд хүрсэн хүн амын сүүлийн 1 сард стандарт уултаас илүү архи, согтууруулах ундаа хэрэглэсэн хүн амын хувь 7.5% байх бөгөөд эрэгтэйчүүдийн дунд согтууруулах ундааны хэрэглээ эмэгтэйчүүдээс 6.0 дахин их байна.
2. Хөдөлмөрийн насны (20-49 нас) хүмүүсийн архины хэрэглээ бусад насны бүлэгтэй харьцуулахад их байна.
3. Багануур, Багахангай, Сүхбаатар, Налайх, Чингэлтэй, Баянзүрх дүүргүүдэд Сүүлийн 1 сард стандарт уултаас илүү архи, согтууруулах ундаа хэрэглэсэн хүн амын хувь хотын дундаж (8.7%)-аас өндөр байна.

## ХӨДӨЛГӨӨН

Хүснэгт 20. Хөдөлгөөний үзүүлэлт хүйсээр

Насанд хүрсэн хүн амын дунд (95% ИХ)	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
7 хоногийн 5-аас доошгүй өдөр 30 минутаас дээш дасгал хөдөлгөөн хийдэггүй, эсвэл 10000 алхдаггүй хүн амын хувь	<b>59.7</b> (59.4 – 59.9)	<b>58.7</b> (58.4 – 59.1)	<b>60.2</b> (59.9 – 60.5)



Зураг 10. 7 хоногийн 5-аас доошгүй өдөр 30 минутаас дээш дасгал хөдөлгөөн хийдэггүй, эсвэл 10000 алхдаггүй хүн амын тархалт, хүйс ба насны ангилалаар

## ГОЛ МЭДЭЭЛЭЛ




Зураг 11. 7 хоногийн 5-аас доошгүй өдөр 30 минутаас дээш дасгал хөдөлгөөн хийдэггүй, эсвэл 10000 алхдаггүй хүн амын тархалт, сумаар

1. Улаанбаатар хотын “Урьдчилан сэргийлэх эрт илрүүлэгт” хамрагдсан нийт хүн амын 2 хүн тутмын нэг буюу 59.7% нь 7 хоногийн 5-аас доошгүй өдөр 30 минутаас дээш дасгал хөдөлгөөн хийдэггүй, эсвэл 10000 алхдаггүй байна.
2. Хүйсээр авч үзвэл эмэгтэйчүүд (60.2%), эрэгтэйчүүдээс (58.7%) 1.5%-иар их, нас ахих тусам хөдөлгөөний идэвхгүй байдал нэмэгдэж байна.
3. Налайх, Сонгинохайрхан, Багахангай, Баянзүрх дүүргүүдэд 7 хоногийн 5-аас доошгүй өдөр 30 минутаас дээш дасгал хөдөлгөөн хийдэггүй, эсвэл 10000 алхдаггүй хүн амын хувь аймгийн дундаж (59.7%-аас өндөр байна.


## ЖИМС, ЖИМСГЭНЭ, НОГООНЫ ХЭРЭГЛЭЭ

Хүснэгт 21. Жимс, жимсгэнэ, ногооны хэрэглээ хүйсээр

Насанд хүрсэн хүн амын дунд (95% ИХ)	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
Зохистой хэрэглээтэй хүн амын хувь (хоногт $\geq 5$ нэгж буюу 400 г)	<b>33.5</b> (33.3-33.8)	<b>31.1</b> (30.8-31.5)	<b>35.0</b> (34.7-35.3)
Хангалтгүй хэрэглээтэй хүн амын хувь (хоногт $< 5$ нэгж /400 г)	<b>30.8</b> (30.-31.1)	<b>31.9</b> (31.6-32.3)	<b>30.2</b> (29.9-30.5)
Жимс, ногоо бага хэрэглэдэг ХБӨ-ний эрсдэлтэй хүн амын хувь (жимс, ногоог өдөр бүр хэрэглэдэггүй эсвэл хоногт 400 граммаас бага хэрэглэдэг)	<b>66.4</b> (66.2-66.7)	<b>68.9</b> (68.6-69.3)	<b>65.0</b> (64.7-65.3)



Зураг 12. Жимс, жимсгэнэ, хүнсний ногоо бага хэрэглэдэг насанд хүрэгчдийн хувь, насны бүлгээр



Зураг 13. Жимс, жимсгэнэ, ногооны зохистой хэрэглээтэй насанд хүрэгчдийн хувь, дүүргээр


### ГОЛ МЭДЭЭЛЭЛ

1. Улаанбаатар хотын насанд хүрсэн иргэдийн дөнгөж 33.5% жимс, жимсгэнэ, хүнсний ногооны зохистой хэрэглээтэй буюу хоногт  $\geq 400$  г хэмжээгээр хэрэглэж байна. Жимс, жимсгэнэ, хүнсний ногооны зохистой хэрэглээтэй иргэдийн хувь Чингэлтэй, Хан-Уул дүүрэгт хамгийн өндөр, Налайх, Багахангай дүүрэгт хамгийн бага байв.
2. Эрт илрүүлэг үзлэгт хамрагдсан 18–102 насны иргэдийн иргэдийн 66.4% өдөр бүр жимс, ногоо хэрэглэдэггүй эсвэл хоногт 400 граммаас бага хэмжээгээр хэрэглэж байна. Улаанбаатар хотын насанд хүрсэн 3 хүн тутмын 2 “Эрүүл хооллолтын ГЭР зөвлөмж”-д заасан хэмжээ (Хоногт  $\geq 400$ г)-ээр жимс, жимсгэнэ, хүнсний ногоо хэрэглэдэггүй буюу ХБӨ-өөр өвчлөх эрсдэлтэй байв.
3. Жимс, жимсгэнэ, хүнсний ногоо бага хэрэглэдэг буюу ХБӨ-өөр өвчлөх эрсдэлтэй насанд хүрэгчдийн тархалт  $\leq 19$  нас, 60 ба түүнээс дээш насны хүн амын дунд харьцангуй өндөр, харин 20–39 насны залуучуудын дунд бага байна.


## ИЛҮҮДЭЛ ЖИН БА ТАРГАЛАЛТ

Хүснэгт 22. Илүүдэл жин ба таргалалт хүйсээр

Насанд хүрсэн хүн амын дунд (95% ИХ)	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
Биеийн жингийн индекс (БЖИ)-ийн дундаж хэмжээ (кг/м <sup>2</sup> )	<b>26.4</b> (26.3-26.4)	<b>26.8</b> (26.7-26.8)	<b>26.1</b> (26.0-26.1)
Илүүдэл жин ба таргалалттай хүн амын хувь (БЖИ ≥ 25 кг/м <sup>2</sup> )	<b>57.5</b> (57.3-57.8)	<b>63.1</b> (62.8-63.5)	<b>54.2</b> (53.9-54.5)
Таргалалттай хүн амын хувь (БЖИ ≥ 30 кг/м <sup>2</sup> )	<b>18.9</b> (18.7-19.1)	<b>20.6</b> (20.3-20.9)	<b>17.9</b> (17.7-18.1)
Бүсэлхийн тойргийн дундаж хэмжээ (см)	-	<b>89.7</b> (89.6-89.8)	<b>83.2</b> (83.1-83.3)
Төвийн таргалалттай хүн амын хувь (Бүсэлхийн тойрог: эр ≥ 90 см, эм ≥ 80 см)	<b>56.0</b> (55.7-56.2)	<b>50.1</b> (49.7-50.5)	<b>59.4</b> (59.1-59.7)



Зураг 14. Илүүдэл жин ба таргалалтын тархалт, насны бүлгээр



Зураг 15. Таргалалтын тархалт (БЖИ ≥ 30 кг/м<sup>2</sup>), дүүргээр


### ГОЛ МЭДЭЭЛЭЛ

1. Урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдсан Улаанбаатар хотын насанд хүрэгчдийн БЖИ-ийн дундаж хэмжээ 26.4 кг/м<sup>2</sup> байгаа нь ДЭМБ-аас зөвлөсөн хэвийн хязгаараас хэтэрсэн байна. Иргэдийн БЖИ-ийн дундаж хэмжээ хүйсийн ялгаатай, эрэгтэйчүүдэд статистик ач холбогдол бүхий өндөр байв.
2. Улаанбаатар хотын насанд хүрэгчдийн 57.5% илүүдэл жин ба таргалалттай, 18.9% тарган байна. Таргалалтын тархалт эрэгтэйчүүдийн дунд статистик ач холбогдол бүхий өндөр, Улаанбаатар хотын 5 эрэгтэй тутмын 1 нь тарган байна. Илүүдэл жин ба таргалалтын тархалт аль ч хүйсийн насанд хүрэгчдийн дунд нас ахих тутам нэмэгдэх хандлага ажиглагдсан бөгөөд 30 ба түүнээс дээш насны 2 хүн тутмын 1-ээс илүү нь илүүдэл жин ба таргалалттай байв.
3. Эрт илрүүлэг үзлэгт хамрагдсан насанд хүрэгчдийн 56.0% төвийн таргалалттай, төвийн таргалалтын тархалт эмэгтэйчүүдийн дунд эрэгтэйчүүдээс харьцангуй өндөр байна.


## АРТЕРИЙН ГИПЕРТЕНЗИ

Хүснэгт 23. Артерийн гипертензи хүйсээр

Насанд хүрсэн хүн амын дунд (95% ИХ)	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
Систолын артерийн даралт (САД)-ын дундаж хэмжээ, мм МУБ (даралт бууруулах эм хэрэглэж байгаа хүн амыг оролцуулсан)	<b>120.6</b> (120.5-120.6)	<b>123.1</b> (123.0-123.3)	<b>119.1</b> (118.9-119.2)
Диастолын артерийн даралт (ДАД)-ын дундаж хэмжээ, мм МУБ (даралт бууруулах эм хэрэглэж байгаа хүн амыг оролцуулсан)	<b>78.1</b> (78.0-78.1)	<b>79.9</b> (79.8-80.0)	<b>77.0</b> (76.9-77.1)
Артерийн даралт ихсэлтгүй хүн амын хувь (САД = 120-129 мм МУБ ба/эсвэл ДАД ≤ 80 мм МУБ)	<b>30.4</b> (30.2-30.6)	<b>33.4</b> (33.0-33.8)	<b>28.6</b> (28.4-28.9)
Артерийн гипертензитай хүн амын хувь (САД ≥ 130 ба/эсвэл ДАД ≥ 81 мм МУБ эсвэл даралт бууруулах эм хэрэглэдэг хүн амын оролцуулсан)	<b>31.0</b> (30.7-31.2)	<b>35.8</b> (35.4-36.2)	<b>28.1</b> (27.9-28.4)



Зураг 16. Артерийн гипертензийн тархалт, насны бүлгээр



Зураг 17. Артерийн гипертензийн тархалт, дүүргээр


### ГОЛ МЭДЭЭЛЭЛ

1. Эрт илрүүлэг үзлэгт хамрагдсан Улаанбаатар хотын насанд хүрэгчдийн САД-ын дундаж хэмжээ 120.6 мм МУБ, ДАД-ын дундаж үзүүлэлт 78.1 мм МУБ байна.
2. Насанд хүрэгчдийн 30.4% артерийн даралт ихсэлтгүй буюу САД нь 120–129 мм ба/эсвэл ДАД ≤ 80 мм МУБ байв. Артерийн даралт ихсэлтийн тархалт эрэгтэйчүүдийн дунд статистик ач холбогдол бүхий өндөр байна.
3. Урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдсан насанд хүрсэн иргэдийн дунд САД ≥ 130 мм МУБ ба ДАД ≥ 81 мм МУБ-ээс дээш буюу Артерийн гипертензи (АГ)-ийн тархалт 31.0% байв. АГ-ийн тархалт Улаанбаатар хотын эрэгтэйчүүдийн дунд эмэгтэйчүүдийн үзүүлэлтээс статистик ач холбогдол бүхий өндөр байна ( $p < 0.0001$ ).
4. АГ-ийн тархалт иргэдийн нас ахих тутам нэмэгдэх хандлага ажиглагдсан бөгөөд 60 ба түүнээс дээш насны 2 хүн тутмын 1-ээс илүү нь АГ-тэй байв.
5. АГ-ийн тархалт Сонгинохайрхан, Сүхбаатар, Баянзүрх дүүргийн иргэдийн дунд харьцангуй өндөр ажиглагдсан болно.


## ЧИХРИЙН ШИЖИН

Хүснэгт 24. Чихрийн шижин хүйсээр

Насанд хүрсэн хүн амын дунд (95% ИХ)	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
Өлөн үеийн цусны глюкозын дундаж хэмжээ (ммоль/л), глюкоз бууруулах эм хэрэглэж буй хүн амыг оруулаад	<b>5.2</b> (5.2-5.3)	<b>5.5</b> (5.4-5.5)	<b>5.1</b> (5.0-5.1)
Өлөн үеийн цусны глюкозын өөрчлөлттэй хүн амын хувь (Ийлдсийн глюкозын хэмжээ $\geq 6.1$ ммол/л ба $< 7.0$ ммол/л)	<b>5.2</b> (5.1-5.3)	<b>6.7</b> (6.5-7.0)	<b>4.3</b> (4.2-4.4)
Өлөн үеийн цусны глюкозын хэмжээ ихэссэн болон глюкоз бууруулах эм хэрэглэж буй хүн амын хувь (Ийлдсийн глюкозын хэмжээ $\geq 7.0$ ммол/л)	<b>8.7</b> (8.6-8.9)	<b>11.5</b> (11.2-11.8)	<b>7.1</b> (7.0-7.3)



Зураг 18. Өлөн үеийн цусны глюкозын өөрчлөлттэй болон ЧШ-тэй хүн амын хувь, насны бүлгээр



Зураг 19. Чихрийн шижингийн тархалт, дүүргээр


## ГОЛ МЭДЭЭЛЭЛ

1. Улаанбаатар хотын эрт ирүүлэг үзлэгт хамрагдсан насанд хүрэгчдийн өлөн үеийн цусны глюкозын дундаж хэмжээ 5.2 ммоль/л байна. Цусны глюкозын дундаж хэмжээ нь хүйсийн ялгаа ажиглагдсан бөгөөд эрэгтэйчүүдэд харьцангуй өндөр байв.
2. Насанд хүрсэн иргэдийн 5.2% өлөн үеийн цусны глюкозын өөрчлөлттэй, 8.7% цусны глюкозын хэмжээ ихэссэн буюу чихрийн шижинтэй байна. Өлөн үеийн цусны глюкозын өөрчлөлт, чихрийн шижингийн тархалт нь иргэдийн настай шууд хамааралтай ихсэх хандлагатай байв.
3. Эрт илрүүлэг үзлэгт хамрагдсан эрэгтэйчүүдийн дунд өлөн үеийн цусны глюкозын өөрчлөлт болон чихрийн шижингийн тархалт эмэгтэйчүүдээс статистик ач холбогдол бүхий илүү байв.
4. Урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдсан Улаанбаатар хотын  $\leq 19$  насны залуучуудын дунд далд чихрийн шижин буюу өлөн үеийн цусны глюкозын өөрчлөлтийн тохиолдол 2.2% байгаа нь анхаарал татаж байна.
5. Чихрийн шижингийн тархалт Багахангай, Баянзүрх, Баянгол, Чингэлтэй дүүргийн иргэдийн дунд харьцангуй илүү байв.


## ӨЛӨН ҮЕИЙН ЦУСНЫ ЛИПИДЫН ҮНЭЛГЭЭ

Хүснэгт 25. Өлөн үеийн цусны липидын үнэлгээ хүйсээр

Насанд хүрсэн хүн амын дунд (95% ИХ)	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
“Өлөн үеийн цусны холестерин хэмжээ ихэссэн” гэж оношлогдож байсан хүн амын хувь	<b>8.1</b> (7.9-8.2)	<b>8.4</b> (8.2-8.6)	<b>7.8</b> (7.7-8.0)
Цусны нийт холестерин хэмжээ ихэссэн ( $\geq 5.3$ ммоль/л) хүн амын хувь	<b>37.3</b> (37.0-37.6)	<b>40.3</b> (39.9-40.8)	<b>35.4</b> (35.1-35.8)
“Өлөн үеийн цусны триглицеридийн хэмжээ ихэссэн” гэж оношлогдож байсан хүн амын хувь	<b>3.6</b> (3.5-3.7)	<b>4.4</b> (4.3-4.6)	<b>3.1</b> (3.0-3.2)
Цусны триглицеридийн хэмжээ ихэссэн ( $\geq 1.7$ ммоль/л) хүн амын хувь	<b>12.7</b> (12.5-12.9)	<b>18.9</b> (18.5-19.3)	<b>8.9</b> (8.7-9.1)



Зураг 20. Өлөн үеийн цусны липидын хэмжээ ихэссэн хүн амын хувь, насны бүлгээр



Зураг 21. Өлөн үеийн цусны нийт холестерин агууламж ихэссэн хүн амын хувь


### ГОЛ МЭДЭЭЛЭЛ

1. Улаанбаатар хотын эрт илрүүлэгт хамрагдсан насанд хүрэгчдийн 8.1% цусны нийт холестерин хэмжээ ихэссэн, харин 3.6% триглицеридийн агууламж ихэссэн гэж оношлогдож байжээ.
2. Насанд хүрэгчдийн 37.3% өлөн үеийн цусны нийт холестерин, 12.7% триглицеридийн агууламж ихэссэн байна. Цусны нийт холестерин хэмжээ ихэссэн тохиолдол эрэгтэйчүүдийн дунд 4.9 хувиар илүү, триглицеридийн ихсэлт эрэгтэйчүүдэд эмэгтэйчүүдээс 2.1 дахин өндөр байв ( $p < 0.001$ ).
3. Өлөн үеийн цусны липидын ихсэлт иргэдийн настай шууд хамааралтай нэмэгдэх хандлага ажиглагдсан бөгөөд Улаанбаатар хотын 50–69 насны хүн амын талаас илүү хувь цусны холестерин агууламж ихэссэн байна.
4. Цусны нийт холестерин агууламж ихэссэн иргэдийн хувь Хан-Уул, Сүхбаатар, Чингэлтэй дүүрэгт харьцан илүү байв.

## ХУВЬ ХҮНИЙ ЭРСДЭЛИЙН ҮНЭЛГЭЭ

Хүснэгт 26. Хувь хүний эрсдэлийн үнэлгээ хүйсээр

Насанд хүрсэн хүн амын дунд (95% ИХ)	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
Гэр бүлийн гишүүн чихрийн шижингээр өвчилж байсан <i>Өвөө, эмээ, нагац, авга Эцэг, эх, ах дүү, өөрийн хүүхэд</i>	<b>11.7</b> (11.5-11.9)	<b>10.3</b> (10.1-10.6)	<b>12.5</b> (12.3-12.8)
Жирэмсний чихрийн шижингээр өвчилж байсан	-	-	<b>9.9</b> (9.7-10.1)
Хавдраар өвчилж байсан түүх (гэр бүлийн гишүүн)	<b>15.4</b> (15.3-15.6)	<b>12.6</b> (12.3-12.8)	<b>17.1</b> (16.9-17.3)
Артерийн даралт бууруулах эм тогтмол хэрэглэдэг	<b>19.0</b> (18.8-19.2)	<b>15.0</b> (14.7-15.2)	<b>21.2</b> (21.0-21.5)
Цусны өөх тос бууруулах эм хэрэглэж байгаа	<b>13.8</b> (13.6-13.9)	<b>12.3</b> (12.0-12.5)	<b>14.6</b> (14.4-14.9)



Зураг 22. "Гэр бүлийн хэн нэгэн гишүүн нь чихрийн шижин, хавдраар өвчилж байсан" гэж хариулсан насанд хүрэгчдийн хувь, насны бүлгээр

### ГОЛ МЭДЭЭЛЭЛ


1. Эрт илрүүлэг урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдсан Улаанбаатар хотын насанд хүрэгчдийн 11.7% гэр бүлийн хэн нэгэн гишүүн "чихрийн шижингээр өвчилсөн", 15.4% хавдраар өвчилсөн гэж хариулсан байна. Нийт эмэгтэйчүүдийн 9.9% жирэмсний чихрийн шижин оношлогдож байжээ.
2. Урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдсан Улаанбаатар хотын иргэдийн 19.0% артерийн даралт бууруулах эмийг тогтмол хэрэглэдэг, харин 13.8% цусны өөх тос бууруулах эмийг одоо хэрэглэж байв.
3. Гэр бүлийн хэн нэгэн гишүүн чихрийн шижингээр өвчилсөн гэж хариулсан хүн амын тархалт иргэдийн настай урвуу хамааралтай буюу нас ахих тутам буурах хандлага ажиглагдсан болно. Тодруулбал, 18–29 насны залуучуудын дунд хамгийн түгээмэл, 60 ба түүнээс дээш насны иргэдийн дунд хамгийн бага байв.
4. Гэр бүлийн хэн нэгэн гишүүн хавдраар өвчилсөн өгүүлэмжтэй иргэдийн хувь тэдний настай шууд хамааралтай ихсэх зүй тогтол ажиглагдсан бөгөөд урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдсан 40–59 насны хүн амын дунд харьцангуй өндөр байв.



**АРХАНГАЙ АЙМГИЙН НАСАНД ХҮРЭГЧДИЙН ДУНДАХ  
ХАЛДВАРТ БУС ӨВЧНИЙ ЭРСДЭЛТ ХҮЧИН ЗҮЙЛСИЙН  
ТАРХАЛТ**

**ТАНИЛЦУУЛГА**

Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/248 дугаар тушаалыг хэрэгжүүлэх арга хэмжээний хүрээнд 2022 оны 5 дугаар сарын 1-ээс 2023 оны 5 дугаар сар хүртэлх хугацаанд эрт илрүүлэг, урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдсан Архангай аймгийн 10.066 насанд хүрэгчдийн мэдээллийг нэгтгэн, Монгол Улсад түгээмэл тохиолдож буй Халдварт бус өвчин (ХБӨ)-ий эрсдэлт хүчин зүйлсийн тархалтын тархалтын байдалд дүн шинжилгээ хийв (Зураг 23).



Зураг 23. Эрт илрүүлэг үзлэгт хамрагдсан насанд хүрэгчдийн тоо, сумдын дүнгээр

Эрт илрүүлэг, урьдчилан сэргийлэх үзлэгт Архангай аймгаас 18-89 насны нийт 10.066 хүн хамрагдсан бөгөөд тэдний 43.8% (n=4,406) эрэгтэйчүүд, 56.2% (n=5,660) эмэгтэйчүүд байв (Хүснэгт 27).

Хүснэгт 27. Эрт илрүүлэгт хамрагдсан насанд хүрэгчид, нас ангилал ба хүйсээр

Насны ангилал, жилээр	N	Эрэгтэй			Эмэгтэй		
		Тоо	Хувь	95% ИХ	Тоо	Хувь	95% ИХ
≤ 19	515	395	76.7	72.9-80.2	120	23.3	19.8-27.1
20 – 29	2011	906	45.1	42.9-47.2	1105	54.9	52.8-57.1
30 – 39	2121	900	42.4	40.3-44.5	1221	57.6	55.5-59.7
40 – 49	2113	884	41.8	39.7-43.9	1229	58.2	56.1-60.3
50 – 59	1916	776	40.5	38.3-42.7	1140	59.5	57.3-61.7
60 – 69	1038	401	39.6	35.7-41.6	637	61.4	58.4-64.3
≥ 70	352	144	40.9	35.9-46.1	208	59.1	53.9-64.1
<b>Нийт</b>	<b>10,066</b>	<b>4,406</b>	<b>43.8</b>	<b>42.8-44.7</b>	<b>5,660</b>	<b>56.2</b>	<b>55.3-57.2</b>


Эрт илрүүлэг үзлэгт хамрагдсан Архангай аймгийн насанд хүрэгчдийн дундаж нас 41.9 (95%ИХ 41.7–42.3) жил, эмэгтэйчүүдийн дундаж нас эрэгтэйчүүдээс 2.8 жилээр илүү байна (дундаж нас: эр 40.4 жил, эм 43.2 жил).

## ХАЛДВАРТ БУС ӨВЧНИЙ НИЙТЛЭГ ЭРСДЭЛТ ХҮЧИН ЗҮЙЛС ХАВСРАН ИЛЭРСЭН ХҮН АМ

Хүснэгт 28. Халдварт бус өвчний нийтлэг эрсдэлт хүчин зүйлс хавсран илэрсэн хүн ам хүйсээр

Хүн амын дунд (95% ИХ)	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
<b>ХБӨ-ий нийтлэг эрсдэлт хүчин зүйлс</b>			
<ul style="list-style-type: none"> <li>Өдөр бүр тамхи татдаг</li> <li>Өдөрт 5 нэгжээс бага хэмжээгээр жимс, ногоо хэрэглэдэг</li> <li>Хөдөлгөөний хомсдолтой</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Илүүдэл жинтэй (БЖИ <math>\geq 25</math> кг/м<sup>2</sup>)</li> <li>Артерийн даралт ихсэлттэй (САД <math>\geq 140</math> ба/эсвэл ДАД <math>\geq 90</math> мм МУБ эсвэл даралт бууруулах эм хэрэглэж байгаа)*</li> </ul>		
Нийтлэг эрсдэлт хүчин зүйлс илрээгүй хүн амын хувь	<b>2.0</b> (1.7 – 2.3)	<b>1.6</b> (1.2 – 2.0)	<b>2.4</b> (1.9 – 2.8)
Нийтлэг эрсдэлт хүчин зүйлсээс 1-2 эрсдэл хавсран илэрсэн хүн амын хувь	<b>40.2</b> (39.1 – 41.2)	<b>37.3</b> (35.8 – 38.9)	<b>42.5</b> (41.1 – 44.0)
Нийтлэг эрсдэлт хүчин зүйлсээс 3 ба түүнээс олон эрсдэл хавсран илэрсэн хүн амын хувь	<b>57.8</b> (56.7 – 58.9)	<b>61.1</b> (59.6 – 62.7)	<b>55.1</b> (53.7 – 56.6)

\*ДЭМБ-ын үзүүлэлтийг баримтлав.




Зураг 24. Нийтлэг эрсдэлт хүчин зүйлсээс 3 ба түүнээс олон эрсдэл хавсран илэрсэн хүн амын хувь, хүйс, насны ангилал


## ТАМХИНЫ ХЭРЭГЛЭЭ

Хүснэгт 29. Тамхины хэрэглээ хүйсээр

Насанд хүрсэн хүн амын дунд (95% ИХ)	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
Тамхи татдаг хүн амын хувь	<b>20.6</b> (19.8 – 21.5)	<b>45.4</b> (43.8 – 46.9)	<b>0.9</b> (0.7 – 1.2)
Өдөр бүр тамхи татдаг хүн амын хувь	<b>12.1%</b> (11.4 – 12.6)	<b>26.8%</b> (25.5 – 28.2)	<b>0.4%</b> (0.2 – 0.6)
<i>Өдөр бүр тамхи татдаг хүн амын дунд:</i>			
Тамхи татаж эхэлсэн дундаж нас (жилээр)	<b>19.4</b> (19.1 – 19.6)	<b>19.2</b> (18.9 – 19.5)	<b>28.4</b> (24.4 – 32.4)



Зураг 25. Тамхи татдаг хүн ам, хүйс ба насны ангилал



Зураг 26. Тамхи татдаг хүн амын тархалт, сумаар


### ГОЛ МЭДЭЭЛЭЛ

1. Архангай аймгийн насанд хүрсэн хүн амын 5 хүн тутмын 1 нь (20.6%) тамхи татдаг бөгөөд эрэгтэйчүүдийн дунд тамхины хэрэглээ эмэгтэйчүүдээс 50.4 дахин их байна.
2. Өдөр бүр тамхи татдаг хүн амын хувь нийт тамхи татдаг хүмүүсийн 58.7%-ийг эзэлж байна.
3. Тамхи татаж эхэлсэн нас дунджаар 19.4 байна.
4. 59 нас хүртэлх бүх насны ангилалд тамхины хэрэглээ жигд өндөр байна.
5. Цэнхэр, Өлзийт, Өндөр-улаан, Хайрхан, Чулуут, Эрдэнэбулган, Булган, Цэцэрлэг, Цахир, Өгийнуур, Жаргалант, Хангай сумуудад тамхи татдаг хүн амын хувь аймгийн дундаж (20.6%)-аас өндөр байна.

## АРХИ, СОГТУУРУУЛАХ УНДААНЫ ХЭРЭГЛЭЭ

Хүснэгт 30. Архи, согтууруулах ундааны хэрэглээ хүйсээр

Насанд хүрсэн хүн амын дунд (95% ИХ)	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
Сүүлийн 1 сард стандарт уулгаас илүү архи, согтууруулах ундаа хэрэглэсэн хүн амын хувь	<b>7.5</b> (6.9 – 8.0)	<b>13.9</b> (12.8 – 15.0)	<b>2.3</b> (1.9 – 2.7)



Зураг 27. Сүүлийн 1 сард архи, согтууруулах ундаа хэрэглэсэн хүн ам, хүйс ба насны ангиллаар



Зураг 28. Сүүлийн 1 сард архи, согтууруулах ундаа хэрэглэсэн хүн ам, сумаар


### ГОЛ МЭДЭЭЛЭЛ

1. Архангай аймгийн насанд хүрсэн хүн амын сүүлийн 1 сард стандарт уулгаас илүү архи, согтууруулах ундаа хэрэглэсэн хүн амын хувь 7.5% байх бөгөөд эрэгтэйчүүдийн дунд согтууруулах ундааны хэрэглээ эмэгтэйчүүдээс 6.0 дахин их байна.
2. Хөдөлмөрийн насны (20-49 нас) хүмүүсийн архины хэрэглээ бусад насны ангилалтай харьцуулахад их байна.
3. Чулуут, Эрдэнэмандал, Хайрхан, Цэнхэр, Жаргалант, Эрдэнэбулган, Цэцэрлэг, Тариат, Өлзийт, Өгийнуур сумуудад Сүүлийн 1 сард стандарт уулгаас илүү архи, согтууруулах ундаа хэрэглэсэн хүн амын хувь аймгийн дундаж (7.5%)-аас өндөр байна.


## ЖИМС, ЖИМСГЭНЭ, НОГООНЫ ХЭРЭГЛЭЭ

Хүснэгт 31. Жимс, жимсгэнэ, ногооны хэрэглээ хүйсээр

Насанд хүрсэн хүн амын дунд (95% ИХ)	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
Зохистой хэрэглээтэй хүн амын хувь (хоногт $\geq 5$ нэгж буюу 400 г)	<b>21.8</b> (20.9 – 22.6)	<b>20.4</b> (19.2 – 21.7)	<b>22.8</b> (21.6 – 24.0)
Хангалтгүй хэрэглээтэй хүн амын хувь (хоногт $< 5$ нэгж /400 г)	<b>35.3</b> (34.3 – 36.3)	<b>36.3</b> (34.8 – 37.8)	<b>34.6</b> (33.3 – 35.9)
Жимс, ногоо бага хэрэглэдэг ХБӨ-ний эрсдэлтэй хүн амын хувь (жимс, ногоог өдөр бүр хэрэглэдэггүй эсвэл хоногт 400 граммаас бага хэрэглэдэг)	<b>78.2</b> (77.4 – 79.1)	<b>79.6</b> (78.3 – 80.8)	<b>77.2</b> (76.0 – 78.4)



Зураг 29. Жимс, жимсгэнэ, хүнсний ногоо бага хэрэглэдэг насанд хүрэгчдийн хувь, насны ангиллаар



Зураг 30. Жимс, жимсгэнэ, ногооны зохистой хэрэглээтэй насанд хүрэгчдийн хувь, сумаар


### ГОЛ МЭДЭЭЛЭЛ

1. Архангай аймгийн насанд хүрсэн иргэдийн 5 хүн тутмын 1 буюу 21.8% нь жимс, жимсгэнэ, хүнсний ногоог хоногт 5 нэгж буюу 400 граммаас их хэмжээгээр хэрэглэдэг буюу зохистой хэрэглээтэй байна.
2. Эрт илрүүлэг үзлэгт хамрагдсан 18-89 насны иргэдийн 78.2% нь өдөр бүр жимс, ногоо хэрэглэдэггүй эсвэл хоногт 400 граммаас бага хэмжээгээр хэрэглэж байна.
3. Насанд хүрсэн 10 хүн тутмын 9 нь “Эрүүл хооллолтын ГЭР зөвлөмж”-д заасан хэмжээ (Хоногт  $\geq 400$ г)-ээр жимс, хүнсний ногоог хэрэглэдэггүй буюу ХБӨ-өөр өвчлөх эрсдэлтэй байв.
4. Жимс, жимсгэнэ, хүнсний ногоо бага хэрэглэдэг буюу ХБӨ-өөр өвчлөх эрсдэлтэй насанд хүрэгчдийн тархалт 19 ба түүнээс доош, 60 ба түүнээс дээш насны иргэдийн дунд харьцангуй их байна.


## ХӨДӨЛГӨӨН

Хүснэгт 32. Хөдөлгөөн хүйсээр

Насанд хүрсэн хүн амын дунд (95% ИХ)	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
7 хоногийн 5-аас доошгүй өдөр 30 минутаас дээш дасгал хөдөлгөөн хийдэггүй, эсвэл 10000 алхдаггүй хүн амын хувь	<b>58.5</b> (57.5 – 59.6)	<b>53.2</b> (51.7 – 54.8)	<b>62.7</b> (61.4 – 64.1)



Зураг 31. 7 хоногийн 5-аас доошгүй өдөр 30 минутаас дээш дасгал хөдөлгөөн хийдэггүй, эсвэл 10000 алхдаггүй хүн амын тархалт, хүйс ба насны ангиллаар



Зураг 32. 7 хоногийн 5-аас доошгүй өдөр 30 минутаас дээш дасгал хөдөлгөөн хийдэггүй, эсвэл 10000 алхдаггүй хүн амын тархалт, сумаар


### ГОЛ МЭДЭЭЛЭЛ

1. Архангай аймгийн “Урьдчилан сэргийлэх эрт илрүүлэгт” хамрагдсан нийт хүн амын 2 хүн тутмын нэг буюу 58.5% нь 7 хоногийн 5-аас доошгүй өдөр 30 минутаас дээш дасгал хөдөлгөөн хийдэггүй, эсвэл 10000 алхдаггүй байна.
2. Хүйсээр авч үзвэл эмэгтэйчүүд (62.7%), эрэгтэйчүүдээс (53.2%) 9.5%-иар их, нас ахих тусам хөдөлгөөний идэвхгүй байдал нэмэгдэж байна.
3. Их тамир, Цэцэрлэг, Төвшрүүлэх Чулуут, Өндөр-улаан, Цахир, Жаргалант, сумуудад 7 хоногийн 5-аас доошгүй өдөр 30 минутаас дээш дасгал хөдөлгөөн хийдэггүй, эсвэл 10000 алхдаггүй хүн амын хувь аймгийн дундаж (58.5%)-аас өндөр байна.


## ИЛҮҮДЭЛ ЖИН БА ТАРГАЛАЛТ

Хүснэгт 33. Илүүдэл жин ба таргалалт хүйсээр

Насанд хүрсэн хүн амын дунд (95% ИХ)	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
Биеийн жингийн индекс (БЖИ)-ийн дундаж хэмжээ (кг/м <sup>2</sup> )	<b>26.3</b> (26.2-26.4)	<b>25.9</b> (25.8-26.1)	<b>26.6</b> (26.4-26.7)
Илүүдэл жин ба таргалалттай хүн амын хувь (БЖИ ≥ 25 кг/м <sup>2</sup> )	<b>49.4</b> (47.8 – 51.1)	<b>48.0</b> (45.8 – 50.7)	<b>50.9</b> (48.7 – 53.0)
Таргалалттай хүн амын хувь (БЖИ ≥ 30 кг/м <sup>2</sup> )	<b>18.0</b> (17.2 – 18.8)	<b>15.2</b> (14.1 – 16.4)	<b>20.2</b> (19.1-21.3)
Бүсэлхийн тойргийн дундаж хэмжээ (см)	-	<b>84.9</b> (84.5 – 85.4)	<b>81.1</b> (85.0 – 86.4)
Төвийн таргалалттай хүн амын хувь (Бүсэлхийн тойрог: эр ≥ 90 см, эм ≥ 80 см)	<b>41.6</b> (40.6-42.6)	<b>30.5</b> (29.1-32.0)	<b>50.4</b> (48.9-51.8)



Зураг 33. Илүүдэл жин ба таргалалтын тархалт, насны ангиллаар



Зураг 34. Таргалалтын тархалт (БЖИ≥30 кг/м<sup>2</sup>), сумаар


## ГОЛ МЭДЭЭЛЭЛ

1. Урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдсан Архангай аймгийн 18–89 насны иргэдийн БЖИ-ийн дундаж хэмжээ 26.3 кг/м<sup>2</sup> байгаа нь ДЭМБ-аас зөвлөсөн хэвийн хязгаараас давсан байна.
2. Нийт насанд хүрэгчдийн 49.4% илүүдэл жин ба таргалалттай, 18.0% нь тарган байна. Таргалалтын тархалт эмэгтэйчүүдийн дунд эрэгтэйчүүдийн үзүүлэлтээс 5.0 хувиар илүү, аль ч хүйсийн насанд хүрэгчдийн дунд нас ахих тутам нэмэгдэх хандлагатай байв.
3. Архангай аймгийн насанд хүрэгчдийн 41.6% төвийн таргалалттай, төвийн таргалалттай эмэгтэйчүүдийн хувь эрэгтэйчүүдээс 1.7 дахин илүү байна.


## АРТЕРИЙН ГИПЕРТЕНЗИ

Хүснэгт 34. Артерийн гипертензи хүйсээр

Насанд хүрсэн хүн амын дунд (95% ИХ)	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
Систолийн артерийн даралт (САД)-ын дундаж хэмжээ, мм МУБ (даралт бууруулах эм хэрэглэж байгаа хүн амыг оролцуулсан)	<b>124.0</b> (123.6-124.4)	<b>125.3</b> (124.8-125.9)	<b>122.9</b> (122.3-123.4)
Диастольн артерийн даралт (ДАД)-ын дундаж хэмжээ, мм МУБ (даралт бууруулах эм хэрэглэж байгаа хүн амыг оролцуулсан)	<b>78.5</b> (78.2-78.7)	<b>79.2</b> (78.8-79.5)	<b>77.9</b> (77.6-78.2)
Артерийн даралт ихсэлттэй хүн амын хувь (САД = 120-129 мм МУБ ба/эсвэл ДАД ≤ 80 мм МУБ)	<b>33.9</b> (32.9-34.9)	<b>36.4</b> (34.9-37.9)	<b>32.0</b> (30.7-33.3)
Артерийн гипертензитэй хүн амын хувь (САД ≥ 130 ба/эсвэл ДАД ≥ 81 мм МУБ эсвэл даралт бууруулах эм хэрэглэдэг хүн амын оролцуулсан)	<b>35.9</b> (34.9-36.9)	<b>37.7</b> (36.1-39.2)	<b>34.5</b> (33.2-35.9)



Зураг 35. Артерийн гипертензийн тархалт, насны ангиллаар



Зураг 36. Артерийн гипертензийн тархалт, сумаар

## ГОЛ МЭДЭЭЛЭЛ


1. Эрт илрүүлэг үзлэгт хамрагдсан Архангай аймгийн насанд хүрэгчдийн САД болон ДАД-ын дундаж хэмжээ тус тус, 124.0 мм ба 78.5 мм МУБ байна.
2. Насанд хүрэгчдийн 33.9% артерийн даралт ихсэлттэй буюу САД нь 120–129 мм ба/эсвэл ДАД ≤ 80 мм МУБ байв. Артерийн даралт ихсэлтийн тархалт эрэгтэйчүүдийн дунд статистик ач холбогдол бүхий өндөр байна.
3. Урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдсан насанд хүрэгчдийн дунд САД ≥ 130 мм МУБ ба ДАД ≥ 81 мм МУБ-ээс дээш буюу Артерийн гипертензи (АГ)-ийн тархалт 35.9%, эрэгтэйчүүдийн дунд харьцангуй өндөр байна.
4. Архангай аймгийн 50–59 насны 2 хүн тутмын 1 нь, 60 ба түүнээс дээш насны 10 хүн тутмын 7 орчим АГ-тэй байв.




## ЧИХРИЙН ШИЖИН

Хүснэгт 35. Чихрийн шижин хүйсээр

Насанд хүрсэн хүн амын дунд (95% ИХ)	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
Өлөн үеийн цусны глюкозын дундаж хэмжээ (ммоль/л), глюкоз бууруулах эм хэрэглэж буй хүн амыг оруулаад	<b>4.9</b> (4.9 – 5.0)	<b>5.1</b> (5.0 – 5.2)	<b>4.9</b> (4.87-4.94)
Өлөн үеийн цусны глюкозын өөрчлөлттэй хүн амын хувь (Ийлдсийн глюкозын хэмжээ $\geq 6.1$ ммол/л ба $< 7.0$ ммол/л)	<b>3.1</b> (2.7-3.5)	<b>3.9</b> (3.2-4.6)	<b>2.5</b> (1.9-2.9)
Өлөн үеийн цусны глюкозын хэмжээ ихэссэн болон глюкоз бууруулах эм хэрэглэж буй хүн амын хувь (Ийлдсийн глюкозын хэмжээ $\geq 7.0$ ммол/л)	<b>3.9</b> (3.5-4.4)	<b>4.6</b> (3.9-5.4)	<b>3.4</b> (2.9-3.9)



Зураг 37. Өлөн үеийн цусны глюкозын өөрчлөлттэй болон ЧШ-тэй хүн амын хувь, насны ангиллаар



Зураг 38. Чихрийн шижингийн тархалт, сумаар


## ГОЛ МЭДЭЭЛЭЛ

1. Архангай аймгийн эрт ирүүлэг үзлэгт хамрагдсан насанд хүрэгчдийн өлөн үеийн цусны глюкозын дундаж хэмжээ 4.9 ммоль/л байв.
2. Насанд хүрсэн иргэдийн 3.1% нь өлөн үеийн цусны глюкозын өөрчлөлттэй, 3.9% өлөн үеийн цусны глюкозын хэмжээ ихэссэн буюу чихрийн шижинтэй байна.
3. Эрт илрүүлэг үзлэгт хамрагдсан эрэгтэйчүүдийн дунд өлөн үеийн цусны глюкозын өөрчлөлт болон чихрийн шижингийн тархалт эмэгтэйчүүдээс харьцангуй өндөр байв.
4. Урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдсан  $\leq 19$  насны залуучуудын дунд өлөн үеийн цусны глюкозын өөрчлөлт, болон чихрийн шижингийн тохиолдол илрээгүй болно.


## ӨЛӨН ҮЕИЙН ЦУСНЫ ЛИПИДЫН ҮНЭЛГЭЭ

Хүснэгт 36. Өлөн үеийн цусны липидын үнэлгээ хүйсээр

Насанд хүрсэн хүн амын дунд (95% ИХ)	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
“Өлөн үеийн цусны холестерин хэмжээ ихэссэн” гэж оношлогдож байсан хүн амын хувь	<b>8.7</b> (8.1-9.2)	<b>9.4</b> (8.5-10.2)	<b>8.1</b> (7.4-8.9)
Цусны нийт холестерин хэмжээ ихэссэн ( $\geq 5.3$ ммоль/л) хүн амын хувь	<b>31.5</b> (30.2-32.8)	<b>31.0</b> (29.0-33.0)	<b>31.8</b> (30.1-33.6)
“Өлөн үеийн цусны триглицеридийн хэмжээ ихэссэн” гэж оношлогдож байсан хүн амын хувь	<b>4.0</b> (3.6-4.4)	<b>4.8</b> (4.2-5.5)	<b>3.4</b> (2.9-3.8)
Цусны триглицеридийн хэмжээ ихэссэн ( $\geq 1.7$ ммоль/л) хүн амын хувь	<b>18.9</b> (17.8-19.9)	<b>20.3</b> (18.6-22.1)	<b>17.9</b> (16.4-19.3)



Зураг 39. Өлөн үеийн цусны липидын хэмжээ ихэссэн хүн амын хувь, насны ангиллаар



Зураг 40. Өлөн үеийн цусны нийт холестерин агууламж ихэссэн хүн амын хувь


### ГОЛ МЭДЭЭЛЭЛ

1. Эрг илрүүлэг үзлэгт хамрагдсан Архангай аймгийн насанд хүрсэн иргэдийн 8.7% цусны холестерин ихэссэн, харин 4.0% триглицеридийн агууламж ихэссэн гэж оношлогдож байжээ.
2. Нийт насанд хүрэгчдийн 31.5% өлөн үеийн цусны нийт холестерин, 18.9% триглицеридийн агууламж ихэссэн байгааг урьдчилан сэргийлэх үзлэгээр илэрсэн байна.
3. Цусны липидын агууламж ихэссэн насанд хүрэгчдийн тархалт тэдний наснаас шууд хамааралтайгаар ихсэж байв. Өлөн үеийн цусны липидын агууламж ихсэх байдалд хүйсийн ялгаа ажиглагдаагүй болно.

## ХУВЬ ХҮНИЙ ЭРСДЭЛИЙН ҮНЭЛГЭЭ

Хүснэгт 37. Хувь хүний эрсдэлийн үнэлгээ хүйсээр

Насанд хүрсэн хүн амын дунд (95% ИХ)	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
Гэр бүлийн гишүүн чихрийн шижингээр өвчилж байсан <i>Өвөө, эмээ, нагац, авга Эцэг, эх, ах дүү, өөрийн хүүхэд</i>	<b>5.7</b> (5.1-6.3)	<b>5.6</b> (4.6-6.6)	<b>5.8</b> (4.9-6.6)
Жирэмсний чихрийн шижингээр өвчилж байсан	-	-	<b>4.8</b> (4.3-5.4)
Хавдраар өвчилж байсан түүх (гэр бүлийн гишүүн)	<b>8.6</b> (8.0-9.2)	<b>7.4</b> (6.6-8.2)	<b>9.6</b> (8.7-10.4)
Артерийн даралт бууруулах эм тогтмол хэрэглэдэг	<b>21.6</b> (20.7-22.4)	<b>18.3</b> (17.1-19.6)	<b>23.7</b> (22.6-24.8)
Цусны өөх тос бууруулах эм хэрэглэж байгаа	<b>7.1</b> (6.5-7.6)	<b>6.4</b> (5.6-7.1)	<b>7.6</b> (6.9-8.4)



Зураг 41. “Гэр бүлийн хэн нэгэн гишүүн нь чихрийн шинжин, хавдраар өвчилж байсан” гэж хариулсан насанд хүрэгчдийн хувь, насны ангиллаар


### ГОЛ МЭДЭЭЛЭЛ

1. Эрт илрүүлэг урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдсан Архангай аймгийн насанд хүрсэн иргэдийн 5.7% гэр бүлийн хэн нэгэн гишүүн чихрийн шижингээр өвчилсөн, 8.6% хавдраар өвчилсөн, нийт эмэгтэйчүүдийн 4.8% жирэмсний чихрийн шижин оношлогдож байсан гэж өгүүлжээ.
2. Архангай аймгийн насанд хүрэгчдийн 21.6% артерийн даралт бууруулах эмийг тогтмол хэрэглэдэг, харин 7.1% цусны өөх тос бууруулах эмийг одоо хэрэглэж байв.
3. Гэр бүлийн хэн нэгэн гишүүн чихрийн шижингээр өвчилсөн гэж хариулсан хүн амын тархалт 18–39 насны залуучуудын дунд харьцангуй түгээмэл, энэхүү өгүүлэмж эрт илрүүлэг үзлэгт хамрагдсан иргэдийн настай урвуу хамааралтай байна.
4. Хавдраар өвчилсөн гэр бүлийн түүхтэй насанд хүрэгчдийн хувь урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдсан 40–59 насны иргэдийн дунд статистик ач холбогдол бүхий өндөр байв.

**БАЯНХОНГОР АЙМГИЙН НАСАНД ХҮРЭГЧДИЙН ДУНДАХ  
ХАЛДВАРТ БУС ӨВЧНИЙ ЭРСДЭЛТ ХҮЧИН ЗҮЙЛСИЙН  
ТАРХАЛТ**

**ТАНИЛЦУУЛГА**

Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/248 дугаар тушаалыг хэрэгжүүлэх арга хэмжээний хүрээнд 2022 оны 5 дугаар сарын 1-ээс 2023 оны 5 дугаар сарын 1 хүртэлх хугацаанд эрт илрүүлэг, урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдсан Баянхонгор аймгийн 4,835 насанд хүрэгчдийн мэдээллийг нэгтгэн, хүн амын дунд түгээмэл тохиолдож буй Халдварт бус өвчин (ХБӨ)-ий эрсдэлт хүчин зүйлсийн тархалтын байдалд дүн шинжилгээ хийв.



**Зураг 42. Эрт илрүүлэг үзлэгт хамрагдсан насанд хүрэгчдийн тоо, сумын дүнгээр**

Эрт илрүүлэг, урьдчилан сэргийлэх үзлэгт Баянхонгор (БХ) аймгийн 18-94 насны нийт 4,835 хүн хамрагдсан бөгөөд тэдний 37.2% (n=1,799) эрэгтэйчүүд, 62.8% (n=3,036) эмэгтэйчүүд байв.

**Хүснэгт 38. Эрт илрүүлэгт хамрагдсан насанд хүрэгчид, нас бүлэг ба хүйсээр**

Насны бүлэг, жилээр	N	Эрэгтэй			Эмэгтэй		
		Тоо	Хувь	95% ИХ	Тоо	Хувь	95% ИХ
≤ 19	232	137	59.1	52.7-65.4	95	40.9	34.6-47.3
20 – 29	711	288	40.5	36.9-44.1	423	59.5	55.9-63.1
30 – 39	831	294	35.4	32.1-38.6	537	64.6	61.4-67.9
40 – 49	1070	376	35.1	32.3-38.0	694	64.9	61.9-67.7
50 – 59	1106	364	32.9	30.1-35.7	742	67.1	64.3-69.9
60 – 69	676	248	36.7	33.0-40.3	428	63.3	59.7-67.0
≥ 70	209	92	44.0	37.2-50.8	117	56.0	49.2-62.8
<b>Нийт</b>	<b>4835</b>	<b>1799</b>	<b>37.2</b>	<b>35.8-38.6</b>	<b>3036</b>	<b>62.8</b>	<b>61.4-64.2</b>


Эрт илрүүлэг үзлэгт хамрагдсан Баянхонгор аймгийн насанд хүрэгчдийн дундаж нас 44.9 (95%ИХ 44.5–45.4) жил, эмэгтэйчүүдийн дундаж нас эрэгтэйчүүдээс 1.7 жилээр илүү байна (дундаж нас: эр 43.9 жил, эм 45.6 жил).

## ХБӨ-ИЙ НИЙТЛЭГ ЭРСДЭЛТ ХҮЧИН ЗҮЙЛС ХАВСРАН ИЛЭРСЭН ХҮН АМ

Хүснэгт 39. ХБӨ-ий нийтлэг эрсдэлт хүчин зүйлс хавсран илэрсэн хүн ам хүйсээр


Хүн амын дунд (95% ИХ)	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
<b>ХБӨ-ий нийтлэг эрсдэлт хүчин зүйлс</b>			
<ul style="list-style-type: none"> <li>Өдөр бүр тамхи татдаг</li> <li>Өдөрт 5 нэгжээс бага хэмжээгээр жимс, ногоо хэрэглэдэг</li> <li>Хөдөлгөөний хомсдолтой</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Илүүдэл жинтэй (БЖИ <math>\geq 25</math> кг/м<sup>2</sup>)</li> <li>Артерийн даралт ихсэлттэй (САД <math>\geq 140</math> ба/эсвэл ДАД <math>\geq 90</math> мм МУБ эсвэл даралт бууруулах эм хэрэглэж байгаа)*</li> </ul>		
Нийтлэг эрсдэлт хүчин зүйлс илрээгүй хүн амын хувь	<b>1.7</b> (1.3 – 2.1)	<b>1.7</b> (1.2 – 2.4)	<b>1.6</b> (1.2 – 2.1)
Нийтлэг эрсдэлт хүчин зүйлсээс 1-2 эрсдэл хавсран илэрсэн хүн амын хувь	<b>40.6</b> (39.2 – 42.0)	<b>35.0</b> (32.8 – 37.3)	<b>43.9</b> (42.1 – 45.8)
Нийтлэг эрсдэлт хүчин зүйлсээс 3 ба түүнээс олон эрсдэл хавсран илэрсэн хүн амын хувь	<b>57.7</b> (56.3 – 59.2)	<b>63.2</b> (30.9 – 65.5)	<b>54.5</b> (52.6 – 56.3)

\*ДЭМБ-ын үзүүлэлтийг баримтлав.



Зураг 43. Нийтлэг эрсдэлт хүчин зүйлсээс 3 ба түүнээс олон эрсдэл хавсран илэрсэн хүн амын хувь, хүйсээр

### ГОЛ МЭДЭЭЛЭЛ




Зураг 44. ХБӨ-өөр өвчлөх өндөр эрсдэлтэй хүн амын хувь, сумаар

1. Баянхонгор аймгийн насанд хүрсэн хүн амын ХБӨ-өөр өвчлөх эрсдэлгүй хүн амын тархалт дөнгөж 1.7% байна.
2. Насанд хүрсэн хүн амын 2 хүн тутмын 1 нь (57.7%) нийтлэг эрсдэлт хүчин зүйлсээс 3 ба түүнээс олон эрсдэл хавсран илэрсэн байна.
3. Нас ахих тусам эрсдэлт хүчин зүйл хавсран илэрсэн хүн амын тоо өсөж байна.
4. Баянцагаан, Гурванбулаг, Богд, Заг, Жаргалант, Бууцагаан сумуудад Нийтлэг эрсдэлт хүчин зүйлсээс 3 ба түүнээс олон эрсдэл хавсран илэрсэн хүн амын хувь аймгийн дундаж (57.7%)-аас өндөр байна.


## ТАМХИНЫ ХЭРЭГЛЭЭ

Хүснэгт 40. Тамхины хэрэглээ хүйсээр

Насанд хүрсэн хүн амын дунд (95% ИХ)	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
Тамхи татдаг хүн амын хувь	<b>16.1</b> (15.0 – 17.1)	<b>41.3</b> (38.9 – 43.5)	<b>1.0</b> (0.7 – 1.4)
Өдөр бүр тамхи татдаг хүн амын хувь	<b>13.2%</b> (12.2 – 14.2)	<b>34.2%</b> (32.0 – 36.4)	<b>0.7%</b> (0.4 – 1.0)
<i>Өдөр бүр тамхи татдаг хүн амын дунд:</i>			
Тамхи татаж эхэлсэн дундаж нас (жилээр)	<b>21</b> (20.4 – 21.6)	<b>20.7</b> (20.1 – 21.3)	<b>28.9</b> (23.8 – 34.0)



Зураг 45. Тамхи татдаг хүн ам, хүйс ба насны ангилал



Зураг 46. Тамхи татдаг хүн амын тархалт, сумаар


## ГОЛ МЭДЭЭЛЭЛ

1. Баянхонгор аймгийн насанд хүрсэн 5 хүн тутмын 1 нь (16.1%) тамхи татдаг бөгөөд эрэгтэйчүүдийн дунд тамхины хэрэглээ эмэгтэйчүүдээс 41.3 дахин их байна.
2. Өдөр бүр тамхи татдаг хүн амын хувь нийт тамхи татдаг хүмүүсийн 81.9%-ийг эзэлж байна.
3. Тамхи татаж эхэлсэн нас дунджаар 21 байна.
4. 20-69 нас хүртэлх насны ангилалд тамхины хэрэглээ жигд өндөр байна.
5. Баян-овоо, Эрдэнэцогт, Өлзийт, Бууцагаан, Гурванбулаг, Шинэжинст, Заг, Хүрээмарал, Галуут, Баянбулаг, Баянговь, Баянцагаан, Бөмбөгөр, Баян-өндөр сумуудад тамхи татдаг хүн амын хувь аймгийн дундаж (16.1%)-аас өндөр байна.


## АРХИ, СОГТУУРУУЛАХ УНДААНЫ ХЭРЭГЛЭЭ

Хүснэгт 41. Архи, согтууруулах ундааны хэрэглээ хүйсээр

Насанд хүрсэн хүн амын дунд (95% ИХ)	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
Сүүлийн 1 сард стандарт уултаас илүү архи, согтууруулах ундаа хэрэглэсэн хүн амын хувь	<b>6.2</b> (5.5 – 6.9)	<b>15.3</b> (13.6 – 16.9)	<b>0.8</b> (0.5 – 1.2)



Зураг 47. Сүүлийн 1 сард стандарт уултаас илүү архи, согтууруулах ундаа хэрэглэсэн хүн ам, хүйс ба насны ангиллаар



Зураг 48. Сүүлийн 1 сард архи, согтууруулах ундаа хэрэглэсэн хүн амын хувь, бүс нутгаар


## ГОЛ МЭДЭЭЛЭЛ

1. Баянхонгор аймгийн насанд хүрсэн хүн амын сүүлийн 1 сард стандарт уултаас илүү архи, согтууруулах ундаа хэрэглэсэн хүн амын хувь 6.2% байх бөгөөд эрэгтэйчүүдийн дунд согтууруулах ундааны хэрэглээ эмэгтэйчүүдээс 19.1 дахин их байна.
2. Хөдөлмөрийн насны (30-59 нас) хүмүүсийн архины хэрэглээ бусад насны бүлэгтэй харьцуулахад их байна.
3. Шинэжинст, Баянхонгор, Өлзийт, Заг, Баянцагаан, Галуут, Баянговь, Бууцагаан сумуудад Сүүлийн 1 сард стандарт уултаас илүү архи, согтууруулах ундаа хэрэглэсэн хүн амын хувь аймгийн дундаж (6.2%)-аас өндөр байна.

## ЖИМС, ЖИМСГЭНЭ, НОГООНЫ ХЭРЭГЛЭЭ

Хүснэгт 42. Жимс, жимсгэнэ, ногооны хэрэглээ хүйсээр

Насанд хүрсэн хүн амын дунд (95% ИХ)	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
Зохистой хэрэглээтэй хүн амын хувь (хоногт $\geq 5$ нэгж буюу 400 г)	<b>13.2</b> (12.3-14.2)	<b>12.2</b> (10.7-13.7)	<b>13.9</b> (12.6-15.1)
Хангалтгүй хэрэглээтэй хүн амын хувь (хоногт $< 5$ нэгж /400 г)	<b>17.3</b> (16.2-18.4)	<b>18.4</b> (16.6-20.2)	<b>16.7</b> (15.3-18.0)
Жимс, ногоо бага хэрэглэдэг ХБӨ-ний эрсдэлтэй хүн амын хувь (жимс, ногоог өдөр бүр хэрэглэдэггүй эсвэл хоногт 400 граммаас бага хэрэглэдэг)	<b>86.8</b> (85.8-87.7)	<b>87.8</b> (86.3-89.4)	<b>86.1</b> (84.9-87.4)



Зураг 49. Жимс, жимсгэнэ, хүнсний ногоо бага хэрэглэдэг насанд хүрэгчдийн хувь, насны бүлгээр



Зураг 50. Жимс, жимсгэнэ, ногооны зохистой хэрэглээтэй насанд хүрэгчдийн хувь, сумаар

## ГОЛ МЭДЭЭЛЭЛ


1. Баянхонгор аймгийн насанд хүрсэн иргэдийн дөнгөж 13.3% жимс, жимсгэнэ, хүнсний ногооны зохистой хэрэглээтэй буюу хоногт 5 нэгж буюу 400 граммаас их хэмжээгээр хэрэглэж байна. Жимс, жимсгэнэ, хүнсний ногооны зохистой хэрэглээтэй иргэдийн хувь Жинст, Жаргалант, Баян-Овоо, Өлзийт, Бууцагаан суманд хамгийн байгаа (5.7%–8.9%) нь анхаарал татаж байна.
2. Эрт илрүүлэг үзлэгт хамрагдсан 18-94 насны иргэдийн 86.8% өдөр бүр жимс, ногоо хэрэглэдэггүй эсвэл хоногт 400 граммаас бага хэмжээгээр хэрэглэж байна. Насанд хүрсэн 10 хүн тутмын 9 орчим нь “Эрүүл хооллолтын ГЭР зөвлөмж”-д заасан хэмжээ (Хоногт  $\geq 400$ г)-гээр жимс, хүнсний ногоог хэрэглэдэггүй буюу ХБӨ-өөр өвчлөх эрсдэлтэй байв.
3. Жимс, жимсгэнэ, хүнсний ногоо бага хэрэглэдэг буюу ХБӨ-өөр өвчлөх эрсдэлтэй насанд хүрэгчдийн тархалт 40 ба түүнээс дээш насны хүн амын дунд харьцангуй өндөр, харин 18–29 насны залуучуудын дунд бага байна.




## ХӨДӨЛГӨӨН

Хүснэгт 43. Хөдөлгөөн хүйсээр

Насанд хүрсэн хүн амын дунд (95% ИХ)	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
7 хоногийн 5-аас доошгүй өдөр 30 минутаас дээш дасгал хөдөлгөөн хийдэггүй, эсвэл 10000 алхдаггүй хүн амын хувь	<b>60.9</b> (59.5 – 62.3)	<b>57.9</b> (55.6 – 60.3)	<b>62.7</b> (60.9 – 64.4)



Зураг 51. 7 хоногийн 5-аас доошгүй өдөр 30 минутаас дээш дасгал хөдөлгөөн хийдэггүй, эсвэл 10000 алхдаггүй хүн амын тархалт, насны бүлгээр ба хүйсээр



Зураг 52. 7 хоногийн 5-аас доошгүй өдөр 30 минутаас дээш дасгал хөдөлгөөн хийдэггүй, эсвэл 10000 алхдаггүй хүн амын тархалт, бүс нутгаар


## ГОЛ МЭДЭЭЛЭЛ

1. Баянхонгор аймгийн “Урьдчилан сэргийлэх эрт илрүүлэгт” хамрагдсан нийт хүн амын 60.9% нь 7 хоногийн 5-аас доошгүй өдөр 30 минутаас дээш дасгал хөдөлгөөн хийдэггүй, эсвэл 10000 алхдаггүй байна.
2. Хүйсээр авч үзвэл эмэгтэйчүүд (62.7%), эрэгтэйчүүдээс (57.9%) 4.8%-иар их, нас ахих тусам хөдөлгөөний идэвхгүй байдал нэмэгдэж байгаа нь ажиглагдав.
3. Баянлиг, Галуут, Богд, Жаргалант, Заг, Эрдэнэцогт, Баян-овоо, Гурванбулаг сумуудад 7 хоногийн 5-аас доошгүй өдөр 30 минутаас дээш дасгал хөдөлгөөн хийдэггүй, эсвэл 10000 алхдаггүй хүн амын хувь аймгийн дундаж (60.9%)-аас өндөр байна.


## ИЛҮҮДЭЛ ЖИН БА ТАРГАЛАЛТ

Хүснэгт 44. Илүүдэл жин ба таргалалт хүйсээр

Насанд хүрсэн хүн амын дунд (95% ИХ)	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
Биеийн жингийн индекс (БЖИ)-ийн дундаж хэмжээ (кг/м <sup>2</sup> )	<b>27.4</b> (27.2-27.5)	<b>26.9</b> (26.7-27.1)	<b>27.6</b> (27.4-27.8)
Илүүдэл жин ба таргалалттай хүн амын хувь (БЖИ ≥ 25 кг/м <sup>2</sup> )	<b>63.3</b> (61.9-64.6)	<b>61.5</b> (59.2-63.8)	<b>64.3</b> (62.6-66.0)
Таргалалттай хүн амын хувь (БЖИ ≥ 30 кг/м <sup>2</sup> )	<b>27.3</b> (26.0-28.6)	<b>22.7</b> (20.7-24.6)	<b>30.1</b> (28.4-31.7)
Бүсэлхийн тойргийн дундаж хэмжээ (см)	-	<b>90.1</b> (89.5-90.8)	<b>87.2</b> (86.7-87.7)
Төвийн таргалалттай хүн амын хувь (Бүсэлхийн тойрог: эр ≥ 90 см, эм ≥ 80 см)	<b>62.7</b> (61.3-64.1)	<b>50.4</b> (48.0-52.7)	<b>69.9</b> (68.2-71.6)



Зураг 53. Илүүдэл жин ба таргалалтын тархалт, насны бүлгээр



Зураг 54. Таргалалтын тархалт (БЖИ ≥ 30 кг/м<sup>2</sup>), сумаар


## ГОЛ МЭДЭЭЛЭЛ

1. Урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдсан Баянхонгор аймгийн насанд хүрэгчдийн БЖИ-ийн дундаж хэмжээ 27.4 кг/м<sup>2</sup> байгаа нь ДЭМБ-аас зөвлөсөн хэвийн хязгаараас хэтэрсэн байна. Иргэдийн БЖИ-ийн дундаж хэмжээ хүйсийн ялгаатай, эмэгтэйчүүдэд статистик аж холбогдол бүхий өндөр байв.
2. Баянхонгор аймгийн насанд хүрэгчдийн 63.3% илүүдэл жин ба таргалалттай, 27.3% тарган байна. Таргалалтын тархалт эмэгтэйчүүдийн дунд эрэгтэйчүүдээс харьцангуй өндөр, гурван эмэгтэй тутмын 1 нь тарган байна. Таргалалтын тархалт аль ч хүйсийн насанд хүрэгчдийн дунд нас ахих тутам нэмэгдэх хандлага ажиглагдлаа.
3. Эрт илрүүлэгт хамрагдсан насанд хүрэгчдийн 62.7% төвийн таргалалттай, төвийн таргалалттай эмэгтэйчүүдийн хувь эрэгтэйчүүдээс 1.4 дахин өндөр байна.


## АРТЕРИЙН ГИПЕРТЕНЗИ

Хүснэгт 45. Артерийн гипертензи хүйсээр

Насанд хүрсэн хүн амын дунд (95% ИХ)	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
Систолын артерийн даралт (САД)-ын дундаж хэмжээ, мм МУБ (даралт бууруулах эм хэрэглэж байгаа хүн амыг оролцуулсан)	<b>121.4</b> (120.9-121.9)	<b>122.3</b> (121.6-123.1)	<b>120.9</b> (120.3-121.5)
Диастолын артерийн даралт (ДАД)-ын дундаж хэмжээ, мм МУБ (даралт бууруулах эм хэрэглэж байгаа хүн амыг оролцуулсан)	<b>77.4</b> (77.1-77.7)	<b>78.5</b> (77.9-78.9)	<b>76.8</b> (76.4-77.1)
Артерийн даралт ихсэлттэй хүн амын хувь (САД = 120-129 мм МУБ ба/эсвэл ДАД ≤ 80 мм МУБ)	<b>29.9</b> (28.6-31.2)	<b>33.5</b> (31.3-35.8)	<b>27.7</b> (26.1-29.4)
Артерийн гипертензитай хүн амын хувь (САД ≥ 130 ба/эсвэл ДАД ≥ 81 мм МУБ эсвэл даралт бууруулах эм хэрэглэдэг хүн амын оролцуулсан)	<b>32.3</b> (30.9-33.7)	<b>33.2</b> (30.9-35.4)	<b>31.8</b> (30.1-33.5)



Зураг 55. Артерийн гипертензийн тархалт, насны бүлгээр



Зураг 56. Артерийн гипертензийн тархалт, сумаар


## ГОЛ МЭДЭЭЛЭЛ

1. Эрт илрүүлэг үзлэгт хамрагдсан Баянхонгор аймгийн насанд хүрэгчдийн САД-ын дундаж хэмжээ 121.4 мм МУБ, ДАД-ын дундаж үзүүлэлт 77.4 мм МУБ байна.
2. Насанд хүрэгчдийн 29.9% артерийн даралт ихсэлттэй буюу САД нь 120–129 мм ба/эсвэл ДАД ≤ 80 мм МУБ байв. Артерийн даралт ихсэлтийн тархалт эрэгтэйчүүдийн дунд статистик ач холбогдол бүхий өндөр байна.
3. Урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдсан насанд хүрсэн иргэдийн дунд САД ≥ 130 мм МУБ ба ДАД ≥ 81 мм МУБ-ээс дээш буюу Артерийн гипертензи (АГ)-ийн тархалт 32.3% байв. АГ-ийн тархалтад хүйсийн ялгаа ажиглагдаагүй болно.
4. АГ-ийн тархалт иргэдийн нас ахих тутам нэмэгдэж, 40–49 насны хүн амын дунд огцом өсөлт ажиглагдсан бөгөөд 50–59 насны 2 хүн тутмын 1 нь, 60 ба түүнээс дээш насны 10 хүн тутмын 7 орчим АГ-тэй байв.

## ЧИХРИЙН ШИЖИН

Хүснэгт 46. Чихрийн шижин хүйсээр

Насанд хүрсэн хүн амын дунд (95% ИХ)	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
Өлөн үеийн цусны глюкозын дундаж хэмжээ (ммоль/л), глюкоз бууруулах эм хэрэглэж буй хүн амыг оруулаад	<b>5.5</b> (5.4-5.6)	<b>5.7</b> (5.6-5.8)	<b>5.4</b> (5.3-5.4)
Өлөн үеийн цусны глюкозын өөрчлөлттэй хүн амын хувь (Ийлдсийн глюкозын хэмжээ $\geq 6.1$ ммол/л ба $< 7.0$ ммол/л)	<b>9.5</b> (8.6-10.4)	<b>14.6</b> (12.7-16.5)	<b>6.6</b> (5.7-7.6)
Өлөн үеийн цусны глюкозын хэмжээ ихэссэн болон глюкоз бууруулах эм хэрэглэж буй хүн амын хувь (Ийлдсийн глюкозын хэмжээ $\geq 7.0$ ммол/л)	<b>5.7</b> (5.0-6.5)	<b>7.6</b> (6.2-9.0)	<b>4.7</b> (3.8-5.5)



Зураг 57. Өлөн үеийн цусны глюкозын өөрчлөлттэй болон ЧШ-тэй хүн амын хувь, насны бүлгээр



Зураг 58. Чихрийн шижингийн тархалт, сумаар


## ГОЛ МЭДЭЭЛЭЛ

1. Баянхонгор аймгийн эрт ирүүлэг үзлэгт хамрагдсан насанд хүрэгчдийн өлөн үеийн цусны глюкозын дундаж хэмжээ 5.5 ммоль/л байв.
2. Насанд хүрсэн иргэдийн 9.5% өлөн үеийн цусны глюкозын өөрчлөлттэй, 5.7% цусны глюкозын хэмжээ ихэссэн буюу чихрийн шижинтэй байна. Өлөн үеийн цусны глюкозын өөрчлөлт, чихрийн шижингийн тархалт нь иргэдийн настай шууд хамааралтай ихсэх хандлагатай байна.
3. Эрт илрүүлэг үзлэгт хамрагдсан эрэгтэйчүүдийн дунд өлөн үеийн цусны глюкозын өөрчлөлт болон чихрийн шижингийн тархалт эмэгтэйчүүдээс статистик ач холбогдол бүхий илүү байв.
4. Урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдсан Өвөрхангай аймгийн  $\leq 19$  насны залуучуудын дунд чихрийн шижин илрээгүй боловч, далд чихрийн шижин буюу өлөн үеийн цусны глюкозын өөрчлөлтийн тохиолдол 2.6% байна.


## ӨЛӨН ҮЕИЙН ЦУСНЫ ЛИПИДЫН ҮНЭЛГЭЭ

Хүснэгт 47. Өлөн үеийн цусны липидын үнэлгээ хүйсээр

Насанд хүрсэн хүн амын дунд (95% ИХ)	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
“Өлөн үеийн цусны холестерин хэмжээ ихэссэн” гэж оношлогдож байсан хүн амын хувь	<b>2.2</b> (1.7-2.5)	<b>2.3</b> (1.6-3.0)	<b>2.0</b> (1.5-2.5)
Цусны нийт холестерин хэмжээ ихэссэн ( $\geq 5.3$ ммоль/л) хүн амын хувь	<b>22.9</b> (20.1-25.7)	<b>21.7</b> (17.7-25.7)	<b>24.0</b> (20.0-28.0)
“Өлөн үеийн цусны триглицеридийн хэмжээ ихэссэн” гэж оношлогдож байсан хүн амын хувь	<b>3.5</b> (3.0-4.1)	<b>3.7</b> (2.8-4.5)	<b>3.4</b> (2.8-4.1)
Цусны триглицеридийн хэмжээ ихэссэн ( $\geq 1.7$ ммоль/л) хүн амын хувь	<b>9.4</b> (7.5-11.4)	<b>13.1</b> (9.9-16.4)	<b>5.9</b> (3.7-8.2)



Зураг 59. Өлөн үеийн цусны липидын хэмжээ ихэссэн хүн амын хувь, насны бүлгээр



Зураг 60. Өлөн үеийн цусны нийт холестерин агууламж ихэссэн хүн амын хувь


### ГОЛ МЭДЭЭЛЭЛ

1. Баянхонгор аймгийн эрт илрүүлэгт хамрагдсан насанд хүрсэн иргэдийн 2.2% цусны холестерин ихэссэн, харин 3.5% триглицеридийн агууламж ихэссэн гэж оношлогдож байжээ.
2. Насанд хүрэгчдийн 22.9% өлөн үеийн цусны нийт холестерин, 9.4% триглицеридийн агууламж ихэссэн байна. Цусны триглицеридийн хэмжээ ихэссэн тохиолдол эрэгтэйчүүдийн дунд 2.2 дахин өндөр байв ( $p < 0.001$ ).
3. Цусны холестерин агууламж ихэссэн насанд хүрэгчдийн хувь 50–69 насны иргэдийн дунд харьцангуй өндөр байна. Өлөн үеийн цусны холестерин агууламж ихсэх байдалд хүйсийн ялгаа ажиглагдаагүй болно.

## ХУВЬ ХҮНИЙ ЭРСДЭЛИЙН ҮНЭЛГЭЭ

Хүснэгт 48. Хувь хүний эрсдэлийн үнэлгээ хүйсээр

Насанд хүрсэн хүн амын дунд (95% ИХ)	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
Гэр бүлийн гишүүн чихрийн шижингээр өвчилж байсан <i>Өвөө, эмээ, нагац, авга Эцэг, эх, ах дүү, өөрийн хүүхэд</i>	<b>6.1</b> (4.6-7.6)	<b>3.7</b> (2.0-5.5)	<b>8.0</b> (5.8-10.3)
Жирэмсний чихрийн шижингээр өвчилж байсан	-	-	<b>8.6</b> (7.6-9.6)
Хавдраар өвчилж байсан түүх (гэр бүлийн гишүүн)	<b>8.4</b> (7.7-9.2)	<b>5.6</b> (4.5-6.6)	<b>10.2</b> (9.1-11.3)
Артерийн даралт бууруулах эм тогтмол хэрэглэдэг	<b>23.1</b> (21.8-24.3)	<b>14.1</b> (12.4-15.8)	<b>28.1</b> (26.5-29.7)
Цусны өөх тос бууруулах эм хэрэглэж байгаа	<b>9.5</b> (8.6-10.3)	<b>8.1</b> (6.9-9.4)	<b>10.3</b> (9.2-11.4)



Зураг 61. “Гэр бүлийн хэн нэгэн гишүүн нь чихрийн шинжин, хавдраар өвчилж байсан” гэж хариулсан насанд хүрэгчдийн хувь, насны бүлгээр


## ГОЛ МЭДЭЭЛЭЛ

1. Эрт илрүүлэг урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдсан Баянхонгор аймгийн насанд хүрэгчдийн 6.1% гэр бүлийн хэн нэгэн гишүүн “чихрийн шижингээр өвчилсөн”, 8.4% хавдраар өвчилсөн гэж хариулсан байна. Нийт эмэгтэйчүүдийн 8.6% жирэмсний чихрийн шижин оношлогдож байжээ.
2. Урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдсан Баянхонгор аймгийн насанд хүрэгчдийн 23.1% артерийн даралт бууруулах эмийг тогтмол хэрэглэдэг, харин 9.5% цусны өөх тос бууруулах эмийг одоо хэрэглэж байв.
3. Гэр бүлийн хэн нэгэн гишүүн чихрийн шижингээр өвчилсөн гэж хариулсан хүн амын тархалт 40–49 насны иргэдийн дунд харьцангуй өндөр, энэхүү өгүүлэмж эрт илрүүлэгт хамрагдсан 50 ба түүнээс доош насны иргэдийн дунд буурах хандлага ажиглагдсан болно.
4. Хавдраар өвчилсөн гэр бүлийн түүхтэй насанд хүрэгчдийн хувь эрт илрүүлэг үзлэгт хамрагдсан 30–59 насны иргэдийн дунд харьцангуй өндөр байв.

**БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН НАСАНД ХҮРЭГЧДИЙН ДУНДАХ  
ХАЛДВАРТ БУС ӨВЧНИЙ ЭРСДЭЛТ ХҮЧИН ЗҮЙЛСИЙН  
ТАРХАЛТ**

**ТАНИЛЦУУЛГА**

Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/248 дугаар тушаалыг хэрэгжүүлэх арга хэмжээний хүрээнд 2022 оны 5 дугаар сарын 3-ны өдрөөс 2023 оны 5 дугаар сарын 1 хүртэлх хугацаанд эрт илрүүлэг, урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдсан Баян-Өлгий аймгийн 6.691 насанд хүрэгчдийн мэдээллийг нэгтгэн, хүн амын дунд түгээмэл тохиолдож буй Халдварт бус өвчин (ХБӨ)-ий эрсдэлт хүчин зүйлсийн тархалтын байдалд дүн шинжилгээ хийв (Зураг 62).



Зураг 62. Эрт илрүүлэг үзлэгт хамрагдсан насанд хүрэгчдийн тоо, дүүргээр

Эрт илрүүлэг, урьдчилан сэргийлэх үзлэгт Баян-Өлгий аймгийн 18-92 насны нийт 6.691 хүн хамрагдсан бөгөөд тэдний 39.5% (n=2.641) эрэгтэйчүүд, 60.5% (n=4.050) эмэгтэйчүүд байв (Хүснэгт 49).

Хүснэгт 49. Эрт илрүүлэгт хамрагдсан насанд хүрэгчид, нас бүлэг ба хүйсээр

Насны бүлэг, жилээр	N	Эрэгтэй			Эмэгтэй		
		Тоо	Хувь	95% ИХ	Тоо	Хувь	95% ИХ
≤ 19	226	138	60.1	54.7-67.5	88	38.9	49.2-55.3
20 – 29	1030	492	47.8	44.7-50.8	538	52.2	61.1-65.7
30 – 39	1697	621	36.6	34.3-38.9	1076	63.4	66.1-70.9
40 – 49	1465	462	31.5	29.2-33.9	1003	68.5	59.6-64.9
50 – 59	1283	484	37.7	35.1-40.4	799	62.3	53.6-60.6
60 – 69	788	338	42.9	39.4-46.4	450	57.1	40.6-54.5
≥ 70	202	106	52.5	45.5-59.4	96	47.5	40.6-54.5
<b>Нийт</b>	<b>6691</b>	<b>2641</b>	<b>39.5</b>	<b>38.3-40.6</b>	<b>4050</b>	<b>60.5</b>	<b>59.4-61.7</b>


Эрт илрүүлэг үзлэгт хамрагдсан Баян-Өлгий аймгийн насанд хүрэгчдийн дундаж нас 45.8 (95%ИХ 42.8-43.5) жил, эмэгтэйчүүдийн дундаж нас эрэгтэйчүүдээс 1.0 жилээр илүү байна (дундаж нас: эр 42.5 жил, эм 43.5 жил).

## ХБӨ-ИЙ НИЙТЛЭГ ЭРСДЭЛТ ХҮЧИН ЗҮЙЛС ХАВСРАН ИЛЭРСЭН ХҮН АМ


Хүснэгт 50. ХБӨ-ий нийтлэг эрсдэлт хүчин зүйлс хавсран илэрсэн хүн ам хүйсээр

Хүн амын дунд (95% ИХ)	Бүгд	эрэгтэй	Эмэгтэй
<b>ХБӨ-ий нийтлэг эрсдэлт хүчин зүйлс</b>			
<ul style="list-style-type: none"> <li>Өдөр бүр тамхи татдаг</li> <li>Өдөрт 5 нэгжээс бага хэмжээгээр жимс, ногоо хэрэглэдэг</li> <li>Хөдөлгөөний хомсдолтой</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Илүүдэл жинтэй (БЖИ <math>\geq 25</math> кг/м<sup>2</sup>)</li> <li>Артерийн даралт ихсэлттэй (САД <math>\geq 140</math> ба/эсвэл ДАД <math>\geq 90</math> мм МУБ эсвэл даралт бууруулах эм хэрэглэж байгаа)*</li> </ul>		
Нийтлэг эрсдэлт хүчин зүйлс илрээгүй хүн амын хувь	<b>2.2</b> (1.9 – 2.6)	<b>2.4</b> (1.9 – 3.1)	<b>2.1</b> (1.6 – 2.6)
Нийтлэг эрсдэлт хүчин зүйлсээс 1-2 эрсдэл хавсран илэрсэн хүн амын хувь	<b>48.7</b> (47.5 – 50.0)	<b>43.7</b> (41.7 – 45.8)	<b>52.0</b> (50.3 – 53.6)
Нийтлэг эрсдэлт хүчин зүйлсээс 3 ба түүнээс олон эрсдэл хавсран илэрсэн хүн амын хувь	<b>49.0</b> (47.8 – 50.3)	<b>53.8</b> (51.8 – 55.9)	<b>46.0</b> (44.3 – 47.6)

\*ДЭМБ-ын үзүүлэлтийг баримтлав.



Зураг 63. Нийтлэг эрсдэлт хүчин зүйлсээс 3 ба түүнээс олон эрсдэл хавсран илэрсэн хүн амын хувь, хүйсээр



Зураг 64. ХБӨ-өөр өвчлөх өндөр эрсдэлтэй хүн амын хувь, сумаар

### ГОЛ МЭДЭЭЛЭЛ


1. Эрт илрүүлэг үзлэгт хамрагдсан Баян-өлгий аймгийн насанд хүрсэн хүн амын ХБӨ-өөр өвчлөх эрсдэлгүй хүн амын тархалт дөнгөж 2.2% байна.
2. Насанд хүрсэн хүн амын 2 хүн тутмын 1 нь (49%) нийтлэг эрсдэлт хүчин зүйлсээс 3 ба түүнээс олон эрсдэл хавсран илэрсэн байна.
3. ХБӨ-өөр өвчлөх өндөр эрсдэлтэй хүн амын тархалт эмэгтэйчүүд болон эрэгтэйчүүдэд ойролцоо байна.
4. Нас ахих тусам эрсдэлт хүчин зүйл хавсран илэрсэн хүн амын тоо өсөж байна.
5. Өлгий, Буянт сумуудад Нийтлэг эрсдэлт хүчин зүйлсээс 3 ба түүнээс олон эрсдэл хавсран илэрсэн хүн амын хувь аймгийн дундаж (49%)-аас өндөр байна.




## ТАМХИНЫ ХЭРЭГЛЭЭ

### Хүснэгт 51. Тамхины хэрэглээ хүйсээр

Насанд хүрсэн хүн амын дунд (95% ИХ)	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
Тамхи татдаг хүн амын хувь	<b>11.0</b> (10.2 – 11.8)	<b>26.8</b> (25.0 – 28.5)	<b>0.4</b> (0.2 – 0.6)
Өдөр бүр тамхи татдаг хүн амын хувь	<b>8.0</b> (7.4 – 8.7)	<b>20.3</b> (18.7 – 21.8)	<b>0.1</b> (0.0 – 0.2)
<i>Өдөр бүр тамхи татдаг хүн амын дунд:</i>			
Тамхи татаж эхэлсэн дундаж нас (жилээр)	<b>22.5</b> (21.9 – 23.0)	<b>22.5</b> (21.9 – 23.0)	<b>21.6</b> (14.5 – 28.8)



Зураг 65. Тамхи татдаг хүн ам, хүйс ба насны ангилал



Зураг 66. Тамхи татдаг хүн амын тархалт, сумаар


## ГОЛ МЭДЭЭЛЭЛ

1. Эрт илрүүлэг үзлэгт хамрагдсан Баян-өлгий аймгийн насанд хүрсэн хүн амын 10 хүн тутмын 1 нь (11%) тамхи татдаг бөгөөд эрэгтэйчүүдийн дунд тамхины хэрэглээ эмэгтэйчүүдээс 67 дахин их байна.
2. Өдөр бүр тамхи татдаг хүн амын хувь нийт тамхи татдаг хүмүүсийн 72.7%-ийг эзэлж байна.
3. Тамхи татаж эхэлсэн нас дунджаар 22.5 байна.
4. 20-59 нас хүртэлх насны ангилалд тамхины хэрэглээ жигд өндөр байна.
5. Дэлүүн, Өлгий, Толбо, Булган сумуудад тамхи татдаг хүн амын хувь аймгийн дундаж (11%)-аас өндөр байна.


## АРХИ, СОГТУУРУУЛАХ УНДААНЫ ХЭРЭГЛЭЭ

Хүснэгт 52. Архи, согтууруулах ундааны хэрэглээ хүйсээр

Монгол улсын 15-69 насны хүн амын дунд (95% ИХ)	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
Сүүлийн 1 сард стандарт уултаас илүү архи, согтууруулах ундаа хэрэглэсэн хүн амын хувь	<b>4.0</b> (3.5 – 4.5)	<b>9.7</b> (8.5 – 10.9)	<b>0.3</b> (0.1 – 0.5)



Зураг 67. Сүүлийн 1 сард стандарт уултаас илүү архи, согтууруулах ундаа хэрэглэсэн хүн ам, хүйс, насны ангиллаар



Зураг 68. Сүүлийн 1 сард архи, согтууруулах ундаа хэрэглэсэн хүн амын хувь, сумаар


### ГОЛ МЭДЭЭЛЭЛ

1. Эрт илрүүлэг үзлэгт хамрагдсан Баян-өлгий аймгийн насанд хүрсэн хүн амын сүүлийн 1 сард стандарт уултаас илүү архи, согтууруулах ундаа хэрэглэсэн хүн амын хувь 4% байх бөгөөд эрэгтэйчүүдийн дунд согтууруулах ундааны хэрэглээ эмэгтэйчүүдээс 32.3 дахин их байна.
2. Хөдөлмөрийн насны (30-59 нас) хүмүүсийн архины хэрэглээ бусад насны бүлэгтэй харьцуулахад их байна.
3. Өлгий, Алтай, Ногооннуур, Сагсай, Цэнгэл, Булган, Улаанхус, Баяннуур сумуудад Сүүлийн 1 сард стандарт уултаас илүү архи, согтууруулах ундаа хэрэглэсэн хүн амын хувь аймгийн дундаж (4%)-аас өндөр байна.


## ХӨДӨЛГӨӨН

Хүснэгт 53. Хөдөлгөөн хүйсээр

Насанд хүрсэн хүн амын дунд (95% ИХ)	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
7 хоногийн 5-аас доошгүй өдөр 30 минутаас дээш дасгал хөдөлгөөн хийдэггүй, эсвэл 10000 алхдаггүй хүн амын хувь	<b>74.6</b> (73.5 – 75.7)	<b>67.3</b> (65.4 – 69.1)	<b>79.3</b> (78.0 – 80.6)



Зураг 69. 7 хоногийн 5-аас доошгүй өдөр 30 минутаас дээш дасгал хөдөлгөөн хийдэггүй, эсвэл 10000 алхдаггүй хүн амын тархалт, хүйс ба насны ангиллаар




### ГОЛ МЭДЭЭЛЭЛ

1. Эрт илрүүлэг үзлэгт хамрагдсан Баян-өлгий аймгийн “Урьдчилан сэргийлэх эрт илрүүлэгт” хамрагдсан нийт хүн амын 74.6% нь 7 хоногийн 5-аас доошгүй өдөр 30 минутаас дээш дасгал хөдөлгөөн хийдэггүй, эсвэл 10000 алхдаггүй байна.
2. Хүйсээр авч үзвэл эмэгтэйчүүд (79.3%), эрэгтэйчүүдээс (67.3%) 12%-иар илүү, нас ахих тусам хөдөлгөөний идэвхгүй байдал нэмэгдэж байгаа нь ажиглагдав.
3. Баяннуур, Булган, Бугат, Сагсай, Буянт, Толбо сумуудад 7 хоногийн 5-аас доошгүй өдөр 30 минутаас дээш дасгал хөдөлгөөн хийдэггүй, эсвэл 10000 алхдаггүй хүн амын хувь аймгийн дундаж (74.6%)-аас өндөр байна.


Зураг 70. 7 хоногийн 5-аас доошгүй өдөр 30 минутаас дээш дасгал хөдөлгөөн хийдэггүй, эсвэл 10000 алхдаггүй хүн амын тархалт, сумаар

**ЖИМС, ЖИМСГЭНЭ, НОГООНЫ ХЭРЭГЛЭЭ**  
Хүснэгт 54. Жимс, жимсгэнэ, ногооны хэрэглээ хүйсээр

Насанд хүрсэн хүн амын дунд (95% ИХ)	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
Зохистой хэрэглээтэй хүн амын хувь (хоногт $\geq 5$ нэгж буюу 400 г)	<b>20.2</b> (19.3-21.2)	<b>18.5</b> (17.0-20.0)	<b>21.4</b> (20.1-22.6)
Хангалтгүй хэрэглээтэй хүн амын хувь (хоногт $< 5$ нэгж /400 г)	<b>36.0</b> (34.9-37.2)	<b>34.6</b> (32.8-36.5)	<b>36.9</b> (20.1-22.6)
Жимс, ногоо бага хэрэглэдэг ХБӨ-ний эрсдэлтэй хүн амын хувь (жимс, ногоог өдөр бүр хэрэглэдэггүй эсвэл хоногт 400 граммаас бага хэрэглэдэг)	<b>79.8</b> (78.8-80.8)	<b>81.5</b> (80.0-83.0)	<b>78.6</b> (77.4-79.9)



Зураг 71. Жимс, жимсгэнэ, хүнсний ногоо бага хэрэглэдэг насанд хүрэгчдийн хувь, насны бүлгээр




Зураг 72. Жимс, жимсгэнэ, ногооны зохистой хэрэглээтэй насанд хүрэгчдийн хувь, дүүргээр

**ГОЛ МЭДЭЭЛЭЛ**


1. Баян-Өлгий аймгийн насанд хүрэгчдийн иргэдийн дөнгөж 20.2% жимс, жимсгэнэ, хүнсний ногооны зохистой хэрэглээтэй буюу хоногт  $\geq 400$  г хэмжээгээр хэрэглэж байна. Жимс, жимсгэнэ, хүнсний ногооны зохистой хэрэглээтэй иргэдийн хувь Толбо, Буянт, булган суманд хамгийн бага байв.
2. Эрт илрүүлэг үзлэгт хамрагдсан 18–92 насны иргэдийн 79.8% өдөр бүр жимс, ногоо хэрэглэдэггүй эсвэл хоногт 400 граммаас бага хэмжээгээр хэрэглэж байна. Баян-Өлгий аймгийн насанд хүрсэн 5 хүн тутмын 4 нь “Эрүүл хооллолтын ГЭР зөвлөмж”-д заасан хэмжээ (Хоногт  $\geq 400$ г)-гээр жимс, жимсгэнэ, хүнсний ногоо хэрэглэдэггүй буюу ХБӨ-өөр өвчлөх эрсдэлтэй байв.
3. Жимс, жимсгэнэ, хүнсний ногоо бага хэрэглэдэг буюу ХБӨ-өөр өвчлөх эрсдэлтэй насанд хүрэгчдийн тархалт иргэдийн насны бүлгээр ялгаатай бус, Баян – Өлгий аймгийн аль ч насны хүн амын дунд жигд өндөр байна.

**ИЛҮҮДЭЛ ЖИН БА ТАРГАЛАЛТ**  
Хүснэгт 55. Илүүдэл жин ба таргалалт хүйсээр

Насанд хүрсэн хүн амын дунд (95% ИХ)	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
Биеийн жингийн индекс (БЖИ)-ийн дундаж хэмжээ (кг/м <sup>2</sup> )	<b>26.0</b> (25.9-26.1)	<b>25.9</b> (25.7-26.1)	<b>26.1</b> (25.9-26.2)
Илүүдэл жин ба таргалалттай хүн амын хувь (БЖИ ≥ 25 кг/м <sup>2</sup> )	<b>51.4</b> (50.2-52.7)	<b>50.7</b> (48.7-52.7)	<b>51.9</b> (50.3-53.5)
Таргалалттай хүн амын хувь (БЖИ ≥ 30 кг/м <sup>2</sup> )	<b>18.7</b> (17.7-19.7)	<b>17.2</b> (15.7-18.7)	<b>19.7</b> (18.4-21.0)
Бүсэлхийн тойргийн дундаж хэмжээ (см)	-	<b>89.1</b> (88.5-89.6)	<b>85.0</b> (84.5-85.4)
Төвийн таргалалттай хүн амын хувь (Бүсэлхийн тойрог: эр ≥ 90 см, эм ≥ 80 см)	<b>57.3</b> (56.0-58.5)	<b>47.4</b> (45.4-49.4)	<b>63.7</b> (62.1-65.3)



Зураг 73. Илүүдэл жин ба таргалалтын тархалт, насны бүлгээр



Зураг 74. Таргалалтын тархалт (БЖИ≥30 кг/м<sup>2</sup>), сумаар


**ГОЛ МЭДЭЭЛЭЛ**

1. Урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдсан Баян-Өлгий аймгийн насанд хүрэгчдийн БЖИ-ийн дундаж хэмжээ 26.0 кг/м<sup>2</sup> байгаа нь ДЭМБ-аас зөвлөсөн хэвийн хязгаараас хэтэрсэн байна. Иргэдийн БЖИ-ийн дундаж хэмжээ нь хүйсийн хувьд ялгаатай бус, харин насны бүлгээр статистик ач холбогдол бүхий ялгаа илэрсэн болно.
2. Насанд хүрэгчдийн 51.7% илүүдэл жин ба таргалалттай, 18.7% тарган байв. Таргалалтын тархалт эмэгтэйчүүдийн дунд харьцангуй өндөр байна. Илүүдэл жин ба таргалалтын тархалт аль ч хүйсийн насанд хүрэгчдийн дунд нас ахих тутам нэмэгдэх хандлага ажиглагдсан бөгөөд 30 ба түүнээс дээш насны 2 хүн тутмын 1-ээс илүү нь илүүдэл жин ба таргалалттай байв. Мөн Баян – Өлгий аймгийн 40–69 насны 4 хүн тутмын 1 нь тарган байна.
3. Баян–Өлгий аймгийн эрт илрүүлэг үзлэгт хамрагдсан насанд хүрэгчдийн 56.0% төвийн таргалалттай, төвийн таргалалтын тархалт эмэгтэйчүүдийн дунд эрэгтэйчүүдээс 1.3 дахин өндөр байна (p<0.0001).


## АРТЕРИЙН ГИПЕРТЕНЗИ

Хүснэгт 56. Артерийн гипертензи хүйсээр

Насанд хүрсэн хүн амын дунд (95% ИХ)	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
Систолын артерийн даралт (САД)-ын дундаж хэмжээ, мм МУБ (даралт бууруулах эм хэрэглэж байгаа хүн амыг оролцуулсан)	<b>121.3</b> (120.9-121.7)	<b>123.8</b> (123.1-124.4)	<b>119.7</b> (118.9-119.2)
Диастолын артерийн даралт (ДАД)-ын дундаж хэмжээ, мм МУБ (даралт бууруулах эм хэрэглэж байгаа хүн амыг оролцуулсан)	<b>78.4</b> (78.2-78.7)	<b>79.7</b> (79.3-80.1)	<b>77.7</b> (77.4-80.0)
Артерийн даралт ихсэлттэй хүн амын хувь (САД = 120-129 мм МУБ ба/эсвэл ДАД ≤ 80 мм МУБ)	<b>42.3</b> (41.1-43.6)	<b>46.1</b> (44.1-48.1)	<b>39.9</b> (38.3-41.5)
Артерийн гипертензитай хүн амын хувь (САД ≥ 130 ба/эсвэл ДАД ≥ 81 мм МУБ эсвэл даралт бууруулах эм хэрэглэдэг хүн амын оролцуулсан)	<b>24.8</b> (23.7-25.9)	<b>28.9</b> (27.0-30.7)	<b>22.2</b> (20.9-23.6)



Зураг 75. Артерийн гипертензийн тархалт, насны бүлгээр



Зураг 76. Артерийн гипертензийн тархалт, сумаар


### ГОЛ МЭДЭЭЛЭЛ

1. Эрт илрүүлэг үзлэгт хамрагдсан Баян-Өлгий аймгийн насанд хүрэгчдийн САД-ын дундаж хэмжээ 121.3 мм МУБ, ДАД-ын дундаж үзүүлэлт 78.4 мм МУБ байна.
2. Насанд хүрэгчдийн 42.3% артерийн даралт ихсэлттэй буюу САД нь 120–129 мм ба/эсвэл ДАД ≤ 80 мм МУБ байв. Артерийн даралт ихсэлтийн тархалт эрэгтэйчүүдийн дунд статистик ач холбогдол бүхий өндөр байна.
3. Урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдсан Баян-Өлгий аймгийн насанд хүрэгчдийн 24.8% артерийн гипертензи (АГ)-тэй буюу САД ≥ 130 мм МУБ ба ДАД ≥ 81 мм МУБ-ээс дээш байна. АГ-ийн тархалт эрэгтэйчүүдийн дунд эмэгтэйчүүдийн үзүүлэлтээс 6.7 хувиар илүү байв ( $p < 0.0001$ ).
4. АГ-ийн тархалт иргэдийн нас ахих тутам нэмэгдэх хандлага ажиглагдсан бөгөөд 50 ба түүнээс дээш насны хүн амын 42.5–45.7 хувь нь АГ-тэй байв.
5. АГ-ийн тархалт Буянт сумын иргэдийн дунд хамгийн түгээмэл, Толбо сумын насанд хүрэгчдийн дунд хамгийн бага тархалттай байна.


## ЧИХРИЙН ШИЖИН

Хүснэгт 57. Чихрийн шижин хүйсээр

Насанд хүрсэн хүн амын дунд (95% ИХ)	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
Өлөн үеийн цусны глюкозын дундаж хэмжээ (ммоль/л), глюкоз бууруулах эм хэрэглэж буй хүн амыг оруулаад	<b>5.1</b> (5.0-5.1)	<b>5.2</b> (5.1-5.3)	<b>5.0</b> (4.9-5.0)
Өлөн үеийн цусны глюкозын өөрчлөлттэй хүн амын хувь (Ийлдсийн глюкозын хэмжээ $\geq 6.1$ ммол/л ба $< 7.0$ ммол/л)	<b>5.9</b> (5.3-6.6)	<b>8.2</b> (6.9-9.4)	<b>4.7</b> (3.-5.4)
Өлөн үеийн цусны глюкозын хэмжээ ихэссэн болон глюкоз бууруулах эм хэрэглэж буй хүн амын хувь (Ийлдсийн глюкозын хэмжээ $\geq 7.0$ ммол/л)	<b>4.9</b> (4.3-5.5)	<b>6.1</b> (5.0-7.2)	<b>4.2</b> (3.5-4.9)



Зураг 77. Өлөн үеийн цусны глюкозын өөрчлөлттэй болон ЧШ-тэй хүн амын хувь, насны бүлгээр



Зураг 78. Чихрийн шижингийн тархалт, сумаар


### ГОЛ МЭДЭЭЛЭЛ

1. Баян-Өлгий аймгийн эрт ирүүлэг үзлэгт хамрагдсан насанд хүрэгчдийн өлөн үеийн цусны глюкозын дундаж хэмжээ 5.1 ммоль/л байна. Цусны глюкозын дундаж хэмжээ нь хүйсийн ялгаатай, эрэгтэйчүүдэд дундаж үзүүлэлт харьцангуй илүү байв.
2. Насанд хүрсэн иргэдийн 5.9% өлөн үеийн цусны глюкозын өөрчлөлттэй, 4.9% цусны глюкозын хэмжээ ихэссэн буюу чихрийн шижинтэй байна. Өлөн үеийн цусны глюкозын өөрчлөлт, чихрийн шижингийн тархалт нь иргэдийн насны бүлгээр ялгаатай, Чихрийн шижингийн тархалт 20–29 болон 50–69 насны иргэдийн дунд харьцангуй өндөр байв.
3. Өлөн үеийн цусны глюкозын өөрчлөлт, чихрийн шижингийн тархалт эрт илрүүлэг үзлэгт хамрагдсан эрэгтэйчүүдийн дунд эмэгтэйчүүдээс статистик ач холбогдол бүхий өндөр байна.
4. Урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдсан Баян-Өлгий аймгийн  $\leq 19$  насны залуучуудын дунд өлөн үеийн цусны глюкозын өөрчлөлт болон чихрийн шижингийн тохиолдол илрээгүй болно.
5. Чихрийн шижингийн тохиолдлын тоо харьцангуй цөөн байгаа тул тархалтыг сумаар харьцуулан дүгнэх боломжгүй байна.

## ӨЛӨН ҮЕИЙН ЦУСНЫ ЛИПИДЫН ҮНЭЛГЭЭ

Хүснэгт 58. Өлөн үеийн цусны липидын үнэлгээ хүйсээр

Насанд хүрсэн хүн амын дунд (95% ИХ)	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
“Өлөн үеийн цусны холестерин хэмжээ ихэссэн” гэж оношлогдож байсан хүн амын хувь	<b>5.8</b> (5.2-6.3)	<b>6.6</b> (5.6-7.5)	<b>5.3</b> (4.6-6.0)
Цусны нийт холестерин хэмжээ ихэссэн ( $\geq 5.3$ ммоль/л) хүн амын хувь	<b>21.3</b> (19.6-22.9)	<b>21.5</b> (18.9-24.1)	<b>21.1</b> (19.0-23.2)
“Өлөн үеийн цусны триглицеридийн хэмжээ ихэссэн” гэж оношлогдож байсан хүн амын хувь	<b>1.7</b> (1.4-2.0)	<b>2.1</b> (1.6-2.7)	<b>1.5</b> (1.1-1.8)
Цусны триглицеридийн хэмжээ ихэссэн ( $\geq 1.7$ ммоль/л) хүн амын хувь	<b>3.1</b> (2.4-3.8)	<b>4.8</b> (3.5-6.2)	<b>1.9</b> (1.2-2.6)



Зураг 79. Өлөн үеийн цусны липидын хэмжээ ихэссэн хүн амын хувь, насны бүлгээр



Зураг 80. Өлөн үеийн цусны нийт холестерин агууламж ихэссэн хүн амын хувь

### ГОЛ МЭДЭЭЛЭЛ


1. Баян-Өлгий аймгийн эрт илрүүлэгт хамрагдсан насанд хүрэгчдийн 5.8% цусны холестерин ихэссэн, харин 1.7% триглицеридийн агууламж ихэссэн гэж оношлогдож байжээ.
2. Насанд хүрэгчдийн 21.3% өлөн үеийн цусны нийт холестерин, 3.1% триглицеридийн агууламж ихэссэн байна. Цусны нийт триглицеридийн агууламж ихэссэн тохиолдол эрэгтэйчүүдийн дунд эмэгтэйчүүдээс 2.5 дахин өндөр, харин холестерин ихсэлтэд хүйсийн ялгаа ажиглагдаагүй болно.
3. Өлөн үеийн цусны холестерин ихсэлт иргэдийн настай шууд хамааралтай нэмэгдэх хандлага илэрсэн ба Баян-Өлгий аймгийн 50–69 насны 3 хүн тутмын 1 орчим нь хувь цусны холестерин ихсэлттэй байв.
4. Биохимийн шинжилгээнд хамрагдсан иргэдийн тоо харилцан адилгүй, шинжилгээнд хамрагдсан иргэдийн тоо цөөн байгаа тул цусны нийт холестерин ихсэлтийн тархалтыг сумаар харьцуулан дүгнэх боломжгүй байна.



## ХУВЬ ХҮНИЙ ЭРСДЭЛИЙН ҮНЭЛГЭЭ

Хүснэгт 59. Хувь хүний эрсдэлийн үнэлгээ хүйсээр

Насанд хүрсэн хүн амын дунд (95% ИХ)	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
Гэр бүлийн гишүүн чихрийн шижингээр өвчилж байсан <i>Өвөө, эмээ, нагац, авга Эцэг, эх, ах дүү, өөрийн хүүхэд</i>	<b>4.7</b> (3.9-5.6)	<b>3.9</b> (2.7-5.1)	<b>5.3</b> (4.2-6.5)
Жирэмсний чихрийн шижингээр өвчилж байсан	-	-	<b>17.7</b> (16.5-18.9)
Хавдраар өвчилж байсан түүх (гэр бүлийн гишүүн)	<b>6.1</b> (5.5-6.7)	<b>4.9</b> (4.1-5.8)	<b>6.8</b> (6.0-7.6)
Артерийн даралт бууруулах эм тогтмол хэрэглэдэг	<b>15.0</b> (14.2-15.9)	<b>11.3</b> (10.1-12.6)	<b>17.4</b> (16.2-18.5)
Цусны өөх тос бууруулах эм хэрэглэж байгаа	<b>18.9</b> (17.8-19.8)	<b>18.2</b> (16.7-19.7)	<b>19.2</b> (17.9-20.4)



Зураг 81. “Гэр бүлийн хэн нэгэн гишүүн нь чихрийн шижин, хавдраар өвчилж байсан” гэж хариулсан насанд хүрэгчдийн хувь, насны бүлгээр


## ГОЛ МЭДЭЭЛЭЛ

1. Эрт илрүүлэг үзлэгт хамрагдсан Баян-Өлгий аймгийн насанд хүрэгчдийн 4.7% гэр бүлийн хэн нэгэн гишүүн “чихрийн шижингээр өвчилсөн”, 6.1% хавдраар өвчилсөн гэж хариулсан байна. Нийт эмэгтэйчүүдийн 17.7% жирэмсний чихрийн шижин оношлогдож байжээ.
2. Урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдсан Баян-Өлгий аймгийн иргэдийн 15.0% артерийн даралт бууруулах эмийг тогтмол хэрэглэдэг, харин 18.9% цусны өөх тос бууруулах эмийг одоо хэрэглэж байв.
3. Гэр бүлийн хэн нэгэн гишүүн чихрийн шижингээр өвчилсөн гэж хариулсан насанд хүрэгчдийн хувь тэдний настай урвуу хамааралтай буюу нас ахих тутам буурах хандлага ажиглагдсан болно. Тодруулбал, 18–29 насны залуучуудын дунд хамгийн их, 50 ба түүнээс дээш насны иргэдийн дунд хамгийн бага байв.
4. Гэр бүлийн хэн нэгэн гишүүн хавдраар өвчилсөн өгүүлэмжтэй иргэдийн хувь тэдний настай шууд хамааралтай ихсэх зүй тогтол ажиглагдсан бөгөөд урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдсан 40–69 насны хүн амын дунд харьцангуй өндөр байв.

**БУЛГАН АЙМГИЙН НАСАНД ХҮРЭГЧДИЙН ДУНДАХ  
ХАЛДВАРТ БУС ӨВЧНИЙ ЭРСДЭЛТ ХҮЧИН ЗҮЙЛСИЙН  
ТАРХАЛТ**

**ТАНИЛЦУУЛГА**

Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/248 дугаар тушаалыг хэрэгжүүлэх арга хэмжээний хүрээнд 2022 оны 5 дугаар сарын 3-ны өдрөөс 2023 оны 5 дугаар сарын 1 хүртэлх хугацаанд эрт илрүүлэг, урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдсан Булган аймгийн 6,198 насанд хүрэгчдийн мэдээллийг нэгтгэн, тэдний дунд түгээмэл тохиолдож буй Халдварт бус өвчин (ХБӨ)-ий эрсдэлт хүчин зүйлсийн тархалтын байдалд дүн шинжилгээ хийв (Зураг 82).



Зураг 82. Эрт илрүүлэг үзлэгт хамрагдсан насанд хүрэгчдийн тоо, сумын дүнгээр

Эрт илрүүлэг, урьдчилан сэргийлэх үзлэгт Булган аймгийн 18-90 насны нийт 6,198 хүн хамрагдсан бөгөөд тэдний 37.7% (n=2,334) эрэгтэйчүүд, 62.3% (n=3,864) эмэгтэйчүүд байв (Хүснэгт 60).

Хүснэгт 60. Эрт илрүүлэгт хамрагдсан насанд хүрэгчид, нас бүлэг ба хүйсээр

Насны бүлэг, жилээр	N	Эрэгтэй			Эмэгтэй		
		Тоо	Хувь	95% ИХ	Тоо	Хувь	95% ИХ
≤ 19	230	185	80.4	75.3-85.6	45	19.6	14.4-24.7
20 – 29	984	419	42.6	39.5-45.7	565	57.4	54.3-60.5
30 – 39	1226	452	36.9	34.2-39.6	774	63.1	60.4-65.8
40 – 49	1269	387	30.5	28.0-33.0	882	69.5	67.0-72.0
50 – 59	1462	483	33.0	30.6-35.5	979	67.0	64.6-69.4
60 – 69	797	306	38.4	35.0-41.8	491	61.6	58.2-65.0
≥ 70	230	102	44.4	37.9-50.8	128	55.7	49.2-62.1
<b>Нийт</b>	<b>6198</b>	<b>2334</b>	<b>37.7</b>	<b>36.5-38.9</b>	<b>3864</b>	<b>62.3</b>	<b>61.1-63.6</b>


Урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдсан Булган аймгийн насанд хүрэгчдийн дундаж нас 44.4 (95%ИХ 44.0-44.7) жил, эмэгтэйчүүдийн дундаж нас эрэгтэйчүүдээс 2.5 жилээр илүү байна (дундаж нас: эр 42.8 жил, эм 45.3 жил).

## ХБӨ-ий Нийтлэг Эрсдэлт Хүчин Зүйлс Хавсран Илэрсэн Хүн Ам


Хүснэгт 61. ХБӨ-ий нийтлэг эрсдэлт хүчин зүйлс хавсран илэрсэн хүн ам хүйсээр

Хүн амын дунд (95% ИХ)	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
<b>ХБӨ-ий нийтлэг эрсдэлт хүчин зүйлс</b>			
<ul style="list-style-type: none"> <li>Өдөр бүр тамхи татдаг</li> <li>Өдөрт 5 нэгжээс бага хэмжээгээр жимс, ногоо хэрэглэдэг</li> <li>Хөдөлгөөний хомсдолтой</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Илүүдэл жинтэй (БЖИ <math>\geq 25</math> кг/м<sup>2</sup>)</li> <li>Артерийн даралт ихсэлттэй (САД <math>\geq 140</math> ба/эсвэл ДАД <math>\geq 90</math> мм МУБ эсвэл даралт бууруулах эм хэрэглэж байгаа)*</li> </ul>		
Нийтлэг эрсдэлт хүчин зүйлс илрээгүй хүн амын хувь	<b>1.8</b> (1.5 – 2.2)	<b>1.4</b> (1.0 – 2.0)	<b>2.0</b> (1.6 – 2.5)
Нийтлэг эрсдэлт хүчин зүйлсээс 1-2 эрсдэл хавсран илэрсэн хүн амын хувь	<b>35.1</b> (33.8 – 36.3)	<b>30.5</b> (28.6 – 32.4)	<b>37.9</b> (36.3 – 39.6)
Нийтлэг эрсдэлт хүчин зүйлсээс 3 ба түүнээс олон эрсдэл хавсран илэрсэн хүн амын хувь	<b>63.2</b> (61.9 – 54.4)	<b>68.1</b> (66.1 – 70.0)	<b>60.1</b> (58.4 – 61.7)

\*ДЭМБ-ын үзүүлэлтийг баримтлав.



Зураг 83. Нийтлэг эрсдэлт хүчин зүйлсээс 3 ба түүнээс олон эрсдэл хавсран илэрсэн хүн амын хувь, хүйсээр



Зураг 84. ХБӨ-өөр өвчлөх өндөр эрсдэлтэй хүн амын хувь, сумаар


### ГОЛ МЭДЭЭЛЭЛ

1. Булган аймгийн насанд хүрсэн хүн амын ХБӨ-өөр өвчлөх эрсдэлгүй хүн амын тархалт дөнгөж 1.8% байна.
2. Насанд хүрсэн хүн амын 3 хүн тутмын 2 нь (63.2%) нийтлэг эрсдэлт хүчин зүйлсээс 3 ба түүнээс олон эрсдэл хавсран илэрсэн байна.
3. ХБӨ-өөр өвчлөх өндөр эрсдэлтэй хүн амын тархалт эрэгтэйчүүдийн дунд эмэгтэйчүүдээс 1.4 дахин их байна. Энэ нь эрэгтэйчүүдийн дундаж наслалт болон тэдний амьдралын чанарт сөргөөр нөлөөлөх магадлалтай.
4. Нас ахих тусам эрсдэлт хүчин зүйлс хавсран илэрсэн хүн амын тоо өсөж байна.
5. Хишиг-өндөр, Булган, Хутаг-өндөр, Баян-агт, Сэлэнгэ, Тэшиг, Бүрэгхангай, Сайхан сумуудад Нийтлэг эрсдэлт хүчин зүйлсээс 3 ба түүнээс олон эрсдэл хавсран илэрсэн хүн амын хувь аймгийн дундаж (63.2%) -аас өндөр байна.


## ТАМХИНЫ ХЭРЭГЛЭЭ

Хүснэгт 62. Тамхины хэрэглээ хүйсээр

Насанд хүрсэн хүн амын дунд (95% ИХ)	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
Тамхи татдаг хүн амын хувь	<b>20.7</b> (19.7 – 21.8)	<b>51.4</b> (49.4 – 53.4)	<b>1.9</b> (1.5 – 2.4)
Өдөр бүр тамхи татдаг хүн амын хувь	<b>14.1</b> (13.2 – 14.9)	<b>35.6</b> (33.7 – 37.6)	<b>1.0</b> (0.7 – 1.4)
<i>Өдөр бүр тамхи татдаг хүн амын дунд:</i>			
Тамхи татаж эхэлсэн дундаж нас (жилээр)	<b>19.9</b> (19.6 – 20.3)	<b>19.5</b> (19.1 – 19.8)	<b>28.6</b> (25.7 – 31.5)



Зураг 85. Тамхи татдаг хүн ам, хүйс ба насны ангиллаар




Зураг 86. Тамхи татдаг хүн амын тархалт, сумаар

## ГОЛ МЭДЭЭЛЭЛ


1. Булган аймгийн насанд хүрсэн хүн амын 5 хүн тутмын 1 нь (20.7%) тамхи татдаг бөгөөд эрэгтэйчүүдийн дунд тамхины хэрэглээ эмэгтэйчүүдээс 27 дахин их байна.
2. Өдөр бүр тамхи татдаг хүн амын хувь нийт тамхи татдаг хүмүүсийн 68.1%-ийг эзэлж байна.
3. Тамхи татаж эхэлсэн нас дунджаар 19.9 байна.
4. Бүх насны ангилалд тамхины хэрэглээ жигд өндөр байна.
5. Орхон, Рашаант, Хангал, Тэшиг, Сэлэнгэ, Дашинчилэн, Бугат, Бүрэгхангай сумуудад тамхи татдаг хүн амын хувь аймгийн дундаж (20.7%)-аас өндөр байна.

**АРХИ, СОГТУУРУУЛАХ УНДААНЫ ХЭРЭГЛЭЭ**  
Хүснэгт 63. Архи, согтууруулах ундааны хэрэглээ хүйсээр

Насанд хүрсэн хүн амын дунд (95% ИХ)	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
Сүүлийн 1 сард стандарт уултаас илүү архи, согтууруулах ундаа хэрэглэсэн хүн амын хувь	<b>17.6</b> (16.7 – 18.6)	<b>28.6</b> (26.8 – 30.5)	<b>10.8</b> (9.8 – 11.8)



Зураг 87. Сүүлийн 1 сард стандарт уултаас илүү архи, согтууруулах ундаа хэрэглэсэн хүн ам, хүйс ба насны ангиллаар



Зураг 88. Сүүлийн 1 сард архи, согтууруулах ундаа хэрэглэсэн хүн амын хувь, сумаар


**ГОЛ МЭДЭЭЛЭЛ**

1. Өвөрхангай аймгийн насанд хүрсэн хүн амын сүүлийн 1 сард стандарт уултаас илүү архи, согтууруулах ундаа хэрэглэсэн хүн амын хувь 17.6% байх бөгөөд эрэгтэйчүүдийн дунд согтууруулах ундааны хэрэглээ эмэгтэйчүүдээс 2.4 дахин их байна.
2. Хөдөлмөрийн насны (30-59 нас) хүмүүсийн архины хэрэглээ бусад насны бүлэгтэй харьцуулахад их байна.
3. Бугат, Могод, Тэшиг, Булган, Хангал, Сэлэнгэ, Баян-агт, Сайхан сумуудад Сүүлийн 1 сард стандарт уултаас илүү архи, согтууруулах ундаа хэрэглэсэн хүн амын хувь аймгийн дундаж (17.6%)-аас өндөр байна.


## ХӨДӨЛГӨӨН

Хүснэгт 64. Хөдөлгөөн хүйсээр

Насанд хүрсэн хүн амын дунд (95% ИХ)	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
7 хоногийн 5-аас доошгүй өдөр 30 минутаас дээш дасгал хөдөлгөөн хийдэггүй, эсвэл 10000 алхдаггүй хүн амын хувь	<b>64.8</b> (63.6 – 66.1)	<b>60.9</b> (58.9 – 62.9)	<b>67.3</b> (65.8 – 68.8)



Зураг 89. 7 хоногийн 5-аас доошгүй өдөр 30 минутаас дээш дасгал хөдөлгөөн хийдэггүй, эсвэл 10000 алхдаггүй хүн амын тархалт, насны бүлгээр ба хүйсээр




Зураг 90. 7 хоногийн 5-аас доошгүй өдөр 30 минутаас дээш дасгал хөдөлгөөн хийдэггүй, эсвэл 10000 алхдаггүй хүн амын тархалт, сумаар

## ГОЛ МЭДЭЭЛЭЛ


1. Булган аймгийн “Урьдчилан сэргийлэх эрт илрүүлэгт” хамрагдсан нийт хүн амын 64.8% нь 7 хоногийн 5-аас доошгүй өдөр 30 минутаас дээш дасгал хөдөлгөөн хийдэггүй, эсвэл 10000 алхдаггүй байна.
2. Хүйсээр авч үзвэл эмэгтэйчүүд (67.3%), эрэгтэйчүүдээс (60.9%) 6.4%-иар их, нас ахих тусам хөдөлгөөний идэвхгүй байдал нэмэгдэж байгаа нь ажиглагдав.
3. Гурван булаг, Баян-агт, Бугат, Тэшиг, Бүрэгхангай, Сэлэнгэ, Дашинчилэн, Сайхан, Хишиг-өндөр, Баяннуур сумуудад 7 хоногийн 5-аас доошгүй өдөр 30 минутаас дээш дасгал хөдөлгөөн хийдэггүй, эсвэл 10000 алхдаггүй хүн амын хувь аймгийн дундаж (64.8%-аас өндөр байна.

**ЖИМС, ЖИМСГЭНЭ, НОГООНЫ ХЭРЭГЛЭЭ**  
Хүснэгт 65. Жимс, жимсгэнэ, ногооны хэрэглээ хүйсээр

Насанд хүрсэн хүн амын дунд (95% ИХ)	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
Зохистой хэрэглээтэй хүн амын хувь (хоногт $\geq 5$ нэгж буюу 400 г)	<b>30.0</b> (28.9-31.2)	<b>25.9</b> (24.1-27.7)	<b>32.6</b> (31.1-34.1)
Хангалтгүй хэрэглээтэй хүн амын хувь (хоногт $< 5$ нэгж /400 г)	<b>38.3</b> (37.1-39.6)	<b>41.3</b> (39.3-43.4)	<b>36.5</b> (35.0-38.0)
Жимс, ногоо бага хэрэглэдэг ХБӨ-ний эрсдэлтэй хүн амын хувь (жимс, ногоог өдөр бүр хэрэглэдэггүй эсвэл хоногт 400 граммаас бага хэрэглэдэг)	<b>70.0</b> (68.8-71.1)	<b>74.1</b> (72.3-75.9)	<b>67.4</b> (65.9-68.9)



Зураг 91. Жимс, жимсгэнэ, хүнсний ногоо бага хэрэглэдэг насанд хүрэгчдийн хувь, насны бүлгээр



Зураг 92. Жимс, жимсгэнэ, ногооны зохистой хэрэглээтэй насанд хүрэгчдийн хувь, сумаар


**ГОЛ МЭДЭЭЛЭЛ**

1. Булган аймгийн насанд хүрэгчдийн 30.0% жимс, жимсгэнэ, хүнсний ногооны зохистой хэрэглээтэй буюу хоногт  $\geq 400$  г хэмжээгээр хэрэглэж байна. Жимс, жимсгэнэ, хүнсний ногооны зохистой хэрэглээтэй иргэдийн хувь Бүрэгхангай, Могод, Тэшиг, Сайхан суманд хамгийн бага, харин Баяннуур, Дашинчилэн, Гурванбулаг суманд статистик ач холбогдол бүхий өндөр байв.
2. Эрт илрүүлэг үзлэгт хамрагдсан 18–90 насны иргэдийн 70.0% өдөр бүр жимс, ногоо хэрэглэдэггүй эсвэл хоногт 400 граммаас бага хэмжээгээр хэрэглэж байв. Булган аймгийн насанд хүрсэн 3 хүн тутмын 2-оос илүү нь “Эрүүл хооллолтын ГЭР зөвлөмж”-д заасан хэмжээ (Хоногт  $\geq 400$ г)-гээр жимс, жимсгэнэ, хүнсний ногоо хэрэглэдэггүй буюу ХБӨ-өөр өвчлөх эрсдэлтэй байна.
3. Жимс, жимсгэнэ, хүнсний ногоо бага хэрэглэдэг буюу ХБӨ-өөр өвчлөх эрсдэлтэй насанд хүрэгчдийн тархалт иргэдийн насны бүлгээр ялгаатай,  $\leq 19$  насны залуучуудад хамгийн өндөр, 20-39 насны иргэдийн дунд хамгийн байга байв.


## ИЛҮҮДЭЛ ЖИН БА ТАРГАЛАЛТ

Хүснэгт 66. Илүүдэл жин ба таргалалт хүйсээр

Насанд хүрсэн хүн амын дунд (95% ИХ)	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
Биеийн жингийн индекс (БЖИ)-ийн дундаж хэмжээ (кг/м <sup>2</sup> )	<b>27.4</b> (27.3-27.6)	<b>26.8</b> (26.6-27.0)	<b>27.8</b> (27.7-28.0)
Илүүдэл жин ба таргалалттай хүн амын хувь (БЖИ ≥ 25 кг/м <sup>2</sup> )	<b>67.1</b> (65.9-68.3)	<b>62.3</b> (60.2-64.3)	<b>70.1</b> (68.6-71.6)
Таргалалттай хүн амын хувь (БЖИ ≥ 30 кг/м <sup>2</sup> )	<b>27.2</b> (26.0-28.3)	<b>21.8</b> (20.1-23.5)	<b>30.6</b> (29.0-32.1)
Бүсэлхийн тойргийн дундаж хэмжээ (см)	-	<b>90.6</b> (90.0-91.3)	<b>87.9</b> (87.4-88.4)
Төвийн таргалалттай хүн амын хувь (Бүсэлхийн тойрог: эр ≥ 90 см, эм ≥ 80 см)	<b>59.7</b> (58.4-61.0)	<b>43.9</b> (41.8-45.9)	<b>69.5</b> (68.0-71.0)



Зураг 93. Илүүдэл жин ба таргалалтын тархалт, насны бүлгээр



Зураг 94. Таргалалтын тархалт (БЖИ≥30 кг/м<sup>2</sup>), сумаар

### ГОЛ МЭДЭЭЛЭЛ


1. Урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдсан Булган аймгийн насанд хүрэгчдийн БЖИ-ийн дундаж хэмжээ 27.4 кг/м<sup>2</sup> байгаа нь ДЭМБ-аас зөвлөсөн хэвийн хязгаараас хэтэрсэн байна. Иргэдийн БЖИ-ийн дундаж хэмжээ нь хүйс болон насны бүлгээр ялгаатай, нас ахих тутам нэмэгдэх зүй тогтол ажиглагдсан болно.
2. Насанд хүрэгчдийн 67.1% илүүдэл жин ба таргалалттай, 27.2% тарган байв. Таргалалтын тархалт эмэгтэйчүүдийн дунд харьцангуй өндөр байна. Илүүдэл жин ба таргалалтын тархалт аль ч хүйсийн насанд хүрэгчдийн дунд нас ахих тутам нэмэгдэх хандлага ажиглагдсан бөгөөд 30 ба түүнээс дээш насны 3 хүн тутмын 2-ээс илүү нь илүүдэл жин ба таргалалттай байв. Мөн Булган аймгийн 40–69 насны 3 хүн тутмын 1 нь тарган байна.
3. Булган аймгийн эрт илрүүлэг үзлэгт хамрагдсан насанд хүрэгчдийн 56.0% төвийн таргалалттай, төвийн таргалалтын тархалт эмэгтэйчүүдийн дунд эрэгтэйчүүдээс 1.3 дахин өндөр байна (p<0.0001).




## АРТЕРИЙН ГИПЕРТЕНЗИ

Хүснэгт 67. Артерийн гипертензи хүйсээр

Насанд хүрсэн хүн амын дунд (95% ИХ)	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
Систолын артерийн даралт (САД)-ын дундаж хэмжээ, мм МУБ (даралт бууруулах эм хэрэглэж байгаа хүн амыг оролцуулсан)	<b>127.1</b> (126.6-127.6)	<b>128.2</b> (127.4-128.9)	<b>126.4</b> (125.8-127.0)
Диастолын артерийн даралт (ДАД)-ын дундаж хэмжээ, мм МУБ (даралт бууруулах эм хэрэглэж байгаа хүн амыг оролцуулсан)	<b>81.9</b> (81.5-82.2)	<b>82.8</b> (82.3-83.3)	<b>81.3</b> (80.9-81.7)
Артерийн даралт ихсэлттэй хүн амын хувь (САД = 120-129 мм МУБ ба/эсвэл ДАД ≤ 80 мм МУБ)	<b>21.2</b> (20.2-22.3)	<b>22.8</b> (21.1-24.6)	<b>20.2</b> (18.9-21.6)
Артерийн гипертензитэй хүн амын хувь (САД ≥ 130 ба/эсвэл ДАД ≥ 81 мм МУБ эсвэл даралт бууруулах эм хэрэглэдэг хүн амын оролцуулсан)	<b>50.0</b> (48.7-51.3)	<b>52.6</b> (50.5-54.7)	<b>48.5</b> (46.8-50.1)



Зураг 95. Артерийн гипертензийн тархалт, насны бүлгээр



Зураг 96. Артерийн гипертензийн тархалт, сумаар


### ГОЛ МЭДЭЭЛЭЛ

1. Эрт илрүүлэг үзлэгт хамрагдсан Булган аймгийн насанд хүрэгчдийн САД-ын дундаж хэмжээ 127.1 мм МУБ, ДАД-ын дундаж үзүүлэлт 81.9 мм МУБ байна.
2. Насанд хүрэгчдийн 21.2% артерийн даралт ихсэлттэй буюу САД нь 120–129 мм ба/эсвэл ДАД ≤ 80 мм МУБ байв. Артерийн даралт ихсэлтийн тархалт эрэгтэйчүүдийн дунд ялимгүй өндөр байна.
3. Урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдсан Булган аймгийн насанд хүрэгчдийн 50.0% артерийн гипертензи (АГ)-тэй буюу САД ≥ 130 мм МУБ ба ДАД ≥ 81 мм МУБ-ээс дээш байгаа нь анхаарал татаж байна. АГ-ийн тархалт эрэгтэйчүүдийн дунд эмэгтэйчүүдийн үзүүлэлтээс 4.1 хувиар илүү байв ( $p < 0.0001$ ).
4. АГ-ийн тархалт иргэдийн нас ахих тутам нэмэгдэж, 40 ба түүнээс дээш насны хүн амын 53.2–72.7 хувь АГ-тэй байгаа нь бусад аймгийн дундаж үзүүлэлтээс харьцангуй өндөр байна. Булган аймгийн Орхон, Сайхан, Сэлэнгэ сумын иргэдийн дунд АГ-ийн тархалт хамгийн түгээмэл, хутаг-Өндөр, Рашаант суманд харьцангуй бага байв.


## ЧИХРИЙН ШИЖИН

Хүснэгт 68. Чихрийн шижин хүйсээр

Насанд хүрсэн хүн амын дунд (95% ИХ)	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
Өлөн үеийн цусны глюкозын дундаж хэмжээ (ммоль/л), глюкоз бууруулах эм хэрэглэж буй хүн амыг оруулаад	<b>5.2</b> (5.2-5.3)	<b>5.4</b> (5.3-5.5)	<b>5.1</b> (5.1-5.2)
Өлөн үеийн цусны глюкозын өөрчлөлттэй хүн амын хувь (Ийлдсийн глюкозын хэмжээ $\geq 6.1$ ммол/л ба $< 7.0$ ммол/л)	<b>6.3</b> (5.6-7.0)	<b>7.3</b> (6.1-8.6)	<b>5.7</b> (4.9-6.5)
Өлөн үеийн цусны глюкозын хэмжээ ихэссэн болон глюкоз бууруулах эм хэрэглэж буй хүн амын хувь (Ийлдсийн глюкозын хэмжээ $\geq 7.0$ ммол/л)	<b>5.2</b> (4.6-5.9)	<b>6.7</b> (5.5-7.9)	<b>4.4</b> (3.7-5.2)



Зураг 97. Өлөн үеийн цусны глюкозын өөрчлөлттэй болон ЧШ-тэй хүн амын хувь, насны бүлгээр



Зураг 98. Чихрийн шижингийн тархалт, сумаар


## ГОЛ МЭДЭЭЛЭЛ

1. Булган аймгийн эрт ирүүлэг үзлэгт хамрагдсан насанд хүрэгчдийн өлөн үеийн цусны глюкозын дундаж хэмжээ 5.2 ммоль/л байна. Цусны глюкозын дундаж хэмжээ нь хүйсийн ялгаатай, эрэгтэйчүүдийн дундаж үзүүлэлт харьцангуй өндөр байв.
2. Насанд хүрэгчдийн 6.3% өлөн үеийн цусны глюкозын өөрчлөлттэй, 5.2% цусны глюкозын хэмжээ ихэссэн буюу чихрийн шижинтэй байна. Өлөн үеийн цусны глюкозын өөрчлөлт, чихрийн шижингийн тархалт нь иргэдийн насны бүлгээр ялгаатай, Чихрийн шижингийн тархалт 20–29 болон  $\geq 50$  насны иргэдийн дунд харьцангуй өндөр байв.
3. Өлөн үеийн цусны глюкозын өөрчлөлт, чихрийн шижингийн тархалт эрт илрүүлэг үзлэгт хамрагдсан эрэгтэйчүүдийн дунд эмэгтэйчүүдийн үзүүлэлтээс статистик ач холбогдол бүхий өндөр байна.
4. Урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдсан Булган аймгийн 18-29 насны залуучуудын дунд өлөн үеийн цусны глюкозын өөрчлөлт, чихрийн шижингийн тохиолдол  $\leq 19$  насны залуучуудын дунд илрээгүй болно.
5. Өлөн үеийн цусны глюкозын шинжилгээнд хамрагдсан иргэдийн тоо харьцангуй цөөн байгаа тул чихрийн шижингийн тархалтыг сумаар харьцуулан дүгнэх боломжгүй байна.


## ӨЛӨН ҮЕИЙН ЦУСНЫ ЛИПИДЫН ҮНЭЛГЭЭ

Хүснэгт 69. Өлөн үеийн цусны липидын үнэлгээ хүйсээр

Насанд хүрсэн хүн амын дунд (95% ИХ)	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
“Өлөн үеийн цусны холестерин хэмжээ ихэссэн” гэж оношлогдож байсан хүн амын хувь	<b>3.1</b> (2.7-3.5)	<b>3.2</b> (2.4-3.9)	<b>3.1</b> (2.5-3.6)
Цусны нийт холестерин хэмжээ ихэссэн ( $\geq 5.3$ ммоль/л) хүн амын хувь	<b>21.5</b> (19.8-23.2)	<b>24.0</b> (21.1-26.8)	<b>20.0</b> (18.0-22.1)
“Өлөн үеийн цусны триглицеридийн хэмжээ ихэссэн” гэж оношлогдож байсан хүн амын хувь	<b>1.6</b> (1.2-1.9)	<b>1.6</b> (1.1-2.1)	<b>1.6</b> (1.2-1.9)
Цусны триглицеридийн хэмжээ ихэссэн ( $\geq 1.7$ ммоль/л) хүн амын хувь	<b>10.4</b> (9.2-11.7)	<b>15.1</b> (12.7-17.5)	<b>7.7</b> (6.3-9.0)



Зураг 99. Өлөн үеийн цусны липидын хэмжээ ихэссэн хүн амын хувь, насны бүлгээр



Зураг 100. Өлөн үеийн цусны нийт холестерин агууламж ихэссэн хүн амын хувь


### ГОЛ МЭДЭЭЛЭЛ

1. Булган аймгийн эрт илрүүлэгт хамрагдсан насанд хүрэгчдийн 3.1% цусны холестерин ихэссэн, харин 1.6% триглицеридийн агууламж ихэссэн гэж оношлогдож байжээ.
2. Насанд хүрэгчдийн 21.5% өлөн үеийн цусны нийт холестерин, 10.4% триглицеридийн агууламж ихэссэн байна. Цусны триглицеридийн агууламж ихэссэн Булган аймгийн насанд хүрэгчдийн дундах дислипидемийн тархалтад хүйсийн ялгаа ажиглагдсан бөгөөд цусны триглицеридийн ихсэлт эрэгтэйчүүдийн дунд эмэгтэйчүүдээс 1.9 дахин өндөр байв.
3. Өлөн үеийн цусны холестерин ихсэлтийн тархалт иргэдийн наснаас шууд хамаарч нэмэгдэх хандлага илэрсэн ба Булган аймгийн  $\geq 40$  насны 4 хүн тутмын 1 нь цусны нийт холестерин ихсэлттэй байна.
4. Өлөн үеийн цусны липидын шинжилгээнд хамрагдсан иргэдийн тоо цөөн байгаа хэдий ч, цусны нийт холестерин ихсэлтийн тархалт Хутаг-Өндөр, Бугат, Сайхан сумдад харьцангуй өндөр, Баяннуур, Рашаант, Гурван булаг суманд бага байв.

## ХУВЬ ХҮНИЙ ЭРСДЭЛИЙН ҮНЭЛГЭЭ

Хүснэгт 70. Хувь хүний эрсдэлийн үнэлгээ хүйсээр

Насанд хүрсэн хүн амын дунд (95% ИХ)	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
Гэр бүлийн гишүүн чихрийн шижингээр өвчилж байсан <i>Өвөө, эмээ, нагац, авга Эцэг, эх, ах дүү, өөрийн хүүхэд</i>	<b>8.2</b> (7.1-9.3)	<b>8.4</b> (6.6-10.1)	<b>8.1</b> (6.7-9.4)
Жирэмсний чихрийн шижингээр өвчилж байсан	-	-	<b>14.0</b> (12.9-15.0)
Хавдраар өвчилж байсан түүх (гэр бүлийн гишүүн)	<b>13.5</b> (12.6-14.4)	<b>10.8</b> (9.5-12.1)	<b>15.1</b> (14.0-16.3)
Артерийн даралт бууруулах эм тогтмол хэрэглэдэг	<b>22.5</b> (21.5-23.6)	<b>17.6</b> (16.0-19.2)	<b>25.3</b> (24.0-26.0)
Цусны өөх тос бууруулах эм хэрэглэж байгаа	<b>13.9</b> (13.0-14.8)	<b>11.7</b> (10.4-13.1)	<b>15.2</b> (14.0-16.3)



Зураг 101. “Гэр бүлийн хэн нэгэн гишүүн нь чихрийн шижин, хавдраар өвчилж байсан” гэж хариулсан насанд хүрэгчдийн хувь, насны бүлгээр


### ГОЛ МЭДЭЭЛЭЛ

1. Эрт илрүүлэг үзлэгт хамрагдсан Булган аймгийн насанд хүрэгчдийн 8.2% гэр бүлийн хэн нэгэн гишүүн “чихрийн шижингээр өвчилсөн”, 13.5% хавдраар өвчилсөн гэж хариулсан байна. Нийт эмэгтэйчүүдийн 14.0% жирэмсний чихрийн шижин оношлогдож байжээ.
2. Урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдсан Булган аймгийн иргэдийн 22.5% артерийн даралт бууруулах эмийг тогтмол хэрэглэдэг, харин 13.9% цусны өөх тос бууруулах эмийг одоо хэрэглэж байв.
3. Гэр бүлийн хэн нэгэн гишүүн чихрийн шижингээр өвчилсөн гэж хариулсан насанд хүрэгчдийн хувь тэдний настай урвуу хамааралтай буюу нас ахих тутам буурах хандлага ажиглагдаж байв. Тодруулбал, 18–29 насны залуучуудын дунд уг өгүүлэмж хамгийн их, 50 ба түүнээс дээш насны иргэдийн дунд хамгийн бага байв.
4. Гэр бүлийн хэн нэгэн гишүүн хавдраар өвчилсөн гэж хариулсан насанд хүрэгчдийн хувь тэдний настай шууд хамааралтай ихсэх зүй тогтол ажиглагдсан бөгөөд урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдсан Булган аймгийн 30–59 насны хүн амын дунд харьцангуй өндөр байна.

**ДАРХАН-УУЛ АЙМГИЙН НАСАНД ХҮРЭГЧДИЙН ДУНДАХ  
ХАЛДВАРТ БУС ӨВЧНИЙ ЭРСДЭЛТ ХҮЧИН ЗҮЙЛСИЙН  
ТАРХАЛТ**

**ТАНИЛЦУУЛГА**

Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/248 дугаар тушаалыг хэрэгжүүлэх арга хэмжээний хүрээнд 2022 оны 5 дугаар сарын 3-ны өдрөөс 2023 оны 5 дугаар сарын 1 хүртэлх хугацаанд эрт илрүүлэг, урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдсан Дархан-Уул аймгийн 8,164 насанд хүрэгчдийн мэдээллийг нэгтгэн, тэдний дунд түгээмэл тохиолдож буй халдварт бус өвчин (ХБӨ)-ий эрсдэлт хүчин зүйлсийн тархалтын байдалд дүн шинжилгээ хийв (Зураг 103).



Зураг 102. Эрт илрүүлэг үзлэгт хамрагдсан насанд хүрэгчдийн тоо, сумын дүнгээр

Эрт илрүүлэг, урьдчилан сэргийлэх үзлэгт Дархан-Уул аймгийн 18–92 насны нийт 8,164 хүн хамрагдсан бөгөөд тэдний 37.8% (n=3,176) эрэгтэйчүүд, 62.8% (n=5,234) эмэгтэйчүүд байв (Хүснэгт 71).

Хүснэгт 71. Эрт илрүүлэгт хамрагдсан насанд хүрэгчид, нас бүлэг ба хүйсээр

Насны бүлэг, жилээр	N	Эрэгтэй			Эмэгтэй		
		Тоо	Хувь	95% ИХ	Тоо	Хувь	95% ИХ
≤ 19	379	178	47.0	41.9-52.0	201	53.0	48.0-58.1
20 – 29	1933	723	37.4	35.2-39.6	1210	62.6	60.4-64.8
30 – 39	1792	724	40.4	38.1-42.7	1068	59.6	57.3-61.9
40 – 49	1491	518	34.7	32.3-37.2	973	65.3	62.8-67.7
50 – 59	1497	516	34.5	32.1-36.9	981	65.5	63.1-67.9
60 – 69	972	374	38.5	35.4-41.5	598	61.5	58.5-64.6
≥ 70	346	143	41.3	36.1-46.5	203	58.7	53.5-63.9
<b>Нийт</b>	<b>8,410</b>	<b>3,176</b>	<b>37.8</b>	<b>36.7-38.8</b>	<b>5,234</b>	<b>62.2</b>	<b>61.2-63.3</b>


Урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдсан Дархан-Уул аймгийн насанд хүрэгчдийн дундаж нас 41.9 (95%ИХ 41.5-42.2) жил байна. Эрт илрүүлэг үзлэгт хамрагдсан Дархан-Уул аймгийн иргэдийн дундаж нас нь хүйсийн хувьд төдийлөн ялгаатай бус, эрэгтэйчүүдийн дундаж нас 41.5 жил, эмэгтэйчүүдэд 42.1 жил байв (p=0.06).

## ХБӨ-ИЙ НИЙТЛЭГ ЭРСДЭЛТ ХҮЧИН ЗҮЙЛС ХАВСРАН ИЛЭРСЭН ХҮН АМ

Хүснэгт 72. ХБӨ-ий нийтлэг эрсдэлт хүчин зүйлс хавсран илэрсэн хүн ам хүйсээр


Хүн амын дунд (95% ИХ)	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
<b>ХБӨ-ий нийтлэг эрсдэлт хүчин зүйлс</b>			
<ul style="list-style-type: none"> <li>Өдөр бүр тамхи татдаг</li> <li>Өдөрт 5 нэгжээс бага хэмжээгээр жимс, ногоо хэрэглэдэг</li> <li>Хөдөлгөөний хомсдолтой</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Илүүдэл жинтэй (БЖИ <math>\geq 25</math> кг/м<sup>2</sup>)</li> <li>Артерийн даралт ихсэлттэй (САД <math>\geq 140</math> ба/эсвэл ДАД <math>\geq 90</math> мм МУБ эсвэл даралт бууруулах эм хэрэглэж байгаа)*</li> </ul>		
Нийтлэг эрсдэлт хүчин зүйлс илрээгүй хүн амын хувь	<b>5.1</b> (4.6 – 5.6)	<b>4.1</b> (3.4 – 4.8)	<b>5.7</b> (5.0 – 6.4)
Нийтлэг эрсдэлт хүчин зүйлсээс 1-2 эрсдэл хавсран илэрсэн хүн амын хувь	<b>47.2</b> (46.0 – 48.3)	<b>38.6</b> (36.7 – 40.4)	<b>52.5</b> (51.0 – 53.9)
Нийтлэг эрсдэлт хүчин зүйлсээс 3 ба түүнээс олон эрсдэл хавсран илэрсэн хүн амын хувь	<b>47.8</b> (46.6 – 48.9)	<b>57.4</b> (55.5 – 59.2)	<b>41.9</b> (40.4 – 43.3)

\*ДЭМБ-ын үзүүлэлтийг баримтлав.



Зураг 103. Нийтлэг эрсдэлт хүчин зүйлсээс 3 ба түүнээс олон эрсдэл хавсран илэрсэн хүн амын хувь, хүйсээр

### ГОЛ МЭДЭЭЛЭЛ




Зураг 104. ХБӨ-өөр өвчлөх өндөр эрсдэлтэй хүн амын хувь, сумаар

1. Дархан-ууд аймгийн насанд хүрсэн хүн амын ХБӨ-өөр өвчлөх эрсдэлгүй хүн амын тархалт дөнгөж 5.1% байна.
2. Насанд хүрсэн хүн амын 2 хүн тутмын 1 нь (47.8%) нийтлэг эрсдэлт хүчин зүйлсээс 3 ба түүнээс олон эрсдэл хавсран илэрсэн байна.
3. ХБӨ-өөр өвчлөх өндөр эрсдэлтэй хүн амын тархалт эрэгтэйчүүдийн дунд эмэгтэйчүүдээс 1.3 дахин их байна. Энэ нь эрэгтэйчүүдийн дундаж наслалт болон тэдний амьдралын чанарт сөргөөр нөлөөлөх магадлалтай.
4. Нас ахих тусам эрсдэлт хүчин зүйл хавсран илэрсэн хүн амын тоо өсөж байна.
5. Хонгор суманд Нийтлэг эрсдэлт хүчин зүйлсээс 3 ба түүнээс олон эрсдэл хавсран илэрсэн хүн амын хувь аймгийн дундаж (47.8%)-аас өндөр байна.

## ТАМХИНЫ ХЭРЭГЛЭЭ


Хүснэгт 73. Тамхины хэрэглээ хүйсээр

Насанд хүрсэн хүн амын дунд (95% ИХ)	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
Тамхи татдаг хүн амын хувь	<b>18.0</b> (17.2 – 18.8)	<b>42.3</b> (40.5 – 44.0)	<b>3.2</b> (2.7 – 3.7)
Өдөр бүр тамхи татдаг хүн амын хувь	<b>13.9</b> (13.1 – 14.6)	<b>33.7</b> (32.1 – 35.3)	<b>1.8</b> (1.5 – 2.2)
<i>Өдөр бүр тамхи татдаг хүн амын дунд:</i>			
Тамхи татаж эхэлсэн дундаж нас (жилээр)	<b>20.5</b> (20.1 – 20.9)	<b>19.8</b> (19.4 – 20.2)	<b>26.5</b> (25.1 – 28.1)



Зураг 105. Тамхи татдаг хүн ам, хүйс ба насны ангилал

## ГОЛ МЭДЭЭЛЭЛ




Зураг 106. Тамхи татдаг хүн амын тархалт, сумаар

1. Өвөрхангай аймгийн насанд хүрсэн хүн амын 5 хүн тутмын 1 нь (18.0%) тамхи татдаг бөгөөд эрэгтэйчүүдийн дунд тамхины хэрэглээ эмэгтэйчүүдээс 13.2 дахин их байна.
2. Өдөр бүр тамхи татдаг хүн амын хувь нийт тамхи татдаг хүмүүсийн 77.2%-ийг эзэлж байна.
3. Тамхи татаж эхэлсэн нас дунджаар 20.5 байна.
4. 20-59 нас хүртэлх насны ангилалд тамхины хэрэглээ жигд өндөр байна.
5. Шарын гол, Дархан сумуудад тамхи татдаг хүн амын хувь аймгийн дундаж (18%)-аас өндөр байна.


## АРХИ, СОГТУУРУУЛАХ УНДААНЫ ХЭРЭГЛЭЭ

Хүснэгт 74. Архи, согтууруулах ундааны хэрэглээ хүйсээр

Насанд хүрсэн хүн амын дунд (95% ИХ)	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
Сүүлийн 1 сард стандарт уултаас илүү архи, согтууруулах ундаа хэрэглэсэн хүн амын хувь	<b>7.6</b> (7.0 – 8.2)	<b>13.5</b> (12.2 – 14.6)	<b>4.1</b> (3.5 – 4.6)



Зураг 107. Сүүлийн 1 сард стандарт уултаас илүү архи, согтууруулах ундаа хэрэглэсэн хүн ам, хүйс ба насны ангиллаар



Зураг 108. Сүүлийн 1 сард стандарт уултаас илүү архи, согтууруулах ундаа хэрэглэсэн хүн амын хувь, сумаар

### ГОЛ МЭДЭЭЛЭЛ


1. Өвөрхангай аймгийн насанд хүрсэн хүн амын сүүлийн 1 сард стандарт уултаас илүү архи, согтууруулах ундаа хэрэглэсэн хүн амын хувь 7.6% байх бөгөөд эрэгтэйчүүдийн дунд согтууруулах ундааны хэрэглээ эмэгтэйчүүдээс 3.3 дахин их байна.
2. Хөдөлмөрийн насны (20-39 нас) хүмүүсийн архины хэрэглээ бусад насны бүлэгтэй харьцуулахад их байна.
3. Орхон, Дархан, Хонгор сумуудад Сүүлийн 1 сард стандарт уултаас илүү архи, согтууруулах ундаа хэрэглэсэн хүн амын хувь аймгийн дундаж (7.6%)-аас өндөр байна.




## ХӨДӨЛГӨӨН

Хүснэгт 75. Хөдөлгөөн хүйсээр

Насанд хүрсэн хүн амын дунд (95% ИХ)	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
7 хоногийн 5-аас доошгүй өдөр 30 минутаас дээш дасгал хөдөлгөөн хийдэггүй, эсвэл 10000 алхдаггүй хүн амын хувь	<b>42.1</b> (41.1 – 43.2)	<b>39.2</b> (37.4 – 40.9)	<b>43.9</b> (42.6 – 45.3)



Зураг 109. 7 хоногийн 5-аас доошгүй өдөр 30 минутаас дээш дасгал хөдөлгөөн хийдэггүй, эсвэл 10000 алхдаггүй хүн амын тархалт, насны бүлгээр ба хүйсээр



Зураг 110. 7 хоногийн 5-аас доошгүй өдөр 30 минутаас дээш дасгал хөдөлгөөн хийдэггүй, эсвэл 10000 алхдаггүй хүн амын тархалт, сумаар


## ГОЛ МЭДЭЭЛЭЛ

1. Дархан-Уул аймгийн “Урьдчилан сэргийлэх эрт илрүүлэгт” хамрагдсан нийт хүн амын 42.1% нь 7 хоногийн 5-аас доошгүй өдөр 30 минутаас дээш дасгал хөдөлгөөн хийдэггүй, эсвэл 10000 алхдаггүй байна.
2. Хүйсээр авч үзвэл эмэгтэйчүүд (43.9%), эрэгтэйчүүдээс (39.2%) 4.7%-иар их, хөдөлмөрийн нас (30-39)-ны залуучуудын дунд хөдөлгөөний идэвхгүй байдал ажиглагдаж байна.
3. Хонгор, Шарын гол, Дархан, сумуудад 7 хоногийн 5-аас доошгүй өдөр 30 минутаас дээш дасгал хөдөлгөөн хийдэггүй, эсвэл 10000 алхдаггүй хүн амын хувь аймгийн дундаж (42.1%-аас өндөр байна.


## ЖИМС, ЖИМСГЭНЭ, НОГООНЫ ХЭРЭГЛЭЭ

Хүснэгт 76. Жимс, жимсгэнэ, ногооны хэрэглээ хүйсээр

Насанд хүрсэн хүн амын дунд (95% ИХ)	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
Зохистой хэрэглээтэй хүн амын хувь (хоногт $\geq 5$ нэгж буюу 400 г)	<b>40.0</b> (39.0-41.1)	<b>37.4</b> (35.7-39.1)	<b>41.6</b> (40.3-43.0)
Хангалтгүй хэрэглээтэй хүн амын хувь (хоногт $< 5$ нэгж /400 г)	<b>19.6</b> (18.7-20.5)	<b>19.7</b> (18.3-21.1)	<b>19.5</b> (18.4-20.6)
Жимс, ногоо бага хэрэглэдэг ХБӨ-ний эрсдэлтэй хүн амын хувь (жимс, ногоог өдөр бүр хэрэглэдэггүй эсвэл хоногт 400 граммаас бага хэрэглэдэг)	<b>60.0</b> (58.9-61.1)	<b>62.6</b> (60.9-64.3)	<b>58.4</b> (57.0-59.7)



Зураг 111. Жимс, жимсгэнэ, хүнсний ногоо бага хэрэглэдэг насанд хүрэгчдийн хувь, насны бүлгээр



Зураг 112. Жимс, жимсгэнэ, ногооны зохистой хэрэглээтэй насанд хүрэгчид, сумаар


### ГОЛ МЭДЭЭЛЭЛ

1. Дархан-Уул аймгийн насанд хүрэгчдийн 40.0% жимс, жимсгэнэ, хүнсний ногооны зохистой хэрэглээтэй буюу хоногт  $\geq 400$  г хэмжээгээр хэрэглэж байна. Жимс, жимсгэнэ, хүнсний ногооны зохистой хэрэглээтэй иргэдийн хувь сумаар төдийлөн ялгаатай бус, харин эмэгтэйчүүдэд статистик ач холбогдол бүхий өндөр байв.
2. Эрт илрүүлэг үзлэгт хамрагдсан 18–92 насны иргэдийн 60.0% өдөр бүр жимс, ногоо хэрэглэдэггүй эсвэл хоногт 400 граммаас бага хэмжээгээр хэрэглэж байна. Дархан-Уул аймгийн насанд хүрсэн 3 хүн тутмын 2 орчим нь “Эрүүл хооллолтын ГЭР зөвлөмж”-д заасан хэмжээ (Хоногт  $\geq 400$ г)-гээр жимс, жимсгэнэ, хүнсний ногоо хэрэглэдэггүй буюу ХБӨ-өөр өвчлөх эрсдэлтэй байна.
3. Жимс, жимсгэнэ, хүнсний ногоо бага хэрэглэдэг буюу ХБӨ-өөр өвчлөх эрсдэлтэй насанд хүрэгчдийн тархалт иргэдийн насны бүлгээр ялгаатай,  $\leq 19$  насны залуучууд,  $\geq 60$  насны иргэдийн дунд хамгийн өндөр, 20-39 насныхны дунд харьцангуй бага байв.


## ИЛҮҮДЭЛ ЖИН БА ТАРГАЛАЛТ

Хүснэгт 77. Илүүдэл жин ба таргалалт хүйсээр

Насанд хүрсэн хүн амын дунд (95% ИХ)	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
Биеийн жингийн индекс (БЖИ)-ийн дундаж хэмжээ (кг/м <sup>2</sup> )	<b>26.7</b> (26.6-26.8)	<b>26.9</b> (26.7-27.1)	<b>26.6</b> (26.4-26.7)
Илүүдэл жин ба таргалалттай хүн амын хувь (БЖИ ≥ 25 кг/м <sup>2</sup> )	<b>60.6</b> (59.4-61.7)	<b>62.6</b> (60.8-64.4)	<b>59.3</b> (57.8-60.7)
Таргалалттай хүн амын хувь (БЖИ ≥ 30 кг/м <sup>2</sup> )	<b>21.7</b> (20.7-22.6)	<b>23.1</b> (21.5-24.6)	<b>20.8</b> (19.6-22.0)
Бүсэлхийн тойргийн дундаж хэмжээ (см)	-	<b>92.2</b> (91.7-92.7)	<b>87.4</b> (87.0-87.7)
Төвийн таргалалттай хүн амын хувь (Бүсэлхийн тойрог: эр ≥ 90 см, эм ≥ 80 см)	<b>68.1</b> (67.0-69.2)	<b>58.6</b> (56.7-60.4)	<b>74.0</b> (72.7-75.2)



Зураг 113. Илүүдэл жин ба таргалалтын тархалт, насны бүлгээр



Зураг 114. Таргалалтын тархалт (БЖИ≥30 кг/м<sup>2</sup>), сумаар


## ГОЛ МЭДЭЭЛЭЛ

1. Дархан-Уул аймгийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдсан насанд хүрэгчдийн БЖИ-ийн дундаж хэмжээ 26.7 кг/м<sup>2</sup> байгаа нь ДЭМБ-аас зөвлөсөн хэвийн хязгаараас хэтэрсэн байна. Иргэдийн БЖИ-ийн дундаж хэмжээ нь хүйс болон насны бүлгээр ялгаатай, нас ахих тутам нэмэгдэх зүй тогтол илэрсэн болно.
2. Насанд хүрэгчдийн 60.6% илүүдэл жин ба таргалалттай, 21.7% тарган байв. Таргалалтын тархалт эмэгтэйчүүдийн дунд харьцангуй өндөр байна. Илүүдэл жин ба таргалалтын тархалт аль ч хүйсийн насанд хүрэгчдийн дунд нас ахих тутам нэмэгдэх хандлага ажиглагдсан бөгөөд 30 – 39 насны 2 хүн тутмын 1-ээс илүү, 40 насны 4 хүн тутмын 3 орчим нь илүүдэл жин ба таргалалттай байв. Мөн Дархан-Уул аймгийн 30–69 насны 4 хүн тутмын 1 нь тарган байна.
3. Дархан-Уул аймгийн эрт илрүүлэг үзлэгт хамрагдсан насанд хүрэгчдийн 68.1% төвийн таргалалттай, төвийн таргалалтын тархалт эмэгтэйчүүдийн дунд эрэгтэйчүүдээс 1.3 дахин өндөр байна ( $p < 0.0001$ ).


## АРТЕРИЙН ГИПЕРТЕНЗИ

Хүснэгт 78. Илүүдэл жин ба таргалалт хүйсээр

Насанд хүрсэн хүн амын дунд (95% ИХ)	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
Систолын артерийн даралт (САД)-ын дундаж хэмжээ, мм МУБ (даралт бууруулах эм хэрэглэж байгаа хүн амыг оролцуулсан)	<b>118.9</b> (118.6-119.3)	<b>122.8</b> (122.2-123.4)	<b>116.6</b> (116.1-117.1)
Диастолын артерийн даралт (ДАД)-ын дундаж хэмжээ, мм МУБ (даралт бууруулах эм хэрэглэж байгаа хүн амыг оролцуулсан)	<b>78.0</b> (77.7-78.2)	<b>80.4</b> (79.9-80.8)	<b>76.5</b> (76.2-76.9)
Артерийн даралт ихсэлттэй хүн амын хувь (САД = 120-129 мм МУБ ба/эсвэл ДАД ≤ 80 мм МУБ)	<b>29.6</b> (28.5-30.6)	<b>33.6</b> (31.8-35.4)	<b>27.1</b> (25.8-28.4)
Артерийн гипертензитэй хүн амын хувь (САД ≥ 130 ба/эсвэл ДАД ≥ 81 мм МУБ эсвэл даралт бууруулах эм хэрэглэдэг хүн амын оролцуулсан)	<b>29.8</b> (28.8-30.9)	<b>36.6</b> (34.8-38.4)	<b>25.8</b> (24.5-27.1)



Зураг 115. Артерийн гипертензийн тархалт, насны бүлгээр



Зураг 116. Артерийн гипертензийн тархалт, сумаар


### ГОЛ МЭДЭЭЛЭЛ

1. Эрт илрүүлэг үзлэгт хамрагдсан Дархан-Уул аймгийн насанд хүрэгчдийн САД-ын дундаж хэмжээ 118.9 мм МУБ, ДАД-ын дундаж үзүүлэлт 78.0 мм МУБ байна.
2. Насанд хүрэгчдийн 29.6% артерийн даралт ихсэлттэй буюу САД нь 120–129 мм ба/эсвэл ДАД ≤ 80 мм МУБ байв. Артерийн даралт ихсэлтийн тархалт эрэгтэйчүүдийн дунд өндөр байна.
3. Урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдсан Дархан-Уул аймгийн насанд хүрэгчдийн 29.8% артерийн гипертензи (АГ)-тэй буюу САД ≥ 130 мм МУБ ба ДАД ≥ 81 мм МУБ-аас дээш байгаа нь анхаарал татаж байна. АГ-ийн тархалт эрэгтэйчүүдийн дунд эмэгтэйчүүдийн үзүүлэлтээс 10.6 хувиар илүү байв ( $p < 0.0001$ ).
4. АГ-ийн тархалт иргэдийн нас ахих тутам нэмэгдэж, 50 ба түүнээс дээш насны 2 хүн тутмын 1 нь АГ-тэй байна. Дархан-Уул аймгийн насанд хүрэгчдийн дундах АГ-ийн тархалтыг сумаар харьцуулан үнэлэхэд статистик ач холбогдол бүхий ялгаа илрээгүй болно.


## ЧИХРИЙН ШИЖИН

Хүснэгт 79. Илүүдэл жин ба таргалалт хүйсээр

Насанд хүрсэн хүн амын дунд (95% ИХ)	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
Өлөн үеийн цусны глюкозын дундаж хэмжээ (ммоль/л), глюкоз бууруулах эм хэрэглэж буй хүн амыг оруулаад	<b>5.9</b> (5.9-5.9)	<b>5.9</b> (5.9-6.0)	<b>5.9</b> (5.8-5.9)
Өлөн үеийн цусны глюкозын өөрчлөлттэй хүн амын хувь (Ийлдсийн глюкозын хэмжээ $\geq 6.1$ ммол/л ба $< 7.0$ ммол/л)	<b>16.7</b> (15.8-17.7)	<b>16.3</b> (14.8-17.9)	<b>16.9</b> (15.7-18.2)
Өлөн үеийн цусны глюкозын хэмжээ ихэссэн болон глюкоз бууруулах эм хэрэглэж буй хүн амын хувь (Ийлдсийн глюкозын хэмжээ $\geq 7.0$ ммол/л)	<b>13.8</b> (12.9-14.7)	<b>13.4</b> (12.0-14.9)	<b>14.0</b> (12.8-15.1)



Зураг 117. Өлөн үеийн цусны глюкозын өөрчлөлттэй болон ЧШ-тэй хүн амын хувь, насны бүлгээр



Зураг 118. Чихрийн шижингийн тархалт, сумаар


## ГОЛ МЭДЭЭЛЭЛ

1. Дархан-Уул аймгийн эрт ирүүлэг үзлэгт хамрагдсан насанд хүрэгчдийн өлөн үеийн цусны глюкозын дундаж хэмжээ 5.9 ммоль/л байна. Цусны глюкозын дундаж хэмжээнд хүйсийн ялгаа илрээгүй болно.
2. Насанд хүрэгчдийн 16.7% өлөн үеийн цусны глюкозын өөрчлөлттэй, 13.8% цусны глюкозын хэмжээ ихэссэн буюу чихрийн шижинтэй байна. Өлөн үеийн цусны глюкозын өөрчлөлт, чихрийн шижингийн тархалт нь иргэдийн насны бүлгээр ялгаатай, Чихрийн шижингийн тархалт  $\geq 40$  насны иргэдийн дунд харьцангуй өндөр байв.
3. Дархан-Уул аймгийн насанд хүрэгчдийн дундах өлөн үеийн цусны глюкозын өөрчлөлт, чихрийн шижингийн тархалтад хүйсийн ялгаа ажиглагдаагүй болно. Мөн Дархан-Уул аймгийн 20-29 насны залуучуудын дунд өлөн үеийн цусны глюкозын өөрчлөлт илрээгүй байна.
4. Өлөн үеийн цусны глюкозын шинжилгээнд хамрагдсан иргэдийн тоо Дархан сумаас бусад сумдад харьцангуй цөөн байгаа тул чихрийн шижингийн тархалтыг сумаар харьцуулан дүгнэх боломжгүй болно.


## ӨЛӨН ҮЕЙН ЦУСНЫ ЛИПИДЫН ҮНЭЛГЭЭ

Хүснэгт 80. Илүүдэл жин ба таргалалт хүйсээр

Насанд хүрсэн хүн амын дунд (95% ИХ)	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
“Өлөн үеийн цусны холестерин хэмжээ ихэссэн” гэж оношлогдож байсан хүн амын хувь	<b>2.6</b> (2.3-3.0)	<b>3.1</b> (2.5-3.7)	<b>2.3</b> (1.9-2.7)
Цусны нийт холестерин хэмжээ ихэссэн ( $\geq 5.3$ ммоль/л) хүн амын хувь	<b>33.4</b> (31.7-35.2)	<b>33.0</b> (30.2-35.7)	<b>33.7</b> (31.4-36.0)
“Өлөн үеийн цусны триглицеридийн хэмжээ ихэссэн” гэж оношлогдож байсан хүн амын хувь	<b>1.3</b> (1.1-1.5)	<b>1.5</b> (1.1-1.9)	<b>1.2</b> (0.9-1.5)
Цусны триглицеридийн хэмжээ ихэссэн ( $\geq 1.7$ ммоль/л) хүн амын хувь	<b>14.7</b> (13.3-16.0)	<b>20.0</b> (17.7-22.4)	<b>10.9</b> (9.3-12.4)



Зураг 119. Өлөн үеийн цусны липидийн хэмжээ ихэссэн хүн амын хувь, насны бүлгээр



Зураг 120. Өлөн үеийн цусны нийт холестерин агууламж ихэссэн хүн амын хувь, сумаар


### ГОЛ МЭДЭЭЛЭЛ

1. Дархан-Уул аймгийн эрт илрүүлэгт хамрагдсан насанд хүрэгчдийн 2.6% цусны холестерин ихэссэн, харин 1.3% триглицеридийн агууламж ихэссэн гэж оношлогдож байжээ.
2. Насанд хүрэгчдийн 33.4% өлөн үеийн цусны нийт холестерин, 14.7% триглицеридийн агууламж ихэссэн байна. Дархан-Уул аймгийн насанд хүрэгчдийн дундах дислипидемийн тархалтад хүйсийн ялгаа ажиглагдсан бөгөөд цусны триглицеридийн ихсэлт эрэгтэйчүүдийн дунд эмэгтэйчүүдээс 1.9 дахин өндөр байв.
3. Өлөн үеийн цусны холестерин, триглицеридийн ихсэлтийн тархалт иргэдийн настай шууд хамааралтайгаар нэмэгдэх хандлага илэрсэн ба Дархан-Уул аймгийн 40-49 насны 3 хүн тутмын 1,  $\geq 50$  насны 2 тутмын 1 нь цусны нийт холестерин ихсэлттэй байна.
4. Өлөн үеийн цусны липидийн шинжилгээнд хамрагдсан иргэдийн тоо харилцан адилгүй, Дархан сумаас бусад сумын насанд хүрэгчдийн тоо цөөн байгаа тул дислипидемийн тархалтыг сумаар харьцуулан дүгнэх боломжгүй болно.

## ХУВЬ ХҮНИЙ ЭРСДЭЛИЙН ҮНЭЛГЭЭ

Хүснэгт 81. Хувь хүний эрсдэлийн үнэлгээ хүйсээр

Насанд хүрсэн хүн амын дунд (95% ИХ)	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
Гэр бүлийн гишүүн чихрийн шижингээр өвчилж байсан <i>Өвөө, эмээ, нагац, авга Эцэг, эх, ах дүү, өөрийн хүүхэд</i>	<b>18.7</b> (17.3-20.1)	<b>15.1</b> (13.2-17.1)	<b>21.1</b> (19.2-22.9)
Жирэмсний чихрийн шижингээр өвчилж байсан	-	-	<b>11.6</b> (10.7-12.4)
Хавдраар өвчилж байсан түүх (гэр бүлийн гишүүн)	<b>14.8</b> (14.0-15.5)	<b>12.0</b> (10.8-13.1)	<b>16.5</b> (15.4-17.5)
Артерийн даралт бууруулах эм тогтмол хэрэглэдэг	<b>16.4</b> (15.6-17.2)	<b>12.4</b> (11.2-13.6)	<b>18.7</b> (17.6-19.7)
Цусны өөх тос бууруулах эм хэрэглэж байгаа	<b>17.5</b> (16.7-18.3)	<b>16.2</b> (14.9-17.5)	<b>18.3</b> (17.2-19.4)



Зураг 121. “Гэр бүлийн хэн нэгэн гишүүн нь чихрийн шижин, хавдраар өвчилж байсан” гэж хариулсан насанд хүрэгчдийн хувь, насны бүлгээр


### ГОЛ МЭДЭЭЛЭЛ

1. Эрт илрүүлэг үзлэгт хамрагдсан Дархан-Уул аймгийн насанд хүрэгчдийн 18.7% гэр бүлийн хэн нэгэн гишүүн “чихрийн шижингээр өвчилсөн”, 14.8% хавдраар өвчилсөн гэж хариулсан байна. Нийт эмэгтэйчүүдийн 11.6% жирэмсний чихрийн шижин оношлогдож байжээ.
2. Урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдсан Дархан-Уул аймгийн иргэдийн 16.4% артерийн даралт бууруулах эмийг тогтмол хэрэглэдэг, харин 17.5% цусны өөх тос бууруулах эмийг одоо хэрэглэж байв.
3. Гэр бүлийн хэн нэгэн гишүүн чихрийн шижингээр өвчилсөн гэж хариулсан насанд хүрэгчдийн хувь тэдний настай урвуу хамааралтай буюу нас ахих тутам буурах хандлага ажиглагдаж байв. Тодруулбал, 18–29 насны залуучуудын дунд уг өгүүлэмж хамгийн их, 50 ба түүнээс дээш насны иргэдийн дунд хамгийн бага байв.
4. Гэр бүлийн хэн нэгэн гишүүн хавдраар өвчилсөн гэж хариулсан насанд хүрэгчдийн хувь тэдний настай шууд хамааралтай ихсэх зүй тогтол ажиглагдсан бөгөөд урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдсан Дархан-Уул аймгийн 40–59 насны хүн амын дунд харьцангуй өндөр байна.

**ДОРНОД АЙМГИЙН НАСАНД ХҮРЭГЧДИЙН ДУНДАХ  
ХАЛДВАРТ БУС ӨВЧНИЙ ЭРСДЭЛТ ХҮЧИН ЗҮЙЛСИЙН  
ТАРХАЛТ**

**ТАНИЛЦУУЛГА**

Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/248 дугаар тушаалыг хэрэгжүүлэх арга хэмжээний хүрээнд 2022 оны 5 дугаар сарын 3-ны өдрөөс 2023 оны 5 дугаар сарын 1 хүртэлх хугацаанд эрт илрүүлэг, урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдсан Дорнод аймгийн 5,822 насанд хүрэгчдийн мэдээллийг нэгтгэн, тэдний дунд түгээмэл тохиолдож буй халдварт бус өвчин (ХБӨ)-ий эрсдэлт хүчин зүйлсийн тархалтын байдалд дүн шинжилгээ хийв (Зураг 122).



Зураг 122. Эрт илрүүлэг үзлэгт хамрагдсан насанд хүрэгчдийн тоо, сумын дүнгээр

Эрт илрүүлэг, урьдчилан сэргийлэх үзлэгт Дорнод аймгийн 18–92 насны нийт 5,822 хүн хамрагдсан бөгөөд тэдний 41.4% (n=2,412) эрэгтэйчүүд, 58.6% (n=3,410) эмэгтэйчүүд байв (Хүснэгт 82).

Хүснэгт 82. Эрт илрүүлэгт хамрагдсан насанд хүрэгчид, нас бүлэг ба хүйсээр

Насны бүлэг, жилээр	N	Эрэгтэй			Эмэгтэй		
		Тоо	Хувь	95% ИХ	Тоо	Хувь	95% ИХ
≤ 19	428	321	75.0	70.9-79.1	107	25.0	20.9-29.1
20 – 29	1148	600	52.3	49.4-55.2	548	47.7	44.8-50.6
30 – 39	1149	444	38.6	35.8-41.5	705	61.4	58.5-64.2
40 – 49	1129	379	33.6	30.8-36.3	750	66.4	63.7-69.2
50 – 59	992	339	34.2	31.2-37.1	653	65.8	62.9-68.8
60 – 69	768	255	33.2	29.9-36.5	513	66.8	63.5-70.1
≥ 70	208	74	35.6	29.0-42.1	134	64.4	57.9-71.0
<b>Нийт</b>	<b>5,822</b>	<b>2,412</b>	<b>41.4</b>	<b>40.2-42.7</b>	<b>3,410</b>	<b>58.6</b>	<b>57.3-59.8</b>

Урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдсан Дорнод аймгийн насанд хүрэгчдийн дундаж нас 42.0 (95%ИХ 41.6-42.4) жил байна. Эрт илрүүлэг үзлэгт хамрагдсан эмэгтэйчүүдийн дундаж нас эрэгтэйчүүдийн дундаж үзүүлэлтээс 6.1 жилээр илүү байна (дундаж нас: эр 38.4 жил, эм 44.5 жил).




## ХБӨ-ИЙ НИЙТЛЭГ ЭРСДЭЛТ ХҮЧИН ЗҮЙЛС ХАВСРАН ИЛЭРСЭН ХҮН АМ

Хүснэгт 83. ХБӨ-ий нийтлэг эрсдэлт хүчин зүйлс хавсран илэрсэн хүн ам хүйсээр

Хүн амын дунд (95% ИХ)	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
<b>ХБӨ-ий нийтлэг эрсдэлт хүчин зүйлс</b>			
<ul style="list-style-type: none"> <li>Өдөр бүр тамхи татдаг</li> <li>Өдөрт 5 нэгжээс бага хэмжээгээр жимс, ногоо хэрэглэдэг</li> <li>Хөдөлгөөний хомсдолтой</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Илүүдэл жинтэй (БЖИ <math>\geq 25</math> кг/м<sup>2</sup>)</li> <li>Артерийн даралт ихсэлттэй (САД <math>\geq 140</math> ба/эсвэл ДАД <math>\geq 90</math> мм МУБ эсвэл даралт бууруулах эм хэрэглэж байгаа)*</li> </ul>		
Нийтлэг эрсдэлт хүчин зүйлс илрээгүй хүн амын хувь	<b>4.2</b> (3.7 – 4.8)	<b>3.2</b> (2.6 – 4.0)	<b>5.0</b> (4.2 – 5.8)
Нийтлэг эрсдэлт хүчин зүйлсээс 1-2 эрсдэл хавсран илэрсэн хүн амын хувь	<b>57.2</b> (55.9 – 58.6)	<b>53.6</b> (51.5 – 55.6)	<b>60.0</b> (58.2 – 61.7)
Нийтлэг эрсдэлт хүчин зүйлсээс 3 ба түүнээс олон эрсдэл хавсран илэрсэн хүн амын хувь	<b>38.5</b> (37.2 – 39.9)	<b>43.2</b> (41.1 – 45.3)	<b>35.1</b> (33.4 – 36.8)

\*ДЭМБ-ын үзүүлэлтийг баримтлав.



Зураг 123. Нийтлэг эрсдэлт хүчин зүйлсээс 3 ба түүнээс олон эрсдэл хавсран илэрсэн хүн амын хувь, хүйс, насны ангиллаар



Зураг 124. ХБӨ-өөр өвчлөх өндөр эрсдэлтэй хүн амын хувь, сумаар


### ГОЛ МЭДЭЭЛЭЛ

1. Эрт илрүүлэг үзлэгт хамрагдсан Дорнод аймгийн насанд хүрсэн хүн амын ХБӨ-өөр өвчлөх эрсдэлгүй хүн амын тархалт дөнгөж 4.2% байна.
2. Насанд хүрсэн хүн амын 38.5% нь нийтлэг эрсдэлт хүчин зүйлсээс 3 ба түүнээс олон эрсдэл хавсран илэрсэн байна.
3. ХБӨ-өөр өвчлөх өндөр эрсдэлтэй хүн амын тархалт эрэгтэйчүүдийн дунд эмэгтэйчүүдээс 1.5 дахин их байна. Энэ нь эрэгтэйчүүдийн дундаж наслалт болон тэдний амьдралын чанарт сөргөөр нөлөөлөх магадлалтай.
4. Нас ахих тусам эрсдэлт хүчин зүйл хавсран илэрсэн хүн амын тоо өсөж байна.
5. Халх гол, Матад, Чойбалсан, Баян-уул, Цагаан-овоо, Булган, Гурванзагал, Дашбалбар, Баянтүмэн, Сэргэлэн сумуудад Нийтлэг эрсдэлт хүчин зүйлсээс 3 ба түүнээс олон эрсдэл хавсран илэрсэн хүн амын хувь аймгийн дундаж (63.2%-аас өндөр байна.

## ТАМХИНЫ ХЭРЭГЛЭЭ

Хүснэгт 84. Тамхины хэрэглээ хүйсээр

Насанд хүрсэн хүн амын дунд (95% ИХ)	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
Тамхи татдаг хүн амын хувь	<b>20.1</b> (19.0 – 21.1)	<b>45.3</b> (43.3 – 47.3)	<b>2.2</b> (1.7 – 2.7)
Өдөр бүр тамхи татдаг хүн амын хувь	<b>12.6</b> (11.8 – 13.5)	<b>29.1</b> (27.3 – 30.9)	<b>1.0</b> (0.6 – 1.3)
<i>Өдөр бүр тамхи татдаг хүн амын дунд:</i>			
Тамхи татаж эхэлсэн дундаж нас (жилээр)	<b>18.9</b> (18.5 – 19.2)	<b>18.5</b> (18.2 – 18.8)	<b>26.8</b> (24.1 – 29.4)



Зураг 125. Тамхи татдаг хүн ам, хүйс ба насны ангиллаар



Зураг 126. Тамхи татдаг хүн амын тархалт, сумаар


## ГОЛ МЭДЭЭЛЭЛ

1. Эрт илрүүлэг үзлэгт хамрагдсан Дорнод аймгийн насанд хүрсэн хүн амын 5 хүн тутмын 1 нь (20.1%) тамхи татдаг бөгөөд эрэгтэйчүүдийн дунд тамхины хэрэглээ эмэгтэйчүүдээс 20.5 дахин их байна.
2. Өдөр бүр тамхи татдаг хүн амын хувь нийт тамхи татдаг хүмүүсийн 62.6%-ийг эзэлж байна.
3. Тамхи татаж эхэлсэн нас дунджаар 18.9 байна.
4. Бүх насны ангилалд тамхины хэрэглээ жигд өндөр байна.
5. Халх гол, Матад, Гурванзагал, Булган, Дашбалбар, Хөлөнбуйр, Баянтүмэн, Баян-уул, Сэргэлэн сумуудад тамхи татдаг хүн амын хувь аймгийн дундаж (20.1%)-аас өндөр байна.


## АРХИ, СОГТУУРУУЛАХ УНДААНЫ ХЭРЭГЛЭЭ

Хүснэгт 85. Архи, согтууруулах ундааны хэрэглээ хүйсээр

Насанд хүрсэн хүн амын дунд (95% ИХ)	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
Сүүлийн 1 сард стандарт уултаас илүү архи, согтууруулах ундаа хэрэглэсэн хүн амын хувь	<b>7.8</b> (7.1 – 8.5)	<b>16.6</b> (15.0 – 18.2)	<b>2.0</b> (1.5 – 2.5)



Зураг 127. Сүүлийн 1 сард стандарт уултаас илүү архи, согтууруулах ундаа хэрэглэсэн хүн ам, хүйс ба насны ангиллаар



Зураг 128. Сүүлийн 1 сард стандарт уултаас илүү архи, согтууруулах ундаа хэрэглэсэн хүн амын хувь, сумаар


### ГОЛ МЭДЭЭЛЭЛ

1. Эрт илрүүлэг үзлэгт хамрагдсан Дорнод аймгийн насанд хүрсэн хүн амын сүүлийн 1 сард стандарт уултаас илүү архи, согтууруулах ундаа хэрэглэсэн хүн амын хувь 7.8% байх бөгөөд эрэгтэйчүүдийн дунд согтууруулах ундааны хэрэглээ эмэгтэйчүүдээс 8.3 дахин их байна.
2. Хөдөлмөрийн насны (30-39 нас) хүмүүсийн архины хэрэглээ бусад насны бүлэгтэй харьцуулахад их байна.
3. Чулуунхороот, Булган, Чойбалсан, Баянтүмэн, Гурванзагал, Сэргэлэн, Цагаан-овоо сумуудад Сүүлийн 1 сард стандарт уултаас илүү архи, согтууруулах ундаа хэрэглэсэн хүн амын хувь аймгийн дундаж (7.8%)-аас өндөр байна.


## ХӨДӨЛГӨӨН

Хүснэгт 86. Хөдөлгөөн хүйсээр

Насанд хүрсэн хүн амын дунд (95% ИХ)	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
7 хоногийн 5-аас доошгүй өдөр 30 минутаас дээш дасгал хөдөлгөөн хийдэггүй, эсвэл 10000 алхдаггүй хүн амын хувь	<b>61.4</b> (60.1 – 62.7)	<b>62.1</b> (60.2 – 64.1)	<b>60.9</b> (59.2 – 62.6)



Зураг 129. 7 хоногийн 5-аас доошгүй өдөр 30 минутаас дээш дасгал хөдөлгөөн хийдэггүй, эсвэл 10000 алхдаггүй хүн амын тархалт, насны бүлгээр ба хүйсээр



Зураг 130. 7 хоногийн 5-аас доошгүй өдөр 30 минутаас дээш дасгал хөдөлгөөн хийдэггүй, эсвэл 10000 алхдаггүй хүн амын тархалт, сумаар


### ГОЛ МЭДЭЭЛЭЛ

1. Эрт илрүүлэг үзлэгт хамрагдсан Дорнод аймгийн “Урьдчилан сэргийлэх эрт илрүүлэгт” хамрагдсан нийт хүн амын 61.4% нь 7 хоногийн 5-аас доошгүй өдөр 30 минутаас дээш дасгал хөдөлгөөн хийдэггүй, эсвэл 10000 алхдаггүй байна.
2. Хүйсээр авч үзвэл эрэгтэйчүүд (62.1%), эмэгтэйчүүдээс (60.9%) 1.2%-иар их, аль ч насны ангилалд харилцан адилгүй хөдөлгөөний идэвхгүй байдал ажиглагдав.
3. Хэрлэн сумаас бусад бүх сумуудад 7 хоногийн 5-аас доошгүй өдөр 30 минутаас дээш дасгал хөдөлгөөн хийдэггүй, эсвэл 10000 алхдаггүй хүн амын хувь аймгийн дундаж (61.4%)-аас өндөр байна.

## ЖИМС, ЖИМСГЭНЭ, НОГООНЫ ХЭРЭГЛЭЭ

Хүснэгт 87. Жимс, жимсгэнэ, ногооны хэрэглээ хүйсээр

Насанд хүрсэн хүн амын дунд (95% ИХ)	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
Зохистой хэрэглээтэй хүн амын хувь (хоногт $\geq 5$ нэгж буюу 400 г)	<b>42.4</b> (41.1-43.7)	<b>37.7</b> (35.7-39.7)	<b>45.8</b> (44.0-47.5)
Хангалтгүй хэрэглээтэй хүн амын хувь (хоногт $< 5$ нэгж /400 г)	<b>38.5</b> (37.2-39.8)	<b>39.4</b> (3.4-41.4)	<b>37.9</b> (36.2-39.6)
Жимс, ногоо бага хэрэглэдэг ХБӨ-ний эрсдэлтэй хүн амын хувь (жимс, ногоог өдөр бүр хэрэглэдэггүй эсвэл хоногт 400 граммаас бага хэрэглэдэг)	<b>57.6</b> (56.3-58.9)	<b>62.3</b> (60.3-64.3)	<b>54.3</b> (52.5-56.0)



Зураг 131. Жимс, жимсгэнэ, хүнсний ногоо бага хэрэглэдэг насанд хүрэгчдийн хувь, насны бүлгээр



Зураг 132. Жимс, жимсгэнэ, ногооны зохистой хэрэглээтэй насанд хүрэгчид, сумаар


### ГОЛ МЭДЭЭЛЭЛ

1. Дорнод аймгийн насанд хүрэгчдийн 42.4% жимс, жимсгэнэ, хүнсний ногооны зохистой хэрэглээтэй буюу хоногт  $\geq 400$  г хэмжээгээр хэрэглэж байна. Жимс, жимсгэнэ, хүнсний ногооны зохистой хэрэглээтэй иргэдийн хувь байршлаар ялгаатай, Дашбалбар, Халхгол суманд хамгийн бага, харин Чулуунхороот, Баяндун, Хөлөнбуйр сумдад харьцангуй өндөр байв.
2. Эрт илрүүлэг үзлэгт хамрагдсан Дорнод аймгийн 18–89 насны иргэдийн 57.6% өдөр бүр жимс, ногоо хэрэглэдэггүй эсвэл хоногт 400 граммаас бага хэмжээгээр хэрэглэж байна. Тодруулбал, насанд хүрсэн 10 хүн тутмын 8 нь “Эрүүл хооллолтын ГЭР зөвлөмж”-д заасан хэмжээ (Хоногт  $\geq 400$ г)-ээр жимс, жимсгэнэ, хүнсний ногоо хэрэглэдэггүй буюу ХБӨ-өөр өвчлөх эрсдэлтэй байна.
3. Жимс, жимсгэнэ, хүнсний ногоо бага хэрэглэдэг буюу ХБӨ-өөр өвчлөх эрсдэлтэй насанд хүрэгчдийн тархалт эрэгтэйчүүд ( $p < 0.0001$ ), 18–29 насны залуучууд болон  $\geq 50$  насны иргэдийн дунд харьцангуй өндөр байна. Харин Дорнод аймгийн 30–49 насны иргэдийн дунд тус эрсдэлийн тархалт харьцангуй бага байв.


## ИЛҮҮДЭЛ ЖИН БА ТАРГАЛАЛТ

Хүснэгт 88. Илүүдэл жин ба таргалалт хүйсээр

Насанд хүрсэн хүн амын дунд (95% ИХ)	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
Биеийн жингийн индекс (БЖИ)-ийн дундаж хэмжээ (кг/м <sup>2</sup> )	<b>26.0</b> (25.9-26.1)	<b>25.4</b> (25.2-25.6)	<b>26.5</b> (26.3-26.7)
Илүүдэл жин ба таргалалттай хүн амын хувь (БЖИ ≥ 25 кг/м <sup>2</sup> )	<b>53.4</b> (52.1-54.8)	<b>47.9</b> (45.9-50.0)	<b>57.5</b> (55.8-59.3)
Таргалалттай хүн амын хувь (БЖИ ≥ 30 кг/м <sup>2</sup> )	<b>19.3</b> (18.3-20.4)	<b>15.5</b> (14.0-17.0)	<b>22.2</b> (20.7-23.6)
Бүсэлхийн тойргийн дундаж хэмжээ (см)	-	<b>88.5</b> (88.0-89.1)	<b>86.4</b> (85.9-86.9)
Төвийн таргалалттай хүн амын хувь (Бүсэлхийн тойрог: эр ≥ 90 см, эм ≥ 80 см)	<b>58.1</b> (56.8-59.4)	<b>44.4</b> (42.4-46.5)	<b>68.2</b> (66.6-69.9)



Зураг 133. Илүүдэл жин ба таргалалтын тархалт, насны бүлгээр



Зураг 134. Таргалалтын тархалт (БЖИ≥30 кг/м<sup>2</sup>), сумаар


### ГОЛ МЭДЭЭЛЭЛ

1. Дорнод аймгийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдсан насанд хүрэгчдийн БЖИ-ийн дундаж хэмжээ 26.0 кг/м<sup>2</sup> байгаа нь ДЭМБ-аас зөвлөсөн хэвийн хязгаараас хэтэрсэн байна. Иргэдийн БЖИ-ийн дундаж хэмжээ нь хүйсээр ялгаатай, эмэгтэйчүүдэд өндөр байв ( $p < 0.0001$ ).
2. Насанд хүрэгчдийн 53.4% илүүдэл жин ба таргалалттай, 19.3% тарган байна. Илүүдэл жин, таргалалтын тархалт эмэгтэйчүүдийн дунд статистик ач холбогдол бүхий өндөр ( $p < 0.0001$ ), аль ч хүйсийн насанд хүрэгчдийн дунд нас ахих тутам нэмэгдэх хандлага ажиглагдсан болно. Дорнод аймгийн ≥40 насны 3 хүн тутмын 2 нь илүүдэл жин ба таргалалттай байв. Мөн ≥40 насны 4 хүн тутмын 1 нь тарган байна. Таргалалтын тархалт Цагаан-Овоо, Чойбалсан, Матад сумын иргэдийн дунд харьцангуй өндөр, Дашбалбар, Сэргэлэн суманд хамгийн бага байв.
3. Дорнод аймгийн эрт илрүүлэг үзлэгт хамрагдсан насанд хүрэгчдийн 58.1% төвийн таргалалттай, төвийн таргалалтын тархалт эмэгтэйчүүдийн дунд эрэгтэйчүүдээс 1.5 дахин өндөр байна ( $p < 0.0001$ ).


## АРТЕРИЙН ГИПЕРТЕНЗИ

Хүснэгт 89. Артерийн гипертензи хүйсээр

Насанд хүрсэн хүн амын дунд (95% ИХ)	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
Систолын артерийн даралт (САД)-ын дундаж хэмжээ, мм МУБ (даралт бууруулах эм хэрэглэж байгаа хүн амыг оролцуулсан)	<b>118.5</b> (118.1-118.9)	<b>119.7</b> (119.1-120.3)	<b>117.6</b> (117.1-118.2)
Диастолын артерийн даралт (ДАД)-ын дундаж хэмжээ, мм МУБ (даралт бууруулах эм хэрэглэж байгаа хүн амыг оролцуулсан)	<b>76.8</b> (76.5-77.0)	<b>77.5</b> (77.1-77.9)	<b>76.2</b> (75.9-76.6)
Артерийн даралт ихсэлттэй хүн амын хувь (САД = 120-129 мм МУБ ба/эсвэл ДАД ≤ 80 мм МУБ)	<b>43.0</b> (41.7-44.4)	<b>47.9</b> (45.8-49.9)	<b>39.5</b> (37.8-41.2)
Артерийн гипертензитай хүн амын хувь (САД ≥ 130 ба/эсвэл ДАД ≥ 81 мм МУБ эсвэл даралт бууруулах эм хэрэглэдэг хүн амын оролцуулсан)	<b>19.7</b> (18.6-20.7)	<b>19.4</b> (17.7-21.0)	<b>19.9</b> (18.5-21.3)



Зураг 135. Артерийн гипертензийн тархалт, насны бүлгээр



Зураг 136. Артерийн гипертензийн тархалт, сумаар


### ГОЛ МЭДЭЭЛЭЛ

1. Эрт илрүүлэг үзлэгт хамрагдсан Дорнод аймгийн насанд хүрэгчдийн САД-ын дундаж хэмжээ 118.5 мм МУБ, ДАД-ын дундаж үзүүлэлт 76.8 мм МУБ байна.
2. Насанд хүрэгчдийн 43.0% артерийн даралт ихсэлттэй буюу САД нь 120–129 мм ба/эсвэл ДАД ≤ 80 мм МУБ байв. Артерийн даралт ихсэлтийн тархалт эрэгтэйчүүдийн дунд эмэгтэйчүүдийн дундаж үзүүлэлтээс 8.1 хувиар илүү байна.
3. Урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдсан Дорнод аймгийн насанд хүрэгчдийн 19.7% артерийн гипертензи (АГ)-тэй буюу САД ≥ 130 мм МУБ ба ДАД ≥ 81 мм МУБ-аас дээш байгаа нь анхаарал татаж байна. АГ-ийн тархалтад хүйсийн ялгаа илээгүй болно.
4. АГ-ийн тархалт иргэдийн настай шууд хамааралтайгаар нэмэгдэх зүй тогтол ажиглагдсан бөгөөд 50–59 насны 4 хүн тутмын 1, 60–69 насны 3 хүн тутмын 1-ээс илүү, ≥ 70 насны 2 хүн тутмын 1 орчим нь тус тус АГ-тэй байна.
5. АГ-ийн тархалтыг сумаар харьцуулан үнэлэхэд Баяндун, Дашбалбар сумын иргэдийн дунд бага, харин Чойбалсан, Цагаан-Овоо сумдад харьцангуй өндөр байв.

## ЧИХРИЙН ШИЖИН

Хүснэгт 90. Чихрийн шижин хүйсээр

Насанд хүрсэн хүн амын дунд (95% ИХ)	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
Өлөн үеийн цусны глюкозын дундаж хэмжээ (ммоль/л), глюкоз бууруулах эм хэрэглэж буй хүн амыг оруулаад	<b>4.9</b> (4.9-5.0)	<b>5.2</b> (5.1-5.2)	<b>4.8</b> (4.8-4.9)
Өлөн үеийн цусны глюкозын өөрчлөлттэй хүн амын хувь (Ийлдсийн глюкозын хэмжээ $\geq 6.1$ ммол/л ба $< 7.0$ ммол/л)	<b>2.4</b> (2.0-2.9)	<b>3.3</b> (2.4-4.2)	<b>2.0</b> (1.4-2.5)
Өлөн үеийн цусны глюкозын хэмжээ ихэссэн болон глюкоз бууруулах эм хэрэглэж буй хүн амын хувь (Ийлдсийн глюкозын хэмжээ $\geq 7.0$ ммол/л)	<b>4.2</b> (3.6-4.8)	<b>5.9</b> (4.7-7.2)	<b>3.3</b> (2.6-3.9)



Зураг 137. Өлөн үеийн цусны глюкозын өөрчлөлттэй болон ЧШ-тэй хүн амын хувь, насны бүлгээр



Зураг 138. Чихрийн шижингийн тархалт, сумаар

## ГОЛ МЭДЭЭЛЭЛ


1. Дорнод аймгийн эрт ирүүлэг үзлэгт хамрагдсан насанд хүрэгчдийн өлөн үеийн цусны глюкозын дундаж хэмжээ 4.9 ммоль/л байв. Эрэгтэйчүүдийн цусны глюкозын дундаж хэмжээ нь эмэгтэйчүүдийн үзүүлэлтээс статистик ач холбогдол бүхий өндөр байна.
2. Насанд хүрэгчдийн 2.4% өлөн үеийн цусны глюкозын өөрчлөлттэй, 4.2% цусны глюкозын хэмжээ ихэссэн буюу чихрийн шижинтэй байв. Өлөн үеийн цусны глюкозын өөрчлөлт, чихрийн шижингийн тархалт эрэгтэйчүүдийн дунд харьцангуй өндөр байна ( $p < 0.0001$ ).
3. Өлөн үеийн цусны глюкозын өөрчлөлт, чихрийн шижингийн өвчлөл иргэдийн насны бүлгээр ялгаатай байна. Дорнод аймгийн 18-29 насны залуучуудын дунд өлөн үеийн цусны глюкозын өөрчлөлт, чихрийн шижингийн тохиолдол илрээгүй болно. Чихрийн шижингийн тохиолдол 18-29 насны залуучууд, 60-69 насны иргэдийн дунд 30-49 насныхны үзүүлэлтээс харьцангуй өндөр байгаа нь анхаарал татаж байв.
4. Цусны глюкозын шинжилгээнд хамрагдсан иргэдийн тоо харилцан адилгүй, зарим сумдад хэт цөөн байгаа тул Дорнод аймгийн насанд хүрэгчдийн дундах чихрийн шижингийн тархалтыг сумаар харьцуулан үнэлэх боломжгүй байна.




## ӨЛӨН ҮЕИЙН ЦУСНЫ ЛИПИДЫН ҮНЭЛГЭЭ

Хүснэгт 91. Өлөн үеийн цусны липидын үнэлгээ хүйсээр

Насанд хүрсэн хүн амын дунд (95% ИХ)	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
“Өлөн үеийн цусны холестерин хэмжээ ихэссэн” гэж оношлогдож байсан хүн амын хувь	<b>1.5</b> (1.2-1.8)	<b>1.6</b> (1.1-2.1)	<b>1.4</b> (1.0-1.8)
Цусны нийт холестерин хэмжээ ихэссэн ( $\geq 5.3$ ммоль/л) хүн амын хувь	<b>22.5</b> (19.2-25.8)	<b>20.2</b> (15.6-24.8)	<b>24.6</b> (19.8-29.4)
“Өлөн үеийн цусны триглицеридийн хэмжээ ихэссэн” гэж оношлогдож байсан хүн амын хувь	<b>1.3</b> (1.0-1.6)	<b>1.8</b> (1.3-2.4)	<b>0.9</b> (0.6-1.2)
Цусны триглицеридийн хэмжээ ихэссэн ( $\geq 1.7$ ммоль/л) хүн амын хувь	<b>9.1</b> (6.8-11.4)	<b>10.3</b> (6.8-13.9)	<b>7.9</b> (4.9-10.9)



Зураг 139. Өлөн үеийн цусны липидын хэмжээ ихэссэн хүн амын хувь, насны бүлгээр



Зураг 140. Өлөн үеийн цусны нийт холестерин агууламж ихэссэн хүн амын хувь, сумаар


### ГОЛ МЭДЭЭЛЭЛ

1. Дорнод аймгийн эрт илрүүлэгт хамрагдсан насанд хүрэгчдийн 1.5% цусны холестерин ихэссэн, харин 1.3% триглицеридын агууламж ихэссэн гэж оношлогдож байжээ.
2. Насанд хүрэгчдийн 22.5% өлөн үеийн цусны нийт холестерин, 9.1% триглицеридын агууламж ихэссэн байна. Дислипидемийн тархалтыг хүйсээр харьцуулан үнэлэхэд цусны триглицеридын ихсэлт нь эрэгтэйчүүдийн дунд эмэгтэйчүүдээс 2.4 хувиар, харин цусны нийт холестерин ихсэлт эмэгтэйчүүдэд 4.2 хувиар тус тус илүү байв.
3. Өлөн үеийн цусны нийт холестерин ихсэлтийн тархалт иргэдийн настай шууд хамааралтайгаар нэмэгдэх хандлага илэрсэн ба Дорнод аймгийн 40–49 насны 4 хүн тутмын 1, 50 – 59 насны 2 хүн тутмын 1,  $\geq 60$  насны 3 хүн тутмын 1 нь тус тус цусны нийт холестерин ихсэлттэй буюу судасны хатуурал үүсэх эрсдэлтэй байна. Цусны триглицеридын ихсэлт 50–59 насны иргэдийн дунд харьцангуй өндөр байв.
4. Өлөн үеийн цусны липидын шинжилгээнд хамрагдсан иргэдийн тоо харилцан адилгүй, Хэрлэн сумаас бусад орон нутагт хэт цөөн байгаа тул нийт холестерин ихсэлтийг сумаар харьцуулан дүгнэх боломжгүй байна.

## ХУВЬ ХҮНИЙ ЭРСДЭЛИЙН ҮНЭЛГЭЭ

Хүснэгт 92. Хувь хүний эрсдэлийн үнэлгээ хүйсээр

Насанд хүрсэн хүн амын дунд (95% ИХ)	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
Гэр бүлийн гишүүн чихрийн шижингээр өвчилж байсан <i>Өвөө, эмээ, нагац, авга Эцэг, эх, ах дүү, өөрийн хүүхэд</i>	<b>33.4</b> (30.6-36.2)	<b>26.8</b> (22.7-31.0)	<b>37.9</b> (34.1-41.7)
Жирэмсний чихрийн шижингээр өвчилж байсан	-	-	<b>11.0</b> (10.0-12.1)
Хавдраар өвчилж байсан түүх (гэр бүлийн гишүүн)	<b>14.7</b> (13.8-15.6)	<b>11.2</b> (9.9-12.5)	<b>17.2</b> (15.9-18.5)
Артерийн даралт бууруулах эм тогтмол хэрэглэдэг	<b>16.1</b> (15.1-17.1)	<b>11.8</b> (10.5-13.2)	<b>18.9</b> (17.6-20.2)
Цусны өөх тос бууруулах эм хэрэглэж байгаа	<b>11.9</b> (11.0-12.7)	<b>8.6</b> (7.5-9.8)	<b>14.2</b> (13.0-15.4)



Зураг 141. “Гэр бүлийн хэн нэгэн гишүүн нь чихрийн шижин, хавдраар өвчилж байсан” гэж хариулсан насанд хүрэгчдийн хувь, насны бүлгээр


### ГОЛ МЭДЭЭЛЭЛ

1. Эрт илрүүлэг үзлэгт хамрагдсан Дорнод аймгийн насанд хүрэгчдийн 33.4% гэр бүлийн хэн нэгэн гишүүн “чихрийн шижингээр өвчилсөн”, 14.7% хавдраар өвчилсөн гэж хариулсан байна. Нийт эмэгтэйчүүдийн 11.0% жирэмсний чихрийн шижин оношлогдож байжээ.
2. Урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдсан Дорнод аймгийн насанд хүрэгчдийн 16.1% артерийн даралт бууруулах эмийг тогтмол хэрэглэдэг, харин 11.9% цусны өөх тос бууруулах эмийг одоо хэрэглэж байв. Эрт илрүүлэгт хамрагдсан эмэгтэйчүүдийн дунд артерийн даралт бууруулах эмийн хэрэглээ 1.6 дахин, харин цусны өөх тос бууруулах эмийн хэрэглээ 1.7 дахин өндөр байна ( $p < 0.0001$ ).
3. Гэр бүлийн хэн нэгэн гишүүн чихрийн шижингээр өвчилсөн гэж хариулсан насанд хүрэгчдийн хувь 30–59 насныхны дунд хамгийн өндөр,  $\geq 50$  насны иргэдийн настай урвуу хамааралтай буюу нас ахих тутам буурах хандлагатай байв.
4. Гэр бүлийн хэн нэгэн гишүүн хавдраар өвчилсөн гэж хариулсан иргэдийн хувь насны бүлгээр ялгаатай, 18–59 насны иргэдийн дунд нас ахих тутам нэмэгдэх хандлага ажиглагдсан болно ( $p < 0.0001$ ).

**ДОРНОГОВЬ АЙМГИЙН НАСАНД ХҮРЭГЧДИЙН  
ДУНДАХ ХАЛДВАРТ БУС ӨВЧНИЙ ЭРСДЭЛТ ХҮЧИН ЗҮЙЛСИЙН  
ТАРХАЛТ**

**ТАНИЛЦУУЛГА**

Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/248 дугаар тушаалыг хэрэгжүүлэх арга хэмжээний хүрээнд 2022 оны 5 дугаар сарын 3-ны өдрөөс 2023 оны 5 дугаар сарын 1 хүртэлх хугацаанд эрт илрүүлэг, урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдсан Дорноговь аймгийн 6,581 насанд хүрэгчдийн мэдээллийг нэгтгэн, тэдний дунд түгээмэл тохиолдож буй халдварт бус өвчин (ХБӨ)-ий эрсдэлт хүчин зүйлсийн тархалтын байдалд дүн шинжилгээ хийв (Зураг 142).



Зураг 142. Эрт илрүүлэг үзлэгт хамрагдсан насанд хүрэгчдийн тоо, сумын дүнгээр

Эрт илрүүлэг, урьдчилан сэргийлэх үзлэгт Дорноговь аймгийн 18–90 насны нийт 6,581 хүн хамрагдсан бөгөөд тэдний 39.6% (n=2,604) эрэгтэйчүүд, 60.4% (n=3,977) эмэгтэйчүүд байв (Хүснэгт 93).

Хүснэгт 93. Эрт илрүүлэгт хамрагдсан насанд хүрэгчид, нас бүлэг ба хүйсээр

Насны бүлэг, жилээр	N	Эрэгтэй			Эмэгтэй		
		Тоо	Хувь	95% ИХ	Тоо	Хувь	95% ИХ
≤ 19	268	150	56.0	50.0-62.0	118	44.0	38.1-50.0
20 – 29	1392	683	49.1	46.4-51.7	709	50.9	48.3-53.6
30 – 39	1442	557	38.6	36.1-41.1	885	61.4	58.9-63.9
40 – 49	1372	477	34.8	32.2-37.3	895	65.2	62.7-67.8
50 – 59	1193	391	32.8	30.1-35.4	802	67.2	64.6-69.9
60 – 69	741	281	37.9	34.4-41.4	460	62.1	58.6-65.6
≥ 70	173	65	37.6	30.3-44.9	108	62.4	55.1-69.7
<b>Нийт</b>	<b>6,581</b>	<b>2604</b>	<b>39.6</b>	<b>38.4-40.8</b>	<b>3977</b>	<b>60.4</b>	<b>59.3-61.6</b>


Урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдсан Дорноговь аймгийн насанд хүрэгчдийн дундаж нас 41.8 (95%ИХ 41.5-42.2) жил байна. Эрт илрүүлэг үзлэгт хамрагдсан эмэгтэйчүүдийн дундаж нас эрэгтэйчүүдээс 3.1 жилээр илүү байна (дундаж нас: эр 39.9 жил, эм 43.1 жил).

## ХБӨ-ий Нийтлэг Эрсдэлт Хүчин Зүйлс Хавсран Илэрсэн Хүн Ам

Хүснэгт 94. ХБӨ-ий нийтлэг эрсдэлт хүчин зүйлс хавсран илэрсэн хүн ам хүйсээр

Хүн амын дунд (95% ИХ)	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
<b>ХБӨ-ий нийтлэг эрсдэлт хүчин зүйлс</b>			
<ul style="list-style-type: none"> <li>Өдөр бүр тамхи татдаг</li> <li>Өдөрт 5 нэгжээс бага хэмжээгээр жимс, ногоо хэрэглэдэг</li> <li>Хөдөлгөөний хомсдолтой</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Илүүдэл жинтэй (БЖИ <math>\geq 25</math> кг/м<sup>2</sup>)</li> <li>Артерийн даралт ихсэлттэй (САД <math>\geq 140</math> ба/эсвэл ДАД <math>\geq 90</math> мм МУБ эсвэл даралт бууруулах эм хэрэглэж байгаа)*</li> </ul>		
Нийтлэг эрсдэлт хүчин зүйлс илрээгүй хүн амын хувь	<b>3.6</b> (3.1 – 4.1)	<b>2.1</b> (1.6 – 2.8)	<b>4.6</b> (3.9 – 5.3)
Нийтлэг эрсдэлт хүчин зүйлсээс 1-2 эрсдэл хавсран илэрсэн хүн амын хувь	<b>48.3</b> (47.0 – 49.6)	<b>41.3</b> (39.4 – 43.4)	<b>52.9</b> (51.2 – 54.5)
Нийтлэг эрсдэлт хүчин зүйлсээс 3 ба түүнээс олон эрсдэл хавсран илэрсэн хүн амын хувь	<b>48.1</b> (46.8 – 49.4)	<b>56.5</b> (54.5 – 58.5)	<b>42.6</b> (40.9 – 44.2)

\*ДЭМБ-ын үзүүлэлтийг баримтлав.



Зураг 143. Нийтлэг эрсдэлт хүчин зүйлсээс 3 ба түүнээс олон эрсдэл хавсран илэрсэн хүн амын хувь, хүйсээр



Зураг 144. ХБӨ-өөр өвчлөх өндөр эрсдэлтэй хүн амын хувь, сумаар


### ГОЛ МЭДЭЭЛЭЛ

1. Дорноговь аймгийн насанд хүрсэн хүн амын ХБӨ-өөр өвчлөх эрсдэлгүй хүн амын тархалт дөнгөж 3.6% байна.
2. Насанд хүрсэн хүн амын бараг 2 хүн тутмын 1 нь (48.1%) нийтлэг эрсдэлт хүчин зүйлсээс 3 ба түүнээс олон эрсдэл хавсран илэрсэн байна.
3. Нас ахих тусам эрсдэлт хүчин зүйл хавсран илэрсэн хүн амын тоо өсөж байна.
4. Эрдэнэ, Улаанбадрах, Дэлгэрэх, Замын-үүд, Иххэт сумуудад Нийтлэг эрсдэлт хүчин зүйлсээс 3 ба түүнээс олон эрсдэл хавсран илэрсэн хүн амын хувь аймгийн дундаж (48.1%)-аас өндөр байна.


## ТАМХИНЫ ХЭРЭГЛЭЭ

Хүснэгт 95. Тамхины хэрэглээ хүйсээр

Насанд хүрсэн хүн амын дунд (95% ИХ)	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
Тамхи татдаг хүн амын хувь	<b>19.9</b> (19.0 – 20.9)	<b>42.3</b> (40.3 – 44.2)	<b>5.3</b> (4.6 – 6.0)
Өдөр бүр тамхи татдаг хүн амын хувь	<b>16.6</b> (15.7 – 17.6)	<b>36.3</b> (34.4 – 38.1)	<b>3.8</b> (3.2 – 4.4)
<i>Өдөр бүр тамхи татдаг хүн амын дунд:</i>			
Тамхи татаж эхэлсэн дундаж нас (жилээр)	<b>19.9</b> (19.6 – 20.4)	<b>18.8</b> (18.4 – 19.4)	<b>25.9</b> (24.7 – 27.1)



Зураг 145. Тамхи татдаг хүн ам, хүйс ба насны ангилал



Зураг 146. Тамхи татдаг хүн амын тархалт, сумаар


## ГОЛ МЭДЭЭЛЭЛ

1. Дорноговь аймгийн насанд хүрсэн 5 хүн тутмын 1 нь (19.9%) тамхи татдаг бөгөөд эрэгтэйчүүдийн дунд тамхины хэрэглээ эмэгтэйчүүдээс 7.9 дахин их байна.
2. Өдөр бүр тамхи татдаг хүн амын хувь нийт тамхи татдаг хүмүүсийн 83.4%-ийг эзэлж байна.
3. Тамхи татаж эхэлсэн нас дунджаар 19.9 байна.
4. 30-59 нас хүртэлх насны ангилалд тамхины хэрэглээ жигд өндөр байна.
5. Мандах, Иххэт, Дэлгэрэх, Сайхандулаан, Замын-үүд сумуудад тамхи татдаг хүн амын хувь аймгийн дундаж (19.9%-)-аас өндөр байна.


## АРХИ, СОГТУУРУУЛАХ УНДААНЫ ХЭРЭГЛЭЭ

Хүснэгт 96. Архи, согтууруулах ундааны хэрэглээ хүйсээр

Насанд хүрсэн хүн амын дунд (95% ИХ)	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
Сүүлийн 1 сард стандарт уултаас илүү архи, согтууруулах ундаа хэрэглэсэн хүн амын хувь	<b>17.2</b> (16.3 – 18.1)	<b>27.0</b> (25.2 – 28.7)	<b>10.8</b> (9.8 – 11.8)



Зураг 156. Сүүлийн 1 сард стандарт уултаас илүү архи, согтууруулах ундаа хэрэглэсэн хүн ам, хүйс ба насны ангилалаар



Зураг 147. Сүүлийн 1 сард стандарт уултаас илүү архи, согтууруулах ундаа хэрэглэсэн хүн амын хувь, бүс нутгаар


### ГОЛ МЭДЭЭЛЭЛ

1. Дорноговь аймгийн насанд хүрсэн хүн амын сүүлийн 1 сард стандарт уултаас илүү архи, согтууруулах ундаа хэрэглэсэн хүн амын хувь 14.2% байх бөгөөд эрэгтэйчүүдийн дунд согтууруулах ундааны хэрэглээ эмэгтэйчүүдээс 2.5 дахин их байна.
2. Хөдөлмөрийн насны (20-49 нас) хүмүүсийн архины хэрэглээ бусад насны бүлэгтэй харьцуулахад их байна.
3. Айраг, Сайншанд, Мандах, Алтанширээ, Хөвсгөл сумуудад Сүүлийн 1 сард стандарт уултаас илүү архи, согтууруулах ундаа хэрэглэсэн хүн амын хувь аймгийн дундаж (17.2%)-аас өндөр байна.


## ХӨДӨЛГӨӨН

Хүснэгт 97. Хөдөлгөөн хүйсээр

Насанд хүрсэн хүн амын дунд (95% ИХ)	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
7 хоногийн 5-аас доошгүй өдөр 30 минутаас дээш дасгал хөдөлгөөн хийдэггүй, эсвэл 10000 алхдаггүй хүн амын хувь	<b>61.2</b> (60.0 – 62.4)	<b>59.7</b> (57.8 – 61.6)	<b>62.3</b> (60.7 – 63.8)



Зураг 148. 7 хоногийн 5-аас доошгүй өдөр 30 минутаас дээш дасгал хөдөлгөөн хийдэггүй, эсвэл 10000 алхдаггүй хүн амын тархалт, насны бүлгээр ба хүйсээр



Зураг 149. 7 хоногийн 5-аас доошгүй өдөр 30 минутаас дээш дасгал хөдөлгөөн хийдэггүй, эсвэл 10000 алхдаггүй хүн амын тархалт, сумаар


### ГОЛ МЭДЭЭЛЭЛ

1. Дорноговь аймгийн “Урьдчилан сэргийлэх эрт илрүүлэгт” хамрагдсан нийт хүн амын 61.2% нь 7 хоногийн 5-аас доошгүй өдөр 30 минутаас дээш дасгал хөдөлгөөн хийдэггүй, эсвэл 10000 алхдаггүй байна.
2. Хүйсээр авч үзвэл эмэгтэйчүүд (62.3%), эрэгтэйчүүдээс (59.7%) 2.6%-иар их, нас ахих тусам хөдөлгөөний идэвхгүй байдал нэмэгдэж байгаа нь ажиглагдав.
3. Дэлгэрэх, Өргөн, Улаанбадрах, Иххэт, Алтанширээ, Хатанбулаг, Сайхандулаан, Хөвсгөл, Айраг, Сайншанд сумуудад 7 хоногийн 5-аас доошгүй өдөр 30 минутаас дээш дасгал хөдөлгөөн хийдэггүй, эсвэл 10000 алхдаггүй хүн амын хувь аймгийн дундаж (61.2%)-аас өндөр байна.


## ЖИМС, ЖИМСГЭНЭ, НОГООНЫ ХЭРЭГЛЭЭ

Хүснэгт 98. Жимс, жимсгэнэ, ногооны хэрэглээ хүйсээр

Насанд хүрсэн хүн амын дунд (95% ИХ)	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
Зохистой хэрэглээтэй хүн амын хувь (хоногт $\geq 5$ нэгж буюу 400 г)	<b>39.5</b> (38.3-40.7)	<b>33.1</b> (31.3-34.9)	<b>43.6</b> (42.1-45.2)
Хангалтгүй хэрэглээтэй хүн амын хувь (хоногт $< 5$ нэгж /400 г)	<b>24.8</b> (23.7-25.8)	<b>26.4</b> (23.7-25.8)	<b>23.7</b> (22.3-25.0)
Жимс, ногоо бага хэрэглэдэг ХБӨ-ний эрсдэлтэй хүн амын хувь (жимс, ногоог өдөр бүр хэрэглэдэггүй эсвэл хоногт 400 граммаас бага хэрэглэдэг)	<b>60.5</b> (59.3-61.7)	<b>66.9</b> (65.1-68.8)	<b>56.4</b> (54.8-57.9)



Зураг 150. Жимс, жимсгэнэ, хүнсний ногоо бага хэрэглэдэг насанд хүрэгчдийн хувь, насны бүлгээр



Зураг 151. Жимс, жимсгэнэ, ногооны зохистой хэрэглээтэй насанд хүрэгчид, сумаар

### ГОЛ МЭДЭЭЛЭЛ


1. Дорноговь аймгийн насанд хүрэгчдийн 39.5% жимс, жимсгэнэ, хүнсний ногооны зохистой хэрэглээтэй буюу хоногт  $\geq 400$  г хэмжээгээр хэрэглэж байна. Жимс, жимсгэнэ, хүнсний ногооны зохистой хэрэглээтэй иргэдийн хувь хүйс болон байршлаар ялгаатай, эмэгтэйчүүдийн дунд эрэгтэйчүүдийн дундаж үзүүлэлтээс статистик ач холбогдол бүхий өндөр, Эрдэнэ, Улаанбадрах, Дэлгэрэх сумдад харьцангуй бага байв.
2. Эрт илрүүлэг үзлэгт хамрагдсан Дорноговь аймгийн 18-90 насны иргэдийн 60.5% өдөр бүр жимс, ногоо хэрэглэдэггүй эсвэл хоногт 400 граммаас бага хэмжээгээр хэрэглэж байна. Дорноговь аймгийн насанд хүрсэн 3 хүн тутмын 2 орчим нь “Эрүүл хооллолтын ГЭР зөвлөмж”-д заасан хэмжээ (Хоногт  $\geq 400$ г)-гээр жимс, жимсгэнэ, хүнсний ногоо хэрэглэдэггүй буюу ХБӨ-өөр өвчлөх эрсдэлтэй байна.
3. Жимс, жимсгэнэ, хүнсний ногоо бага хэрэглэдэг буюу ХБӨ-өөр өвчлөх эрсдэлтэй насанд хүрэгчдийн тархалт иргэдийн насны бүлгээр ялгаатай,  $\leq 19$  насны залуучууд,  $\geq 50$  насны иргэдийн дунд хамгийн өндөр байв.



## ИЛҮҮДЭЛ ЖИН БА ТАРГАЛАЛТ

Хүснэгт 99. Илүүдэл жин ба таргалалт хүйсээр

Насанд хүрсэн хүн амын дунд (95% ИХ)	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
Биеийн жингийн индекс (БЖИ)-ийн дундаж хэмжээ (кг/м <sup>2</sup> )	<b>26.7</b> (25.6-26.8)	<b>26.5</b> (26.3-26.6)	<b>26.9</b> (26.7-27.1)
Илүүдэл жин ба таргалалттай хүн амын хувь (БЖИ ≥ 25 кг/м <sup>2</sup> )	<b>59.4</b> (58.1-60.6)	<b>58.3</b> (56.3-60.3)	<b>60.0</b> (58.4-61.6)
Таргалалттай хүн амын хувь (БЖИ ≥ 30 кг/м <sup>2</sup> )	<b>23.2</b> (22.2-24.3)	<b>20.8</b> (19.2-22.5)	<b>24.8</b> (23.4-26.2)
Бүсэлхийн тойргийн дундаж хэмжээ (см)	-	<b>90.3</b> (89.7-90.8)	<b>85.7</b> (85.3-86.1)
Төвийн таргалалттай хүн амын хувь (Бүсэлхийн тойрог: эр ≥ 90 см, эм ≥ 80 см)	<b>60.5</b> (59.3-61.7)	<b>50.8</b> (48.7-52.8)	<b>66.8</b> (65.3-68.3)



Зураг 152. Илүүдэл жин ба таргалалтын тархалт, насны бүлгээр



Зураг 153. Таргалалтын тархалт (БЖИ≥30 кг/м<sup>2</sup>), сумаар


### ГОЛ МЭДЭЭЛЭЛ

1. Дорноговь аймгийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдсан насанд хүрэгчдийн БЖИ-ийн дундаж хэмжээ 26.7 кг/м<sup>2</sup> байгаа нь ДЭМБ-аас зөвлөсөн хэвийн хязгаараас хэтэрсэн байна. Иргэдийн БЖИ-ийн дундаж хэмжээ нь хүйс болон насны бүлгээр ялгаатай, нас ахих тутам нэмэгдэх зүй тогтол илэрсэн болно.
2. Насанд хүрэгчдийн 59.4% илүүдэл жин ба таргалалттай, 23.2% тарган байв. Таргалалтын тархалт эмэгтэйчүүдийн дунд харьцангуй өндөр байна. Илүүдэл жин ба таргалалтын тархалт аль ч хүйсийн насанд хүрэгчдийн дунд нас ахих тутам нэмэгдэх хандлага ажиглагдсан бөгөөд 30–39 насны 2 хүн тутмын 1-ээс илүү, 40 насны 4 хүн тутмын 3 орчим нь илүүдэл жин ба таргалалттай байв. Мөн Дорноговь аймгийн 30–69 насны 4 хүн тутмын 1 нь тарган байна.
3. Дорноговь аймгийн эрт илрүүлэг үзлэгт хамрагдсан насанд хүрэгчдийн 60.5% төвийн таргалалттай, төвийн таргалалтын тархалт эмэгтэйчүүдийн дунд эрэгтэйчүүдээс 1.3 дахин өндөр байна (p<0.0001).

## АРТЕРИЙН ГИПЕРТЕНЗИ

Хүснэгт 100. Артерийн гипертензи хүйсээр

Насанд хүрсэн хүн амын дунд (95% ИХ)	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
Систолийн артерийн даралт (САД)-ын дундаж хэмжээ, мм МУБ (даралт бууруулах эм хэрэглэж байгаа хүн амыг оролцуулсан)	<b>118.0</b> (117.6-118.4)	<b>120.2</b> (119.5-120.9)	<b>116.7</b> (116.1-117.3)
Диастолын артерийн даралт (ДАД)-ын дундаж хэмжээ, мм МУБ (даралт бууруулах эм хэрэглэж байгаа хүн амыг оролцуулсан)	<b>76.7</b> (76.4-77.0)	<b>77.7</b> (75.7-78.2)	<b>76.1</b> (75.7-76.5)
Артерийн даралт ихсэлттэй хүн амын хувь (САД = 120-129 мм МУБ ба/эсвэл ДАД ≤ 80 мм МУБ)	<b>20.6</b> (19.5-21.6)	<b>21.9</b> (20.2-23.6)	<b>19.7</b> (18.4-21.1)
Артерийн гипертензитэй хүн амын хувь (САД ≥ 130 ба/эсвэл ДАД ≥ 81 мм МУБ эсвэл даралт бууруулах эм хэрэглэдэг хүн амын оролцуулсан)	<b>29.8</b> (28.6-31.0)	<b>33.1</b> (31.1-35.2)	<b>27.8</b> (26.3-29.3)



Зураг 154. Артерийн гипертензийн тархалт, насны бүлгээр

### ГОЛ МЭДЭЭЛЭЛ




Зураг 155. Артерийн гипертензийн тархалт, сумаар

1. Эрт илрүүлэг үзлэгт хамрагдсан Дорноговь аймгийн насанд хүрэгчдийн САД-ын дундаж хэмжээ 118.0 мм МУБ, ДАД-ын дундаж үзүүлэлт 76.7 мм МУБ байна.
2. Насанд хүрэгчдийн 20.6% артерийн даралт ихсэлттэй буюу САД нь 120–129 мм ба/эсвэл ДАД ≤ 80 мм МУБ байв.
3. Урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдсан Дорноговь аймгийн насанд хүрэгчдийн 29.8% артерийн гипертензи (АГ)-тэй буюу САД ≥ 130 мм МУБ ба ДАД ≥ 81 мм МУБ-аас дээш байгаа нь анхаарал татаж байна. АГ-ийн тархалт эрэгтэйчүүдийн дунд эмэгтэйчүүдийн үзүүлэлтээс 5.3 хувиар илүү байв ( $p < 0.0001$ ).
4. АГ-ийн тархалт иргэдийн нас ахих тутам нэмэгдэж, 50 ба түүнээс дээш насны 2 хүн тутмын 1 орчим нь АГ-тэй байна. Дорноговь аймгийн насанд хүрэгчдийн дундах АГ-ийн тархалтыг сумаар харьцуулан үнэлэхэд Эрдэнэ, Замын-Үүд, Улаанбадрах суманд харьцангуй өндөр, Хөвсгөл, Айраг, Алтанширээ сумдад хамгийн бага тархалттай байв.


## ЧИХРИЙН ШИЖИН

Хүснэгт 101. Чихрийн шижин хүйсээр

Насанд хүрсэн хүн амын дунд (95% ИХ)	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
Өлөн үеийн цусны глюкозын дундаж хэмжээ (ммоль/л), глюкоз бууруулах эм хэрэглэж буй хүн амыг оруулаад	<b>5.3</b> (5.3-5.4)	<b>5.5</b> (5.4-5.6)	<b>5.2</b> (5.2-5.3)
Өлөн үеийн цусны глюкозын өөрчлөлттэй хүн амын хувь (Ийлдсийн глюкозын хэмжээ $\geq 6.1$ ммол/л ба $< 7.0$ ммол/л)	<b>8.5</b> (7.8-9.3)	<b>11.3</b> (9.9-12.7)	<b>6.9</b> (6.1-7.8)
Өлөн үеийн цусны глюкозын хэмжээ ихэссэн болон глюкоз бууруулах эм хэрэглэж буй хүн амын хувь (Ийлдсийн глюкозын хэмжээ $\geq 7.0$ ммол/л)	<b>6.7</b> (6.1-7.4)	<b>8.6</b> (7.3-9.8)	<b>5.7</b> (4.9-6.4)



Зураг 156. Өлөн үеийн цусны глюкозын өөрчлөлттэй болон ЧШ-тэй хүн амын хувь, насны бүлгээр



Зураг 157. Чихрийн шижингийн тархалт, сумаар


## ГОЛ МЭДЭЭЛЭЛ

1. Дорноговь аймгийн эрт ирүүлэг үзлэгт хамрагдсан насанд хүрэгчдийн өлөн үеийн цусны глюкозын дундаж хэмжээ 5.3 ммоль/л байна. Эрэгтэйчүүдийн цусны глюкозын дундаж хэмжээ нь эмэгтэйчүүдээс бага зэрэг илүү байв.
2. Насанд хүрэгчдийн 8.5% өлөн үеийн цусны глюкозын өөрчлөлттэй, 6.7% цусны глюкозын хэмжээ ихэссэн буюу чихрийн шижинтэй байна. Өлөн үеийн цусны глюкозын өөрчлөлт, чихрийн шижингийн тархалт нь иргэдийн насны бүлгээр ялгаатай, нас ахих тутам нэмэгдэх хандлага ажиглагдсан бөгөөд Чихрийн шижингийн тархалт  $\geq 50$  насны иргэдийн дунд харьцангуй өндөр байв.
3. Дорноговь аймгийн насанд хүрэгчдийн дундах өлөн үеийн цусны глюкозын өөрчлөлт, чихрийн шижингийн тархалтад статистик ач холбогдол бүхий хүйсийн ялгаа илэрсэн болно.
4. Өлөн үеийн цусны глюкозын шинжилгээнд хамрагдсан иргэдийн тоо харилцан адилгүй, зарим сумдад цөөн байгаа тул Дорноговь аймгийн насанд хүрэгчдийн дундах чихрийн шижингийн тархалтыг сумаар харьцуулан дүгнэх боломжгүй байна.

## ӨЛӨН ҮЕИЙН ЦУСНЫ ЛИПИДЫН ҮНЭЛГЭЭ

Хүснэгт 102. Өлөн үеийн цусны липидын үнэлгээ хүйсээр

Насанд хүрсэн хүн амын дунд (95% ИХ)	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
“Өлөн үеийн цусны холестерин хэмжээ ихэссэн” гэж оношлогдож байсан хүн амын хувь	<b>3.5</b> (3.0-3.9)	<b>3.4</b> (2.7-4.1)	<b>3.5</b> (2.9-4.1)
Цусны нийт холестерин хэмжээ ихэссэн ( $\geq 5.3$ ммоль/л) хүн амын хувь	<b>25.8</b> (23.2-28.4)	<b>23.2</b> (19.8-26.6)	<b>28.9</b> (24.9-32.9)
“Өлөн үеийн цусны триглицеридийн хэмжээ ихэссэн” гэж оношлогдож байсан хүн амын хувь	<b>2.6</b> (2.2-3.0)	<b>2.9</b> (2.3-3.6)	<b>2.4</b> (1.9-2.8)
Цусны триглицеридийн хэмжээ ихэссэн ( $\geq 1.7$ ммоль/л) хүн амын хувь	<b>17.6</b> (15.3-19.8)	<b>19.3</b> (16.1-22.5)	<b>15.5</b> (12.3-18.7)



Зураг 158. Өлөн үеийн цусны липидын хэмжээ ихэссэн хүн амын хувь, насны бүлгээр



Зураг 159. Өлөн үеийн цусны нийт холестерин агууламж ихэссэн хүн амын хувь, сумаар


### ГОЛ МЭДЭЭЛЭЛ

1. Дорноговь аймгийн эрт илрүүлэгт хамрагдсан насанд хүрэгчдийн 3.5% цусны холестерин ихэссэн, харин 2.6% триглицеридын агууламж ихэссэн гэж оношлогдож байжээ.
2. Насанд хүрэгчдийн 25.8% өлөн үеийн цусны нийт холестерин, 17.6% триглицеридын агууламж ихэссэн байна. Дорноговь аймгийн насанд хүрэгчдийн дундах дислипидемийн тархалтад хүйсийн ялгаа ажиглагдсан бөгөөд цусны нийт холестерин ихсэлт эмэгтэйчүүдийн дунд эрэгтэйчүүдээс 5.7 хувиар илүү байв.
3. Өлөн үеийн цусны холестерин, триглицеридын ихсэлтийн тархалт иргэдийн настай шууд хамааралтайгаар нэмэгдэх хандлага илэрсэн ба Дорноговь аймгийн 40–59 насны 3 хүн тутмын 1,  $\geq 70$  насны 2 тутмын 1 нь цусны нийт холестерин ихсэлттэй байна.
4. Өлөн үеийн цусны липидын шинжилгээнд хамрагдсан иргэдийн тоо харилцан адилгүй, Замын – Үүд, Сайншанд сумаас бусад сумын насанд хүрэгчдийн тоо хэт цөөн байгаа тул дислипидемийн тархалтыг сумаар харьцуулан дүгнэх боломжгүй болно.

## ХУВЬ ХҮНИЙ ЭРСДЭЛИЙН ҮНЭЛГЭЭ

Хүснэгт 103. Хувь хүний эрсдэлийн үнэлгээ хүйсээр

Насанд хүрсэн хүн амын дунд (95% ИХ)	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
Гэр бүлийн гишүүн чихрийн шижингээр өвчилж байсан <i>Өвөө, эмээ, нагац, авга Эцэг, эх, ах дүү, өөрийн хүүхэд</i>	<b>22.8</b> (20.7-25.0)	<b>16.5</b> (13.8-19.3)	<b>29.1</b> (25.8-32.4)
Жирэмсний чихрийн шижингээр өвчилж байсан	-	-	<b>17.5</b> (16.3-18.7)
Хавдраар өвчилж байсан түүх (гэр бүлийн гишүүн)	<b>17.3</b> (16.3-18.2)	<b>13.8</b> (12.4-15.1)	<b>19.6</b> (18.3-20.8)
Артерийн даралт бууруулах эм тогтмол хэрэглэдэг	<b>17.6</b> (16.7-18.6)	<b>12.3</b> (10.9-13.6)	<b>20.9</b> (19.6-22.2)
Цусны өөх тос бууруулах эм хэрэглэж байгаа	<b>20.6</b> (19.6-21.6)	<b>19.4</b> (17.9-21.0)	<b>21.3</b> (20.0-22.6)



Зураг 160. “Гэр бүлийн хэн нэгэн гишүүн нь чихрийн шижин, хавдраар өвчилж байсан” гэж хариулсан насанд хүрэгчдийн хувь, насны бүлгээр


### ГОЛ МЭДЭЭЛЭЛ

1. Эрт илрүүлэг үзлэгт хамрагдсан Дорноговь аймгийн насанд хүрэгчдийн 22.8% гэр бүлийн хэн нэгэн гишүүн “чихрийн шижингээр өвчилсөн”, 17.3% хавдраар өвчилсөн гэж хариулсан байна. Нийт эмэгтэйчүүдийн 17.5% жирэмсний чихрийн шижин оношлогдож байжээ.
2. Урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдсан Дорноговь аймгийн иргэдийн 17.6% артерийн даралт бууруулах эмийг тогтмол хэрэглэдэг, харин 20.6% цусны өөх тос бууруулах эмийг одоо хэрэглэж байв.
3. Гэр бүлийн хэн нэгэн гишүүн чихрийн шижингээр өвчилсөн гэж хариулсан насанд хүрэгчдийн хувь тэдний настай урвуу хамааралтай буюу нас ахих тутам буурах хандлага ажиглагдаж байв. Тодруулбал, 30–39 насны залуучуудын дунд уг өгүүлэмж хамгийн их, 60 ба түүнээс дээш насны иргэдийн дунд хамгийн бага байв.
4. Гэр бүлийн хэн нэгэн гишүүн хавдраар өвчилсөн гэж хариулсан насанд хүрэгчдийн хувь тэдний настай шууд хамааралтай ихсэх зүй тогтол ажиглагдсан бөгөөд урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдсан Дорноговь аймгийн 40–59 насны хүн амын дунд харьцангуй өндөр байна.

**ДУНДГОВЬ АЙМГИЙН НАСАНД ХҮРЭГЧДИЙН ДУНДАХ  
ХАЛДВАРТ БУС ӨВЧНИЙ ЭРСДЭЛТ ХҮЧИН ЗҮЙЛСИЙН  
ТАРХАЛТ**

**ТАНИЛЦУУЛГА**

Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/248 дугаар тушаалыг хэрэгжүүлэх арга хэмжээний хүрээнд 2022 оны 5 дугаар сарын 3-ны өдрөөс 2023 оны 5 дугаар сарын 1 хүртэлх хугацаанд эрт илрүүлэг, урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдсан Дундговь аймгийн 5,636 насанд хүрэгчдийн мэдээллийг нэгтгэн, тэдний дунд түгээмэл тохиолдож буй халдварт бус өвчин (ХБӨ)-ий эрсдэлт хүчин зүйлсийн тархалтын байдалд дүн шинжилгээ хийв (Зураг 161).



Зураг 161. Эрт илрүүлэг үзлэгт хамрагдсан насанд хүрэгчдийн тоо, сумын дүнгээр

Эрт илрүүлэг, урьдчилан сэргийлэх үзлэгт Дундговь аймгийн 18–92 насны нийт 5,636 хүн хамрагдсан бөгөөд тэдний 39.8% (n=2,243) эрэгтэйчүүд, 60.2% (n=3,393) эмэгтэйчүүд байв (Хүснэгт 104).

Хүснэгт 104. Эрт илрүүлэгт хамрагдсан насанд хүрэгчид, нас бүлэг ба хүйсээр


Насны бүлэг, жилээр	N	Эрэгтэй			Эмэгтэй		
		Тоо	Хувь	95% ИХ	Тоо	Хувь	95% ИХ
≤ 19	347	275	79.3	75.0-83.5	72	20.8	16.5-25.0
20 – 29	1024	489	47.8	44.7-50.8	535	52.3	49.2-55.3
30 – 39	997	324	32.5	29.6-35.4	673	67.5	64.-70.4
40 – 49	1081	344	31.8	29.0-34.6	737	68.2	65.4-71.0
50 – 59	1106	396	35.8	33.0-36.6	710	64.2	61.4-67.0
60 – 69	821	312	38.0	34.7-41.3	509	62.0	58.7-65.3
≥ 70	260	103	39.6	33.6-45.6	157	60.4	54.4-66.4
<b>Нийт</b>	<b>5,636</b>	<b>2,243</b>	<b>39.8</b>	<b>38.5-41.1</b>	<b>3,393</b>	<b>60.2</b>	<b>58.9-61.5</b>

Урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдсан Дундговь аймгийн насанд хүрэгчдийн дундаж нас 43.7 (95%ИХ 43.3-44.1) жил байна. Эрт илрүүлэг үзлэгт хамрагдсан эмэгтэйчүүдийн дундаж нас эрэгтэйчүүдийн дундаж үзүүлэлтээс 4.2 жилээр илүү байна (дундаж нас: эр 41.2 жил, эм 45.3 жил).

**ХБӨ-ИЙ НИЙТЛЭГ ЭРСДЭЛТ ХҮЧИН ЗҮЙЛС ХАВСРАН ИЛЭРСЭН ХҮН АМ**  
Хүснэгт 105. ХБӨ-ий нийтлэг эрсдэлт хүчин зүйлс хавсран илэрсэн хүн ам хүйсээр

Хүн амын дунд (95% ИХ)	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
<b>ХБӨ-ий нийтлэг эрсдэлт хүчин зүйлс</b>			
<ul style="list-style-type: none"> <li>Өдөр бүр тамхи татдаг</li> <li>Өдөрт 5 нэгжээс бага хэмжээгээр жимс, ногоо хэрэглэдэг</li> <li>Хөдөлгөөний хомсдолтой</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Илүүдэл жинтэй (БЖИ <math>\geq 25</math> кг/м<sup>2</sup>)</li> <li>Артерийн даралт ихсэлттэй (САД <math>\geq 140</math> ба/эсвэл ДАД <math>\geq 90</math> мм МУБ эсвэл даралт бууруулах эм хэрэглэж байгаа)*</li> </ul>		
Нийтлэг эрсдэлт хүчин зүйлс илрээгүй хүн амын хувь	<b>2.1</b> (1.7 – 2.5)	<b>1.8</b> (1.3 – 2.4)	<b>2.3</b> (1.8 – 2.8)
Нийтлэг эрсдэлт хүчин зүйлсээс 1-2 эрсдэл хавсран илэрсэн хүн амын хувь	<b>39.6</b> (38.3 – 40.9)	<b>33.5</b> (31.6 – 35.6)	<b>43.7</b> (42.0 – 45.5)
Нийтлэг эрсдэлт хүчин зүйлсээс 3 ба түүнээс олон эрсдэл хавсран илэрсэн хүн амын хувь	<b>58.3</b> (57.0 – 59.6)	<b>64.7</b> (62.6 – 66.7)	<b>54.0</b> (52.2 – 55.7)

\*ДЭМБ-ын үзүүлэлтийг баримтлав.



Зураг 162. Нийтлэг эрсдэлт хүчин зүйлсээс 3 ба түүнээс олон эрсдэл хавсран илэрсэн хүн амын хувь, хүйсээр



Зураг 163. ХБӨ-өөр өвчлөх өндөр эрсдэлтэй хүн амын хувь, сумаар


**ГОЛ МЭДЭЭЛЭЛ**

1. Эрт илрүүлэг үзлэгт хамрагдсан Дундговь аймгийн насанд хүрсэн хүн амын ХБӨ-өөр өвчлөх эрсдэлгүй хүн амын тархалт дөнгөж 2.1% байна.
2. ХБӨ-өөр өвчлөх өндөр эрсдэлтэй хүн амын тархалт эрэгтэйчүүдийн дунд эмэгтэйчүүдээс 1.3 дахин өндөр байна. Энэ нь эрэгтэйчүүдийн дундаж наслалт болон тэдний амьдралын чанарт сөргөөр нөлөөлөх магадлалтай юм.
3. Насанд хүрсэн хүн амын 2 хүн тутмын 1 нь (58.3%) нийтлэг эрсдэлт хүчин зүйлсээс 3 ба түүнээс олон эрсдэл хавсран илэрсэн байна.
4. Нас ахих тусам эрсдэлт хүчин зүйл хавсран илэрсэн хүн амын тоо өсөж байна.
5. Хулд, Дэлгэрхангай, Дэрэн, Говь-угтаал, Баянжаргалан, Өндөршил, Адаацаг, Луус, Дэлгэрцогт, Өлзийт, Гурвансайхан сумуудад Нийтлэг эрсдэлт хүчин зүйлсээс 3 ба түүнээс олон эрсдэл хавсран илэрсэн хүн амын хувь аймгийн дундаж (58.3%)-аас өндөр байна.

## ТАМХИНЫ ХЭРЭГЛЭЭ

Хүснэгт 106. Тамхины хэрэглээ хүйсээр

Насанд хүрсэн хүн амын дунд (95% ИХ)	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
Тамхи татдаг хүн амын хувь	<b>17.0</b> (16.0 – 18.0)	<b>40.9</b> (38.9 – 43.0)	<b>1.0</b> (0.6 – 1.3)
Өдөр бүр тамхи татдаг хүн амын хувь	<b>14.1</b> (13.2 – 15.0)	<b>34.3</b> (32.4 – 36.3)	<b>0.7</b> (0.4 – 1.0)
<i>Өдөр бүр тамхи татдаг хүн амын дунд:</i>			
Тамхи татаж эхэлсэн дундаж нас (жилээр)	<b>19.9</b> (19.4 – 20.4)	<b>19.7</b> (19.3 – 20.2)	<b>25.9</b> (21.7 – 30.1)



Зураг 164. Тамхи татдаг хүн ам, хүйс ба насны ангилал

## ГОЛ МЭДЭЭЛЭЛ



Зураг 165. Тамхи татдаг хүн амын тархалт, сумаар


1. Эрт илрүүлэг үзлэгт хамрагдсан Дундговь аймгийн насанд хүрсэн 5 хүн тутмын 1 нь (17%) тамхи татдаг бөгөөд эрэгтэйчүүдийн дунд тамхины хэрэглээ эмэгтэйчүүдээс 40.9 дахин их байна.
2. Өдөр бүр тамхи татдаг хүн амын хувь нийт тамхи татдаг хүмүүсийн 82.9%-ийг эзэлж байна.
3. Тамхи татаж эхэлсэн нас дунджаар 19.9 байна.
4. 20-69 нас хүртэлх насны ангилалд тамхины хэрэглээ жигд өндөр байна.
5. Баян-овоо, Эрдэнэцогт, Өлзийт, Бууцагаан, Гурванбулаг, Шинэжинст, Заг, Хүрээмарал, Галуут, Баянбулаг, Баянговь, Баянцагаан, Бөмбөгөр, Баян-өндөр сумуудад тамхи татдаг хүн амын хувь аймгийн дундаж (16.1%)-аас өндөр байна.



## АРХИ, СОГТУУРУУЛАХ УНДААНЫ ХЭРЭГЛЭЭ

Хүснэгт 107. Архи, согтууруулах ундааны хэрэглээ хүйсээр

Насанд хүрсэн хүн амын дунд (95% ИХ)	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
Сүүлийн 1 сард стандарт уултаас илүү архи, согтууруулах ундаа хэрэглэсэн хүн амын хувь	<b>10.3</b> (9.5 – 11.1)	<b>21.5</b> (19.8 – 23.3)	<b>2.7</b> (2.1 – 3.2)



Зураг 166. Сүүлийн 1 сард стандарт уултаас илүү архи, согтууруулах ундаа хэрэглэсэн хүн ам, хүйс ба насны ангилал



Зураг 177. Сүүлийн 1 сард стандарт уултаас илүү архи, согтууруулах ундаа хэрэглэсэн хүн амын хувь, бүс нутгаар


### ГОЛ МЭДЭЭЛЭЛ

1. Эрт илрүүлэг үзлэгт хамрагдсан Дундговь аймгийн насанд хүрсэн хүн амын сүүлийн 1 сард стандарт уултаас илүү архи, согтууруулах ундаа хэрэглэсэн хүн амын хувь 10.3% байх бөгөөд эрэгтэйчүүдийн дунд согтууруулах ундааны хэрэглээ эмэгтэйчүүдээс 7.8 дахин их байна.
2. 30-69 насны хүмүүсийн архины хэрэглээ бусад насны бүлэгтэй харьцуулахад их байна.
3. Баянжаргалан, Говь-угтаал, Гурвансайхан, Адаацаг, Өлзийт, Сайхан-овоо, Дэлгэрцогт, сумуудад Сүүлийн 1 сард стандарт уултаас илүү архи, согтууруулах ундаа хэрэглэсэн хүн амын хувь аймгийн дундаж (6.2%)-аас өндөр байна.

## ХӨДӨЛГӨӨН

Хүснэгт 108. Хөдөлгөөн хүйсээр

Насанд хүрсэн хүн амын дунд (95% ИХ)	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
7 хоногийн 5-аас доошгүй өдөр 30 минутаас дээш дасгал хөдөлгөөн хийдэггүй, эсвэл 10000 алхдаггүй хүн амын хувь	<b>67.4</b> (66.1 – 68.6)	<b>69.0</b> (67.1 – 70.9)	<b>66.3</b> (64.7 – 67.9)



Зураг 167. 7 хоногийн 5-аас доошгүй өдөр 30 минутаас дээш дасгал хөдөлгөөн хийдэггүй, эсвэл 10000 алхдаггүй хүн амын тархалт, насны бүлгээр ба хүйсээр



Зураг 168. 7 хоногийн 5-аас доошгүй өдөр 30 минутаас дээш дасгал хөдөлгөөн хийдэггүй, эсвэл 10000 алхдаггүй хүн амын тархалт, бүс нутгаар


### ГОЛ МЭДЭЭЛЭЛ

1. Дундновь аймгийн “Урьдчилан сэргийлэх эрт илрүүлэгт” хамрагдсан нийт хүн амын 67.4% нь 7 хоногийн 5-аас доошгүй өдөр 30 минутаас дээш дасгал хөдөлгөөн хийдэггүй, эсвэл 10000 алхдаггүй байна.
2. Хүйсээр авч үзвэл эмэгтэйчүүд (69.0%), эрэгтэйчүүдээс (66.3%) 2.7%-иар их, бүх насанд хөдөлгөөний идэвхгүй байдал ажиглагдав.
3. Баянжаргалан, Адаацаг, Өлзийт, Өндөршил, Хулд, Цагаандэлгэр, Говь-угтаал, Дэрэн, Дэлгэрхангай, Луус, Дэлгэрцогт, Гурвансайхан сумуудад 7 хоногийн 5-аас доошгүй өдөр 30 минутаас дээш дасгал хөдөлгөөн хийдэггүй, эсвэл 10000 алхдаггүй хүн амын хувь аймгийн дундаж (67.4%)-аас өндөр байна.


## ЖИМС, ЖИМСГЭНЭ, НОГООНЫ ХЭРЭГЛЭЭ

Хүснэгт 109. Жимс, жимсгэнэ, ногооны хэрэглээ хүйсээр

Насанд хүрсэн хүн амын дунд (95% ИХ)	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
Зохистой хэрэглээтэй хүн амын хувь (хоногт $\geq 5$ нэгж буюу 400 г)	<b>20.8</b> (19.7-21.8)	<b>17.5</b> (15.9-19.1)	<b>23.0</b> (21.5-24.4)
Хангалтгүй хэрэглээтэй хүн амын хувь (хоногт $< 5$ нэгж /400 г)	<b>38.8</b> (37.5-40.0)	<b>40.4</b> (38.3-42.5)	<b>37.6</b> (36.0-39.3)
Жимс, ногоо бага хэрэглэдэг ХБӨ-ний эрсдэлтэй хүн амын хувь (жимс, ногоог өдөр бүр хэрэглэдэггүй эсвэл хоногт 400 граммаас бага хэрэглэдэг)	<b>79.2</b> (78.2-80.3)	<b>82.5</b> (80.9-84.1)	<b>77.1</b> (75.6-78.5)



Зураг 169. Жимс, жимсгэнэ, хүнсний ногоо бага хэрэглэдэг насанд хүрэгчдийн хувь, насны бүлгээр



Зураг 170. Жимс, жимсгэнэ, ногооны зохистой хэрэглээтэй насанд хүрэгчид, сумаар


## ГОЛ МЭДЭЭЛЭЛ

1. Дундговь аймгийн насанд хүрэгчдийн дөнгөж 20.8% жимс, жимсгэнэ, хүнсний ногооны зохистой хэрэглээтэй буюу хоногт  $\geq 400$  г хэмжээгээр хэрэглэж байна. Жимс, жимсгэнэ, хүнсний ногооны зохистой хэрэглээтэй иргэдийн хувь байршлаар ялгаатай, Дэлгэрхангай, Өлзийт суманд хамгийн бага, харин Баянжаргалан, Цагаандэлгэр сумдад харьцангуй өндөр байв.
2. Эрт илрүүлэг үзлэгт хамрагдсан Дундговь аймгийн 18–92 насны иргэдийн 79.2% өдөр бүр жимс, ногоо хэрэглэдэггүй эсвэл хоногт 400 граммаас бага хэмжээгээр хэрэглэж байна. Тодруулбал, насанд хүрсэн 10 хүн тутмын 8 нь “Эрүүл хооллолтын ГЭР зөвлөмж”-д заасан хэмжээ (Хоногт  $\geq 400$ г)-гээр жимс, жимсгэнэ, хүнсний ногоо хэрэглэдэггүй буюу ХБӨ-өөр өвчлөх эрсдэлтэй байна.
3. Жимс, жимсгэнэ, хүнсний ногоо бага хэрэглэдэг буюу ХБӨ-өөр өвчлөх эрсдэлтэй насанд хүрэгчдийн тархалт Дундговь аймгийн эрэгтэйчүүд ( $p < 0.0001$ ),  $\leq 19$  насны залуучууд болон  $\geq 40$  насны хүн амын дунд харьцангуй өндөр, харин 20–29 насны иргэдийн бусад насныхантай харьцуулахад ялимгүй бага байв.


## ИЛҮҮДЭЛ ЖИН БА ТАРГАЛАЛТ

Хүснэгт 110. Илүүдэл жин ба таргалалт хүйсээр

Насанд хүрсэн хүн амын дунд (95% ИХ)	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
Биеийн жингийн индекс (БЖИ)-ийн дундаж хэмжээ (кг/м <sup>2</sup> )	<b>26.5</b> (26.4-26.6)	<b>25.9</b> (25.7-26.1)	<b>26.9</b> (26.7-27.1)
Илүүдэл жин ба таргалалттай хүн амын хувь (БЖИ ≥ 25 кг/м <sup>2</sup> )	<b>57.1</b> (55.8-58.4)	<b>51.7</b> (49.6-53.8)	<b>60.6</b> (58.9-62.3)
Таргалалттай хүн амын хувь (БЖИ ≥ 30 кг/м <sup>2</sup> )	<b>22.5</b> (21.4-23.6)	<b>18.8</b> (17.2-20.4)	<b>25.0</b> (23.5-26.5)
Бүсэлхийн тойргийн дундаж хэмжээ (см)	-	<b>86.2</b> (85.7-86.8)	<b>81.2</b> (80.7-81.6)
Төвийн таргалалттай хүн амын хувь (Бүсэлхийн тойрог: эр ≥ 90 см, эм ≥ 80 см)	<b>47.9</b> (46.5-49.2)	<b>39.5</b> (37.5-41.6)	<b>53.5</b> (51.8-55.2)



Зураг 171. Илүүдэл жин ба таргалалтын тархалт, насны бүлгээр



Зураг 171. Таргалалтын тархалт (БЖИ≥30 кг/м<sup>2</sup>), сумаар


### ГОЛ МЭДЭЭЛЭЛ

1. Дундговь аймгийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдсан насанд хүрэгчдийн БЖИ-ийн дундаж хэмжээ 26.5 кг/м<sup>2</sup> байгаа нь ДЭМБ-аас зөвлөсөн хэвийн хязгаараас хэтэрсэн байна. Иргэдийн БЖИ-ийн дундаж хэмжээ нь хүйсээр ялгаатай, эмэгтэйчүүдэд ялимгүй өндөр байв ( $p < 0.0001$ ).
2. Насанд хүрэгчдийн 57.1% илүүдэл жин ба таргалалттай, 22.5% тарган байна. Илүүдэл жин, таргалалтын тархалт эмэгтэйчүүдийн дунд статистик ач холбогдол бүхий өндөр ( $p < 0.0001$ ), аль ч хүйсийн насанд хүрэгчдийн дунд нас ахих тутам нэмэгдэх хандлага ажиглагдсан болно. Дундговь аймгийн 30–69 насны 3 хүн тутмын 2 нь илүүдэл жин ба таргалалттай байв. Мөн ≥30 насны 4 хүн тутмын 1 орчим нь тарган байна. Таргалалтын тархалт Баянжаргалан, Дэрэн сумын иргэдийн дунд харьцангуй өндөр, Дэлгэрцогт, Говь-Угтаал суманд хамгийн бага байв.
3. Дундговь аймгийн эрт илрүүлэг үзлэгт хамрагдсан насанд хүрэгчдийн 47.9% төвийн таргалалттай, төвийн таргалалтын тархалт эмэгтэйчүүдийн дунд эрэгтэйчүүдээс 1.4 дахин өндөр байна ( $p < 0.0001$ ).


## АРТЕРИЙН ГИПЕРТЕНЗИ

Хүснэгт 111. Артерийн гипертензи хүйсээр

Насанд хүрсэн хүн амын дунд (95% ИХ)	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
Систолын артерийн даралт (САД)-ын дундаж хэмжээ, мм МУБ (даралт бууруулах эм хэрэглэж байгаа хүн амыг оролцуулсан)	<b>117.8</b> (117.4-118.2)	<b>120.3</b> (119.6-121.0)	<b>116.1</b> (115.5-116.7)
Диастолын артерийн даралт (ДАД)-ын дундаж хэмжээ, мм МУБ (даралт бууруулах эм хэрэглэж байгаа хүн амыг оролцуулсан)	<b>78.5</b> (78.1-78.8)	<b>79.6</b> (79.1-80.1)	<b>77.8</b> (77.3-78.2)
Артерийн даралт ихсэлттэй хүн амын хувь (САД = 120-129 мм МУБ ба/эсвэл ДАД ≤ 80 мм МУБ)	<b>18.2</b> (17.2-19.2)	<b>21.0</b> (19.3-22.7)	<b>16.3</b> (15.0-17.6)
Артерийн гипертензитэй хүн амын хувь (САД ≥ 130 ба/эсвэл ДАД ≥ 81 мм МУБ эсвэл даралт бууруулах эм хэрэглэдэг хүн амын оролцуулсан)	<b>34.0</b> (32.7-35.2)	<b>36.8</b> (34.8-38.9)	<b>32.1</b> (30.4-33.7)



Зураг 173. Артерийн гипертензийн тархалт, насны бүлгээр



Зураг 174. Артерийн гипертензийн тархалт, сумаар


### ГОЛ МЭДЭЭЛЭЛ

1. Эрт илрүүлэг үзлэгт хамрагдсан Дундговь аймгийн насанд хүрэгчдийн САД-ын дундаж хэмжээ 117.8 мм МУБ, ДАД-ын дундаж үзүүлэлт 78.5 мм МУБ байна.
2. Насанд хүрэгчдийн 18.2% артерийн даралт ихсэлттэй буюу САД нь 120–129 мм ба/эсвэл ДАД ≤ 80 мм МУБ байв. Артерийн даралт ихсэлтийн тархалт эмэгтэйчүүдийн дунд эрэгтэйчүүдийн дундаж үзүүлэлтээс 4.7 хувиар илүү байна.
3. Урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдсан Дундговь аймгийн насанд хүрэгчдийн 34.0% артерийн гипертензи (АГ)-тэй буюу САД ≥ 130 мм МУБ ба ДАД ≥ 81 мм МУБ-аас дээш байгаа нь анхаарал татаж байна. АГ-ийн тархалт эмэгтэйчүүдийн дунд бага зэрэг өндөр байв ( $p < 0.0001$ ).
4. АГ-ийн тархалт иргэдийн настай шууд хамааралтайгаар нэмэгдэх зүй тогтол ажиглагдсан бөгөөд 40–49 насны 3 хүн тутмын 1, ≥ 50 насны 2 хүн тутмын 1 орчим нь тус тус АГ-тэй байна. Эрт илрүүлэгт хамрагдсан хамрагдсан иргэдийн тоо харилцан адилгүй, зарим сумдад хэт цөөн байгаа тул иргэдийн дундах АГ-ийн тархалтыг сумаар харьцуулан дүгнэх боломжгүй байна.

## ЧИХРИЙН ШИЖИН

Хүснэгт 112. Чихрийн шижин хүйсээр

Насанд хүрсэн хүн амын дунд (95% ИХ)	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
Өлөн үеийн цусны глюкозын дундаж хэмжээ (ммоль/л), глюкоз бууруулах эм хэрэглэж буй хүн амыг оруулаад	<b>5.5</b> (5.5-5.6)	<b>5.7</b> (5.6-5.8)	<b>5.4</b> (5.3-5.4)
Өлөн үеийн цусны глюкозын өөрчлөлттэй хүн амын хувь (Ийлдсийн глюкозын хэмжээ $\geq 6.1$ ммол/л ба $< 7.0$ ммол/л)	<b>7.9</b> (7.1-8.7)	<b>11.7</b> (10.0-13.3)	<b>5.9</b> (5.0-6.8)
Өлөн үеийн цусны глюкозын хэмжээ ихэссэн болон глюкоз бууруулах эм хэрэглэж буй хүн амын хувь (Ийлдсийн глюкозын хэмжээ $\geq 7.0$ ммол/л)	<b>6.2</b> (5.5-6.9)	<b>8.2</b> (6.8-9.6)	<b>5.1</b> (4.3-6.0)



Зураг 175. Өлөн үеийн цусны глюкозын өөрчлөлттэй болон ЧШ-тэй хүн амын хувь, насны бүлгээр



Зураг 176. Чихрийн шижингийн тархалт, сумаар


## ГОЛ МЭДЭЭЛЭЛ

1. Дундговь аймгийн эрт ирүүлэг үзлэгт хамрагдсан насанд хүрэгчдийн өлөн үеийн цусны глюкозын дундаж хэмжээ 5.5 ммоль/л байв. Эрэгтэйчүүдийн цусны глюкозын дундаж хэмжээ нь эмэгтэйчүүдийн үзүүлэлтээс статистик ач холбогдол бүхий өндөр байна.
2. Насанд хүрэгчдийн 7.9% өлөн үеийн цусны глюкозын өөрчлөлттэй, 6.2% цусны глюкозын хэмжээ ихэссэн буюу чихрийн шижинтэй байв. Өлөн үеийн цусны глюкозын өөрчлөлт, чихрийн шижингийн тархалт эрэгтэйчүүдийн дунд статистик ач холбогдол бүхий өндөр байна.
3. Өлөн үеийн цусны глюкозын өөрчлөлт, чихрийн шижингийн өвчлөл иргэдийн насны бүлгээр ялгаатай, нас ахих тутам нэмэгдэх хандлагатай байна. Дундговь аймгийн  $\leq 19$  насны залуучуудын дунд өлөн үеийн цусны глюкозын өөрчлөлт, чихрийн шижингийн тохиолдол илрээгүй болно. Чихрийн шижингийн тохиолдол 20–29 насны залуучууд,  $\geq 50$  насны иргэдийн дунд 30–49 насныхны үзүүлэлтээс харьцангуй өндөр байгаа нь анхаарал татаж байв.
4. Цусны глюкозын шинжилгээнд хамрагдсан иргэдийн тоо харилцан адилгүй, зарим сумдад хэт цөөн байгаа тул Дундговь аймгийн насанд хүрэгчдийн дундах чихрийн шижингийн тархалтыг сумаар харьцуулан үнэлэх боломжгүй байна.


## ӨЛӨН ҮЕИЙН ЦУСНЫ ЛИПИДЫН ҮНЭЛГЭЭ

Хүснэгт 113. Өлөн үеийн цусны липидын үнэлгээ хүйсээр

Насанд хүрсэн хүн амын дунд (95% ИХ)	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
“Өлөн үеийн цусны холестерин хэмжээ ихэссэн” гэж оношлогдож байсан хүн амын хувь	<b>4.7</b> (4.1-5.3)	<b>3.9</b> (3.1-4.7)	<b>5.2</b> (4.5-6.0)
Цусны нийт холестерин хэмжээ ихэссэн ( $\geq 5.3$ ммоль/л) хүн амын хувь	<b>36.0</b> (31.9-40.1)	<b>33.5</b> (27.0-40.0)	<b>37.5</b> (32.3-42.8)
“Өлөн үеийн цусны триглицеридийн хэмжээ ихэссэн” гэж оношлогдож байсан хүн амын хувь	<b>1.5</b> (1.1-1.8)	<b>1.5</b> (1.0-2.0)	<b>1.5</b> (1.0-1.9)
Цусны триглицеридийн хэмжээ ихэссэн ( $\geq 1.7$ ммоль/л) хүн амын хувь	<b>10.8</b> (8.2-13.5)	<b>15.2</b> (10.2-20.1)	<b>8.2</b> (5.2-11.1)



Зураг 177. Өлөн үеийн цусны липидын хэмжээ ихэссэн хүн амын хувь, насны бүлгээр



Зураг 178. Өлөн үеийн цусны нийт холестерин агууламж ихэссэн хүн амын хувь, сумаар


### ГОЛ МЭДЭЭЛЭЛ

1. Дундговь аймгийн эрт илрүүлэгт хамрагдсан насанд хүрэгчдийн 4.7% цусны холестерин ихэссэн, харин 1.5% триглицеридын агууламж ихэссэн гэж оношлогдож байжээ.
2. Насанд хүрэгчдийн 36.0% өлөн үеийн цусны нийт холестерин, 10.8% триглицеридын агууламж ихэссэн байна. Дислипидемийн тархалтыг хүйсээр харьцуулан үнэлэхэд цусны триглицеридын ихсэлт нь эрэгтэйчүүдийн дунд эмэгтэйчүүдээс 1.9 дахин өндөр, харин цусны нийт холестерин ихсэлтэд ялгаа илрээгүй болно.
3. Өлөн үеийн цусны нийт холестерин ихсэлтийн тархалт иргэдийн настай шууд хамааралтайгаар нэмэгдэх хандлага илэрсэн ба Дундговь аймгийн 30–49 насны 3 хүн тутмын 1,  $\geq 50$  насны 2 хүн тутмын 1 нь цусны нийт холестерин ихсэлттэй буюу судасны хатуурал үүсэх эрсдэлтэй байна. Цусны триглицеридын ихсэлт  $\geq 50$  насны иргэдийн дунд харьцангуй өндөр байна.
4. Өлөн үеийн цусны липидын шинжилгээнд хамрагдсан иргэдийн тоо харилцан адилгүй, Сайнцагаан, Дэлгэрхангай сумаас бусад орон нутагт хэт цөөн байгаа тул нийт холестерин ихсэлтийг сумаар харьцуулан дүгнэх боломжгүй байв.

## ХУВЬ ХҮНИЙ ЭРСДЭЛИЙН ҮНЭЛГЭЭ

Хүснэгт 114. Хувь хүний эрсдэлийн үнэлгээ хүйсээр

Насанд хүрсэн хүн амын дунд (95% ИХ)	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
Гэр бүлийн гишүүн чихрийн шижингээр өвчилж байсан <i>Өвөө, эмээ, нагац, авга Эцэг, эх, ах дүү, өөрийн хүүхэд</i>	<b>26.3</b> (23.1-29.6)	<b>25.8</b> (20.5-31.1)	<b>26.7</b> (22.6-30.7)
Жирэмсний чихрийн шижингээр өвчилж байсан	-	-	<b>21.6</b> (20.2-23.0)
Хавдраар өвчилж байсан түүх (гэр бүлийн гишүүн)	<b>17.5</b> (16.5-18.5)	<b>14.4</b> (12.9-15.8)	<b>19.6</b> (18.3-21.0)
Артерийн даралт бууруулах эм тогтмол хэрэглэдэг	<b>20.5</b> (19.5-21.6)	<b>16.0</b> (14.4-17.6)	<b>23.4</b> (21.9-24.8)
Цусны өөх тос бууруулах эм хэрэглэж байгаа	<b>20.2</b> (19.1-21.2)	<b>17.0</b> (15.4-18.6)	<b>22.3</b> (20.8-23.7)



Зураг 179. “Гэр бүлийн хэн нэгэн гишүүн нь чихрийн шижин, хавдраар өвчилж байсан” гэж хариулсан насанд хүрэгчдийн хувь, насны бүлгээр

### ГОЛ МЭДЭЭЛЭЛ


1. Эрт илрүүлэг үзлэгт хамрагдсан Дундговь аймгийн насанд хүрэгчдийн 26.3% гэр бүлийн хэн нэгэн гишүүн “чихрийн шижингээр өвчилсөн”, 17.5% хавдраар өвчилсөн гэж хариулсан байна. Нийт эмэгтэйчүүдийн 21.6% жирэмсний чихрийн шижин оношлогдож байжээ.
2. Урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдсан Дундговь аймгийн насанд хүрэгчдийн 20.5% артерийн даралт бууруулах эмийг тогтмол хэрэглэдэг, харин 20.2% цусны өөх тос бууруулах эмийг одоо хэрэглэж байв. Артерийн даралт бууруулах эмийн хэрэглээ Дундговь аймгийн эмэгтэйчүүдийн дунд 1.5 дахин өндөр ( $p < 0.0001$ ), харин цусны өөх тос бууруулах эмийн хэрэглээ эмэгтэйчүүдэд 5.3 хувиар илүү байна.
3. Гэр бүлийн хэн нэгэн гишүүн чихрийн шижингээр өвчилсөн гэж хариулсан насанд хүрэгчдийн хувь 30–39 насныхны дунд хамгин өндөр,  $\geq 40$  насны иргэдийн настай урвуу хамааралтай буюу нас ахих тутам буурах хандлагатай байна.
4. Гэр бүлийн хэн нэгэн гишүүн хавдраар өвчилсөн гэж хариулсан иргэдийн хувь насны бүлгээр ялгаатай бус, нас ахих тутам нэмэгдэх хандлага ажиглагдсан болно ( $p < 0.0001$ ).



**ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН НАСАНД ХҮРЭГЧДИЙН ДУНДАХ  
ХАЛДВАРТ БУС ӨВЧНИЙ ЭРСДЭЛТ ХҮЧИН ЗҮЙЛСИЙН  
ТАРХАЛТ**

**ТАНИЛЦУУЛГА**

Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/248 дугаар тушаалыг хэрэгжүүлэх арга хэмжээний хүрээнд 2022 оны 5 дугаар сарын 1-ээс 2023 оны 5 дугаар сарын 1 хүртэлх хугацаанд эрт илрүүлэг, урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдсан Говь-Алтай аймгийн 6,877 насанд хүрэгчдийн мэдээллийг нэгтгэн, хүн амын дунд түгээмэл тохиолдож буй Халдварт бус өвчин (ХБӨ)-ий эрсдэлт хүчин зүйлсийн тархалтын байдалд дүн шинжилгээ хийв (Зураг 180).



Зураг 180. Эрт илрүүлэг үзлэгт хамрагдсан насанд хүрэгчдийн тоо, сумын дүнгээр

Эрт илрүүлэг, урьдчилан сэргийлэх үзлэгт Говь-Алтай (ГА) аймгийн 18-89 насны нийт 6,877 хүн хамрагдсан бөгөөд тэдний 38.8% (n=2,460) эрэгтэйчүүд, 64.2% (n=4,477) эмэгтэйчүүд байв (Хүснэгт 115).

Хүснэгт 115. Эрт илрүүлэгт хамрагдсан насанд хүрэгчид, нас бүлэг ба хүйсээр

Насны бүлэг, жилээр	N	Эрэгтэй			Эмэгтэй		
		Тоо	Хувь	95% ИХ	Тоо	Хувь	95% ИХ
≤ 19	289	172	59.5	53.8-65.2	117	40.5	34.8-46.2
20 – 29	859	376	43.8	40.5-47.1	483	56.2	52.9-59.6
30 – 39	1341	401	29.9	27.5-32.4	940	70.1	67.6-72.6
40 – 49	1729	565	32.7	30.5-34.9	1164	67.3	65.1-69.5
50 – 59	1582	525	33.2	30.9-35.5	1057	66.8	64.5-69.1
60 – 69	885	354	40.0	36.8-43.2	531	60.0	56.8-63.2
≥ 70	192	67	34.9	28.1-41.7	125	65.1	58.3-71.9
<b>Нийт</b>	<b>6877</b>	<b>2460</b>	<b>35.8</b>	<b>34.6-36.9</b>	<b>4417</b>	<b>64.2</b>	<b>63.1-65.4</b>


Эрт илрүүлэг үзлэгт хамрагдсан Говь-Алтай аймгийн насанд хүрэгчдийн дундаж нас 44.6 (95%ИХ 44.3–45.0) жил, эмэгтэйчүүдийн дундаж нас эрэгтэйчүүдээс 1.4 жилээр илүү (p<0.001) байна (дундаж нас: эр 43.7 жил, эм 45.1 жил).

## ХБӨ-ИЙ НИЙТЛЭГ ЭРСДЭЛТ ХҮЧИН ЗҮЙЛС ХАВСРАН ИЛЭРСЭН ХҮН АМ


Хүснэгт 116. ХБӨ-ий нийтлэг эрсдэлт хүчин зүйлс хавсран илэрсэн хүн ам хүйсээр

Хүн амын дунд (95% ИХ)	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
<b>ХБӨ-ий нийтлэг эрсдэлт хүчин зүйлс</b>			
<ul style="list-style-type: none"> <li>Өдөр бүр тамхи татдаг</li> <li>Өдөрт 5 нэгжээс бага хэмжээгээр жимс, ногоо хэрэглэдэг</li> <li>Хөдөлгөөний хомсдолтой</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Илүүдэл жинтэй (БЖИ <math>\geq 25</math> кг/м<sup>2</sup>)</li> <li>Артерийн даралт ихсэлттэй (САД <math>\geq 140</math> ба/эсвэл ДАД <math>\geq 90</math> мм МУБ эсвэл даралт бууруулах эм хэрэглэж байгаа)*</li> </ul>		
Нийтлэг эрсдэлт хүчин зүйлс илрээгүй хүн амын хувь	<b>2.1</b> (1.8 – 2.5)	<b>1.6</b> (1.1 – 2.2)	<b>2.5</b> (2.0 – 3.0)
Нийтлэг эрсдэлт хүчин зүйлсээс 1-2 эрсдэл хавсран илэрсэн хүн амын хувь	<b>45.8</b> (44.5 – 47.0)	<b>38.8</b> (36.8 – 40.8)	<b>50.0</b> (48.4 – 51.6)
Нийтлэг эрсдэлт хүчин зүйлсээс 3 ба түүнээс олон эрсдэл хавсран илэрсэн хүн амын хувь	<b>52.1</b> (50.8 – 53.4)	<b>59.6</b> (57.6 – 61.7)	<b>47.6</b> (45.9 – 49.2)

\*ДЭМБ-ын үзүүлэлтийг баримтлав.



Зураг 181. Нийтлэг эрсдэлт хүчин зүйлсээс 3 ба түүнээс олон эрсдэл хавсран илэрсэн хүн амын хувь, насны ангиллаар



Зураг 182. Нийтлэг эрсдэлт хүчин зүйлсээс 3 ба түүнээс олон эрсдэл хавсран илэрсэн хүн амын хувь, сумаар


### ГОЛ МЭДЭЭЛЭЛ

1. Говь-алтай аймгийн насанд хүрсэн хүн амын ХБӨ-өөр өвчлөх эрсдэлгүй хүн амын тархалт дөнгөж 2.1% байна.
2. Насанд хүрсэн хүн амын 2 хүн тутмын 1 нь (52.1%) нийтлэг эрсдэлт хүчин зүйлсээс 3 ба түүнээс олон эрсдэл хавсран илэрсэн байна.
3. ХБӨ-өөр өвчлөх өндөр эрсдэлтэй хүн амын тархалт эрэгтэйчүүдийн дунд эмэгтэйчүүдээс 1.5 дахин их байна. Энэ нь эрэгтэйчүүдийн дундаж наслалт болон тэдний амьдралын чанарт сөргөөр нөлөөлөх магадлалтай.
4. Нас ахих тусам эрсдэлт хүчин зүйл хавсран илэрсэн хүн амын тоо өсөж байна.
5. Баян-уул, Бигэр, Дэлгэр, Жаргалан, Тайшир, Халиун, Хөхморьт, Цээл, Эрдэнэ сумуудад Нийтлэг эрсдэлт хүчин зүйлсээс 3 ба түүнээс олон эрсдэл хавсран илэрсэн хүн амын хувь аймгийн дундаж (52.1%-) аас өндөр байна


## ТАМХИНЫ ХЭРЭГЛЭЭ

Хүснэгт 117. Тамхины хэрэглээ хүйсээр

Насанд хүрсэн хүн амын дунд (95% ИХ)	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
Тамхи татдаг хүн амын хувь	<b>18.0</b> (17.1 – 18.9)	<b>48.3</b> (46.3 – 50.3)	<b>0.9</b> (0.6 – 1.2)
Өдөр бүр тамхи татдаг хүн амын хувь	<b>15.2</b> (14.3 – 15.9)	<b>41.2</b> (39.3 – 43.2)	<b>0.6</b> (0.3 – 0.8)
<i>Өдөр бүр тамхи татдаг хүн амын дунд:</i>			
Тамхи татаж эхэлсэн дундаж нас (жилээр)	<b>20.8</b> (20.4 – 21.3)	<b>20.5</b> (20.0 – 20.9)	<b>32.6</b> (28.6 – 36.7)



Зураг 183. Тамхи татдаг хүн ам, насны ангилал



Зураг 184. Тамхи татдаг хүн ам, сумаар


### ГОЛ МЭДЭЭЛЭЛ

1. Говь-алтай аймгийн насанд хүрсэн хүн амын 5 хүн тутмын 1 нь (18.0%) тамхи татдаг бөгөөд эрэгтэйчүүдийн дунд тамхины хэрэглээ эмэгтэйчүүдээс 53.6 дахин их байна.
2. Өдөр бүр тамхи татдаг хүн амын хувь нийт тамхи татдаг хүмүүсийн 84.4%-ийг эзэлж байна.
3. Тамхи татаж эхэлсэн нас дунджаар 20.8 байна.
4. 19 нас хүртэлх насны хүн амын тамхины хэрэглээ хамгийн өндөр байна.
5. Алтай, Бигэр, Дэлгэр, Жаргалан, Тайшир, Халиун, Хөхморьт, Эрдэнэ сумуудад тамхи татдаг хүн амын хувь аймгийн дундаж (18%)-аас өндөр байна.


## АРХИ, СОГТУУРУУЛАХ УНДААНЫ ХЭРЭГЛЭЭ

Хүснэгт 118. Архи, согтууруулах ундааны хэрэглээ хүйсээр

Насанд хүрсэн хүн амын дунд (95% ИХ)	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
Сүүлийн 1 сард стандарт уултаас илүү архи, согтууруулах ундаа хэрэглэсэн хүн амын хувь	<b>12.4</b> (11.6 – 13.1)	<b>23.7</b> (22.0 – 25.4)	<b>5.9</b> (5.2 – 6.6)



Зураг 185. Сүүлийн 1 сард стандарт уултаас илүү архи, согтууруулах ундаа хэрэглэсэн хүн ам, насны бүлгээр



Зураг 186. Сүүлийн 1 сард стандарт уултаас илүү архи, согтууруулах ундаа хэрэглэсэн хүн ам, сумаар


### ГОЛ МЭДЭЭЛЭЛ

1. Говь-алтай аймгийн насанд хүрсэн хүн амын сүүлийн 1 сард стандарт уултаас илүү архи, согтууруулах ундаа хэрэглэсэн хүн амын хувь 12.4% байх бөгөөд эрэгтэйчүүдийн дунд согтууруулах ундааны хэрэглээ эмэгтэйчүүдээс 4 дахин их байна.
2. Хөдөлмөрийн насны (30-49 нас) хүмүүсийн архины хэрэглээ бусад насны бүлэгтэй харьцуулахад их байна.
3. Баян-уул, Есөнбулаг, Тайшир, Төгрөг, Цээл сумуудад Сүүлийн 1 сард стандарт уултаас илүү архи, согтууруулах ундаа хэрэглэсэн хүн амын хувь аймгийн дундаж (12.4%)-аас өндөр байна.


## ЖИМС, ЖИМСГЭНЭ, НОГООНЫ ХЭРЭГЛЭЭ

Хүснэгт 119. Тамхины хэрэглээ хүйсээр

Насанд хүрсэн хүн амын дунд (95% ИХ)	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
Зохистой хэрэглээтэй хүн амын хувь (хоногт $\geq 5$ нэгж буюу 400 г)	<b>23.3</b> (22.2-24.3)	<b>21.0</b> (19.3-22.6)	<b>24.6</b> (23.3-25.9)
Хангалтгүй хэрэглээтэй хүн амын хувь (хоногт $< 5$ нэгж /400 г)	<b>27.1</b> (26.0-28.2)	<b>30.1</b> (28.3-32.0)	<b>25.4</b> (24.1-26.7)
Жимс, ногоо бага хэрэглэдэг ХБӨ-ний эрсдэлтэй хүн амын хувь (жимс, ногоог өдөр бүр хэрэглэдэггүй эсвэл хоногт 400 граммаас бага хэрэглэдэг)	<b>76.7</b> (75.7-77.8)	<b>79.0</b> (77.4-80.7)	<b>75.4</b> (74.1-76.7)



Зураг 187. Жимс, жимсгэнэ, хүнсний ногоо бага хэрэглэдэг насанд хүрэгчдийн хувь, насны бүлгээр



Зураг 188. Жимс, жимсгэнэ, ногооны зохистой хэрэглээтэй насанд хүрэгчдийн хувь, сумаар


### ГОЛ МЭДЭЭЛЭЛ

1. Говь-Алтай аймгийн насанд хүрэгчдийн 23.3% жимс, жимсгэнэ, хүнсний ногооны зохистой хэрэглээтэй буюу хоногт 5 нэгж буюу 400 граммаас их хэмжээгээр хэрэглэж байна. Жимс, жимсгэнэ, хүнсний ногооны зохистой хэрэглээтэй иргэдийн хувь Хөхморьт, Шарга, Бугат сумын иргэдийн дунд хамгийн бага (12.7%–18.0%) байв.
2. Эрт илрүүлэг үзлэгт хамрагдсан 18-89 насны иргэдийн 76.7% өдөр бүр жимс, ногоо хэрэглэдэггүй эсвэл хоногт 400 граммаас бага хэмжээгээр хэрэглэж байна. Насанд хүрсэн 10 хүн тутмын 8 орчим нь “Эрүүл хооллолтын ГЭР зөвлөмж”-д заасан хэмжээ (Хоногт $\geq 400$ г)-гээр жимс, хүнсний ногоог хэрэглэдэггүй буюу ХБӨ-өөр өвчлөх эрсдэлтэй байв.
3. Жимс, жимсгэнэ, хүнсний ногоо бага хэрэглэдэг буюу ХБӨ-өөр өвчлөх эрсдэлтэй насанд хүрэгчдийн тархалт  $\leq 19$ , 60 ба түүнээс дээш насны хүн амын дунд харьцангуй өндөр, харин 20–29 насны залуучуудын дунд бага байна.


## ИЛҮҮДЭЛ ЖИН БА ТАРГАЛАЛТ

Хүснэгт 120. Илүүдэл жин ба таргалалт хүйсээр

Насанд хүрсэн хүн амын дунд (95% ИХ)	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
Биеийн жингийн индекс (БЖИ)-ийн дундаж хэмжээ (кг/м <sup>2</sup> )	<b>25.9</b> (25.8-26.0)	<b>25.5</b> (25.3-25.6)	<b>26.1</b> (25.9-26.3)
Илүүдэл жин ба таргалалттай хүн амын хувь (БЖИ ≥ 25 кг/м <sup>2</sup> )	<b>53.0</b> (51.7-54.2)	<b>49.6</b> (47.6-51.7)	<b>55.0</b> (53.4-56.6)
Таргалалттай хүн амын хувь (БЖИ ≥ 30 кг/м <sup>2</sup> )	<b>17.9</b> (17.0-18.9)	<b>14.5</b> (13.1-16.0)	<b>20.0</b> (18.7-21.3)
Бүсэлхийн тойргийн дундаж хэмжээ (см)	-	<b>88.8</b> (88.3-89.4)	<b>85.7</b> (85.2-86.2)
Төвийн таргалалттай хүн амын хувь (Бүсэлхийн тойрог: эр ≥ 90 см, эм ≥ 80 см)	<b>49.8</b> (48.5-51.1)	<b>37.5</b> (35.5-39.5)	<b>57.2</b> (55.6-58.8)



Зураг 189. Илүүдэл жин ба таргалалтын тархалт, насны бүлгээр



Зураг 190. Таргалалтын тархалт (БЖИ≥30 кг/м<sup>2</sup>), сумаар


## ГОЛ МЭДЭЭЛЭЛ

1. Урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдсан Говь-Алтай аймгийн насанд хүрэгчдийн БЖИ-ийн дундаж хэмжээ 25.9 кг/м<sup>2</sup> буюу ДЭМБ-аас зөвлөсөн зохих хязгаараас хэтэрсэн байна. Иргэдийн БЖИ-ийн дундаж хэмжээ хүйсийн ялгаатай, эмэгтэйчүүдэд статистик ач холбогдол бүхий өндөр байв.
2. Насанд хүрэгчдийн 53.0% илүүдэл жин ба таргалалттай, 17.9% тарган байна. Таргалалтын тархалт эмэгтэйчүүдийн дунд эрэгтэйчүүдээс харьцангуй өндөр, 5 эмэгтэй тутмын 1 нь тарган байв. Таргалалтын тархалт аль ч хүйсийн хүн амын дунд нас ахих тутам нэмэгдэх хандлага ажиглагдсан бөгөөд 40–69 насны иргэдийн дунд хамгийн өндөр байна.
3. Эрт илрүүлэг үзлэгт хамрагдсан Говь-Алтай аймгийн насанд хүрэгчдийн 49.8% төвийн таргалалттай, төвийн таргалалттай эмэгтэйчүүдийн хувь эрэгтэйчүүдээс 1.5 дахин өндөр байна.


## АРТЕРИЙН ГИПЕРТЕНЗИ

Хүснэгт 121. Артерийн гипертензи хүйсээр

Насанд хүрсэн хүн амын дунд (95% ИХ)	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
Систолын артерийн даралт (САД)-ын дундаж хэмжээ, мм МУБ (даралт бууруулах эм хэрэглэж байгаа хүн амыг оролцуулсан)	<b>119.2</b> (118.8-119.6)	<b>120.4</b> (11.8-121.0)	<b>118.5</b> (117.9-119.0)
Диастолын артерийн даралт (ДАД)-ын дундаж хэмжээ, мм МУБ (даралт бууруулах эм хэрэглэж байгаа хүн амыг оролцуулсан)	<b>76.9</b> (76.6-77.1)	<b>77.8</b> (77.4-78.2)	<b>76.3</b> (75.9-76.7)
Артерийн даралт ихсэлтгүй хүн амын хувь (САД = 120-129 мм МУБ ба/эсвэл ДАД ≤ 80 мм МУБ)	<b>38.2</b> (36.9-39.4)	<b>43.5</b> (41.4-45.5)	<b>35.0</b> (33.4-36.5)
Артерийн гипертензигтэй хүн амын хувь (САД ≥ 130 ба/эсвэл ДАД ≥ 81 мм МУБ эсвэл даралт бууруулах эм хэрэглэдэг хүн амын оролцуулсан)	<b>24.6</b> (23.5-25.7)	<b>25.1</b> (23.3-26.9)	<b>24.3</b> (22.9-25.7)



Зураг 191. Артерийн гипертензийн тархалт, насны бүлгээр



Зураг 192. Артерийн гипертензийн тархалт, сумаар

## ГОЛ МЭДЭЭЛЭЛ

1. Эрт илрүүлэг үзлэгт хамрагдсан Говь-Алтай аймгийн насанд хүрэгчдийн САД-ын дундаж хэмжээ 119.2 мм МУБ, ДАД-ын дундаж үзүүлэлт 76.9 мм МУБ байна.
2. Насанд хүрэгчдийн 38.2% артерийн даралт ихсэлтгүй буюу САД нь 120–129 мм ба/эсвэл ДАД ≤ 80 мм МУБ байв. Артерийн даралт ихсэлтийн тархалт эрт илрүүлэг үзлэгт хамрагдсан эрэгтэйчүүдийн дунд статистик ач холбогдол бүхий өндөр байна.
3. Урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдсан Говь-Алтай аймгийн иргэдийн дунд САД ≥ 130 мм МУБ ба ДАД ≥ 81 мм МУБ-ээс дээш буюу Артерийн гипертензи (АГ)-ийн тархалт 24.6% байв. АГ-ийн тархалтад хүйсийн ялгаа ажиглагдаагүй болно.
4. АГ-ийн тархалт хүн амын нас ахих тутам нэмэгдэж, 40–49 насны иргэдийн дунд огцом өсөлт ажиглагдсан бөгөөд 60–69 насны 2 хүн тутмын 1, 70 ба түүнээс дээш насны 10 хүн тутмын 6 нь АГ-тэй байв.
5. АГ-ийн тархалт Алтай сумын насанд хүрэгчдийн дунд хамгийн бага, харин Бигэр, Цээл суманд харьцангуй өндөр ажиглагдсан боловч, эрт илрүүлэг үзлэгт хамрагдсан иргэдийн тоо харилцан адилгүй байгаа тул харьцуулан дүгнэлт өгөх боломжүй байна.


## ЧИХРИЙН ШИЖИН

Хүснэгт 122. Чихрийн шижин хүйсээр

Насанд хүрсэн хүн амын дунд (95% ИХ)	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
Өлөн үеийн цусны глюкозын дундаж хэмжээ (ммоль/л), глюкоз бууруулах эм хэрэглэж буй хүн амыг оруулаад	<b>5.4</b> (5.3-5.4)	<b>5.6</b> (5.5-5.7)	<b>5.3</b> (5.2-5.3)
Өлөн үеийн цусны глюкозын өөрчлөлттэй хүн амын хувь (Ийлдсийн глюкозын хэмжээ $\geq 6.1$ ммол/л ба $< 7.0$ ммол/л)	<b>5.9</b> (5.2-6.5)	<b>8.8</b> (7.5-10.1)	<b>4.4</b> (3.7-5.1)
Өлөн үеийн цусны глюкозын хэмжээ ихэссэн болон глюкоз бууруулах эм хэрэглэж буй хүн амын хувь (Ийлдсийн глюкозын хэмжээ $\geq 7.0$ ммол/л)	<b>5.8</b> (5.2-6.5)	<b>7.7</b> (6.5-8.9)	<b>4.9</b> (4.2-5.6)



Зураг 193. Өлөн үеийн цусны глюкозын өөрчлөлттэй болон ЧШ-тэй хүн амын хувь, насны бүлгээр



Зураг 194. Чихрийн шижингийн тархалт, сумаар

## ГОЛ МЭДЭЭЛЭЛ


1. Говь-Алтай аймгийн эрт ирүүлэг үзлэгт хамрагдсан насанд хүрэгчдийн өлөн үеийн цусны глюкозын дундаж хэмжээ 5.4 ммоль/л байв. Эрэгтэйчүүдийн өлөн үеийн цусны глюкозын дундаж хэмжээ нь эмэгтэйчүүдийн дундаж үзүүлэлтээс статистик ач холбогдол бүхий өндөр байна.
2. Насанд хүрсэн иргэдийн 5.9% өлөн үеийн цусны глюкозын өөрчлөлттэй, 5.8% глюкозын хэмжээ ихэссэн буюу чихрийн шижинтэй байна. Өлөн үеийн цусны глюкозын өөрчлөлтийн тохиолдол 18–29 насны залуучуудын дунд илрээгүй бөгөөд 30–69 насны иргэдийн дунд тэдний наснаас шууд хамааралтай ихсэх хандлага ажиглагдаж байв. Чихрийн шийнгийн тархалт 20–29 насны залуучууд, 50–69 насны иргэдийн дунд харьцангуй түгээмэл илэрсэн болно.
3. Эрт илрүүлэг үзлэгт хамрагдсан эрэгтэйчүүдийн дунд өлөн үеийн цусны глюкозын өөрчлөлт болон чихрийн шижингийн тархалт эмэгтэйчүүдээс статистик ач холбогдол бүхий илүү байв.




## ӨЛӨН ҮЕИЙН ЦУСНЫ ЛИПИДЫН ҮНЭЛГЭЭ

Хүснэгт 123. Өлөн үеийн цусны липидын үнэлгээ хүйсээр

Насанд хүрсэн хүн амын дунд (95% ИХ)	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
“Өлөн үеийн цусны холестерин хэмжээ ихэссэн” гэж оношлогдож байсан хүн амын хувь	<b>4.0</b> (3.6-4.5)	<b>4.4</b> (3.6-5.2)	<b>3.9</b> (3.3-4.4)
Цусны нийт холестерин хэмжээ ихэссэн ( $\geq 5.3$ ммоль/л) хүн амын хувь	<b>25.8</b> (22.2-29.3)	<b>21.2</b> (16.2-26.3)	<b>29.3</b> (24.4-34.2)
“Өлөн үеийн цусны триглицеридийн хэмжээ ихэссэн” гэж оношлогдож байсан хүн амын хувь	<b>2.5</b> (2.1-2.9)	<b>2.7</b> (2.1-3.4)	<b>2.3</b> (1.9-2.8)
Цусны триглицеридийн хэмжээ ихэссэн ( $\geq 1.7$ ммоль/л) хүн амын хувь	<b>6.8</b> (4.8-8.8)	<b>10.0</b> (6.4-13.7)	<b>4.2</b> (2.1-6.4)



Зураг 195. Өлөн үеийн цусны липидын хэмжээ ихэссэн хүн амын хувь, насны бүлгээр



Зураг 196. Өлөн үеийн цусны нийт холестерин агууламж ихэссэн хүн амын хувь, сумаар


### ГОЛ МЭДЭЭЛЭЛ

1. Говь-Алтай аймгийн эрт илрүүлэгт хамрагдсан насанд хүрсэн иргэдийн 4.0% цусны холестерин ихэссэн, харин 2.5% триглицеридийн агууламж ихэссэн гэж оношлогдож байжээ.
2. Насанд хүрэгчдийн 25.8% өлөн үеийн цусны нийт холестерин, 6.8% триглицеридийн агууламж ихэссэн байна. Цусны нийт холестерин, триглицеридийн хэмжээ ихэссэн тохиолдолд хүйсийн ялгаа ажиглагдаагүй болно.
3. Цусны холестерин агууламж ихэссэн насанд хүрэгчдийн хувь 50–69 насны иргэдийн дунд харьцангуй өндөр байна. Цусны липидын ихсэх тохиолдол 30–39 насны иргэдийн дунд огцом нэмэгдэж байв.

## ХУВЬ ХҮНИЙ ЭРСДЭЛИЙН ҮНЭЛГЭЭ

Хүснэгт 197. Хувь хүний эрсдэлийн үнэлгээ хүйсээр

Насанд хүрсэн хүн амын дунд (95% ИХ)	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
Гэр бүлийн гишүүн чихрийн шижингээр өвчилж байсан <i>Өвөө, эмээ, нагац, авга Эцэг, эх, ах дүү, өөрийн хүүхэд</i>	<b>9.4</b> (7.1-11.7)	<b>7.8</b> (4.6-11.0)	<b>10.6</b> (7.4-13.8)
Жирэмсний чихрийн шинжингээр өвчилж байсан	-	-	<b>17.7</b> (16.6-18.8)
Хавдраар өвчилж байсан түүх (гэр бүлийн гишүүн)	<b>23.2</b> (22.2-24.3)	<b>19.7</b> (18.1-21.3)	<b>25.2</b> (23.9-26.5)
Артерийн даралт бууруулах эм тогтмол хэрэглэдэг	<b>21.5</b> (20.5-22.4)	<b>15.1</b> (13.6-16.6)	<b>24.7</b> (23.4-26.0)
Цусны өөх тос бууруулах эм хэрэглэж байгаа	<b>16.9</b> (16.0-17.8)	<b>14.4</b> (13.0-15.8)	<b>18.2</b> (17.1-19.4)



Зураг 198. “Гэр бүлийн хэн нэгэн гишүүн нь чихрийн шинжин, хавдраар өвчилж байсан” гэж хариулсан насанд хүрэгчдийн хувь, насны бүлгээр


### ГОЛ МЭДЭЭЛЭЛ

1. Урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдсан Говь-Алтай аймгийн насанд хүрэгчдийн 9.4% гэр бүлийн хэн нэгэн гишүүн чихрийн шижингээр, харин 23.2% хавдраар өвчилсөн гэж тус тус хариулсан байна. Нийт эмэгтэйчүүдийн 17.7% жирэмсний чихрийн шижин оношлогдож байжээ.
2. Эрт илрүүлэгт хамрагдсан Говь-Алтай аймгийн иргэдийн 21.5% артерийн даралт бууруулах эмийг тогтмол хэрэглэдэг, харин 16.9% цусны өөх тос бууруулах эмийг одоо хэрэглэж байв.
3. Гэр бүлийн хэн нэгэн гишүүн чихрийн шинжингээр өвчилсөн гэж хариулсан хүн амын тархалт 30–49 насны иргэдийн дунд харьцангуй өндөр, энэхүү өгүүлэмж эрт илрүүлэгт хамрагдсан 50–69 насны иргэдийн дунд буурах хандлага ажиглагдсан болно.
4. Хавдраар өвчилсөн гэр бүлийн түүхтэй насанд хүрэгчдийн хувь эрт илрүүлэг үзлэгт хамрагдсан 30 ба түүнээс дээш насны иргэдийн дунд харьцангуй өндөр байв.

**ГОВЬ-СҮМБЭР АЙМГИЙН НАСАНД ХҮРЭГЧДИЙН ДУНДАХ  
ХАЛДВАРТ БУС ӨВЧНИЙ ЭРСДЭЛТ ХҮЧИН ЗҮЙЛСИЙН  
ТАРХАЛТ**

**ТАНИЛЦУУЛГА**

Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/248 дугаар тушаалыг хэрэгжүүлэх арга хэмжээний хүрээнд 2022 оны 5 дугаар сарын 3-ны өдрөөс 2023 оны 5 дугаар сарын 1 хүртэлх хугацаанд эрт илрүүлэг, урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдсан Говь-сүмбэр аймгийн 1,804 насанд хүрэгчдийн мэдээллийг нэгтгэн, тэдний дунд түгээмэл тохиолдож буй халдварт бус өвчин (ХБӨ)-ий эрсдэлт хүчин зүйлсийн тархалтын байдалд дүн шинжилгээ хийв (Зураг 199).



Зураг 199. Эрт илрүүлэг үзлэгт хамрагдсан насанд хүрэгчдийн тоо, сумын дүнгээр

Эрт илрүүлэг, урьдчилан сэргийлэх үзлэгт Говьсүмбэр аймгийн 18–86 насны нийт 1,804 хүн хамрагдсан бөгөөд тэдний 39.7% (n=719) эрэгтэйчүүд, 60.3% (n=1,088) эмэгтэйчүүд байв (Хүснэгт 125).

Хүснэгт 125. Эрт илрүүлэгт хамрагдсан насанд хүрэгчид, нас бүлэг ба хүйсээр

Насны бүлэг, жилээр	N	Эрэгтэй			Эмэгтэй		
		Тоо	Хувь	95% ИХ	Тоо	Хувь	95% ИХ
≤ 19	96	63	65.6	56.0-75.3	33	34.4	24.7-44.1
20 – 29	332	180	54.2	48.8-59.6	152	45.8	40.4-51.2
30 – 39	410	153	37.3	32.6-42.0	257	62.7	58.0-67.4
40 – 49	384	117	30.5	25.8-35.1	267	69.5	64.9-74.2
50 – 59	362	128	35.4	30.4-40.3	234	64.6	59.7-69.6
60 – 69	170	59	34.7	27.5-41.9	111	65.3	58.1-72.5
≥ 70	50	16	32.0	18.6-45.4	34	68.0	54.6-81.4
<b>Нийт</b>	<b>1804</b>	<b>716</b>	<b>39.7</b>	<b>37.4-42.0</b>	<b>1088</b>	<b>60.3</b>	<b>58.1-62.6</b>


Урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдсан Говьсүмбэр аймгийн насанд хүрэгчдийн дундаж нас 41.8 (95%ИХ 41.2-42.5) жил байна. Эрт илрүүлэг үзлэгт хамрагдсан Говьсүмбэр аймгийн иргэдийн дундаж нас хүйсээр ялгаатай, эмэгтэйчүүдийн дундаж нас эрэгтэйчүүдээс 4.7 жилээр илүү байв (дундаж нас: эмэгтэйчүүд 43.7 жил, эрэгтэйчүүд 39.0 жил, p<0.0001).

## ХБӨ-ИЙ НИЙТЛЭГ ЭРСДЭЛТ ХҮЧИН ЗҮЙЛС ХАВСРАН ИЛЭРСЭН ХҮН АМ


Хүснэгт 126. ХБӨ-ИЙ НИЙТЛЭГ ЭРСДЭЛТ ХҮЧИН ЗҮЙЛС ХАВСРАН ИЛЭРСЭН ХҮН АМ ХҮЙСЭЭР

Хүн амын дунд (95% ИХ)	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
<b>ХБӨ-ий нийтлэг эрсдэлт хүчин зүйлс</b>			
<ul style="list-style-type: none"> <li>Өдөр бүр тамхи татдаг</li> <li>Өдөрт 5 нэгжээс бага хэмжээгээр жимс, ногоо хэрэглэдэг</li> <li>Хөдөлгөөний хомсдолтой</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Илүүдэл жинтэй (БЖИ <math>\geq 25</math> кг/м<sup>2</sup>)</li> <li>Артерийн даралт ихсэлттэй (САД <math>\geq 140</math> ба/эсвэл ДАД <math>\geq 90</math> мм МУБ эсвэл даралт бууруулах эм хэрэглэж байгаа)*</li> </ul>		
Нийтлэг эрсдэлт хүчин зүйлс илрээгүй хүн амын хувь	<b>1.8</b> (1.2 – 2.5)	<b>1.5</b> (0.8 – 2.7)	<b>2.0</b> (1.2 – 2.9)
Нийтлэг эрсдэлт хүчин зүйлсээс 1-2 эрсдэл хавсран илэрсэн хүн амын хувь	<b>50.0</b> (47.6 – 52.4)	<b>41.0</b> (37.3 – 44.8)	<b>55.8</b> (52.8 – 58.8)
Нийтлэг эрсдэлт хүчин зүйлсээс 3 ба түүнээс олон эрсдэл хавсран илэрсэн хүн амын хувь	<b>48.2</b> (45.8 – 50.6)	<b>57.5</b> (53.7 – 61.2)	<b>42.2</b> (39.2 – 45.3)

\*ДЭМБ-ын үзүүлэлтийг баримтлав.



Зураг 200. Нийтлэг эрсдэлт хүчин зүйлсээс 3 ба түүнээс олон эрсдэл хавсран илэрсэн хүн амын хувь, хүйсээр



Зураг 201. ХБӨ-өөр өвчлөх өндөр эрсдэлтэй хүн амын хувь, сумаар


### ГОЛ МЭДЭЭЛЭЛ

1. Эрт илрүүлэг үзлэгт хамрагдсан Говьсүмбэр аймгийн насанд хүрсэн хүн амын ХБӨ-өөр өвчлөх эрсдэлгүй хүн амын тархалт дөнгөж 1.8% байна.
2. Насанд хүрсэн хүн амын 2 хүн тутмын 1 нь (48.2%) нийтлэг эрсдэлт хүчин зүйлсээс 3 ба түүнээс олон эрсдэл хавсран илэрсэн байна.
3. Нас ахих тусам эрсдэлт хүчин зүйл хавсран илэрсэн хүн амын тоо өсөж байна.
4. Говьсүмбэр аймгийн Баянтал, Шивээговь сумын эрт ирүүлэг үзлэгт хамрагдсан насанд хүрэгчдийн тоо хэт цөөн байгаа тул Нийтлэг эрсдэлт хүчин зүйлсээс 3 ба түүнээс олон эрсдэл хавсран илэрсэн хүн амын хэрэглээг сумаар харьцуулан үнэлэх боломжгүй болно.

## ТАМХИНЫ ХЭРЭГЛЭЭ


Хүснэгт 127. Тамхины хэрэглээ хүйсээр

Насанд хүрсэн хүн амын дунд (95% ИХ)	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
Тамхи татдаг хүн амын хувь	<b>19.6</b> (17.7 – 21.5)	<b>44.6</b> (40.8 – 48.3)	<b>3.5</b> (2.4 – 4.6)
Өдөр бүр тамхи татдаг хүн амын хувь	<b>17.6</b> (15.8 – 19.49)	<b>39.9</b> (36.3 – 43.5)	<b>2.9</b> (1.9 – 3.9)
<i>Өдөр бүр тамхи татдаг хүн амын дунд:</i>			
Тамхи татаж эхэлсэн дундаж нас (жилээр)	<b>20.1</b> (19.3 – 20.8)	<b>19.2</b> (18.5 – 19.9)	<b>28.5</b> (24.6 – 32.5)



Зураг 202. Тамхи татдаг хүн ам, хүйс ба насны ангилал

## ГОЛ МЭДЭЭЛЭЛ




Зураг 203. Тамхи татдаг хүн амын тархалт, сумаар


1. Эрт илрүүлэг үзлэгт хамрагдсан Говьсүмбэр аймгийн насанд хүрсэн 5 хүн тутмын 1 нь (19.6%) тамхи татдаг бөгөөд эрэгтэйчүүдийн дунд тамхины хэрэглээ эмэгтэйчүүдээс 12.7 дахин их байна.
2. Өдөр бүр тамхи татдаг хүн амын хувь нийт тамхи татдаг хүмүүсийн 89.7%-ийг эзэлж байна.
3. Тамхи татаж эхэлсэн нас дунджаар 20.1 байна. 69 хүртэлх насны ангилалд тамхины хэрэглээ жигд өндөр байна.
4. Говьсүмбэр аймгийн Баянтал, Шивээговь сумын эрт ирүүлэг үзлэгт хамрагдсан насанд хүрэгчдийн тоо хэт цөөн байгаа тул тамхи татдаг хүн амын хэрэглээг сумаар харьцуулан үнэлэх боломжгүй болно.

**АРХИ, СОГТУУРУУЛАХ УНДААНЫ ХЭРЭГЛЭЭ**  
Хүснэгт 128. Архи, согтууруулах ундааны хэрэглээ хүйсээр

Насанд хүрсэн хүн амын дунд (95% ИХ)	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
Сүүлийн 1 сард стандарт уултаас илүү архи, согтууруулах ундаа хэрэглэсэн хүн амын хувь	<b>16.8</b> (15.0 – 18.6)	<b>29.6</b> (26.2 – 33.1)	<b>8.4</b> (6.7 – 10.1)



Зураг 204. Сүүлийн 1 сард стандарт уултаас илүү архи, согтууруулах ундаа хэрэглэсэн хүн ам, хүйс ба насны ангилалаар



Зураг 205. Сүүлийн 1 сард стандарт уултаас илүү архи, согтууруулах ундаа хэрэглэсэн хүн амын хувь, бүс нутгаар


**ГОЛ МЭДЭЭЛЭЛ**

1. Эрт илрүүлэг үзлэгт хамрагдсан Говьсүмбэр аймгийн насанд хүрсэн хүн амын сүүлийн 1 сард стандарт уултаас илүү архи, согтууруулах ундаа хэрэглэсэн хүн амын хувь 16.8% байх бөгөөд эрэгтэйчүүдийн дунд согтууруулах ундааны хэрэглээ эмэгтэйчүүдээс 3.5 дахин их байна.
2. Хөдөлмөрийн насны (20-59 нас) хүмүүсийн архины хэрэглээ бусад насны бүлэгтэй харьцуулахад их байна.
3. Говьсүмбэр аймгийн Баянтал, Шивээговь сумын эрт ирүүлэг үзлэгт хамрагдсан насанд хүрэгчдийн тоо хэт цөөн байгаа тул Сүүлийн 1 сард стандарт уултаас илүү архи, согтууруулах ундаа хэрэглэсэн хүн амыг сумаар харьцуулан үнэлэх боломжгүй болно.

## ХӨДӨЛГӨӨН


Хүснэгт 129. Хөдөлгөөн хүйсээр

Насанд хүрсэн хүн амын дунд (95% ИХ)	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
7 хоногийн 5-аас доошгүй өдөр 30 минутаас дээш дасгал хөдөлгөөн хийдэггүй, эсвэл 10000 алхдаггүй хүн амын хувь	<b>73.9</b> (71.8 – 75.9)	<b>67.8</b> (64.3 – 71.4)	<b>77.8</b> (75.3 – 80.3)



Зураг 206. 7 хоногийн 5-аас доошгүй өдөр 30 минутаас дээш дасгал хөдөлгөөн хийдэггүй, эсвэл 10000 алхдаггүй хүн амын тархалт, насны бүлгээр ба хүйсээр

## ГОЛ МЭДЭЭЛЭЛ




Зураг 207. 7 хоногийн 5-аас доошгүй өдөр 30 минутаас дээш дасгал хөдөлгөөн хийдэггүй, эсвэл 10000 алхдаггүй хүн амын тархалт, бүс нутгаар

1. Говь-сүмбэр аймгийн “Урьдчилан сэргийлэх эрт илрүүлэгт” хамрагдсан нийт хүн амын 73.9% нь 7 хоногийн 5-аас доошгүй өдөр 30 минутаас дээш дасгал хөдөлгөөн хийдэггүй, эсвэл 10000 алхдаггүй байна.
2. Хүйсээр авч үзвэл эмэгтэйчүүд (77.8%), эрэгтэйчүүдээс (67.8%) 10%-иар их, нас ахих тусам хөдөлгөөний идэвхгүй байдал нэмэгдэж байгаа нь ажиглагдав.
3. Говь-сүмбэр аймгийн Баянтал, Шивээговь сумын эрт ирүүлэг үзлэгт хамрагдсан насанд хүрэгчдийн тоо хэт цөөн байгаа тул 7 хоногийн 5-аас доошгүй өдөр 30 минутаас дээш дасгал хөдөлгөөн хийдэггүй, эсвэл 10000 алхдаггүй хүн амыг сумаар харьцуулан үнэлэх боломжгүй болно.


## ЖИМС, ЖИМСГЭНЭ, НОГООНЫ ХЭРЭГЛЭЭ

Хүснэгт 130. Жимс жимсгэнэ, ногооны хэрэглээ хүйсээр

Насанд хүрсэн хүн амын дунд (95% ИХ)	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
Зохистой хэрэглээтэй хүн амын хувь (хоногт $\geq 5$ нэгж буюу 400 г)	<b>40.2</b> (37.9-42.5)	<b>36.2</b> (32.6-39.8)	<b>42.8</b> (39.8-45.8)
Хангалтгүй хэрэглээтэй хүн амын хувь (хоногт $< 5$ нэгж /400 г)	<b>11.9</b> (10.4-13.4)	<b>15.3</b> (12.5-18.0)	<b>9.8</b> (8.0-11.6)
Жимс, ногоо бага хэрэглэдэг ХБӨ-ний эрсдэлтэй хүн амын хувь (жимс, ногоог өдөр бүр хэрэглэдэггүй эсвэл хоногт 400 граммаас бага хэрэглэдэг)	<b>59.8</b> (57.5-62.1)	<b>63.8</b> (60.2-67.4)	<b>57.2</b> (54.2-60.2)



Зураг 208. Жимс, жимсгэнэ, хүнсний ногоо бага хэрэглэдэг насанд хүрэгчдийн хувь, насны бүлгээр



Зураг 209. Жимс, жимсгэнэ, ногооны зохистой хэрэглээтэй насанд хүрэгчид, сумаар

### ГОЛ МЭДЭЭЛЭЛ


1. Говь-сүмбэр аймгийн насанд хүрэгчдийн 40.2% жимс, жимсгэнэ, хүнсний ногооны зохистой хэрэглээтэй буюу хоногт  $\geq 400$  г хэмжээгээр хэрэглэж байна. Жимс, жимсгэнэ, хүнсний ногооны зохистой хэрэглээтэй иргэдийн хувь эмэгтэйчүүдэд статистик ач холбогдол бүхий өндөр байв.
2. Эрт илрүүлэг үзлэгт хамрагдсан 18–86 насны иргэдийн 59.8% өдөр бүр жимс, ногоо хэрэглэдэггүй эсвэл хоногт 400 граммаас бага хэмжээгээр хэрэглэж байв. Говь-сүмбэр аймгийн насанд хүрсэн 3 хүн тутмын 2 орчим нь “Эрүүл хооллолтын ГЭР зөвлөмж”-д заасан хэмжээ (Хоногт  $\geq 400$ г)-ээр жимс, жимсгэнэ, хүнсний ногоо хэрэглэдэггүй буюу ХБӨ-өөр өвчлөх эрсдэлтэй байна.
3. Жимс, жимсгэнэ, хүнсний ногоо бага хэрэглэдэг буюу ХБӨ-өөр өвчлөх эрсдэлтэй насанд хүрэгчдийн хувь иргэдийн насны бүлгээр ялгаатай,  $\leq 19$  насны залуучууд,  $\geq 60$  насны иргэдийн дунд хамгийн өндөр, 30-49 насныхны дунд харьцангуй бага байв.
4. Говь-сүмбэр аймгийн Баянтал, Шивээговь сумын эрт ирүүлэг үзлэгт хамрагдсан насанд хүрэгчдийн тоо хэт цөөн байгаа тул жимс, жимсгэнэ, ногооны зохистой хэрэглээг сумаар харьцуулан үнэлэх боломжгүй болно.




## ИЛҮҮДЭЛ ЖИН БА ТАРГАЛАЛТ

Хүснэгт 131. Илүүдэл жин ба таргалалт хүйсээр

Насанд хүрсэн хүн амын дунд (95% ИХ)	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
Биеийн жингийн индекс (БЖИ)-ийн дундаж хэмжээ (кг/м <sup>2</sup> )	<b>27.1</b> (26.9-27.3)	<b>26.7</b> (26.3-27.0)	<b>27.4</b> (27.1-27.7)
Илүүдэл жин ба таргалалттай хүн амын хувь (БЖИ ≥ 25 кг/м <sup>2</sup> )	<b>62.8</b> (60.5-65.0)	<b>59.7</b> (56.0-63.3)	<b>64.8</b> (61.9-67.7)
Таргалалттай хүн амын хувь (БЖИ ≥ 30 кг/м <sup>2</sup> )	<b>25.0</b> (23.0-27.0)	<b>21.6</b> (18.5-24.7)	<b>27.2</b> (24.5-29.9)
Бүсэлхийн тойргийн дундаж хэмжээ (см)	-	<b>89.3</b> (88.4-90.3)	<b>88.9</b> (88.1-89.7)
Төвийн таргалалттай хүн амын хувь (Бүсэлхийн тойрог: эр ≥ 90 см, эм ≥ 80 см)	<b>64.1</b> (61.9-66.4)	<b>45.6</b> (41.8-49.3)	<b>76.1</b> (73.5-78.7)



Зураг 210. Илүүдэл жин ба таргалалтын тархалт, насны бүлгээр



Зураг 211. Илүүдэл жин ба таргалалтын тархалт, сумаар


## ГОЛ МЭДЭЭЛЭЛ

1. Урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдсан Говь-сүмбэр аймгийн насанд хүрэгчдийн БЖИ-ийн дундаж хэмжээ 27.1 кг/м<sup>2</sup> байгаа нь ДЭМБ-аас зөвлөсөн хэвийн хязгаараас хэтэрсэн байна. Эмэгтэйчүүдийн БЖИ-ийн дундаж хэмжээ эрэгтэйчүүдийн дундаж үзүүлэлтээс ялимгүй өндөр байв (p=0.003).
2. Насанд хүрэгчдийн 62.8% илүүдэл жин ба таргалалттай, 25.0% тарган байна. Илүүдэл жин ба таргалалтын тархалт эмэгтэйчүүдийн дунд статистик ач холбогдол бүхий өндөр байв. Илүүдэл жин ба таргалалтын тархалт аль ч хүйсийн насанд хүрэгчдийн дунд нас ахих тутам нэмэгдэх хандлага ажиглагдсан бөгөөд 40–69 насны 4 хүн тутмын 3 орчим нь илүүдэл жин ба таргалалттай байна. Говь-сүмбэр аймгийн 30–39 насны 4 хүн тутмын 1, 40–69 насны 3 хүн тутмын 1 орчим нь тарган байгааг илрүүлэв.
3. Говь-сүмбэр аймгийн эрт илрүүлэг үзлэгт хамрагдсан насанд хүрэгчдийн 64.1% төвийн таргалалттай, төвийн таргалалтын тархалт эмэгтэйчүүдийн дунд эрэгтэйчүүдээс 1.7 дахин өндөр байна.


## АРТЕРИЙН ГИПЕРТЕНЗИ

Хүснэгт 132. Артерийн гипертензи хүйсээр

Насанд хүрсэн хүн амын дунд (95% ИХ)	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
Систолийн артерийн даралт (САД)-ын дундаж хэмжээ, мм МУБ (даралт бууруулах эм хэрэглэж байгаа хүн амыг оролцуулсан)	<b>115.7</b> (115.0-116.4)	<b>117.6</b> (116.4-118.7)	<b>114.6</b> (113.6-115.5)
Диастолын артерийн даралт (ДАД)-ын дундаж хэмжээ, мм МУБ (даралт бууруулах эм хэрэглэж байгаа хүн амыг оролцуулсан)	<b>76.6</b> (76.1-77.1)	<b>77.6</b> (76.8-78.4)	<b>76.0</b> (75.3-76.7)
Артерийн даралт ихсэлттэй хүн амын хувь (САД = 120-129 мм МУБ ба/эсвэл ДАД ≤ 80 мм МУБ)	<b>25.2</b> (23.2-27.3)	<b>27.0</b> (23.6-27.3)	<b>24.1</b> (21.5-26.7)
Артерийн гипертензитай хүн амын хувь (САД ≥ 130 ба/эсвэл ДАД ≥ 81 мм МУБ эсвэл даралт бууруулах эм хэрэглэдэг хүн амын оролцуулсан)	<b>21.1</b> (19.1-23.1)	<b>21.9</b> (18.6-25.2)	<b>20.6</b> (18.1-23.1)



Зураг 212. Артерийн гипертензийн тархалт, насны бүлгээр



Зураг 213. Артерийн гипертензийн тархалт, сумаар


### ГОЛ МЭДЭЭЛЭЛ

1. Эрт илрүүлэг үзлэгт хамрагдсан Говь-сүмбэр аймгийн иргэдийн САД-ын дундаж хэмжээ 115.7 мм МУБ, ДАД-ын дундаж үзүүлэлт 76.6 мм МУБ байна.
2. Насанд хүрэгчдийн 25.2% артерийн даралт ихсэлттэй буюу САД нь 120–129 мм ба/эсвэл ДАД ≤ 80 мм МУБ байв. Артерийн даралт ихсэлтийн тархалт эрэгтэйчүүдийн дунд эмэгтэйчүүдээс бага зэрэг илүү байна.
3. Урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдсан Говь-сүмбэр аймгийн насанд хүрэгчдийн 21.1% артерийн гипертензи (АГ)-тэй буюу САД ≥ 130 мм МУБ ба ДАД ≥ 81 мм МУБ-аас дээш байна. АГ-ийн тархалтад хүйсийн ялгаа ажиглагдаагүй болно.
4. АГ-ийн тархалт иргэдийн нас ахих тутам нэмэгдэж, 50 ба түүнээс дээш насны 3 хүн тутмын 1-ээс илүү нь АГ-тэй байна. Говь-сүмбэр аймгийн Баянтал, Шивээговь сумаас эрт илрүүлэг үзлэгт хамрагдсан иргэдийн тоо харьцангуй цөөн байгаа тул насанд хүрэгчдийн дундах АГ-ийн тархалтыг сумаар харьцуулан үнэлэх боломжгүй байна.


## ЧИХРИЙН ШИЖИН

Хүснэгт 133. Чихрийн шижин хүйсээр

Насанд хүрсэн хүн амын дунд (95% ИХ)	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
Өлөн үеийн цусны глюкозын дундаж хэмжээ (ммоль/л), глюкоз бууруулах эм хэрэглэж буй хүн амыг оруулаад	<b>5.5</b> (5.4-5.6)	<b>5.7</b> (5.6-5.9)	<b>5.4</b> (5.3-5.5)
Өлөн үеийн цусны глюкозын өөрчлөлттэй хүн амын хувь (Ийлдсийн глюкозын хэмжээ $\geq 6.1$ ммол/л ба $< 7.0$ ммол/л)	<b>8.5</b> (7.0-10.1)	<b>12.1</b> (9.1-15.2)	<b>6.7</b> (5.0-8.3)
Өлөн үеийн цусны глюкозын хэмжээ ихэссэн болон глюкоз бууруулах эм хэрэглэж буй хүн амын хувь (Ийлдсийн глюкозын хэмжээ $\geq 7.0$ ммол/л)	<b>7.5</b> (6.1-8.9)	<b>10.2</b> (7.4-13.0)	<b>6.1</b> (4.5-7.7)



Зураг 214. Өлөн үеийн цусны глюкозын өөрчлөлттэй болон ЧШ-тэй хүн амын хувь, насны бүлгээр



Зураг 215. Өлөн үеийн цусны глюкозын өөрчлөлт, чихрийн шижингийн тархалт, сумаар


## ГОЛ МЭДЭЭЛЭЛ

1. Говь-сүмбэр аймгийн эрт ирүүлэг үзлэгт хамрагдсан насанд хүрэгчдийн өлөн үеийн цусны глюкозын дундаж хэмжээ 5.5 ммоль/л байв. Эрэгтэйчүүдийн цусны глюкозын дундаж хэмжээ нь эмэгтэйчүүдийн дундаж үзүүлэлтээс ялимгүй өндөр байна.
2. Насанд хүрэгчдийн 8.5% өлөн үеийн цусны глюкозын өөрчлөлттэй, 7.5% цусны глюкозын хэмжээ ихэссэн буюу чихрийн шижинтэй байв. Өлөн үеийн цусны глюкозын өөрчлөлт, чихрийн шижингийн тархалт нь иргэдийн насны бүлгээр ялгаатай, чихрийн шижингийн тархалт 20–29 насны иргэдийн дунд харьцангуй өндөр байна. Говь-сүмбэр аймгийн 18–29 насны залуучуудын дунд өлөн үеийн цусны глюкозын өөрчлөлтийн тохиолдол илрээгүй болно.
3. Говь-сүмбэр аймгийн насанд хүрэгчдийн дундах өлөн үеийн цусны глюкозын өөрчлөлт, чихрийн шижингийн тархалт эрэгтэйчүүдийн дунд статистик ач холбогдол бүхий өндөр байв.
4. Өлөн үеийн цусны глюкозын шинжилгээнд хамрагдсан иргэдийн тоо харилцан адилгүй, Баянтал, Шивээговь сумдад хэт цөөн байгаа тул цусны глюкозын өөрчлөлт болон чихрийн шижингийн тархалтыг сумаар харьцуулан дүгнэх боломжгүй байна.

## ӨЛӨН ҮЕИЙН ЦУСНЫ ЛИПИДЫН ҮНЭЛГЭЭ

Хүснэгт 134. Өлөн үеийн цусны липидын үнэлгээ хүйсээр

Насанд хүрсэн хүн амын дунд (95% ИХ)	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
“Өлөн үеийн цусны холестерин хэмжээ ихэссэн” гэж оношлогдож байсан хүн амын хувь	<b>1.8</b> (1.1-2.4)	<b>1.3</b> (0.5-2.1)	<b>2.1</b> (1.2-2.9)
Цусны нийт холестерин хэмжээ ихэссэн ( $\geq 5.3$ ммоль/л) хүн амын хувь	<b>16.3</b> (11.7-20.9)	<b>12.8</b> (7.0-18.5)	<b>20.3</b> (13.0-27.7)
“Өлөн үеийн цусны триглицеридийн хэмжээ ихэссэн” гэж оношлогдож байсан хүн амын хувь	<b>1.5</b> (0.9-2.0)	<b>1.2</b> (0.4-1.9)	<b>1.7</b> (0.9-2.5)
Цусны триглицеридийн хэмжээ ихэссэн ( $\geq 1.7$ ммоль/л) хүн амын хувь	<b>8.4</b> (4.9-11.8)	<b>6.8</b> (2.4-11.1)	<b>10.2</b> (4.6-15.7)



Зураг 216. Өлөн үеийн цусны липидын хэмжээ ихэссэн хүн амын хувь, насны бүлгээр



Зураг 217. Өлөн үеийн цусны нийт холестерин, триглицеридийн агууламж ихэссэн хүн амын хувь, сумаар


### ГОЛ МЭДЭЭЛЭЛ

1. Говь-сүмбэр аймгийн эрт илрүүлэгт хамрагдсан насанд хүрэгчдийн 1.8% цусны холестерин ихэссэн, харин 1.5% триглицеридийн агууламж ихэссэн гэж оношлогдож байжээ.
2. Насанд хүрэгчдийн 16.3% өлөн үеийн цусны нийт холестерин, 8.4% триглицеридийн агууламж ихэссэн байна. Говьсүмбэр аймгийн насанд хүрэгчдийн дундах дислипидемийн тархалтад хүйсийн ялгаа илээгүй болно.
3. Өлөн үеийн цусны холестерин ихсэлтийн тархалт иргэдийн настай шууд хамааралтайгаар нэмэгдэх хандлага илэрсэн ба Говь-сүмбэр аймгийн 40-59 насны 4 хүн тутмын 1,  $\geq 60$  насны 3 тутмын 1 нь нийт холестерин ихсэлттэй байна. Цусны триглицеридийн ихсэлтийн тохиолдол тус аймгийн  $\geq 70$  насны иргэдийн дунд харьцангуй түгээмэл илэрч байв.
4. Өлөн үеийн цусны липидийн шинжилгээнд хамрагдсан иргэдийн тоо харилцан адилгүй байгаа тул дислипидемийн тархалтыг сумаар харьцуулан дүгнэх боломжгүй болно.

## ХУВЬ ХҮНИЙ ЭРСДЭЛИЙН ҮНЭЛГЭЭ

Хүснэгт 135. Хувь хүний эрсдэлийн үнэлгээ хүйсээр

Насанд хүрсэн хүн амын дунд (95% ИХ)	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
Гэр бүлийн гишүүн чихрийн шижингээр өвчилж байсан <i>Өвөө, эмээ, нагац, авга Эцэг, эх, ах дүү, өөрийн хүүхэд</i>	<b>12.2</b> (8.4-16.0)	<b>7.1</b> (2.8-11.5)	<b>17.0</b> (10.9-23.2)
Жирэмсний чихрийн шижингээр өвчилж байсан	-	-	<b>4.5</b> (3.3-5.7)
Хавдраар өвчилж байсан түүх (гэр бүлийн гишүүн)	<b>12.0</b> (10.5-13.6)	<b>7.7</b> (5.7-9.7)	<b>14.8</b> (12.7-17.0)
Артерийн даралт бууруулах эм тогтмол хэрэглэдэг	<b>17.3</b> (15.5-19.0)	<b>12.5</b> (10.0-15.1)	<b>20.1</b> (17.7-22.5)
Цусны өөх тос бууруулах эм хэрэглэж байгаа	<b>4.6</b> (3.6-5.6)	<b>3.4</b> (2.0-4.8)	<b>5.4</b> (4.0-6.8)



Зураг 218. “Гэр бүлийн хэн нэгэн гишүүн нь чихрийн шижин, хавдраар өвчилж байсан” гэж хариулсан насанд хүрэгчдийн хувь, насны бүлгээр


### ГОЛ МЭДЭЭЛЭЛ

1. Эрт илрүүлэг үзлэгт хамрагдсан Говьсүмбэр аймгийн насанд хүрэгчдийн 12.2% гэр бүлийн хэн нэгэн гишүүн “чихрийн шижингээр өвчилсөн”, 12.0% хавдраар өвчилсөн гэж хариулсан байна. Нийт эмэгтэйчүүдийн 4.5% жирэмсний чихрийн шижин оношлогдож байжээ.
2. Урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдсан Говьсүмбэр аймгийн иргэдийн 17.3% артерийн даралт бууруулах эмийг тогтмол хэрэглэдэг, харин 4.6% цусны өөх тос бууруулах эмийг одоо хэрэглэж байв.
3. Гэр бүлийн хэн нэгэн гишүүн чихрийн шижингээр өвчилсөн гэж хариулсан насанд хүрэгчдийн үзүүлэлтийг насны бүлгээр харьцуулан судлахад статистик ач холбогдол бүхий ялгаа илрээгүй болно. Гэхдээ 30–39 насны залуучуудын дунд уг өгүүлэмж хамгийн их, ≤19 насны бүлэгт хамгийн бага байв.
4. Гэр бүлийн хэн нэгэн гишүүн хавдраар өвчилсөн гэж хариулсан насанд хүрэгчдийн хувь тэдний насны бүлгээр ялгаатай, 18 – 49 насны иргэдийн дунд наснаас шууд хамааралтай ихсэх зүй тогтол ажиглагдсан бөгөөд ≥50 насны иргэдийн дунд тус өгүүлэмж нас ахих тутам буурч байна.

**ЗАВХАН АЙМГИЙН НАСАНД ХҮРЭГЧДИЙН ДУНДАХ  
ХАЛДВАРТ БУС ӨВЧНИЙ ЭРСДЭЛТ ХҮЧИН ЗҮЙЛСИЙН  
ТАРХАЛТ**

**ТАНИЛЦУУЛГА**

Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/248 дугаар тушаалыг хэрэгжүүлэх арга хэмжээний хүрээнд 2022 оны 5 дугаар сарын 3-ны өдрөөс 2023 оны 5 дугаар сарын 1 хүртэлх хугацаанд эрт илрүүлэг, урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдсан Завхан аймгийн 10,080 насанд хүрэгчдийн мэдээллийг нэгтгэн, тэдний дунд түгээмэл тохиолдож буй халдварт бус өвчин (ХБӨ)-ий эрсдэлт хүчин зүйлсийн тархалтын байдалд дүн шинжилгээ хийв (Зураг 229).



Зураг 219. Эрт илрүүлэг үзлэгт хамрагдсан насанд хүрэгчдийн тоо, сумын дүнгээр

Эрт илрүүлэг, урьдчилан сэргийлэх үзлэгт Завхан аймгийн 18–92 насны нийт 10,080 хүн хамрагдсан бөгөөд тэдний 39.7% (n=3,998) эрэгтэйчүүд, 60.3% (n=6,083) эмэгтэйчүүд байв (Хүснэгт 136).

Хүснэгт 136. Эрт илрүүлэгт хамрагдсан насанд хүрэгчид, нас бүлэг ба хүйсээр

Насны бүлэг, жилээр	N	Эрэгтэй			Эмэгтэй		
		Тоо	Хувь	95% ИХ	Тоо	Хувь	95% ИХ
≤ 19	324	217	67.0	61.8-72.1	107	33.0	27.9-38.2
20 – 29	1240	555	44.8	42.0-47.5	685	55.2	52.5-58.0
30 – 39	1919	705	36.7	34.6-38.9	1214	63.3	61.1-65.4
40 – 49	2532	918	36.3	34.4-38.1	1614	63.7	61.9-65.6
50 – 59	2426	953	39.3	37.3-41.2	1473	60.7	58.8-62.7
60 – 69	1243	495	39.8	37.1-42.6	748	60.2	57.5-62.9
≥ 70	393	155	39.1	34.3-44.0	241	60.9	56.0-65.7
<b>Нийт</b>	<b>10,080</b>	<b>3,998</b>	<b>39.7</b>	<b>38.7-40.6</b>	<b>6,082</b>	<b>60.3</b>	<b>59.4-61.3</b>


Урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдсан Завхан аймгийн насанд хүрэгчдийн дундаж нас 45.3 (95%ИХ 45.1-45.6) жил байна. Эрт илрүүлэг үзлэгт хамрагдсан эмэгтэйчүүдийн дундаж нас эрэгтэйчүүдийн дундаж үзүүлэлтээс ялимгүй илүү байна (дундаж нас: эр 44.5 жил, эм 45.9 жил).

## ХБӨ-ИЙ НИЙТЛЭГ ЭРСДЭЛТ ХҮЧИН ЗҮЙЛС ХАВСРАН ИЛЭРСЭН ХҮН АМ


Хүснэгт 137. ХБӨ-ий нийтлэг эрсдэлт хүчин зүйлс хавсран илэрсэн хүн ам хүйсээр

Хүн амын дунд (95% ИХ)	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
<b>ХБӨ-ий нийтлэг эрсдэлт хүчин зүйлс</b>			
<ul style="list-style-type: none"> <li>Өдөр бүр тамхи татдаг</li> <li>Өдөрт 5 нэгжээс бага хэмжээгээр жимс, ногоо хэрэглэдэг</li> <li>Хөдөлгөөний хомсдолтой</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Илүүдэл жинтэй (БЖИ <math>\geq 25</math> кг/м<sup>2</sup>)</li> <li>Артерийн даралт ихсэлттэй (САД <math>\geq 140</math> ба/эсвэл ДАД <math>\geq 90</math> мм МУБ эсвэл даралт бууруулах эм хэрэглэж байгаа)*</li> </ul>		
Нийтлэг эрсдэлт хүчин зүйлс илрээгүй хүн амын хувь	<b>1.5</b> (1.2 – 1.7)	<b>1.0</b> (0.7 – 1.3)	<b>1.8</b> (1.5 – 2.1)
Нийтлэг эрсдэлт хүчин зүйлсээс 1-2 эрсдэл хавсран илэрсэн хүн амын хувь	<b>46.1</b> (45.1 – 47.1)	<b>39.7</b> (38.2 – 41.3)	<b>50.4</b> (49.1 – 51.7)
Нийтлэг эрсдэлт хүчин зүйлсээс 3 ба түүнээс олон эрсдэл хавсран илэрсэн хүн амын хувь	<b>52.4</b> (51.4 – 53.4)	<b>59.3</b> (57.7 – 60.8)	<b>47.8</b> (46.5 – 49.1)

\*ДЭМБ-ын үзүүлэлтийг баримтлав.



Зураг 220. Нийтлэг эрсдэлт хүчин зүйлсээс 3 ба түүнээс олон эрсдэл хавсран илэрсэн хүн амын хувь, хүйсээр



Зураг 221. ХБӨ-өөр өвчлөх өндөр эрсдэлтэй хүн амын хувь, сумаар


## ГОЛ МЭДЭЭЛЭЛ

1. Эрт илрүүлэг үзлэгт хамрагдсан Завхан аймгийн насанд хүрсэн хүн амын ХБӨ-өөр өвчлөх эрсдэлгүй хүн амын тархалт дөнгөж 1.5% байна.
2. Насанд хүрсэн хүн амын 2 хүн тутмын 1 нь (52.4%) нийтлэг эрсдэлт хүчин зүйлсээс 3 ба түүнээс олон эрсдэл хавсран илэрсэн байна.
3. Нас ахих тусам эрсдэлт хүчин зүйл хавсран илэрсэн хүн амын тоо өсөж байна.
4. Түдэвтэй, Баянхайрхан, Асгат, Нөмрөг, Тэс, Алдархаан, Яруу, Отгон, Цагаанчулуут, Цагаанхайрхан, Тосонцэнгэл сумуудад Нийтлэг эрсдэлт хүчин зүйлсээс 3 ба түүнээс олон эрсдэл хавсран илэрсэн хүн амын хувь аймгийн дундаж (52.4%)-аас өндөр байна.


## ТАМХИНЫ ХЭРЭГЛЭЭ

Хүснэгт 138. Тамхины хэрэглээ хүйсээр

Насанд хүрсэн хүн амын дунд (95% ИХ)	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
Тамхи татдаг хүн амын хувь	<b>18.1</b> (17.3 – 18.8)	<b>43.2</b> (41.7 – 44.8)	<b>1.4</b> (1.1 – 1.7)
Өдөр бүр тамхи татдаг хүн амын хувь	<b>14.3</b> (13.5 – 14.9)	<b>34.5</b> (33.1 – 36.0)	<b>0.8</b> (0.6 – 1.1)
<i>Өдөр бүр тамхи татдаг хүн амын дунд:</i>			
Тамхи татаж эхэлсэн дундаж нас (жилээр)	<b>19.9</b> (19.5 – 20.3)	<b>19.5</b> (19.1 – 19.9)	<b>29.7</b> (26.3 – 33.0)



Зураг 222. Тамхи татдаг хүн ам, хүйс ба насны ангилал



Зураг 223. Тамхи татдаг хүн амын тархалт, сумаар

## ГОЛ МЭДЭЭЛЭЛ


1. Эрт илрүүлэг үзлэгт хамрагдсан Завхан аймгийн насанд хүрсэн 5 хүн тутмын 1 нь (18.1%) тамхи татдаг бөгөөд эрэгтэйчүүдийн дунд тамхины хэрэглээ эмэгтэйчүүдээс 30.8 дахин их байна.
2. Өдөр бүр тамхи татдаг хүн амын хувь нийт тамхи татдаг хүмүүсийн 79.0%-ийг эзэлж байна.
3. Тамхи татаж эхэлсэн нас дунджаар 19.9 байна.
4. 30-69 нас хүртэлх насны ангилалд тамхины хэрэглээ жигд өндөр байна.
5. Баянхайрхан, Түдэвтэй, Отгон, Тэлмэн, Нөмрөг, Тосонцэнгэл, Цагаанхайрхан, Тэс, Алдархаан, Яруу, Эрдэнэхайрхан, Шилүүстэй сумуудад тамхи татдаг хүн амын хувь аймгийн дундаж (18.1%)-аас өндөр байна.



## АРХИ, СОГТУУРУУЛАХ УНДААНЫ ХЭРЭГЛЭЭ

Хүснэгт 139. Архи, согтууруулах ундааны хэрэглээ хүйсээр

Насанд хүрсэн хүн амын дунд (95% ИХ)	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
Сүүлийн 1 сард стандарт уултаас илүү архи, согтууруулах ундаа хэрэглэсэн хүн амын хувь	<b>7.4</b> (6.8 – 7.9)	<b>14.2</b> (13.1 – 15.3)	<b>2.9</b> (2.4 – 3.3)



Зураг 224. Сүүлийн 1 сард стандарт уултаас илүү архи, согтууруулах ундаа хэрэглэсэн хүн ам, хүйс ба насны бүлгээр



Зураг 225. Сүүлийн 1 сард стандарт уултаас илүү архи, согтууруулах ундаа хэрэглэсэн хүн амын хувь, сумаар


### ГОЛ МЭДЭЭЛЭЛ

1. Эрт илрүүлэг үзлэгт хамрагдсан Завхан аймгийн насанд хүрсэн хүн амын сүүлийн 1 сард стандарт уултаас илүү архи, согтууруулах ундаа хэрэглэсэн хүн амын хувь 7.4% байх бөгөөд эрэгтэйчүүдийн дунд согтууруулах ундааны хэрэглээ эмэгтэйчүүдээс 4.9 дахин их байна.
2. Хөдөлмөрийн насны (30-59 нас) хүмүүсийн архины хэрэглээ бусад насны бүлэгтэй харьцуулахад их байна.
3. Түдэвтэй, Баянхайрхан, Асгат, Ургамал, Цагаанхайрхан, Сонгино, Тэс сумуудад Сүүлийн 1 сард стандарт уултаас илүү архи, согтууруулах ундаа хэрэглэсэн хүн амын хувь аймгийн дундаж (7.4%)-аас өндөр байна.


## ХӨДӨЛГӨӨН

Хүснэгт 140. Хөдөлгөөн хүйсээр

Насанд хүрсэн хүн амын дунд (95% ИХ)	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
7 хоногийн 5-аас доошгүй өдөр 30 минутаас дээш дасгал хөдөлгөөн хийдэггүй, эсвэл 10000 алхдаггүй хүн амын хувь	<b>53.7</b> (52.7 – 54.6)	<b>50.1</b> (48.6 – 51.7)	<b>56.0</b> (54.8 – 57.3)



Зураг 226. 7 хоногийн 5-аас доошгүй өдөр 30 минутаас дээш дасгал хөдөлгөөн хийдэггүй, эсвэл 10000 алхдаггүй хүн амын тархалт, насны бүлгээр ба хүйсээр



Зураг 227. 7 хоногийн 5-аас доошгүй өдөр 30 минутаас дээш дасгал хөдөлгөөн хийдэггүй, эсвэл 10000 алхдаггүй хүн амын тархалт, сумаар


### ГОЛ МЭДЭЭЛЭЛ

1. Завхан аймгийн “Урьдчилан сэргийлэх эрт илрүүлэгт” хамрагдсан нийт хүн амын 53.7% нь 7 хоногийн 5-аас доошгүй өдөр 30 минутаас дээш дасгал хөдөлгөөн хийдэггүй, эсвэл 10000 алхдаггүй байна.
2. Хүйсээр авч үзвэл эмэгтэйчүүд (56%), эрэгтэйчүүдээс (50.1%) 5.9%-иар их, нас ахих тусам хөдөлгөөний идэвхгүй байдал нэмэгдэж байгаа нь ажиглагдав.
3. Баянхайрхан, Асгат, Түдэвтэй, Тосонцэнгэл, Яруу, Шилүүстэй, Сонгино, Отгон, Тэлмэн, Эрдэнэхайрхан, Тэс, Нөмрөг, Их-уул сумуудад 7 хоногийн 5-аас доошгүй өдөр 30 минутаас дээш дасгал хөдөлгөөн хийдэггүй, эсвэл 10000 алхдаггүй хүн амын хувь аймгийн дундаж (53.7%)-аас өндөр байна.


## ЖИМС, ЖИМСГЭНЭ, НОГООНЫ ХЭРЭГЛЭЭ

Хүснэгт 141. Жимс, жимсгэнэ, ногооны хэрэглээ хүйсээр

Насанд хүрсэн хүн амын дунд (95% ИХ)	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
Зохистой хэрэглээтэй хүн амын хувь (хоногт $\geq 5$ нэгж буюу 400 г)	<b>13.6</b> (12.9-14.3)	<b>11.4</b> (10.4-12.4)	<b>15.1</b> (14.2-16.0)
Хангалтгүй хэрэглээтэй хүн амын хувь (хоногт $< 5$ нэгж /400 г)	<b>31.7</b> (30.8-32.6)	<b>30.3</b> (28.9-31.7)	<b>32.7</b> (31.5-33.9)
Жимс, ногоо бага хэрэглэдэг ХБӨ-ний эрсдэлтэй хүн амын хувь (жимс, ногоог өдөр бүр хэрэглэдэггүй эсвэл хоногт 400 граммаас бага хэрэглэдэг)	<b>86.4</b> (85.7-87.1)	<b>88.6</b> (87.7-89.6)	<b>84.9</b> (84.0-85.8)



Зураг 228. Жимс, жимсгэнэ, хүнсний ногоо бага хэрэглэдэг насанд хүрэгчдийн хувь, насны бүлгээр



Зураг 229. Жимс, жимсгэнэ, ногооны зохистой хэрэглээтэй насанд хүрэгчид, сумаар


### ГОЛ МЭДЭЭЛЭЛ

1. Завхан аймгийн насанд хүрэгчдийн дөнгөж 13.6% жимс, жимсгэнэ, хүнсний ногооны зохистой хэрэглээтэй буюу хоногт  $\geq 400$  г хэмжээгээр хэрэглэж байна. Жимс, жимсгэнэ, хүнсний ногооны зохистой хэрэглээтэй иргэдийн хувь хүйс болон байршлаар ялгаатай, зохистой хэрэглээтэй эмэгтэйчүүдийн хувь эрэгтэйчүүдийн дундаж үзүүлэлтээс статистик ач холбогдол бүхий өндөр, Түдэвтэй, Идэр, Баянхайрхан, Сантмаргац сумдад харьцангуй бага байв.
2. Эрт илрүүлэг үзлэгт хамрагдсан Завхан аймгийн 18-92 насны иргэдийн 86.4% өдөр бүр жимс, ногоо хэрэглэдэггүй эсвэл хоногт 400 граммаас бага хэмжээгээр хэрэглэж байна. Завхан аймгийн насанд хүрсэн 5 хүн тутмын 4 нь “Эрүүл хооллолтын ГЭР зөвлөмж”-д заасан хэмжээ (Хоногт  $\geq 400$ г)-гээр жимс, жимсгэнэ, хүнсний ногоо хэрэглэдэггүй буюу ХБӨ-өөр өвчлөх эрсдэлтэй байна.
3. Жимс, жимсгэнэ, хүнсний ногоо бага хэрэглэдэг буюу ХБӨ-өөр өвчлөх эрсдэлтэй насанд хүрэгчдийн тархалт иргэдийн насны бүлгээр ялгаатай,  $\geq 40$  насны иргэдийн дунд хамгийн өндөр байв.

## ИЛҮҮДЭЛ ЖИН БА ТАРГАЛАЛТ

Хүснэгт 142. Илүүдэл жин ба таргалалт хүйсээр

Насанд хүрсэн хүн амын дунд (95% ИХ)	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
Биеийн жингийн индекс (БЖИ)-ийн дундаж хэмжээ (кг/м <sup>2</sup> )	<b>26.3</b> (26.2-26.4)	<b>26.0</b> (25.9-26.1)	<b>26.5</b> (26.4-26.6)
Илүүдэл жин ба таргалалттай хүн амын хувь (БЖИ ≥ 25 кг/м <sup>2</sup> )	<b>56.0</b> (55.0-57.0)	<b>55.0</b> (53.5-56.6)	<b>56.7</b> (55.4-58.0)
Таргалалттай хүн амын хувь (БЖИ ≥ 30 кг/м <sup>2</sup> )	<b>18.7</b> (17.9-19.5)	<b>15.7</b> (14.6-16.8)	<b>20.7</b> (19.6-21.7)
Бүсэлхийн тойргийн дундаж хэмжээ (см)	-	<b>87.7</b> (87.3-88.2)	<b>84.7</b> (84.4-85.0)
Төвийн таргалалттай хүн амын хувь (Бүсэлхийн тойрог: эр ≥ 90 см, эм ≥ 80 см)	<b>50.1</b> (49.1-51.1)	<b>39.4</b> (37.9-41.0)	<b>57.2</b> (56.0-58.5)



Зураг 230. Илүүдэл жин ба таргалалтын тархалт, насны бүлгээр



Зураг 231. Таргалалтын тархалт (БЖИ≥30 кг/м<sup>2</sup>), сумаар


## ГОЛ МЭДЭЭЛЭЛ

1. Завхан аймгийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдсан насанд хүрэгчдийн БЖИ-ийн дундаж хэмжээ 26.3 кг/м<sup>2</sup> байгаа нь ДЭМБ-аас зөвлөсөн хэвийн хязгаараас хэтэрсэн байна. Иргэдийн БЖИ-ийн дундаж хэмжээ нь хүйс болон насны бүлгээр ялгаатай, эмэгтэйчүүдэд ялимгүй өндөр байв.
2. Насанд хүрэгчдийн 56.0% илүүдэл жин ба таргалалттай, 18.7% тарган байна. Таргалалтын тархалт эмэгтэйчүүдийн дунд 5.0 хувиар илүү байв. Илүүдэл жин ба таргалалтын тархалт аль ч хүйсийн насанд хүрэгчдийн дунд нас ахих тутам нэмэгдэх хандлага ажиглагдсан бөгөөд 30–39 насны 2 хүн тутмын 1-ээс илүү, 40 насны 10 хүн тутмын 6 нь илүүдэл жин ба таргалалттай байна. Мөн Завхан аймгийн ≥ 30 насны 5 хүн тутмын 1 орчим нь тарган байв. Таргалалтын тархалт Тэс, Түдэвтэй сумын насанд хүрэгчдийн дунд харьцангуй өндөр байв.
3. Завхан аймгийн эрт илрүүлэг үзлэгт хамрагдсан насанд хүрэгчдийн 50.1% төвийн таргалалттай, төвийн таргалалтын тархалт эмэгтэйчүүдийн дунд эрэгтэйчүүдээс 1.4 дахин өндөр байна (p<0.0001).

## АРТЕРИЙН ГИПЕРТЕНЗИ


Хүснэгт 143. Артерийн гипертензи хүйсээр

Насанд хүрсэн хүн амын дунд (95% ИХ)	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
Систолын артерийн даралт (САД)-ын дундаж хэмжээ, мм МУБ (даралт бууруулах эм хэрэглэж байгаа хүн амыг оролцуулсан)	<b>118.3</b> (118.0-118.6)	<b>119.9</b> (119.4-120.3)	<b>117.2</b> (116.8-117.6)
Диастолын артерийн даралт (ДАД)-ын дундаж хэмжээ, мм МУБ (даралт бууруулах эм хэрэглэж байгаа хүн амыг оролцуулсан)	<b>77.9</b> (77.7-78.1)	<b>79.0</b> (78.6-79.3)	<b>77.2</b> (76.9-77.4)
Артерийн даралт ихсэлттэй хүн амын хувь (САД = 120-129 мм МУБ ба/эсвэл ДАД ≤ 80 мм МУБ)	<b>36.4</b> (35.5-37.4)	<b>40.8</b> (39.3-42.3)	<b>33.5</b> (32.3-34.7)
Артерийн гипертензитэй хүн амын хувь (САД ≥ 130 ба/эсвэл ДАД ≥ 81 мм МУБ эсвэл даралт бууруулах эм хэрэглэдэг хүн амын оролцуулсан)	<b>24.0</b> (23.2-24.8)	<b>25.4</b> (24.1-26.8)	<b>23.1</b> (22.0-24.1)



Зураг 232. Артерийн гипертензийн тархалт, насны бүлгээр

## ГОЛ МЭДЭЭЛЭЛ




Зураг 233. Артерийн гипертензийн тархалт, сумаар

1. Эрт илрүүлэг үзлэгт хамрагдсан Завхан аймгийн насанд хүрэгчдийн САД-ын дундаж хэмжээ 118.3 мм МУБ, ДАД-ын дундаж үзүүлэлт 77.9 мм МУБ байна.
2. Нийт иргэдийн 36.4% артерийн даралт ихсэлттэй буюу САД нь 120–129 мм ба/эсвэл ДАД ≤ 80 мм МУБ байв.
3. Урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдсан Завхан аймгийн насанд хүрэгчдийн 29.8% артерийн гипертензи (АГ)-тэй буюу САД ≥ 130 мм МУБ ба ДАД ≥ 81 мм МУБ-аас дээш байгаа нь анхаарал татаж байна. АГ-ийн тархалт эрэгтэйчүүдийн дунд эмэгтэйчүүдийн үзүүлэлтээс бага зэрэг өндөр байв ( $p < 0.0001$ ).
4. Завхан аймгийн насанд хүрэгчдийн дундах АГ-ийн тархалт тэдний настай шууд хамааралтайгаар нэмэгдэх хандлага ажиглагдсан болно. Тодруулбал, 40–49 насны 5 хүн тутмын 1, 50–59 насны 3 хүн тутмын 1, ≥ 60 насны иргэдийн тал орчим хувь нь тус тус АГ-тэй байна. АГ-ийн тархалтыг сумаар харьцуулан үнэлэхэд Нөмрөг, Түдэвтэй, Тэс суманд харьцангуй өндөр, Асгат, Сонгино сумын иргэдийн дунд хамгийн бага байв.

## ЧИХРИЙН ШИЖИН


Хүснэгт 144. Чихрийн шижин хүйсээр

Насанд хүрсэн хүн амын дунд (95% ИХ)	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
Өлөн үеийн цусны глюкозын дундаж хэмжээ (ммоль/л), глюкоз бууруулах эм хэрэглэж буй хүн амыг оруулаад	<b>5.5</b> (5.4-5.5)	<b>5.7</b> (5.6-5.7)	<b>5.4</b> (5.4-5.5)
Өлөн үеийн цусны глюкозын өөрчлөлттэй хүн амын хувь (Ийлдсийн глюкозын хэмжээ $\geq 6.1$ ммол/л ба $< 7.0$ ммол/л)	<b>10.3</b> (9.7-11.0)	<b>12.1</b> (11.0-13.2)	<b>9.2</b> (8.4-10.0)
Өлөн үеийн цусны глюкозын хэмжээ ихэссэн болон глюкоз бууруулах эм хэрэглэж буй хүн амын хувь (Ийлдсийн глюкозын хэмжээ $\geq 7.0$ ммол/л)	<b>8.9</b> (8.3-9.5)	<b>10.7</b> (9.6-11.7)	<b>7.8</b> (7.1-8.5)



Зураг 234. Өлөн үеийн цусны глюкозын өөрчлөлттэй болон ЧШ-тэй хүн амын хувь, насны бүлгээр

## ГОЛ МЭДЭЭЛЭЛ




Зураг 235. Чихрийн шижингийн тархалт, сумаар

1. Завхан аймгийн эрт ирүүлэг үзлэгт хамрагдсан насанд хүрэгчдийн өлөн үеийн цусны глюкозын дундаж хэмжээ 5.5 ммоль/л байна. Эрэгтэйчүүдийн цусны глюкозын дундаж хэмжээ нь эмэгтэйчүүдийн дундаж үзүүлэлтээс статистик ач холбогдол бүхий өндөр байв.
2. Насанд хүрэгчдийн 10.3% өлөн үеийн цусны глюкозын өөрчлөлттэй, 8.9% цусны глюкозын хэмжээ ихэссэн буюу чихрийн шижинтэй байна. Чихрийн шижингийн тархалт нь иргэдийн бүлгээр ялгаатай, нас ахих тутам нэмэгдэх хандлага ажиглагдсан болно. Өлөн үеийн цусны өөрчлөлттэй иргэдийн тархалт  $\leq 19$  насны залуучуудын дунд 7.5% байгаа нь анхаарал татаж байна. Мөн  $\geq 70$  насны иргэдийн дунд цусны глюкозын өөрчлөлтийн тархалт харьцангуй өндөр байв.
3. Завхан аймгийн насанд хүрэгчдийн дундах өлөн үеийн цусны глюкозын өөрчлөлт, чихрийн шижингийн тархалтад статистик ач холбогдол бүхий хүйсийн ялгаа илэрсэн болно.
4. Цусны глюкозын шинжилгээнд хамрагдсан иргэдийн тоо харилцан адилгүй, зарим сумдад цөөн байгаа тул Завхан аймгийн насанд хүрэгчдийн дундах чихрийн шижингийн тархалтыг сумаар харьцуулан дүгнэх боломжгүй байна.


## ӨЛӨН ҮЕИЙН ЦУСНЫ ЛИПИДЫН ҮНЭЛГЭЭ

Хүснэгт 145. Өлөн үеийн цусны липидын үнэлгээ хүйсээр

Насанд хүрсэн хүн амын дунд (95% ИХ)	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
“Өлөн үеийн цусны холестерин хэмжээ ихэссэн” гэж оношлогдож байсан хүн амын хувь	<b>5.4</b> (4.9-5.8)	<b>5.3</b> (4.6-6.0)	<b>5.4</b> (4.9-6.0)
Цусны нийт холестерин хэмжээ ихэссэн ( $\geq 5.3$ ммоль/л) хүн амын хувь	<b>20.1</b> (19.1-21.1)	<b>21.2</b> (19.6-22.9)	<b>19.3</b> (18.1-20.6)
“Өлөн үеийн цусны триглицеридийн хэмжээ ихэссэн” гэж оношлогдож байсан хүн амын хувь	<b>3.6</b> (3.2-4.0)	<b>3.8</b> (3.2-4.4)	<b>3.5</b> (3.0-4.0)
Цусны триглицеридийн хэмжээ ихэссэн ( $\geq 1.7$ ммоль/л) хүн амын хувь	<b>8.3</b> (7.7-9.0)	<b>11.4</b> (10.2-12.7)	<b>6.4</b> (5.6-7.2)



Зураг 236. Өлөн үеийн цусны липидын хэмжээ ихэссэн хүн амын хувь, насны бүлгээр



Зураг 237. Өлөн үеийн цусны нийт холестерин агууламж ихэссэн хүн амын хувь, сумаар


## ГОЛ МЭДЭЭЛЭЛ

1. Завхан аймгийн эрт илрүүлэгт хамрагдсан насанд хүрэгчдийн 5.4% цусны холестерин ихэссэн, харин 3.6% триглицеридийн агууламж ихэссэн гэж оношлогдож байжээ.
2. Насанд хүрэгчдийн 20.1% өлөн үеийн цусны нийт холестерин, 8.3% триглицеридийн агууламж ихэссэн байна. Завхан аймгийн насанд хүрэгчдийн дундах дислипидемийн тархалтад хүйсийн ялгаа ажиглагдсан бөгөөд цусны триглицеридийн ихсэлт эрэгтэйчүүдийн дунд эмэгтэйчүүдээс 5.0 хувиар илүү байв.
3. Өлөн үеийн цусны холестерин, триглицеридийн ихсэлтийн тархалт иргэдийн настай шууд хамааралтайгаар нэмэгдэх хандлага илэрсэн ба Завхан аймгийн  $\geq 40$  насны 4 тутмын 1 нь цусны нийт холестерин ихсэлттэй буюу судасны хагуурал үүсэх эрсдэлтэй байна.
4. Өлөн үеийн цусны липидын шинжилгээнд хамрагдсан иргэдийн тоо харилцан адилгүй байгаа хэдий ч, Завханмандал, Сантмаргац, Их-уул, Тэс зэрэг сумын иргэдийн дунд харьцангуй өндөр тархалт ажиглагдсан болно. Гэхдээ эдгээр сумын шинжилгээнд хамрагдсан иргэдийн тоо цөөн байгааг анхаарах зүйтэй.

## ХУВЬ ХҮНИЙ ЭРСДЭЛИЙН ҮНЭЛГЭЭ

Хүснэгт 146. Хувь хүний эрсдэлийн үнэлгээ хүйсээр

Насанд хүрсэн хүн амын дунд (95% ИХ)	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
Гэр бүлийн гишүүн чихрийн шижингээр өвчилж байсан <i>Өвөө, эмээ, нагац, авга Эцэг, эх, ах дүү, өөрийн хүүхэд</i>	<b>7.6</b> (6.9-8.2)	<b>6.3</b> (5.3-7.2)	<b>8.4</b> (7.5-9.3)
Жирэмсний чихрийн шижингээр өвчилж байсан	-	-	<b>4.8</b> (4.3-5.3)
Хавдраар өвчилж байсан түүх (гэр бүлийн гишүүн)	<b>10.7</b> (10.1-11.4)	<b>8.7</b> (7.8-9.6)	<b>12.1</b> (11.3-12.9)
Артерийн даралт бууруулах эм тогтмол хэрэглэдэг	<b>19.2</b> (18.4-20.0)	<b>14.6</b> (13.5-15.7)	<b>22.2</b> (21.2-23.3)
Цусны өөх тос бууруулах эм хэрэглэж байгаа	<b>8.0</b> (7.5-8.5)	<b>7.3</b> (6.5-8.1)	<b>8.4</b> (7.7-9.1)



Зураг 238. “Гэр бүлийн хэн нэгэн гишүүн нь чихрийн шижин, хавдраар өвчилж байсан” гэж хариулсан насанд хүрэгчдийн хувь, насны бүлгээр

### ГОЛ МЭДЭЭЛЭЛ


1. Эрт илрүүлэг үзлэгт хамрагдсан Завхан аймгийн насанд хүрэгчдийн 7.6% гэр бүлийн хэн нэгэн гишүүн “чихрийн шижингээр өвчилсөн”, 10.7% хавдраар өвчилсөн гэж хариулсан байна. Нийт эмэгтэйчүүдийн 4.8% жирэмсний чихрийн шижин оношлогдож байжээ.
2. Урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдсан Завхан аймгийн иргэдийн 19.2% артерийн даралт бууруулах эмийг тогтмол хэрэглэдэг, харин 8.0% цусны өөх тос бууруулах эмийг одоо хэрэглэж байв.
3. Гэр бүлийн хэн нэгэн гишүүн чихрийн шижингээр өвчилсөн гэж хариулсан насанд хүрэгчдийн хувь тэдний настай урвуу хамааралтай буюу нас ахих тутам буурах хандлага ажиглагдаж байна. Тодруулбал, 20–39 насны залуучуудын дунд уг өгүүлэмж хамгийн их, 60 ба түүнээс дээш насны иргэдийн дунд хамгийн бага байв.
4. Гэр бүлийн хэн нэгэн гишүүн хавдраар өвчилсөн гэж хариулсан насанд хүрэгчдийн хувь тэдний настай шууд хамааралтай ихсэх зүй тогтол ажиглагдсан бөгөөд урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдсан Завхан аймгийн 30–59 насны хүн амын дунд харьцангуй өндөр байна.



**ХЭНТИЙ АЙМГИЙН НАСАНД ХҮРЭГЧДИЙН ДУНДАХ  
ХАЛДВАРТ БУС ӨВЧНИЙ ЭРСДЭЛТ ХҮЧИН ЗҮЙЛСИЙН  
ТАРХАЛТ**

**ТАНИЛЦУУЛГА**

Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/248 дугаар тушаалыг хэрэгжүүлэх арга хэмжээний хүрээнд 2022 оны 5 дугаар сарын 3-ны өдрөөс 2023 оны 5 дугаар сарын 1 хүртэлх хугацаанд эрт илрүүлэг, урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдсан Хэнтий аймгийн 6,184 насанд хүрэгчдийн мэдээллийг нэгтгэн, тэдний дунд түгээмэл тохиолдож буй халдварт бус өвчин (ХБӨ)-ий эрсдэлт хүчин зүйлсийн тархалтын байдалд дүн шинжилгээ хийв (Зураг 239).



Зураг 239. Эрт илрүүлэг үзлэгт хамрагдсан насанд хүрэгчдийн тоо, сумын дүнгээр

Эрт илрүүлэг, урьдчилан сэргийлэх үзлэгт Хэнтий аймгийн 18–92 насны нийт 6,184 хүн хамрагдсан бөгөөд тэдний 38.2% (n=2,362) эрэгтэйчүүд, 61.8% (n=3,822) эмэгтэйчүүд байв (Хүснэгт 146).

Хүснэгт 147. Эрт илрүүлэгт хамрагдсан насанд хүрэгчид, нас бүлэг ба хүйсээр

Насны бүлэг, жилээр	N	Эрэгтэй			Эмэгтэй		
		Тоо	Хувь	95% ИХ	Тоо	Хувь	95% ИХ
≤ 19	259	173	66.8	61.0-72.6	86	33.2	27.4-39.0
20 – 29	737	320	43.4	39.8-47.0	417	56.6	53.0-60.2
30 – 39	986	348	35.3	32.3-38.3	638	64.7	61.7-67.7
40 – 49	1312	451	34.4	31.8-37.0	861	65.6	63.1-68.2
50 – 59	1453	488	33.6	31.2-36.0	965	66.4	64.0-68.9
60 – 69	1081	436	40.3	37.4-43.3	645	59.7	56.7-62.6
≥ 70	356	146	41.0	35.9-46.2	210	59.0	53.9-64.1
<b>Нийт</b>	<b>6,184</b>	<b>2,362</b>	<b>38.2</b>	<b>37.0-39.4</b>	<b>3,822</b>	<b>61.8</b>	<b>60.6-63.0</b>


Урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдсан Хэнтий аймгийн насанд хүрэгчдийн дундаж нас 46.9 (95%ИХ 46.5-47.3) жил байна. Эрт илрүүлэг үзлэгт хамрагдсан эмэгтэйчүүдийн дундаж нас эрэгтэйчүүдийн дундаж үзүүлэлтээс 1.8 жилээр илүү байна (дундаж нас: эр 45.8 жил, эм 47.6 жил).

## ХБӨ-ИЙ НИЙТЛЭГ ЭРСДЭЛТ ХҮЧИН ЗҮЙЛС ХАВСРАН ИЛЭРСЭН ХҮН АМ

Хүснэгт 148. ХБӨ-ий нийтлэг эрсдэлт хүчин зүйлс хавсран илэрсэн хүн ам хүйсээр

Хүн амын дунд (95% ИХ)	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
<b>ХБӨ-ий нийтлэг эрсдэлт хүчин зүйлс</b>			
<ul style="list-style-type: none"> <li>Өдөр бүр тамхи татдаг</li> <li>Өдөрт 5 нэгжээс бага хэмжээгээр жимс, ногоо хэрэглэдэг</li> <li>Хөдөлгөөний хомсдолтой</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Илүүдэл жинтэй (БЖИ <math>\geq 25</math> кг/м<sup>2</sup>)</li> <li>Артерийн даралт ихсэлттэй (САД <math>\geq 140</math> ба/эсвэл ДАД <math>\geq 90</math> мм МУБ эсвэл даралт бууруулах эм хэрэглэж байгаа)*</li> </ul>		
Нийтлэг эрсдэлт хүчин зүйлс илрээгүй хүн амын хувь	<b>1.7</b> (1.4 – 2.0)	<b>1.5</b> (1.0 – 2.0)	<b>1.8</b> (1.4 – 2.3)
Нийтлэг эрсдэлт хүчин зүйлсээс 1-2 эрсдэл хавсран илэрсэн хүн амын хувь	<b>31.5</b> (30.3 – 32.8)	<b>26.4</b> (24.6 – 28.2)	<b>35.0</b> (33.4 – 36.6)
Нийтлэг эрсдэлт хүчин зүйлсээс 3 ба түүнээс олон эрсдэл хавсран илэрсэн хүн амын хувь	<b>66.8</b> (65.5 – 68.0)	<b>72.2</b> (70.3 – 74.0)	<b>63.2</b> (61.5 – 64.8)

\*ДЭМБ-ын үзүүлэлтийг баримтлав.



Зураг 240. Нийтлэг эрсдэлт хүчин зүйлсээс 3 ба түүнээс олон эрсдэл хавсран илэрсэн хүн амын хувь, хүйсээр



Зураг 241. ХБӨ-өөр өвчлөх өндөр эрсдэлтэй хүн амын хувь, сумаар


### ГОЛ МЭДЭЭЛЭЛ

1. Эрт илрүүлэг үзлэгт хамрагдсан Хэнтий аймгийн насанд хүрсэн хүн амын ХБӨ-өөр өвчлөх эрсдэлгүй хүн амын тархалт дөнгөж 1.7% байна.
2. Насанд хүрсэн хүн амын 3 хүн тутмын 2 нь (66.8%) нийтлэг эрсдэлт хүчин зүйлсээс 3 ба түүнээс олон эрсдэл хавсран илэрсэн байна.
3. Нас ахих тусам эрсдэлт хүчин зүйл хавсран илэрсэн хүн амын тоо өсөж байна.
4. Галшар, Баянмөнх, Батширээт, Биндэр, Дэлгэрхаан, Баян-адарга, Баянхутаг, Жаргалтхаан, Баян-овоо, Өмнөдэлгэр, Дархан сумуудад Нийтлэг эрсдэлт хүчин зүйлсээс 3 ба түүнээс олон эрсдэл хавсран илэрсэн хүн амын хувь аймгийн дундаж (66.8%)-аас өндөр байна.


## ТАМХИНЫ ХЭРЭГЛЭЭ

Хүснэгт 149. Тамхины хэрэглээ хүйсээр

Насанд хүрсэн хүн амын дунд (95% ИХ)	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
Тамхи татдаг хүн амын хувь	<b>15.9</b> (15.0 – 16.9)	<b>37.7</b> (35.7 – 39.6)	<b>1.8</b> (1.3 – 2.2)
Өдөр бүр тамхи татдаг хүн амын хувь	<b>13.6</b> (12.7 – 14.4)	<b>33.4</b> (31.5 – 35.3)	<b>1.3</b> (0.9 – 1.7)
<i>Өдөр бүр тамхи татдаг хүн амын дунд:</i>			
Тамхи татаж эхэлсэн дундаж нас (жилээр)	<b>19.7</b> (19.2 – 20.1)	<b>19.6</b> (19.2 – 19.9)	<b>22.6</b> (21.2 – 23.9)



Зураг 242. Тамхи татдаг хүн ам, хүйс ба насны ангилалаар



Зураг 243. Тамхи татдаг хүн амын тархалт, сумаар


## ГОЛ МЭДЭЭЛЭЛ

1. Хэнтий аймгийн насанд хүрсэн 6 хүн тутмын 1 нь (15.9%) тамхи татдаг бөгөөд эрэгтэйчүүдийн дунд тамхины хэрэглээ эмэгтэйчүүдээс 20.9 дахин их байна.
2. Өдөр бүр тамхи татдаг хүн амын хувь нийт тамхи татдаг хүмүүсийн 85.5%-ийг эзэлж байна.
3. Тамхи татаж эхэлсэн нас дунджаар 19.7 байна.
4. 40-59 нас хүртэлх насны ангилалд тамхины хэрэглээ хамгийн өндөр байна.
5. Дадал, Баянмөнх, Дэлгэрхаан, Баян-адарга, Батширээт, Цэнхэрмандал, Жаргалтхаан, Галшар сумуудад тамхи татдаг хүн амын хувь аймгийн дундаж (15.9%)-аас өндөр байна.


## АРХИ, СОГТУУРУУЛАХ УНДААНЫ ХЭРЭГЛЭЭ

Хүснэгт 150. Архи, согтууруулах ундааны хэрэглээ хүйсээр

Насанд хүрсэн хүн амын дунд (95% ИХ)	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
Сүүлийн 1 сард стандарт уултаас илүү архи, согтууруулах ундаа хэрэглэсэн хүн амын хувь	<b>4.2</b> (3.7 – 4.7)	<b>8.5</b> (7.4 – 9.7)	<b>1.4</b> (1.0 – 1.7)



Зураг 244. Сүүлийн 1 сард стандарт уултаас илүү архи, согтууруулах ундаа хэрэглэсэн хүн ам, хүйс ба насны ангилалаар



Зураг 245. Сүүлийн 1 сард стандарт уултаас илүү архи, согтууруулах ундаа хэрэглэсэн хүн амын хувь, сумаар


### ГОЛ МЭДЭЭЛЭЛ

1. Хэнтий аймгийн насанд хүрсэн хүн амын сүүлийн 1 сард стандарт уултаас илүү архи, согтууруулах ундаа хэрэглэсэн хүн амын хувь 4.2% байх бөгөөд эрэгтэйчүүдийн дунд согтууруулах ундааны хэрэглээ эмэгтэйчүүдээс 6.1 дахин их байна.
2. Хөдөлмөрийн насны (20-69 нас) хүмүүсийн архины хэрэглээ бусад насны бүлэгтэй харьцуулахад их байна.
3. Цэнхэрмандал, Бор-өндөр, Мөрөн, Дэлгэрхаан, Хэрлэн сумуудад Сүүлийн 1 сард стандарт уултаас илүү архи, согтууруулах ундаа хэрэглэсэн хүн амын хувь аймгийн дундаж (4.2%)-аас өндөр байна.

## ХӨДӨЛГӨӨН

Хүснэгт 151. Хөдөлгөөн хүйсээр

Насанд хүрсэн хүн амын дунд (95% ИХ)	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
7 хоногийн 5-аас доошгүй өдөр 30 минутаас дээш дасгал хөдөлгөөн хийдэггүй, эсвэл 10000 алхдаггүй хүн амын хувь	<b>78.7</b> (77.6 – 79.7)	<b>78.6</b> (76.9 – 80.3)	<b>78.7</b> (77.4 – 80.1)



Зураг 246. 7 хоногийн 5-аас доошгүй өдөр 30 минутаас дээш дасгал хөдөлгөөн хийдэггүй, эсвэл 10000 алхдаггүй хүн амын тархалт, насны бүлгээр ба хүйсээр



Зураг 247. 7 хоногийн 5-аас доошгүй өдөр 30 минутаас дээш дасгал хөдөлгөөн хийдэггүй, эсвэл 10000 алхдаггүй хүн амын тархалт, сумаар


## ГОЛ МЭДЭЭЛЭЛ

1. Хэнтий аймгийн “Урьдчилан сэргийлэх эрт илрүүлэгт” хамрагдсан нийт хүн амын 78.7% нь 7 хоногийн 5-аас доошгүй өдөр 30 минутаас дээш дасгал хөдөлгөөн хийдэггүй, эсвэл 10000 алхдаггүй байна.
2. Хүйсээр авч үзвэл эмэгтэйчүүд (78.7%), эрэгтэйчүүдэд (78.6%) ялгаагүй, нас ахих тусам хөдөлгөөний идэвхгүй байдал нэмэгдэж байгаа нь ажиглагдав.
3. Галшар, Баянмөнх, Жаргалтхаан, Норовлин, Баян-адарга, Биндэр, Баян-овоо, Өмнөдэлгэр, Дэргэрхаан, Батноров, Баянхутаг сумуудад 7 хоногийн 5-аас доошгүй өдөр 30 минутаас дээш дасгал хөдөлгөөн хийдэггүй, эсвэл 10000 алхдаггүй хүн амын хувь аймгийн дундаж (78.7%-аас өндөр байна.

## ЖИМС, ЖИМСГЭНЭ, НОГООНЫ ХЭРЭГЛЭЭ

Хүснэгт 152. Жимс, жимсгэнэ, ногооны хэрэглээ хүйсээр

Насанд хүрсэн хүн амын дунд (95% ИХ)	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
Зохистой хэрэглээтэй хүн амын хувь (хоногт $\geq 5$ нэгж буюу 400 г)	<b>14.9</b> (14.0-15.8)	<b>13.4</b> (12.0-14.8)	<b>15.8</b> (14.6-17.0)
Хангалтгүй хэрэглээтэй хүн амын хувь (хоногт $< 5$ нэгж /400 г)	<b>12.3</b> (11.5-13.2)	<b>12.9</b> (11.5-14.2)	<b>12.0</b> (10.9-13.0)
Жимс, ногоо бага хэрэглэдэг ХБӨ-ний эрсдэлтэй хүн амын хувь (жимс, ногоог өдөр бүр хэрэглэдэггүй эсвэл хоногт 400 граммаас бага хэрэглэдэг)	<b>85.1</b> (84.2-86.1)	<b>86.6</b> (85.2-88.0)	<b>84.2</b> (83.0-85.4)



Зураг 248. Жимс, жимсгэнэ, хүнсний ногоо бага хэрэглэдэг насанд хүрэгчдийн хувь, насны бүлгээр

## ГОЛ МЭДЭЭЛЭЛ




Зураг 249. Жимс, жимсгэнэ, ногооны зохистой хэрэглээтэй насанд хүрэгчид, сумаар

1. Хэнтий аймгийн насанд хүрэгчдийн 14.9% жимс, жимсгэнэ, хүнсний ногооны зохистой хэрэглээтэй буюу хоногт  $\geq 400$  г хэмжээгээр хэрэглэж байна. Жимс, жимсгэнэ, хүнсний ногооны зохистой хэрэглээтэй иргэдийн хувь байршлаар ялгаатай, Гаршар, Биндэр, Баян-Овоо сумдад хамгийн бага, харин Бор-Өндөр, Дархан сумдад харьцангуй өндөр байв.
2. Эрт илрүүлэг үзлэгт хамрагдсан Хэнтий аймгийн 18–92 насны иргэдийн 85.1% өдөр бүр жимс, ногоо хэрэглэдэггүй эсвэл хоногт 400 граммаас бага хэмжээгээр хэрэглэж байна. Тодруулбал, насанд хүрсэн 5 хүн тутмын 4 нь “Эрүүл хооллолтын ГЭР зөвлөмж”-д заасан хэмжээ (Хоногт  $\geq 400$ г)-гээр жимс, жимсгэнэ, хүнсний ногоо хэрэглэдэггүй буюу ХБӨ-өөр өвчлөх эрсдэлтэй байв.
3. Жимс, жимсгэнэ, хүнсний ногоо бага хэрэглэдэг буюу ХБӨ-өөр өвчлөх эрсдэлтэй насанд хүрэгчдийн тархалт Хэнтий аймгийн аль ч хүйсийн хүн амын дунд жигд өндөр, ялангуяа 40–49 нас,  $\geq 70$  насны иргэдийн дунд харьцангуй өндөр байна. Харин 20–29 насны иргэдийн дунд тус эрсдэлийн тархалт өндөр хэдий ч, бусад насны бүлэгтэй харьцуулахад бага байв.


## ИЛҮҮДЭЛ ЖИН БА ТАРГАЛАЛТ

Хүснэгт 153. Илүүдэл жин ба таргалалт хүйсээр

Насанд хүрсэн хүн амын дунд (95% ИХ)	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
Биеийн жингийн индекс (БЖИ)-ийн дундаж хэмжээ (кг/м <sup>2</sup> )	<b>27.6</b> (27.5-27.7)	<b>27.1</b> (26.9-27.3)	<b>27.9</b> (27.7-28.1)
Илүүдэл жин ба таргалалттай хүн амын хувь (БЖИ ≥ 25 кг/м <sup>2</sup> )	<b>65.5</b> (64.3-66.7)	<b>62.3</b> (60.3-64.3)	<b>67.6</b> (66.0-69.1)
Таргалалттай хүн амын хувь (БЖИ ≥ 30 кг/м <sup>2</sup> )	<b>28.4</b> (27.2-29.5)	<b>24.8</b> (23.1-26.6)	<b>30.6</b> (29.1-32.1)
Бүсэлхийн тойргийн дундаж хэмжээ (см)	-	<b>91.0</b> (90.5-91.6)	<b>86.7</b> (86.2-87.1)
Төвийн таргалалттай хүн амын хувь (Бүсэлхийн тойрог: эр ≥ 90 см, эм ≥ 80 см)	<b>63.2</b> (62.0-64.5)	<b>53.7</b> (51.7-55.8)	<b>69.3</b> (67.8-70.8)



Зураг 250. Илүүдэл жин ба таргалалтын тархалт, насны бүлгээр



Зураг 251. Таргалалтын тархалт (БЖИ ≥ 30 кг/м<sup>2</sup>), сумаар


## ГОЛ МЭДЭЭЛЭЛ

- Хэнтий аймгийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдсан насанд хүрэгчдийн БЖИ-ийн дундаж хэмжээ 27.6 кг/м<sup>2</sup> байгаа нь ДЭМБ-аас зөвлөсөн хэвийн хязгаараас хэтэрсэн байна. Эмэгтэйчүүдийн БЖИ-ийн дундаж хэмжээ нь эрэгтэйчүүдийн дундаж үзүүлэлтээс өндөр байв ( $p < 0.0001$ ).
- Насанд хүрэгчдийн 65.5% илүүдэл жин ба таргалалттай, 28.4% тарган байна. Илүүдэл жин, таргалалтын тархалт эмэгтэйчүүдийн дунд статистик ач холбогдол бүхий өндөр ( $p < 0.0001$ ), аль ч хүйсийн насанд хүрэгчдийн дунд нас ахих тутам нэмэгдэх хандлага ажиглагдсан болно. Хэнтий аймгийн ≥30 насны 3 хүн тутмын 2 нь илүүдэл жин ба таргалалттай байв. Мөн ≥40 насны 3 хүн тутмын 1 нь тарган байна. Таргалалтын тархалт Дэлгэрхаан, Дархан, Галшар сумын иргэдийн дунд харьцангуй өндөр, Дадал, Бор-Өндөр суманд хамгийн бага байв.
- Хэнтий аймгийн эрт илрүүлэг үзлэгт хамрагдсан насанд хүрэгчдийн 63.2% төвийн таргалалттай, төвийн таргалалтын тархалт эмэгтэйчүүдийн дунд эрэгтэйчүүдээс 1.3 дахин өндөр байна ( $p < 0.0001$ ).


## АРТЕРИЙН ГИПЕРТЕНЗИ

Хүснэгт 154. Артерийн гипертензи хүйсээр

Насанд хүрсэн хүн амын дунд (95% ИХ)	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
Систолын артерийн даралт (САД)-ын дундаж хэмжээ, мм МУБ (даралт бууруулах эм хэрэглэж байгаа хүн амыг оролцуулсан)	<b>124.7</b> (124.2-125.2)	<b>126.3</b> (125.5-127.1)	<b>123.7</b> (123.1-124.3)
Диастолын артерийн даралт (ДАД)-ын дундаж хэмжээ, мм МУБ (даралт бууруулах эм хэрэглэж байгаа хүн амыг оролцуулсан)	<b>77.0</b> (76.7-77.3)	<b>79.1</b> (78.6-79.6)	<b>75.7</b> (75.3-76.1)
Артерийн даралт ихсэлттэй хүн амын хувь (САД = 120-129 мм МУБ ба/эсвэл ДАД ≤ 80 мм МУБ)	<b>24.3</b> (23.2-25.4)	<b>24.2</b> (22.4-26.0)	<b>24.3</b> (22.9-25.7)
Артерийн гипертензитай хүн амын хувь (САД ≥ 130 ба/эсвэл ДАД ≥ 81 мм МУБ эсвэл даралт бууруулах эм хэрэглэдэг хүн амын оролцуулсан)	<b>41.5</b> (40.2-42.8)	<b>45.4</b> (43.3-47.5)	<b>39.0</b> (37.4-40.7)



Зураг 252. Артерийн гипертензийн тархалт, насны бүлгээр



Зураг 253. Артерийн гипертензийн тархалт, сумаар

### ГОЛ МЭДЭЭЛЭЛ


1. Эрт илрүүлэг үзлэгт хамрагдсан Хэнтий аймгийн насанд хүрэгчдийн САД-ын дундаж хэмжээ 124.7 мм МУБ, ДАД-ын дундаж үзүүлэлт 77.0 мм МУБ байна.
2. Насанд хүрэгчдийн 24.3% артерийн даралт ихсэлттэй буюу САД нь 120–129 мм ба/эсвэл ДАД ≤ 80 мм МУБ байв. Артерийн даралт ихсэлтийн тархалтад хүйсийн ялгаа илээгүй болно.
3. Урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдсан Хэнтий аймгийн насанд хүрэгчдийн 41.5% артерийн гипертензи (АГ)-тэй буюу САД ≥ 130 мм МУБ ба ДАД ≥ 81 мм МУБ-аас дээш байгаа нь анхаарал татаж байна. АГ-ийн тархалт эрэгтэйчүүдийн дунд статистик ач холбогдол бүхий өндөр байв.
4. АГ-ийн тархалт иргэдийн настай шууд хамааралтайгаар нэмэгдэх зүй тогтол ажиглагдсан бөгөөд 50–59 насны 2 хүн тутмын 1, ≥ 60 насны 3 хүн тутмын 2 орчим нь тус тус АГ-тэй байна.
5. АГ-ийн тархалтыг сумаар харьцуулан үнэлэхэд Батширээт, Биндэр, Галшар сумын иргэдийн харьцангуй өндөр, харин Дадал суманд хамгийн бага байв.



## ЧИХРИЙН ШИЖИН


Хүснэгт 155. Чихрийн шижин хүйсээр

Насанд хүрсэн хүн амын дунд (95% ИХ)	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
Өлөн үеийн цусны глюкозын дундаж хэмжээ (ммоль/л), глюкоз бууруулах эм хэрэглэж буй хүн амыг оруулаад	<b>5.0</b> (5.0-5.1)	<b>5.3</b> (5.2-5.4)	<b>4.9</b> (4.9-5.0)
Өлөн үеийн цусны глюкозын өөрчлөлттэй хүн амын хувь (Ийлдсийн глюкозын хэмжээ $\geq 6.1$ ммол/л ба $< 7.0$ ммол/л)	<b>4.9</b> (4.3-5.5)	<b>6.4</b> (5.3-7.5)	<b>4.0</b> (3.3-4.6)
Өлөн үеийн цусны глюкозын хэмжээ ихэссэн болон глюкоз бууруулах эм хэрэглэж буй хүн амын хувь (Ийлдсийн глюкозын хэмжээ $\geq 7.0$ ммол/л)	<b>5.3</b> (4.6-5.9)	<b>7.6</b> (6.3-8.8)	<b>3.9</b> (3.3-4.6)



Зураг 254. Өлөн үеийн цусны глюкозын өөрчлөлттэй болон ЧШ-тэй хүн амын хувь, насны бүлгээр

## ГОЛ МЭДЭЭЛЭЛ




Зураг 255. Чихрийн шижингийн тархалт, сумаар

1. Хэнтий аймгийн эрт ирүүлэг үзлэгт хамрагдсан насанд хүрэгчдийн өлөн үеийн цусны глюкозын дундаж хэмжээ 5.0 ммоль/л байв. Эрэгтэйчүүдийн цусны глюкозын дундаж хэмжээ нь эмэгтэйчүүдийн үзүүлэлтээс бага зэрэг илүү байна ( $p < 0.0001$ ).
2. Насанд хүрэгчдийн 4.9% өлөн үеийн цусны глюкозын өөрчлөлттэй, 5.3% цусны глюкозын хэмжээ ихэссэн буюу чихрийн шижинтэй байв. Өлөн үеийн цусны глюкозын өөрчлөлт, чихрийн шижингийн тархалтад хүйсийн ялгаа илрээгүй болно.
3. Өлөн үеийн цусны глюкозын өөрчлөлт, чихрийн шижингийн өвчлөл иргэдийн насны бүлгээр ялгаатай байна. Хэнтий аймгийн  $\leq 19$  насны залуучуудын дунд чихрийн шижингийн тохиолдол илрээгүй боловч, өлөн үеийн цусны глюкозын өөрчлөлт харьцангуй өндөр байгаа нь анхаарал татаж байна. Чихрийн шижингийн тохиолдол 60–69 насны иргэдийн дунд харьцангуй өндөр байв.
4. Цусны глюкозын шинжилгээнд хамрагдсан насанд хүрэгчдийн тоо харилцан адилгүй, Хэрлэн сумаас бусад сумын иргэдийн тоо хэт цөөн байгаа тул чихрийн шижингийн тархалтыг сумаар харьцуулан дүгнэх боломжгүй байна.

## ӨЛӨН ҮЕИЙН ЦУСНЫ ЛИПИДЫН ҮНЭЛГЭЭ

Хүснэгт 156. Өлөн үеийн цусны липидын үнэлгээ хүйсээр

Насанд хүрсэн хүн амын дунд (95% их)	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
“Өлөн үеийн цусны холестерин хэмжээ ихэссэн” гэж оношлогдож байсан хүн амын хувь	<b>1.9</b> (1.6-2.3)	<b>1.9</b> (1.4-2.5)	<b>1.9</b> (1.5-2.4)
Цусны нийт холестерин хэмжээ ихэссэн ( $\geq 5.3$ ммоль/л) хүн амын хувь	<b>30.3</b> (27.1-33.4)	<b>30.1</b> (25.4-34.8)	<b>30.4</b> (26.2-34.6)
“Өлөн үеийн цусны триглицеридийн хэмжээ ихэссэн” гэж оношлогдож байсан хүн амын хувь	<b>0.9</b> (0.7-1.1)	<b>0.9</b> (0.5-1.3)	<b>0.9</b> (0.6-1.2)
Цусны триглицеридийн хэмжээ ихэссэн ( $\geq 1.7$ ммоль/л) хүн амын хувь	<b>10.1</b> (8.0-12.1)	<b>11.9</b> (8.6-15.2)	<b>8.6</b> (6.0-11.2)



Зураг 256. Өлөн үеийн цусны липидын хэмжээ ихэссэн хүн амын хувь, насны бүлгээр



Зураг 257. Өлөн үеийн цусны нийт холестерин агууламж ихэссэн хүн амын хувь, сумаар


## ГОЛ МЭДЭЭЛЭЛ

1. Хэнтий аймгийн эрт илрүүлэгт хамрагдсан насанд хүрэгчдийн 1.9% цусны холестерин ихэссэн, харин 0.9% триглицеридын агууламж ихэссэн гэж оношлогдож байжээ.
2. Насанд хүрэгчдийн 30.3% өлөн үеийн цусны нийт холестерин, 10.1% триглицеридын агууламж ихэссэн байна. Дислипидемийн тархалтыг хүйсээр харьцуулан үнэлэхэд цусны триглицеридын ихсэлт эрэгтэйчүүдэд 3.3 хувиар илүү, харин нийт холестерин ихсэлтэд хүйсийн ялгаа илрээгүй болно.
3. Өлөн үеийн цусны нийт холестерин, триглицеридын ихсэлтийн тархалт иргэдийн настай шууд хамааралтайгаар нэмэгдэх хандлага илэрч байв. Тодруулбал,  $\geq 50$  насны 2 хүн тутмын 1 орчим нь тус тус цусны нийт холестерин ихсэлттэй буюу судасны хатуурал үүсэх эрсдэлтэй байна. Цусны триглицеридын ихсэлт  $\geq 60$  насны иргэдийн дунд харьцангуй өндөр байв.
4. Өлөн үеийн цусны липидын шинжилгээнд хамрагдсан иргэдийн тоо харилцан адилгүй, Хэрлэн сумаас бусад орон нутагт хэт цөөн байгаа тул нийт холестерин ихсэлтийн тархалтыг сумаар харьцуулан дүгнэх боломжгүй байна.

## ХУВЬ ХҮНИЙ ЭРСДЭЛИЙН ҮНЭЛГЭЭ

Хүснэгт 157. Хувь хүний эрсдэлийн үнэлгээ хүйсээр

Насанд хүрсэн хүн амын дунд (95% ИХ)	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
Гэр бүлийн гишүүн чихрийн шижингээр өвчилж байсан <i>Өвөө, эмээ, нагац, авга Эцэг, эх, ах дүү, өөрийн хүүхэд</i>	<b>11.7</b> (9.6-13.7)	<b>11.1</b> (8.0-14.3)	<b>12.0</b> (9.3-14.8)
Жирэмсний чихрийн шижингээр өвчилж байсан	-	-	<b>13.3</b> (12.2-14.4)
Хавдраар өвчилж байсан түүх (гэр бүлийн гишүүн)	<b>6.8</b> (6.2-7.5)	<b>4.6</b> (3.8-5.5)	<b>8.3</b> (7.4-9.2)
Артерийн даралт бууруулах эм тогтмол хэрэглэдэг	<b>18.1</b> (17.1-19.1)	<b>13.8</b> (12.4-15.3)	<b>20.7</b> (19.4-22.0)
Цусны өөх тос бууруулах эм хэрэглэж байгаа	<b>13.3</b> (12.4-14.1)	<b>11.8</b> (10.5-13.2)	<b>14.2</b> (13.0-15.3)



Зураг 258. “Гэр бүлийн хэн нэгэн гишүүн нь чихрийн шижин, хавдраар өвчилж байсан” гэж хариулсан насанд хүрэгчдийн хувь, насны бүлгээр


### ГОЛ МЭДЭЭЛЭЛ

1. Эрт илрүүлэг үзлэгт хамрагдсан Хэнтий аймгийн насанд хүрэгчдийн 11.7% гэр бүлийн хэн нэгэн гишүүн “чихрийн шижингээр өвчилсөн”, 6.5% хавдраар өвчилсөн гэж хариулсан байна. Нийт эмэгтэйчүүдийн 13.3% жирэмсний чихрийн шижин оношлогдож байжээ.
2. Урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдсан Хэнтий аймгийн насанд хүрэгчдийн 18.1% артерийн даралт бууруулах эмийг тогтмол хэрэглэдэг, харин 13.3% цусны өөх тос бууруулах эмийг одоо хэрэглэж байв. Эрт илрүүлэгт хамрагдсан эмэгтэйчүүдийн дунд артерийн даралт бууруулах эмийн хэрэглээ 1.5 дахин өндөр ( $p < 0.0001$ ), цусны өөх тос бууруулах эмийн хэрэглээ эмэгтэйчүүдэд бага зэрэг илүү байна ( $p = 0.009$ ).
3. Эрт илрүүлэг үзлэгт хамрагдсан эмэгтэйчүүдийн дунд “Гэр бүлийн хэн нэгэн гишүүн хавдраар өвчилсөн” гэж хариулсан иргэдийн хувь харьцангуй өндөр, эрэгтэйчүүдээс 1.8 дахин илүү байв.
4. Гэр бүлийн хэн нэгэн гишүүн “чихрийн шижингээр өвчилсөн”, эсвэл “хавдраар өвчилсөн” гэж хариулсан иргэдийн үзүүлэлтэд статистик ач холбогдол бүхий насны бүлгийн ялгаа илрээгүй болно.

**ХОВД АЙМГИЙН НАСАНД ХҮРЭГЧДИЙН ДУНДАХ  
ХАЛДВАРТ БУС ӨВЧНИЙ ЭРСДЭЛТ ХҮЧИН ЗҮЙЛСИЙН  
ТАРХАЛТ**

**ТАНИЛЦУУЛГА**

Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/248 дугаар тушаалыг хэрэгжүүлэх арга хэмжээний хүрээнд 2022 оны 5 дугаар сарын 3-ны өдрөөс 2023 оны 5 дугаар сарын 1 хүртэлх хугацаанд эрт илрүүлэг, урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдсан Ховд аймгийн 8,719 насанд хүрэгчдийн мэдээллийг нэгтгэн, тэдний дунд түгээмэл тохиолдож буй халдварт бус өвчин (ХБӨ)-ий эрсдэлт хүчин зүйлсийн тархалтын байдалд дүн шинжилгээ хийв (Зураг 259).



Зураг 259. Эрт илрүүлэг үзлэгт хамрагдсан насанд хүрэгчдийн тоо, сумын дүнгээр  
Эрт илрүүлэг, урьдчилан сэргийлэх үзлэгт Ховд аймгийн 18–86 насны нийт 8,719 хүн хамрагдсан бөгөөд тэдний 39.2% (n=3,417) эрэгтэйчүүд, 60.8% (n=5,302) эмэгтэйчүүд байв (Хүснэгт 158).

Хүснэгт 158. Эрт илрүүлэгт хамрагдсан насанд хүрэгчид, нас бүлэг ба хүйсээр

Насны бүлэг, жилээр	N	Эрэгтэй			Эмэгтэй		
		Тоо	Хувь	95% ИХ	Тоо	Хувь	95% ИХ
≤ 19	485	280	57.7	53.3-62.1	205	42.3	37.9-46.7
20 – 29	1646	700	42.5	40.1-44.9	946	57.5	55.1-59.9
30 – 39	1773	665	37.5	35.3-39.8	1108	62.5	60.2-64.8
40 – 49	2023	706	34.9	32.8-37.0	1317	65.1	63.0-67.2
50 – 59	1670	611	36.6	34.3-38.9	1059	63.4	61.1-65.7
60 – 69	879	365	41.5	38.3-44.8	514	58.5	55.2-61.7
≥ 70	243	90	37.0	30.9-43.2	153	63.0	56.9-69.1
<b>Нийт</b>	<b>8,719</b>	<b>3417</b>	<b>39.2</b>	<b>38.2-40.2</b>	<b>5302</b>	<b>60.8</b>	<b>59.8-61.8</b>


Урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдсан Ховд аймгийн насанд хүрэгчдийн дундаж нас 41.9 (95%ИХ 41.6-42.2) жил байна. Эрт илрүүлэг үзлэгт хамрагдсан эмэгтэйчүүдийн дундаж нас эрэгтэйчүүдийн дундаж үзүүлэлтээс ялимгүй илүү байна (дундаж нас: эр 40.8 жил, эм 42.6 жил).

## ХБӨ-ИЙ НИЙТЛЭГ ЭРСДЭЛТ ХҮЧИН ЗҮЙЛС ХАВСРАН ИЛЭРСЭН ХҮН АМ


Хүснэгт 159. ХБӨ-ий нийтлэг эрсдэлт хүчин зүйлс хавсран илэрсэн хүн ам хүйсээр

Хүн амын дунд (95% ИХ)	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
<b>ХБӨ-ий нийтлэг эрсдэлт хүчин зүйлс</b>			
<ul style="list-style-type: none"> <li>Өдөр бүр тамхи татдаг</li> <li>Өдөрт 5 нэгжээс бага хэмжээгээр жимс, ногоо хэрэглэдэг</li> <li>Хөдөлгөөний хомсдолтой</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Илүүдэл жинтэй (БЖИ <math>\geq 25</math> кг/м<sup>2</sup>)</li> <li>Артерийн даралт ихсэлттэй (САД <math>\geq 140</math> ба/эсвэл ДАД <math>\geq 90</math> мм МУБ эсвэл даралт бууруулах эм хэрэглэж байгаа)*</li> </ul>		
Нийтлэг эрсдэлт хүчин зүйлс илрээгүй хүн амын хувь	<b>3.2</b> (2.8 – 3.6)	<b>3.3</b> (2.6 – 4.0)	<b>3.2</b> (2.7 – 3.7)
Нийтлэг эрсдэлт хүчин зүйлсээс 1-2 эрсдэл хавсран илэрсэн хүн амын хувь	<b>59.4</b> (58.2 – 60.6)	<b>51.3</b> (49.4 – 53.2)	<b>64.8</b> (63.3 – 66.2)
Нийтлэг эрсдэлт хүчин зүйлсээс 3 ба түүнээс олон эрсдэл хавсран илэрсэн хүн амын хувь	<b>37.4</b> (36.2 – 38.5)	<b>45.4</b> (43.6 – 47.3)	<b>32.1</b> (30.6 – 33.5)

\*ДЭМБ-ын үзүүлэлтийг баримтлав.



Зураг 260. Нийтлэг эрсдэлт хүчин зүйлсээс 3 ба түүнээс олон эрсдэл хавсран илэрсэн хүн амын хувь, хүйс, насны ангиллаар



Зураг 261. ХБӨ-өөр өвчлөх өндөр эрсдэлтэй хүн амын хувь, сумаар


### ГОЛ МЭДЭЭЛЭЛ

1. Эрт илрүүлэг үзлэгт хамрагдсан Ховд аймгийн насанд хүрсэн хүн амын ХБӨ-өөр өвчлөх эрсдэлгүй хүн амын тархалт дөнгөж 3.2% байна.
2. Насанд хүрсэн хүн амын 3 хүн тутмын 1 нь (37.4%) нийтлэг эрсдэлт хүчин зүйлсээс 3 ба түүнээс олон эрсдэл хавсран илэрсэн байна.
3. Нас ахих тусам эрсдэлт хүчин зүйл хавсран илэрсэн хүн амын тоо өсөж байна.
4. Мөст, Ховд, Чандмань, Цэцэг, Алтай, Манхан, Зэрэг сумуудад Нийтлэг эрсдэлт хүчин зүйлсээс 3 ба түүнээс олон эрсдэл хавсран илэрсэн хүн амын хувь аймгийн дундаж (37.4%)-аас өндөр байна

## ТАМХИНЫ ХЭРЭГЛЭЭ


Хүснэгт 160. Тамхины хэрэглээ хүйсээр

Насанд хүрсэн хүн амын дунд (95% ИХ)	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
Тамхи татдаг хүн амын хувь	<b>18.0</b> (17.2 – 18.9)	<b>44.3</b> (42.5 – 46.0)	<b>0.7</b> (0.4 – 0.9)
Өдөр бүр тамхи татдаг хүн амын хувь	<b>12.6</b> (11.9 – 13.3)	<b>31.8</b> (30.2 – 33.3)	<b>0.3</b> (0.2 – 0.5)
<i>Өдөр бүр тамхи татдаг хүн амын дунд:</i>			
Тамхи татаж эхэлсэн дундаж нас (жилээр)	<b>20.3</b> (19.9 – 20.7)	<b>20.2</b> (19.9 – 20.7)	<b>28.9</b> (21.8 – 35.9)



Зураг 262. Тамхи татдаг хүн ам, хүйс ба насны ангиллаар

## ГОЛ МЭДЭЭЛЭЛ




Зураг 263. Тамхи татдаг хүн амын тархалт, сумаар

1. Эрт илрүүлэг үзлэгт хамрагдсан Ховд аймгийн насанд хүрсэн 5 хүн тутмын 1 нь (18%) тамхи татдаг бөгөөд эрэгтэйчүүдийн дунд тамхины хэрэглээ эмэгтэйчүүдээс 63.2 дахин их байна.
2. Өдөр бүр тамхи татдаг хүн амын хувь нийт тамхи татдаг хүмүүсийн 70%-ийг эзэлж байна.
3. Тамхи татаж эхэлсэн нас дунджаар 20.3 байна.
4. 20-иос дээш насанд тамхины хэрэглээ жигд өндөр байна.
5. Алтай, Жаргалант, Манхан, Чандмань, Мөст, Эрдэнэбүрэн, Дуут, Мянгад сумуудад тамхи татдаг хүн амын хувь аймгийн дундаж (18%)-аас өндөр байна.


## АРХИ, СОГТУУРУУЛАХ УНДААНЫ ХЭРЭГЛЭЭ

Хүснэгт 161. Архи, согтууруулах ундааны хэрэглээ хүйсээр

Насанд хүрсэн хүн амын дунд (95% ИХ)	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
Сүүлийн 1 сард стандарт уултаас илүү архи, согтууруулах ундаа хэрэглэсэн хүн амын хувь	<b>7.8</b> (7.2 – 8.5)	<b>13.7</b> (12.4 – 15.0)	<b>4.1</b> (3.5 – 4.7)



Зураг 264. Сүүлийн 1 сард стандарт уултаас илүү архи, согтууруулах ундаа хэрэглэсэн хүн ам, хүйс ба насны ангиллаар



Зураг 265. Сүүлийн 1 сард стандарт уултаас илүү архи, согтууруулах ундаа хэрэглэсэн хүн амын хувь, бүс нутгаар


### ГОЛ МЭДЭЭЛЭЛ

1. Эрт илрүүлэг үзлэгт хамрагдсан Ховд аймгийн насанд хүрсэн хүн амын сүүлийн 1 сард стандарт уултаас илүү архи, согтууруулах ундаа хэрэглэсэн хүн амын хувь 7.8% байх бөгөөд эрэгтэйчүүдийн дунд согтууруулах ундааны хэрэглээ эмэгтэйчүүдээс 3.3 дахин их байна.
2. Хөдөлмөрийн насны (20-59 нас) хүмүүсийн архины хэрэглээ бусад насны бүлэгтэй харьцуулахад их байна.
3. Жаргалант, Манхан, Чандмань сумуудад Сүүлийн 1 сард стандарт уултаас илүү архи, согтууруулах ундаа хэрэглэсэн хүн амын хувь аймгийн дундаж (7.8%)-аас өндөр байна.


## ХӨДӨЛГӨӨН

Хүснэгт 162. Хөдөлгөөн хүйсээр

Насанд хүрсэн хүн амын дунд (95% ИХ)	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
7 хоногийн 5-аас доошгүй өдөр 30 минутаас дээш дасгал хөдөлгөөн хийдэггүй, эсвэл 10000 алхдаггүй хүн амын хувь	<b>73.3</b> (72.3 – 74.4)	<b>66.8</b> (65.0 – 68.5)	<b>77.6</b> (76.4 – 78.8)



Зураг 266. 7 хоногийн 5-аас доошгүй өдөр 30 минутаас дээш дасгал хөдөлгөөн хийдэггүй, эсвэл 10000 алхдаггүй хүн амын тархалт, насны бүлгээр ба хүйсээр



Зураг 267. 7 хоногийн 5-аас доошгүй өдөр 30 минутаас дээш дасгал хөдөлгөөн хийдэггүй, эсвэл 10000 алхдаггүй хүн амын тархалт, сумаар

## ГОЛ МЭДЭЭЛЭЛ


1. Ховд аймгийн “Урьдчилан сэргийлэх эрт илрүүлэгт” хамрагдсан нийт хүн амын 70.3% нь 7 хоногийн 5-аас доошгүй өдөр 30 минутаас дээш дасгал хөдөлгөөн хийдэггүй, эсвэл 10000 алхдаггүй байна.
2. Хүйсээр авч үзвэл эмэгтэйчүүд (77.6%), эрэгтэйчүүдээс (66.8%) 10.8%-иар их, нас ахих тусам хөдөлгөөний идэвхгүй байдал нэмэгдэж байгаа нь ажиглагдав.
3. Ховд, Чандмань, Мөнххайрхан, Цэцэг, Мөст, Зэрэг, Манхан, Эрдэнэбүрэн, Дарви, Буянт, Дөргөн сумуудад 7 хоногийн 5-аас доошгүй өдөр 30 минутаас дээш дасгал хөдөлгөөн хийдэггүй, эсвэл 10000 алхдаггүй хүн амын хувь аймгийн дундаж (73.3%)-аас өндөр байна.



## ЖИМС, ЖИМСГЭНЭ, НОГООНЫ ХЭРЭГЛЭЭ


Хүснэгт 163. Жимс, жимсгэнэ, ногооны хэрэглээ хүйсээр

Насанд хүрсэн хүн амын дунд (95% ИХ)	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
Зохистой хэрэглээтэй хүн амын хувь (хоногт $\geq 5$ нэгж буюу 400 г)	<b>19.2</b> (18.3-20.1)	<b>20.2</b> (18.7-21.7)	<b>18.6</b> (17.4-19.7)
Хангалтгүй хэрэглээтэй хүн амын хувь (хоногт $< 5$ нэгж /400 г)	<b>13.8</b> (13.0-14.6)	<b>16.0</b> (14.7-17.4)	<b>12.3</b> (11.3-13.3)
Жимс, ногоо бага хэрэглэдэг ХБӨ-ний эрсдэлтэй хүн амын хувь (жимс, ногоог өдөр бүр хэрэглэдэггүй эсвэл хоногт 400 граммаас бага хэрэглэдэг)	<b>80.8</b> (79.9-81.7)	<b>79.8</b> (78.3-81.3)	<b>81.4</b> (80.3-82.6)



Зураг 268. Жимс, жимсгэнэ, хүнсний ногоо бага хэрэглэдэг насанд хүрэгчдийн хувь, насны бүлгээр

## ГОЛ МЭДЭЭЛЭЛ




Зураг 269. Жимс, жимсгэнэ, ногооны зохистой хэрэглээтэй насанд хүрэгчид, сумаар

1. Ховд аймгийн насанд хүрэгчдийн дөнгөж 19.2% жимс, жимсгэнэ, хүнсний ногооны зохистой хэрэглээтэй буюу хоногт  $\geq 400$  г хэмжээгээр хэрэглэж байна. Жимс, жимсгэнэ, хүнсний ногооны зохистой хэрэглээтэй иргэдийн хувь байршлаар ялгаатай, Мөст, Цэцэг суманд хамгийн бага, харин Булган, Үенч сумдад харьцангуй өндөр байв.
2. Эрт илрүүлэг үзлэгт хамрагдсан Ховд аймгийн 18–86 насны иргэдийн 80.8% өдөр бүр жимс, ногоо хэрэглэдэггүй эсвэл хоногт 400 граммаас бага хэмжээгээр хэрэглэж байна. Ховд аймгийн насанд хүрсэн 5 хүн тутмын 4 нь “Эрүүл хооллолтын ГЭР зөвлөмж”-д заасан хэмжээ (Хоногт  $\geq 400$ г)-гээр жимс, жимсгэнэ, хүнсний ногоо хэрэглэдэггүй буюу ХБӨ-өөр өвчлөх эрсдэлтэй байна.
3. Жимс, жимсгэнэ, хүнсний ногоо бага хэрэглэдэг буюу ХБӨ-өөр өвчлөх эрсдэлтэй насанд хүрэгчдийн тархалт иргэдийн насны бүлгээр ялгаатай,  $\geq 40$  насны иргэдийн дунд хамгийн өндөр, харин 20–29 насныхны дунд харьцангуй бага байв.

## ИЛҮҮДЭЛ ЖИН БА ТАРГАЛАЛТ


Хүснэгт 164. Илүүдэл жин ба таргалалт хүйсээр

Насанд хүрсэн хүн амын дунд (95% ИХ)	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
Биеийн жингийн индекс (БЖИ)-ийн дундаж хэмжээ (кг/м <sup>2</sup> )	<b>24.8</b> (24.7-24.9)	<b>24.6</b> (24.4-24.7)	<b>25.0</b> (24.8-25.1)
Илүүдэл жин ба таргалалттай хүн амын хувь (БЖИ ≥ 25 кг/м <sup>2</sup> )	<b>38.4</b> (37.3-39.6)	<b>35.8</b> (34.0-37.6)	<b>40.2</b> (38.7-41.7)
Таргалалттай хүн амын хувь (БЖИ ≥ 30 кг/м <sup>2</sup> )	<b>10.4</b> (9.3-11.1)	<b>9.3</b> (8.2-10.4)	<b>11.1</b> (10.1-12.1)
Бүсэлхийн тойргийн дундаж хэмжээ (см)	-	<b>80.3</b> (79.7-80.8)	<b>77.8</b> (77.3-78.3)
Төвийн таргалалттай хүн амын хувь (Бүсэлхийн тойрог: эр ≥ 90 см, эм ≥ 80 см)	<b>33.0</b> (31.9-34.2)	<b>23.7</b> (22.1-25.4)	<b>39.3</b> (37.7-40.8)



Зураг 270. Илүүдэл жин ба таргалалтын тархалт, насны бүлгээр

## ГОЛ МЭДЭЭЛЭЛ




Зураг 271. Таргалалтын тархалт (БЖИ ≥ 30 кг/м<sup>2</sup>), сумаар

1. Ховд аймгийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдсан насанд хүрэгчдийн БЖИ-ийн дундаж хэмжээ 24.8 кг/м<sup>2</sup> байгаа нь ДЭМБ-аас зөвлөсөн хэвийн хязгаарт байна. Иргэдийн БЖИ-ийн дундаж хэмжээ нь хүйс болон насны бүлгээр ялгаатай, эмэгтэйчүүдэд ялимгүй өндөр байв ( $p < 0.0001$ ).
2. Насанд хүрэгчдийн 38.4% илүүдэл жин ба таргалалттай, 10.4% тарган байна. Илүүдэл жин, таргалалтын тархалт эмэгтэйчүүдийн дунд статистик ач холбогдол бүхий өндөр, аль ч хүйсийн насанд хүрэгчдийн дунд нас ахих тутам нэмэгдэх хандлага ажиглагдсан бөгөөд 40–69 насны 2 хүн тутмын 1 орчим нь илүүдэл жин ба таргалалттай байна. Мөн Ховд аймгийн 40 – 69 насны иргэдийн 5 хүн тутмын 1 орчим нь тарган байв. Таргалалтын тархалт мөст, Ховд сумын иргэдийн дунд харьцангуй өндөр байв.
3. Ховд аймгийн эрт илрүүлэг үзлэгт хамрагдсан насанд хүрэгчдийн 33.0% төвийн таргалалттай, төвийн таргалалтын тархалт эмэгтэйчүүдийн дунд эрэгтэйчүүдээс 1.7 дахин өндөр байна ( $p < 0.0001$ ).

## АРТЕРИЙН ГИПЕРТЕНЗИ


Хүснэгт 165. Артерийн гипертензи хүйсээр

Насанд хүрсэн хүн амын дунд (95% ИХ)	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
Систолийн артерийн даралт (САД)-ын дундаж хэмжээ, мм МУБ (даралт бууруулах эм хэрэглэж байгаа хүн амыг оролцуулсан)	<b>115.4</b> (115.1-115.7)	<b>116.2</b> (115.7-116.7)	<b>115.0</b> (114.6-115.3)
Диастолын артерийн даралт (ДАД)-ын дундаж хэмжээ, мм МУБ (даралт бууруулах эм хэрэглэж байгаа хүн амыг оролцуулсан)	<b>76.4</b> (76.2-76.6)	<b>76.9</b> (76.6-77.3)	<b>76.1</b> (75.8-76.4)
Артерийн даралт ихсэлттэй хүн амын хувь (САД = 120-129 мм МУБ ба/эсвэл ДАД ≤ 80 мм МУБ)	<b>32.2</b> (31.1-33.2)	<b>34.5</b> (32.7-36.2)	<b>30.7</b> (29.3-32.0)
Артерийн гипертензитэй хүн амын хувь (САД ≥ 130 ба/эсвэл ДАД ≥ 81 мм МУБ эсвэл даралт бууруулах эм хэрэглэдэг хүн амын оролцуулсан)	<b>15.8</b> (15.0-16.6)	<b>16.1</b> (14.8-17.5)	<b>15.6</b> (14.5-16.6)



Зураг 272. Артерийн гипертензийн тархалт, насны бүлгээр

## ГОЛ МЭДЭЭЛЭЛ




Зураг 273. Артерийн гипертензийн тархалт, сумаар

1. Эрт илрүүлэг үзлэгт хамрагдсан Ховд аймгийн насанд хүрэгчдийн САД-ын дундаж хэмжээ 115.4 мм МУБ, ДАД-ын дундаж үзүүлэлт 76.4 мм МУБ байна.
2. Насанд хүрэгчдийн 32.2% артерийн даралт ихсэлттэй буюу САД нь 120–129 мм ба/эсвэл ДАД ≤ 80 мм МУБ байв. Артерийн даралт ихсэлтийн тархалт Ховд аймгийн эрэгтэйчүүдийн дунд бага зэрэг илүү байна ( $p < 0.0001$ ).
3. Урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдсан Ховд аймгийн насанд хүрэгчдийн 15.9% артерийн гипертензи (АГ)-тэй буюу САД ≥ 130 мм МУБ ба ДАД ≥ 81 мм МУБ-аас дээш байгаа нь анхаарал татаж байна. Ховд аймгийн насанд хүрэгчдийн дундах АГ-ийн тархалтал хүйсийн ялгаа илрээгүй болно.
4. АГ-ийн тархалт иргэдийн настай шууд хамааралтайгаар нэмэгдэх хандлага ажиглагдсан бөгөөд 50–59 насны 4 хүн тутмын 1, 60–69 насны 3 хүн тутмын 1, ≥ 70 насны 10 хүн тутмын 4 нь тус тус АГ-тэй байна. АГ-ийн тархалтыг сумаар харьцуулан үнэлэхэд Ховд, Цэцэг суманд харьцангуй өндөр байв.

## ЧИХРИЙН ШИЖИН


Хүснэгт 166. Чихрийн шижин хүйсээр

Насанд хүрсэн хүн амын дунд (95% ИХ)	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
Өлөн үеийн цусны глюкозын дундаж хэмжээ (ммоль/л), глюкоз бууруулах эм хэрэглэж буй хүн амыг оруулаад	<b>5.3</b> (5.2-5.3)	<b>5.4</b> (5.3-5.5)	<b>5.2</b> (5.2-5.3)
Өлөн үеийн цусны глюкозын өөрчлөлттэй хүн амын хувь (Ийлдсийн глюкозын хэмжээ $\geq 6.1$ ммол/л ба $< 7.0$ ммол/л)	<b>8.6</b> (7.7-9.5)	<b>11.5</b> (9.8-13.1)	<b>7.0</b> (6.0-8.0)
Өлөн үеийн цусны глюкозын хэмжээ ихэссэн болон глюкоз бууруулах эм хэрэглэж буй хүн амын хувь (Ийлдсийн глюкозын хэмжээ $\geq 7.0$ ммол/л)	<b>5.9</b> (5.1-6.6)	<b>7.4</b> (6.0-8.8)	<b>5.0</b> (4.2-5.9)



Зураг 274. Өлөн үеийн цусны глюкозын өөрчлөлттэй болон ЧШ-тэй хүн амын хувь, насны бүлгээр

## ГОЛ МЭДЭЭЛЭЛ




Зураг 275. Чихрийн шижингийн тархалт, сумаар

1. Ховд аймгийн эрт ирүүлэг үзлэгт хамрагдсан насанд хүрэгчдийн өлөн үеийн цусны глюкозын дундаж хэмжээ 5.5 ммоль/л байна. Эрэгтэйчүүдийн цусны глюкозын дундаж хэмжээ нь эмэгтэйчүүдийн үзүүлэлтээс статистик ач холбогдол бүхий илүү байв.
2. Насанд хүрэгчдийн 8.6% өлөн үеийн цусны глюкозын өөрчлөлттэй, 5.9% цусны глюкозын хэмжээ ихэссэн буюу чихрийн шижинтэй байна. Чихрийн шижингийн тархалт нь иргэдийн бүлгээр ялгаатай, нас ахих тутам нэмэгдэх хандлага ажиглагдсан болно. Өлөн үеийн цусны өөрчлөлт 18–29 насны залуучуудын дунд илрээгүй бөгөөд  $\geq 50$  насны иргэдийн дунд цусны глюкозын өөрчлөлт болон чихрийн шижингийн тархалт харьцангуй өндөр байв.
3. Ховд аймгийн насанд хүрсэн эрэгтэйчүүдийн өлөн үеийн цусны глюкозын дундаж хэмжээ эмэгтэйчүүдийн үзүүлэлтээс харьцангуй өндөр, цусны глюкозын өөрчлөлт болон чихрийн шижингийн тархалт статистик ач холбогдол бүхий өндөр байна.
4. Цусны глюкозын шинжилгээнд хамрагдсан иргэдийн тоо харилцан адилгүй, зарим сумдад хэт цөөн байгаа тул чихрийн шижингийн тархалтыг Ховд аймгийн сумаар харьцуулан дүгнэх боломжгүй байна.


## ӨЛӨН ҮЕИЙН ЦУСНЫ ЛИПИДЫН ҮНЭЛГЭЭ

Хүснэгт 167. Өлөн үеийн цусны липидын үнэлгээ хүйсээр

Насанд хүрсэн хүн амын дунд (95% ИХ)	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
“Өлөн үеийн цусны холестерин хэмжээ ихэссэн” гэж оношлогдож байсан хүн амын хувь	<b>2.9</b> (2.5-3.4)	<b>3.0</b> (2.3-3.7)	<b>2.9</b> (2.3-3.4)
Цусны нийт холестерин хэмжээ ихэссэн ( $\geq 5.3$ ммоль/л) хүн амын хувь	<b>37.1</b> (35.2-38.9)	<b>34.2</b> (31.4-37.0)	<b>39.2</b> (36.7-41.7)
“Өлөн үеийн цусны триглицеридийн хэмжээ ихэссэн” гэж оношлогдож байсан хүн амын хувь	<b>2.0</b> (1.6-2.4)	<b>2.3</b> (1.6-3.0)	<b>1.7</b> (1.3-2.2)
Цусны триглицеридийн хэмжээ ихэссэн ( $\geq 1.7$ ммоль/л) хүн амын хувь	<b>7.6</b> (6.6-8.6)	<b>12.5</b> (10.5-14.4)	<b>4.0</b> (3.0-5.0)



Зураг 276. Өлөн үеийн цусны липидын хэмжээ ихэссэн хүн амын хувь, насны бүлгээр



Зураг 277. Өлөн үеийн цусны нийт холестерин агууламж ихэссэн хүн амын хувь, сумаар


### ГОЛ МЭДЭЭЛЭЛ

1. Ховд аймгийн эрт илрүүлэгт хамрагдсан насанд хүрэгчдийн 2.9% цусны холестерин ихэссэн, харин 2.0% триглицеридийн агууламж ихэссэн гэж оношлогдож байжээ.
2. Насанд хүрэгчдийн 37.1% өлөн үеийн цусны нийт холестерин, 7.6% триглицеридийн агууламж ихэссэн байна. Ховд аймгийн насанд хүрэгчдийн дундах дислипидемийн тархалтад хүйсийн ялгаа ажиглагдсан бөгөөд цусны триглицеридийн ихсэлт эрэгтэйчүүдийн дунд эмэгтэйчүүдээс 3.1 дахин өндөр, харин цусны нийт холестерин ихсэлт эмэгтэйчүүдийн дунд эрэгтэйчүүдээс 5.0 хувиар илүү байв.
3. Өлөн үеийн цусны нийт холестерин ихсэлтийн тархалт иргэдийн настай шууд хамааралтайгаар нэмэгдэх хандлага илэрсэн ба Ховд аймгийн  $\geq 40$  насны 2 тутмын 1 нь цусны нийт холестерин ихсэлттэй буюу судасны хатуурал үүсэх эрсдэлтэй байна. Цусны триглицеридийн ихсэлт 20–39 насны залуучуудын дунд харьцангуй өндөр байна.
4. Өлөн үеийн цусны липидын шинжилгээнд хамрагдсан иргэдийн тоо харилцан адилгүй байгаа тул нийт холестерин ихсэлтийг сумаар харьцуулан дүгнэх боломжгүй болно.

## ХУВЬ ХҮНИЙ ЭРСДЭЛИЙН ҮНЭЛГЭЭ

Хүснэгт 168. Хувь хүний эрсдэлийн үнэлгээ хүйсээр

Насанд хүрсэн хүн амын дунд (95% ИХ)	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
Гэр бүлийн гишүүн чихрийн шижингээр өвчилж байсан <i>Өвөө, эмээ, нагац, авга Эцэг, эх, ах дүү, өөрийн хүүхэд</i>	<b>6.9</b> (6.0-8.6)	<b>6.3</b> (4.9-7.7)	<b>7.3</b> (6.0-8.6)
Жирэмсний чихрийн шижингээр өвчилж байсан	-	-	<b>9.2</b> (8.4-10.0)
Хавдраар өвчилж байсан түүх (гэр бүлийн гишүүн)	<b>4.8</b> (4.3-5.2)	<b>3.6</b> (3.0-4.3)	<b>5.5</b> (4.8-6.1)
Артерийн даралт бууруулах эм тогтмол хэрэглэдэг	<b>12.7</b> (12.0-13.4)	<b>8.2</b> (7.2-9.2)	<b>15.3</b> (14.3-16.3)
Цусны өөх тос бууруулах эм хэрэглэж байгаа	<b>11.0</b> (10.3-11.7)	<b>9.4</b> (8.4-10.4)	<b>12.0</b> (11.1-12.9)



Зураг 278. “Гэр бүлийн хэн нэгэн гишүүн нь чихрийн шижин, хавдраар өвчилж байсан” гэж хариулсан насанд хүрэгчдийн хувь, насны бүлгээр


### ГОЛ МЭДЭЭЛЭЛ

1. Эрт илрүүлэг үзлэгт хамрагдсан Ховд аймгийн насанд хүрэгчдийн 6.9% гэр бүлийн хэн нэгэн гишүүн “чихрийн шижингээр өвчилсөн”, 4.8% хавдраар өвчилсөн гэж хариулсан байна. Нийт эмэгтэйчүүдийн 9.2% жирэмсний чихрийн шижин оношлогдож байжээ.
Цусны өөх тос бууруулах эм хэрэглэж байгаа	<b>17.0</b> (16.1-17.8)	<b>15.9</b> (14.5-17.2)	<b>17.7</b> (16.5-18.8)



Зураг 377. “Гэр бүлийн хэн нэгэн гишүүн нь чихрийн шижин, хавдраар өвчилж байсан” гэж хариулсан насанд хүрэгчдийн хувь, насны бүлгээр


### ГОЛ МЭДЭЭЛЭЛ

1. Эрт илрүүлэг үзлэгт хамрагдсан Төв аймгийн насанд хүрэгчдийн 10.6% гэр бүлийн хэн нэгэн гишүүн “чихрийн шижингээр өвчилсөн”, 11.9% хавдраар өвчилсөн гэж хариулсан байна. Нийт эмэгтэйчүүдийн 15.5% жирэмсний чихрийн шижин оношлогдож байжээ.
2. Урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдсан Төв аймгийн иргэдийн 23.3% артерийн даралт бууруулах эмийг тогтмол хэрэглэдэг, харин 17.0% цусны өөх тос бууруулах эмийг одоо хэрэглэж байна.
3. Гэр бүлийн хэн нэгэн гишүүн чихрийн шижингээр өвчилсөн гэж хариулсан насанд хүрэгчдийн хувь тэдний настай урвуу хамааралтай буюу нас ахих тутам буурах хандлага ажиглагдаж байв. Годруулбал, 20–59 насны иргэдийн дунд уг өгүүлэмж харьцангуй өндөр, 70 ба түүнээс дээш насны иргэдийн дунд хамгийн бага байв.
4. Гэр бүлийн хэн нэгэн гишүүн хавдраар өвчилсөн гэж хариулсан насанд хүрэгчдийн хувь тэдний настай шууд хамааралтай ихсэх зүй тогтол ажиглагдсан бөгөөд урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдсан Төв аймгийн 30–59 насны иргэдийн дунд харьцангуй өндөр байна.

**УВС АЙМГИЙН НАСАНД ХҮРЭГЧДИЙН ДУНДАХ  
ХАЛДВАРТ БУС ӨВЧНИЙ ЭРСДЭЛТ ХҮЧИН ЗҮЙЛСИЙН  
ТАРХАЛТ**

**ТАНИЛЦУУЛГА**

Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/248 дугаар тушаалыг хэрэгжүүлэх арга хэмжээний хүрээнд 2022 оны 5 дугаар сарын 3-аас 2023 оны 5 дугаар сарын 1 хүртэлх хугацаанд эрт илрүүлэг, урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдсан Увс аймгийн 5.800 насанд хүрэгчдийн мэдээллийг нэгтгэн, хүн амын дунд түгээмэл тохиолдож буй Халдварт бус өвчин (ХБӨ)-ий эрсдэлт хүчин зүйлсийн тархалтын байдалд дүн шинжилгээ хийв (Зураг 378).



Зураг 378. Эрт илрүүлэг үзлэгт хамрагдсан насанд хүрэгчдийн тоо, сумын дүнгээр

Эрт илрүүлэг, урьдчилан сэргийлэх үзлэгт Увс аймгийн 18-89 насны нийт 5.800 хүн хамрагдсан бөгөөд тэдний 39.7% (n=2.300) эрэгтэйчүүд, 60.3% (n=3.500) эмэгтэйчүүд байв (Хүснэгт 224).

Хүснэгт 224. Эрт илрүүлэгт хамрагдсан насанд хүрэгчид, нас бүлэг ба хүйсээр

Насны бүлэг, жилээр	N	Эрэгтэй			Эмэгтэй		
		Тоо	Хувь	95% ИХ	Тоо	Хувь	95% ИХ
≤ 19	313	196	62.9	57.2-67.8	117	37.4	32.2-42.8
20 – 29	1033	453	43.9	40.8-46.9	580	56.1	53.1-59.2
30 – 39	1216	493	40.5	37.8-43.3	723	59.5	56.7-62.2
40 – 49	1195	414	34.6	32.0-37.4	781	65.4	62.6-68.0
50 – 59	1239	421	34.0	31.4-36.7	818	66.0	63.3-68.6
60 – 69	662	261	39.4	35.8-43.2	401	60.6	56.8-64.2
≥ 70	142	62	43.7	35.7-51.9	80	56.3	48.1-64.3
<b>Нийт</b>	<b>5800</b>	<b>2300</b>	<b>39.7</b>	<b>38.4-40.9</b>	<b>3500</b>	<b>60.3</b>	<b>59.1-61.6</b>


Эрт илрүүлэг үзлэгт хамрагдсан Увс аймгийн насанд хүрэгчдийн дундаж нас 42.5 (95%ИХ 42.1–42.9) жил, эмэгтэйчүүдийн дундаж нас эрэгтэйчүүдээс 2.5 жилээр илүү (p<0.001) байна (дундаж нас: эр 41.0 жил, эм 43.5 жил).

## ХБӨ-ИЙ НИЙТЛЭГ ЭРСДЭЛТ ХҮЧИН ЗҮЙЛС ХАВСРАН ИЛЭРСЭН ХҮН АМ

Хүснэгт 225. ХБӨ-ий нийтлэг эрсдэлт хүчин зүйлс хавсран илэрсэн хүн ам хүйсээр

Хүн амын дунд (95% ИХ)	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
<b>ХБӨ-ий нийтлэг эрсдэлт хүчин зүйлс</b>			
<ul style="list-style-type: none"> <li>Өдөр бүр тамхи татдаг</li> <li>Өдөрт 5 нэгжээс бага хэмжээгээр жимс, ногоо хэрэглэдэг</li> <li>Хөдөлгөөний хомсдолтой</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Илүүдэл жинтэй (БЖИ <math>\geq 25</math> кг/м<sup>2</sup>)</li> <li>Артерийн даралт ихсэлттэй (САД <math>\geq 140</math> ба/эсвэл ДАД <math>\geq 90</math> мм МУБ эсвэл даралт бууруулах эм хэрэглэж байгаа)*</li> </ul>		
Нийтлэг эрсдэлт хүчин зүйлс илрээгүй хүн амын хувь	<b>1.9</b> (1.6 – 2.3)	<b>1.5</b> (1.1 – 2.1)	<b>2.2</b> (1.7 – 2.7)
Нийтлэг эрсдэлт хүчин зүйлсээс 1-2 эрсдэл хавсран илэрсэн хүн амын хувь	<b>53.6</b> (52.2 – 55.0)	<b>47.3</b> (45.2 – 49.5)	<b>58.1</b> (56.3 – 59.8)
Нийтлэг эрсдэлт хүчин зүйлсээс 3 ба түүнээс олон эрсдэл хавсран илэрсэн хүн амын хувь	<b>44.5</b> (43.1 – 45.8)	<b>51.1</b> (49.0 – 53.2)	<b>39.7</b> (38.0 – 41.5)

\*ДЭМБ-ын үзүүлэлтийг баримтлав.



Зураг 379. Нийтлэг эрсдэлт хүчин зүйлсээс 3 ба түүнээс олон эрсдэл хавсран илэрсэн хүн амын хувь, хүйс, насны ангиллаар



Зураг 380. ХБӨ-өөр өвчлөх өндөр эрсдэлтэй хүн амын хувь, сумаар


### ГОЛ МЭДЭЭЛЭЛ

1. Эрт илрүүлэг үзлэгт хамрагдсан Увс аймгийн насанд хүрсэн хүн амын ХБӨ-өөр өвчлөх эрсдэлгүй хүн амын тархалт дөнгөж 1.9% байна.
2. Насанд хүрсэн хүн амын 2 хүн тутмын 1 нь (53.6%) нийтлэг эрсдэлт хүчин зүйлсээс 3 ба түүнээс олон эрсдэл хавсран илэрсэн байна.
3. ХБӨ-өөр өвчлөх өндөр эрсдэлтэй хүн амын тархалт эрэгтэйчүүдийн дунд эмэгтэйчүүдээс 1.5 дахин их байна. Энэ нь эрэгтэйчүүдийн дундаж наслалт болон тэдний амьдралын чанарт сөргөөр нөлөөлөх магадлалтай.
4. Нас ахих тусам эрсдэлт хүчин зүйл хавсран илэрсэн хүн амын тоо өсөж байна.
5. Өндөрхангай, Давст, Сагил, Тэс, Улаангом, Зүүнхангай, Баруунтуруун сумдуудад Нийтлэг эрсдэлт хүчин зүйлсээс 3 ба түүнээс олон эрсдэл хавсран илэрсэн хүн амын хувь аймгийн дундаж (44.5%-аас өндөр байна.

## ТАМХИНЫ ХЭРЭГЛЭЭ

Хүснэгт 226. Тамхины хэрэглээ хүйсээр

Насанд хүрсэн хүн амын дунд (95% ИХ)	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
Тамхи татдаг хүн амын хувь	<b>15.0</b> (14.1 – 16.0)	<b>35.6</b> (33.6 – 37.5)	<b>0.7</b> (0.3 – 0.9)
Өдөр бүр тамхи татдаг хүн амын хувь	<b>11.0</b> (10.2 – 11.8)	<b>27.1</b> (25.3 – 28.9)	<b>0.4</b> (0.2 – 0.6)
<i>Өдөр бүр тамхи татдаг хүн амын дунд:</i>			
Тамхи татаж эхэлсэн дундаж нас (жилээр)	<b>21.5</b> (20.9 – 22.1)	<b>21.3</b> (20.7 – 21.8)	<b>32</b> (24.3 – 39.7)



Зураг 381. Тамхи татдаг хүн ам, хүйс ба насны ангиллаар



Зураг 382. Тамхи татдаг хүн амын тархалт, сумаар


## ГОЛ МЭДЭЭЛЭЛ

1. Эрт илрүүлэг үзлэгт хамрагдсан Увс аймгийн насанд хүрсэн хүн амын 6 хүн тутмын 1 нь (15%) тамхи татдаг бөгөөд эрэгтэйчүүдийн дунд тамхины хэрэглээ эмэгтэйчүүдээс 50.5 дахин их байна.
2. Өдөр бүр тамхи татдаг хүн амын хувь нийт тамхи татдаг хүмүүсийн 73.3%-ийг эзэлж байна.
3. Тамхи татаж эхэлсэн нас дунджаар 21.5 байна.
4. Бүх насны ангилалд тамхины хэрэглээ жигд өндөр байна.
5. Тариалан, Завхан, Зүүнговь, Баруунтуруун, Зүүнхангай, Сагил, Бөхмөрөн сумдуудад тамхи татдаг хүн амын хувь аймгийн дундаж (15%)-аас өндөр байна.



**АРХИ, СОГТУУРУУЛАХ УНДААНЫ ХЭРЭГЛЭЭ**  
Хүснэгт 227. Архи, согтууруулах ундааны хэрэглээ хүйсээр

Насанд хүрсэн хүн амын дунд (95% ИХ)	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
Сүүлийн 1 сард стандарт уултаас илүү архи, согтууруулах ундаа хэрэглэсэн хүн амын хувь	<b>4.7</b> (4.1 – 5.3)	<b>10.2</b> (8.9 – 11.4)	<b>0.9</b> (0.6 – 1.3)



Зураг 383. Сүүлийн 1 сард стандарт уултаас илүү архи, согтууруулах ундаа хэрэглэсэн хүн ам, хүйс ба насны ангиллаар



**ГОЛ МЭДЭЭЛЭЛ**


1. Эрт илрүүлэг үзлэгт хамрагдсан Увс аймгийн насанд хүрсэн хүн амын сүүлийн 1 сард стандарт уултаас илүү архи, согтууруулах ундаа хэрэглэсэн хүн амын хувь 4.7% байх бөгөөд эрэгтэйчүүдийн дунд согтууруулах ундааны хэрэглээ эмэгтэйчүүдээс 11.3 дахин их байна.
2. 30-69 насны хүмүүсийн архины хэрэглээ бусад насны бүлэгтэй харьцуулахад их байна.
3. Түргэн, Цагаанхайрхан, Тэс, Хяргас, Өмнөговь, Завхан, Ховд, Бөхмөрөн сумуудад Сүүлийн 1 сард стандарт уултаас илүү архи, согтууруулах ундаа хэрэглэсэн хүн амын хувь аймгийн дундаж (4.7%)-аас өндөр байна.

Зураг 384.Сүүлийн 1 сард стандарт уултаас илүү архи, согтууруулах ундаа хэрэглэсэн хүн амын хувь, сумаар


## ХӨДӨЛГӨӨН

Хүснэгт 228. Хөдөлгөөн хүйсээр

Насанд хүрсэн хүн амын дунд (95% ИХ)	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
7 хоногийн 5-аас доошгүй өдөр 30 минутаас дээш дасгал хөдөлгөөн хийдэггүй, эсвэл 10000 алхдаггүй хүн амын хувь	<b>66.7</b> (65.4 – 67.9)	<b>61.1</b> (59.1 – 63.2)	<b>70.5</b> (69.0 – 72.1)



Зураг 385.7 хоногийн 5-аас доошгүй өдөр 30 минутаас дээш дасгал хөдөлгөөн хийдэггүй, эсвэл 10000 алхдаггүй хүн амын тархалт, насны бүлгээр ба хүйсээр



Зураг 386. 7 хоногийн 5-аас доошгүй өдөр 30 минутаас дээш дасгал хөдөлгөөн хийдэггүй, эсвэл 10000 алхдаггүй хүн амын тархалт, сумаар


### ГОЛ МЭДЭЭЛЭЛ

1. Эрт илрүүлэг үзлэгт хамрагдсан Увс аймгийн “Урьдчилан сэргийлэх эрт илрүүлэгт” хамрагдсан нийт хүн амын 66.7% нь 7 хоногийн 5-аас доошгүй өдөр 30 минутаас дээш дасгал хөдөлгөөн хийдэггүй, эсвэл 10000 алхдаггүй байна.
2. Хүйсээр авч үзвэл эмэгтэйчүүд (70.5%), эрэгтэйчүүдээс (61.1%) 9.4%-иар илүү, нас ахих тусам хөдөлгөөний идэвхгүй байдал нэмэгдэж байгаа нь ажиглагдав.
3. Улаангом, Өндөрхангай, Сагил, Өмнөговь, Тариалан, Наранбулаг, Завхан, Бөхмөрөн сумуудад 7 хоногийн 5-аас доошгүй өдөр 30 минутаас дээш дасгал хөдөлгөөн хийдэггүй, эсвэл 10000 алхдаггүй хүн амын хувь аймгийн дундаж (66.7%)-аас өндөр байна.


## ЖИМС, ЖИМСГЭНЭ, НОГООНЫ ХЭРЭГЛЭЭ

Хүснэгт 229. Жимс, жимсгэнэ, ногооны хэрэглээ хүйсээр

Насанд хүрсэн хүн амын дунд (95% ИХ)	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
Зохистой хэрэглээтэй хүн амын хувь (хоногт $\geq 5$ нэгж буюу 400 г)	<b>14.7</b> (13.8-15.7)	<b>13.1</b> (11.7-14.5)	<b>15.9</b> (14.6-17.1)
Хангалтгүй хэрэглээтэй хүн амын хувь (хоногт $< 5$ нэгж /400 г)	<b>12.8</b> (11.9-13.7)	<b>12.6</b> (11.3-14.0)	<b>12.9</b> (11.7-14.0)
Жимс, ногоо бага хэрэглэдэг ХБӨ-ний эрсдэлтэй хүн амын хувь (жимс, ногоог өдөр бүр хэрэглэдэггүй эсвэл хоногт 400 граммаас бага хэрэглэдэг)	<b>85.3</b> (8.3-86.2)	<b>86.9</b> (85.5-88.3)	<b>84.1</b> (82.9-85.4)



Зураг 387. Жимс, жимсгэнэ, хүнсний ногоо бага хэрэглэдэг насанд хүрэгчдийн хувь, насны бүлгээр



Зураг 388. Жимс, жимсгэнэ, ногооны зохистой хэрэглээтэй насанд хүрэгчдийн хувь, сумаар


### ГОЛ МЭДЭЭЛЭЛ

1. Увс аймгийн насанд хүрэгчдийн 14.7% жимс, жимсгэнэ, хүнсний ногооны зохистой хэрэглээтэй буюу жимс, ногоог хоногт 400 г ба түүнээс их хэмжээгээр хэрэглэж байна. Жимс, жимсгэнэ, хүнсний ногооны зохистой хэрэглээтэй иргэдийн хувь Түргэн, Зүүнговь, Малчин, Давст сумын иргэдийн дунд хамгийн бага (4.7%–9.5%) байв.
2. Эрт илрүүлэг үзлэгт хамрагдсан 18-89 насны иргэдийн 85.3% өдөр бүр жимс, ногоо хэрэглэдэггүй эсвэл хоногт 400 граммаас бага хэмжээгээр хэрэглэж байна. Насанд хүрсэн 4 хүн тутмын 3-аас илүү хувь нь “Эрүүл хооллолтын ГЭР зөвлөмж”-д заасан хэмжээ (Хоногт  $\geq 400$ г)-гээр жимс, хүнсний ногоог хэрэглэдэггүй буюу ХБӨ-өөр өвчлөх эрсдэлтэй байв.
3. Жимс, жимсгэнэ, хүнсний ногоо бага хэрэглэдэг буюу ХБӨ-өөр өвчлөх эрсдэлтэй насанд хүрэгчдийн тархалт 40 ба түүнээс дээш насны иргэдийн дунд харьцангуй өндөр, харин 20–29 насны залуучуудын дунд хамгийн бага байна.


## ИЛҮҮДЭЛ ЖИН БА ТАРГАЛАЛТ

Хүснэгт 230. Илүүдэл жин ба таргалалт хүйсээр

Насанд хүрсэн хүн амын дунд (95% ИХ)	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
Биеийн жингийн индекс (БЖИ)-ийн дундаж хэмжээ (кг/м <sup>2</sup> )	<b>25.7</b> (25.5-25.8)	<b>25.8</b> (25.6-25.9)	<b>25.6</b> (25.4-25.8)
Илүүдэл жин ба таргалалттай хүн амын хувь (БЖИ ≥ 25 кг/м <sup>2</sup> )	<b>46.4</b> (45.1-47.7)	<b>48.2</b> (46.1-50.3)	<b>45.2</b> (43.5-46.9)
Таргалалттай хүн амын хувь (БЖИ ≥ 30 кг/м <sup>2</sup> )	<b>16.4</b> (15.5-17.4)	<b>15.9</b> (14.4-17.4)	<b>16.8</b> (15.5-18.1)
Бүсэлхийн тойргийн дундаж хэмжээ (см)	-	<b>84.1</b> (83.5-84.7)	<b>79.2</b> (78.8-79.6)
Төвийн таргалалттай хүн амын хувь (Бүсэлхийн тойрог: эр ≥ 90 см, эм ≥ 80 см)	<b>39.7</b> (38.4-41.0)	<b>32.3</b> (30.3-34.2)	<b>44.8</b> (43.1-46.5)



Зураг 389. Илүүдэл жин ба таргалалтын тархалт, насны бүлгээр



Зураг 390. Таргалалтын тархалт (БЖИ≥30 кг/м<sup>2</sup>), сумаар


## ГОЛ МЭДЭЭЛЭЛ

1. Эрт илрүүлэг үзлэгт хамрагдсан Увс аймгийн насанд хүрэгчдийн БЖИ-ийн дундаж хэмжээ 25.7 кг/м<sup>2</sup> буюу ДЭМБ-аас зөвлөсөн зохих хязгаараас хэтэрсэн байна.
2. Насанд хүрэгчдийн 46.4% илүүдэл жин ба таргалалттай, 16.4% тарган байна. Илүүдэл жин ба таргалалтын тархалт эрэгтэйчүүдийн статистик ач холбогдол бүхий өндөр байв (p=0.03). Таргалалтын тархалт аль ч хүйсийн хүн амын дунд нас ахих тутам нэмэгдэх хандлага ажиглагдсан бөгөөд 40–69 насны иргэдийн дунд хамгийн өндөр байна.
3. Эрт илрүүлэг үзлэгт хамрагдсан Увс аймгийн насанд хүрэгчдийн 39.7% төвийн таргалалттай, төвийн таргалалттай эмэгтэйчүүдийн хувь эрэгтэйчүүдээс 1.4 дахин өндөр байна.


## АРТЕРИЙН ГИПЕРТЕНЗИ

Хүснэгт 231. Артерийн гипертензи хүйсээр

Насанд хүрсэн хүн амын дунд (95% ИХ)	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
Систолын артерийн даралт (САД)-ын дундаж хэмжээ, мм МУБ (даралт бууруулах эм хэрэглэж байгаа хүн амыг оролцуулсан)	<b>119.5</b> (119.1-119.8)	<b>121.3</b> (120.8-121.9)	<b>118.2</b> (117.7-118.7)
Диастолын артерийн даралт (ДАД)-ын дундаж хэмжээ, мм МУБ (даралт бууруулах эм хэрэглэж байгаа хүн амыг оролцуулсан)	<b>78.7</b> (78.4-78.9)	<b>79.8</b> (79.4-80.2)	<b>77.9</b> (77.5-78.2)
Артерийн даралт ихсэлтгүй хүн амын хувь (САД = 120-129 мм МУБ ба/эсвэл ДАД ≤ 80 мм МУБ)	<b>50.0</b> (48.7-51.3)	<b>52.1</b> (50.1-54.2)	<b>48.6</b> (46.9-50.3)
Артерийн гипертензигтэй хүн амын хувь (САД ≥ 130 ба/эсвэл ДАД ≥ 81 мм МУБ эсвэл даралт бууруулах эм хэрэглэдэг хүн амын оролцуулсан)	<b>20.7</b> (19.6-21.8)	<b>23.7</b> (22.0-25.5)	<b>18.6</b> (17.3-20.0)



Зураг 391. Артерийн гипертензийн тархалт, насны бүлгээр



Зураг 392. Артерийн гипертензийн тархалт, сумаар


## ГОЛ МЭДЭЭЛЭЛ

1. Эрт илрүүлэг үзлэгт хамрагдсан Увс аймгийн насанд хүрэгчдийн САД-ын дундаж хэмжээ 119.5 мм МУБ, ДАД-ын дундаж үзүүлэлт 78.7 мм МУБ байна.
2. Насанд хүрэгчдийн 50.0% артерийн даралт ихсэлтгүй буюу САД нь 120–129 мм ба/эсвэл ДАД ≤ 80 мм МУБ байв. Артерийн даралт ихсэлтийн тархалт эрт илрүүлэг үзлэгт хамрагдсан эрэгтэйчүүдийн дунд статистик ач холбогдол бүхий өндөр байна (p=0.012).
3. Увс аймгийн иргэдийн дунд САД ≥ 130 мм МУБ ба ДАД ≥ 81 мм МУБ-ээс дээш буюу Артерийн гипертензи (АГ)-ийн тархалт 20.7% байна. Эрт илрүүлэгт хамрагдсан эрэгтэйчүүдийн дунд АГ-ийн тархалт 5.3 хувиар илүү байв.
4. АГ-ийн тархалт хүн амын нас ахих тутам нэмэгдэж, 50–59 насны иргэдийн дунд огцом өсөлт ажиглагдсан бөгөөд 60-аас дээш насны 10 хүн тутмын 4 нь АГ-тэй байв.
5. Эрт илрүүлэг үзлэгт хамрагдсан иргэдийн тоо харилцан адилгүй байгаа тул АГ-ийн тархалтыг сумаар харьцуулан дүгнэх боломжгүй байна.


## ЧИХРИЙН ШИЖИН

Хүснэгт 232. Чихрийн шижин хүйсээр

Насанд хүрсэн хүн амын дунд (95% ИХ)	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
Өлөн үеийн цусны глюкозын дундаж хэмжээ (ммоль/л), глюкоз бууруулах эм хэрэглэж буй хүн амыг оруулаад	<b>5.0</b> (4.9-5.1)	<b>5.2</b> (5.1-5.2)	<b>4.8</b> (4.8-4.9)
Өлөн үеийн цусны глюкозын өөрчлөлттэй хүн амын хувь (Ийлдсийн глюкозын хэмжээ $\geq 6.1$ ммоль/л ба $< 7.0$ ммоль/л)	<b>3.3</b> (2.8-3.9)	<b>4.2</b> (3.2-5.3)	<b>2.8</b> (2.1-3.4)
Өлөн үеийн цусны глюкозын хэмжээ ихэссэн болон глюкоз бууруулах эм хэрэглэж буй хүн амын хувь (Ийлдсийн глюкозын хэмжээ $\geq 7.0$ ммоль/л)	<b>5.7</b> (5.0-6.4)	<b>7.3</b> (6.0-8.6)	<b>4.7</b> (3.9-5.6)



Зураг 393. Өлөн үеийн цусны глюкозын өөрчлөлттэй болон ЧШ-тэй хүн амын хувь, насны бүлгээр



Зураг 394. Чихрийн шижингийн тархалт, сумаар


## ГОЛ МЭДЭЭЛЭЛ

1. Увс аймгийн эрт ирүүлэг үзлэгт хамрагдсан насанд хүрэгчдийн өлөн үеийн цусны глюкозын дундаж хэмжээ 5.0 ммоль/л байв. Эрэгтэйчүүдийн өлөн үеийн цусны глюкозын дундаж хэмжээ нь эмэгтэйчүүдийн дундаж үзүүлэлтээс статистик ач холбогдол бүхий өндөр байна.
2. Эрт илрүүлэг үзлэгт хамрагдсан эрэгтэйчүүдийн дунд өлөн үеийн цусны глюкозын өөрчлөлт болон чихрийн шижингийн тархалт эмэгтэйчүүдээс статистик ач холбогдол бүхий илүү байв.
3. Насанд хүрсэн иргэдийн 3.3% өлөн үеийн цусны глюкозын өөрчлөлттэй, 5.7% глюкозын хэмжээ ихэссэн буюу чихрийн шижинтэй байна. Өлөн үеийн цусны глюкозын өөрчлөлтийн тохиолдол 18–19 насны залуучуудын дунд 6.3% байгаа нь анхаарал татаж байна. Чихрийн шижингийн тархалт иргэдийн настай шууд хамааралтайгаар ихсэж байгаа бөгөөд илрээгүй бөгөөд 40–49 насанд огцом нэмэгдэж байна.
4. Эрт илрүүлэг үзлэгт хамрагдсан иргэдийн тоо харилцан адилгүй байгаа тул чихрийн шижингийн тархалтыг сумаар харьцуулан дүгнэх боломжүй байна.


## ӨЛӨН ҮЕИЙН ЦУСНЫ ЛИПИДЫН ҮНЭЛГЭЭ

Хүснэгт 233. Өлөн үеийн цусны липидын үнэлгээ хүйсээр

Насанд хүрсэн хүн амын дунд (95% ИХ)	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
“Өлөн үеийн цусны холестерин хэмжээ ихэссэн” гэж оношлогдож байсан хүн амын хувь	<b>4.2</b> (3.6-4.7)	<b>4.1</b> (3.3-4.9)	<b>4.2</b> (3.5-4.9)
Цусны нийт холестерин хэмжээ ихэссэн ( $\geq 5.3$ ммоль/л) хүн амын хувь	<b>25.7</b> (23.1-28.3)	<b>26.1</b> (22.2-29.9)	<b>25.5</b> (22.0-29.0)
“Өлөн үеийн цусны триглицеридийн хэмжээ ихэссэн” гэж оношлогдож байсан хүн амын хувь	<b>2.0</b> (1.6-2.3)	<b>1.8</b> (1.2-2.3)	<b>2.1</b> (1.6-2.6)
Цусны триглицеридийн хэмжээ ихэссэн ( $\geq 1.7$ ммоль/л) хүн амын хувь	<b>5.7</b> (4.3-7.1)	<b>7.5</b> (5.2-9.8)	<b>4.2</b> (2.6-5.8)



Зураг 395. Өлөн үеийн цусны липидын хэмжээ ихэссэн хүн амын хувь, насны бүлгээр



Зураг 396. Өлөн үеийн цусны нийт холестерин агууламж ихэссэн хүн амын хувь, сумаар


### ГОЛ МЭДЭЭЛЭЛ

1. Увс аймгийн эрт илрүүлэг үзлэгт хамрагдсан насанд хүрэгчдийн 4.2% цусны холестерин ихэссэн, харин 2.0% триглицеридийн агууламж ихэссэн гэж оношлогдож байжээ.
2. Насанд хүрэгчдийн 25.7% өлөн үеийн цусны нийт холестерин, 5.7% триглицеридийн агууламж ихэссэн байна. Цусны нийт холестерин хэмжээ ихэссэн тохиолд хүйсийн ялгаа ажиглагдаагүй болно. Харин цусны триглицеридийн хэмжээ ихсэлтийн тархалт эрэгтэйчүүдийн дунд 1.8 дахин өндөр байв.
3. Өлөн үеийн цусны нийт холестерин ихсэлтийн тархалт иргэдийн нас ахих тутам нэмэгдэх зүй тогтол ажиглагдсан болно. Ялангуяа, 50 ба түүнээс дээш насны иргэдийн 41.5%–50.0% нийт холестерин агууламж ихэссэн байв. Цусны липидын ихсэлт 40–49 насны иргэдийн дунд огцом нэмэгдэж байна.
4. Эрт илрүүлэг үзлэгт хамрагдсан иргэдийн тоо харилцан адилгүй байгааг харгалзан цусны холестерин ихсэлтийн тархалтыг сумаар харьцуулан дүгнэх боломжгүй байв.

## ХУВЬ ХҮНИЙ ЭРСДЭЛИЙН ҮНЭЛГЭЭ

Хүснэгт 234. Хувь хүний эрсдэлийн үнэлгээ хүйсээр

Насанд хүрсэн хүн амын дунд (95% ИХ)	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
Гэр бүлийн гишүүн чихрийн шижингээр өвчилж байсан <i>Өвөө, эмээ, нагац, авга Эцэг, эх, ах дүү, өөрийн хүүхэд</i>	<b>5.5</b> (4.2-6.8)	<b>4.7</b> (2.9-6.5)	<b>6.2</b> (4.3-8.0)
Жирэмсний чихрийн шинжингээр өвчилж байсан	-	-	<b>11.9</b> (16.4-24.4)
Хавдраар өвчилж байсан түүх (гэр бүлийн гишүүн)	<b>8.3</b> (7.5-9.0)	<b>6.8</b> (5.8-7.9)	<b>9.2</b> (8.2-10.2)
Артерийн даралт бууруулах эм тогтмол хэрэглэдэг	<b>17.2</b> (16.2-18.2)	<b>10.8</b> (9.5-12.1)	<b>21.1</b> (19.8-22.5)
Цусны өөх тос бууруулах эм хэрэглэж байгаа	<b>13.1</b> (12.2-14.0)	<b>11.8</b> (10.4-13.1)	<b>14.0</b> (12.8-15.2)



Зураг 397. “Гэр бүлийн хэн нэгэн гишүүн нь чихрийн шинжин, хавдраар өвчилж байсан” гэж хариулсан насанд хүрэгчдийн хувь, насны бүлгээр

### ГОЛ МЭДЭЭЛЭЛ


1. Урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдсан Увс аймгийн насанд хүрэгчдийн 5.5% гэр бүлийн хэн нэгэн гишүүн чихрийн шижингээр, харин 8.3% хавдраар өвчилсөн гэж тус тус хариулсан байна. Нийт эмэгтэйчүүдийн 11.9% жирэмсний чихрийн шижин оношлогдож байжээ.
2. Эрт илрүүлэгт хамрагдсан Увс аймгийн иргэдийн 17.2% артерийн даралт бууруулах эмийг тогтмол хэрэглэдэг, харин 13.1% цусны өөх тос бууруулах эмийг одоо хэрэглэж байв.
3. Гэр бүлийн хэн нэгэн гишүүн чихрийн шижингээр өвчилсөн гэж хариулсан хүн амын тархалт 40 хүртэлх насны залуучуудын дунд харьцангуй өндөр, харин хавдраар өвчилж байсан гэж хариулсан иргэдийн тархалт нас ахих тутам ихсэх хандлага ажиглагдсан болно. Хавдраар өвчилсөн гэр бүлийн түүхтэй насанд хүрэгчдийн хувь эрт илрүүлэг үзлэгт хамрагдсан 40 ба түүнээс дээш насны иргэдийн дунд харьцангуй өндөр байв.
4. “Гэр бүлийн хэн нэгэн гишүүн хавдраар өвчилсөн”, “АД бууруулах эм тогтмол хэрэглэдэг”, “Цусны өөх тос буурах эм хэрэглэж байгаа” гэж хариулсан эмэгтэйчүүдийн хувь эрэгтэйчүүдийн дундаж үзүүлэлтээс статистик ач холбогдол бүхий өндөр байна.



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН НАСАНД ХҮРЭГЧДИЙН ДУНДАХ  
ХАЛДВАРТ БУС ӨВЧНИЙ ЭРСДЭЛТ ХҮЧИН ЗҮЙЛСИЙН  
ТАРХАЛТ**

**ТАНИЛЦУУЛГА**

Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/248 дугаар тушаалыг хэрэгжүүлэх арга хэмжээний хүрээнд 2022 оны 5 дугаар сарын 1-ээс 2023 оны 5 дугаар сарын 1 хүртэлх хугацаанд эрт илрүүлэг, урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдсан Өвөрхангай аймгийн нийт 11.193 насанд хүрэгчдийн мэдээллийг нэгтгэн, хүн амын дунд түгээмэл тохиолдож буй Халдварт бус өвчин (ХБӨ)-ий эрсдэлт хүчин зүйлсийн тархалтын байдалд дүн шинжилгээ хийв (Зураг 409).



**Зураг 398. Өвөрхангай аймгийн эрт илрүүлэг үзлэгт хамрагдсан насанд хүрэгчдийн тоо, сумаар**

Өвөрхангай аймгийн эрт илрүүлэг үзлэгт хамрагдсан насанд хүрэгчдийн тоо сум бүрд харилцан адилгүй хамрагдалтай байх бөгөөд 18-90 насны нийт 11.193 хүн хамрагдсаны 45.0% (n=5,032) эрэгтэйчүүд, 55.0% (n=6,161) эмэгтэйчүүд байв (Хүснэгт 1).

Хүснэгт 235. Эрт илрүүлэгт хамрагдсан насанд хүрэгчид, насны бүлэг ба хүйсээр


Насны бүлэг, жилээр	N	Эрэгтэй			Эмэгтэй		
		Тоо	Хувь	95% ИХ	Тоо	Хувь	95% ИХ
≤ 19	844	635	75.2	72.3-78.2	209	24.8	21.9-27.7
20 – 29	3059	1735	56.7	55.0-58.5	1324	43.3	41.5-45.0
30 – 39	2007	742	37.0	34.9-39.1	1265	63.0	60.9-65.1
40 – 49	1771	599	33.8	31.6-36.0	1172	66.2	64.0-68.4
50 – 59	1889	698	36.9	34.8-39.1	1191	63.1	60.9-65.2
60 – 69	1214	455	37.5	34.8-40.2	759	62.5	59.8-65.3
≥ 70	409	168	41.1	36.3-45.9	241	58.9	54.1-63.7
<b>Нийт</b>	<b>11,193</b>	<b>5,032</b>	<b>45.0</b>	<b>44.0-45.9</b>	<b>6,161</b>	<b>55.0</b>	<b>54.1-56.0</b>

Өвөрхангай аймгийн насанд хүрэгчдийн Эрт илрүүлэг үзлэгт хамрагдсан дундаж нас 40.0 (95%ИХ 39.7–40.3) жил, эмэгтэйчүүдийн дундаж нас эрэгтэйчүүдээс 4.2 жилээр илүү байна (дундаж нас: эр 36.6 жил, эм 42.8 жил).


**ХАЛДВАРТ БУС ӨВЧНИЙ НИЙТЛЭГ ЭРСДЭЛТ ХҮЧИН ЗҮЙЛС ХАВСРАН ИЛЭРСЭН ХҮН АМ**  
Хүснэгт 236. Халдварт бус өвчний нийтлэг эрсдэлт хүчин зүйлс хавсран илэрсэн хүн ам хүйсээр

Хүн амын дунд (95% ИХ)	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
<b>ХБӨ-ий нийтлэг эрсдэлт хүчин зүйлс</b>			
<ul style="list-style-type: none"> <li>Өдөр бүр тамхи татдаг</li> <li>Өдөрт 5 нэгжээс бага хэмжээгээр жимс, ногоо хэрэглэдэг</li> <li>Хөдөлгөөний хомсдолтой</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Илүүдэл жинтэй (БЖИ <math>\geq 25</math> кг/м<sup>2</sup>)</li> <li>Артерийн даралт ихсэлттэй (САД <math>\geq 140</math> ба/эсвэл ДАД <math>\geq 90</math> мм МУБ эсвэл даралт бууруулах эм хэрэглэж байгаа)*</li> </ul>		
Нийтлэг эрсдэлт хүчин зүйлс илрээгүй хүн амын хувь	<b>2.0</b> (1.7 – 2.3)	<b>1.2</b> (0.9 – 1.5)	<b>2.7</b> (2.3 – 3.2)
Нийтлэг эрсдэлт хүчин зүйлсээс 1-2 эрсдэл хавсран илэрсэн хүн амын хувь	<b>41.7</b> (40.7 – 42.7)	<b>40.3</b> (38.8 – 41.7)	<b>43.0</b> (41.7 – 44.4)
Нийтлэг эрсдэлт хүчин зүйлсээс 3 ба түүнээс олон эрсдэл хавсран илэрсэн хүн амын хувь	<b>56.3</b> (55.3 – 57.2)	<b>58.5</b> (57.1 – 60.0)	<b>54.2</b> (52.9 – 55.6)

\*ДЭМБ-ын үзүүлэлтийг баримтлав.



Зураг 399 .Түгээмэл тохиолдох эрсдэлт хүчин зүйлс хавсран илэрсэн хүн ам, насны ангилал ба хүйсээр



Зураг 400. ХБӨ-өөр өвчлөх өндөр эрсдэлтэй хүн амын хувь, сумаар


**ГОЛ МЭДЭЭЛЭЛ**

1. Өвөрхангай аймгийн насанд хүрсэн хүн амын ХБӨ-өөр өвчлөх эрсдэлгүй хүн амын тархалт дөнгөж 2.0% байна.
2. Насанд хүрсэн хүн амын 2 хүн тутмын 1 нь (56.3%) нийтлэг эрсдэлт хүчин зүйлсээс 3 ба түүнээс олон эрсдэл хавсран илэрсэн байна.
3. ХБӨ-өөр өвчлөх өндөр эрсдэлтэй хүн амын тархалт эрэгтэйчүүдийн дунд эмэгтэйчүүдээс 2.2 дахин их байна. Энэ нь эрэгтэйчүүдийн дундаж наслалт болон тэдний амьдралын чанарт сөргөөр нөлөөлөх магадлалтай.
4. Нас ахих тусам эрсдэлт хүчин зүйлс хавсран илэрсэн хүн амын тоо өсөж байна.
5. Уянга, Сант, Зүүнбаян-Улаан, Богд, Баян-Өндөр, Гучин-Ус сумуудад Нийтлэг эрсдэлт хүчин зүйлсээс 3 ба түүнээс олон эрсдэл хавсран илэрсэн хүн амын хувь аймгийн дундаж (56.3%)-аас өндөр байна.


## ТАМХИНЫ ХЭРЭГЛЭЭ

Хүснэгт 237. Тамхины хэрэглээ хүйсээр

Насанд хүрсэн хүн амын дунд (95% ИХ)	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
Тамхи татдаг хүн амын хувь	<b>18.8</b> (18.0 – 19.5)	<b>40.5</b> (39.1 – 41.9)	<b>0.8</b> (0.6 – 1.0)
Өдөр бүр тамхи татдаг хүн амын хувь	<b>13.2</b> (12.6 – 13.8)	<b>28.8</b> (27.5 – 30.0)	<b>0.5</b> (0.3 – 0.6)
<i>Өдөр бүр тамхи татдаг хүн амын дунд:</i>			
Тамхи татаж эхэлсэн дундаж нас (жилээр)	<b>19.6</b> (19.3 – 19.8)	<b>19.5</b> (19.2 – 19.7)	<b>25.5</b> (22.1 – 28.9)



Зураг 401. Тамхи татдаг хүн ам, хүйс ба насны ангилал



Зураг 402. Тамхи татдаг хүн амын тархалт, сумаар


## ГОЛ МЭДЭЭЛЭЛ

1. Өвөрхангай аймгийн насанд хүрсэн хүн амын 5 хүн тутмын 1 нь (18.8%) тамхи татдаг бөгөөд эрэгтэйчүүдийн дунд тамхины хэрэглээ эмэгтэйчүүдээс 50.6 дахин их байна.
2. Өдөр бүр тамхи татдаг хүн амын хувь нийт тамхи татдаг хүмүүсийн 70.2%-ийг эзэлж байна.
3. Тамхи татаж эхэлсэн нас дунджаар 19.6 байна.
4. 59 нас хүртэлх бүх насны ангилалд тамхины хэрэглээ жигд өндөр байна.
5. Есөнзүйл, Тарагт, Хархорин, Бүрд, Уянга, Бат-өлзий, Хайрхандулаан Хужирт, Нарийн тээл сумуудад тамхи татдаг хүн амын хувь аймгийн дундаж (19.6%)-аас өндөр байна.


## АРХИ, СОГТУУРУУЛАХ УНДААНЫ ХЭРЭГЛЭЭ

Хүснэгт 238. Архи, согтууруулах ундааны хэрэглээ хүйсээр

Насанд хүрсэн хүн амын дунд (95% ИХ)	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
Сүүлийн 1 сард стандарт уултаас илүү архи, согтууруулах ундаа хэрэглэсэн хүн амын хувь	<b>12.2</b> (11.6 – 12.8)	<b>23.1</b> (21.9 – 24.2)	<b>3.1</b> (2.7 – 3.6)



Зураг 403. Сүүлийн 1 сард стандарт уултаас илүү архи, согтууруулах ундаа хэрэглэсэн хүн ам, хүйс ба насны бүлгээр



Зураг 404. Сүүлийн 1 сард стандарт уултаас илүү архи, согтууруулах ундаа хэрэглэсэн хүн ам, сумаар


### ГОЛ МЭДЭЭЛЭЛ

1. Өвөрхангай аймгийн насанд хүрсэн хүн амын сүүлийн 1 сард стандарт уултаас илүү архи, согтууруулах ундаа хэрэглэсэн хүн амын хувь 12.2% байх бөгөөд эрэгтэйчүүдийн дунд согтууруулах ундааны хэрэглээ эмэгтэйчүүдээс 7.4 дахин их байна.
2. Хөдөлмөрийн насны (30-59 нас) хүмүүсийн архины хэрэглээ бусад насны бүлэгтэй харьцуулахад их байна.
3. Хархорин, Өлзийт, Зүүнбаян-Улаан, Бат-өлзий, Есөн зүйл, Нарийнтээл, сумаудад Сүүлийн 1 сард стандарт уултаас илүү архи, согтууруулах ундаа хэрэглэсэн хүн амын хувь аймгийн дундаж (12.2%)-аас өндөр байна.


## ЖИМС, ЖИМСГЭНЭ, НОГООНЫ ХЭРЭГЛЭЭ

Хүснэгт 239. Жимс, жимсгэнэ, ногооны хэрэглээ хүйсээр

Насанд хүрсэн хүн амын дунд (95% ИХ)	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
Зохистой хэрэглээтэй хүн амын хувь (хоногт $\geq 5$ нэгж буюу 400 г)	<b>14.6</b> (13.9-15.2)	<b>10.9</b> (10.0-11.8)	<b>17.6</b> (16.6-18.6)
Хангалтгүй хэрэглээтэй хүн амын хувь (хоногт $< 5$ нэгж /400 г)	<b>24.2</b> (23.4-25.0)	<b>29.6</b> (28.4-30.9)	<b>19.8</b> (18.8-20.8)
Жимс, ногоо бага хэрэглэдэг ХБӨ-ний эрсдэлтэй хүн амын хувь (жимс, ногоог өдөр бүр хэрэглэдэггүй эсвэл хоногт 400 граммаас бага хэрэглэдэг)	<b>85.4</b> (84.8-86.1)	<b>89.1</b> (88.3-90.0)	<b>82.4</b> (81.4-83.4)



Зураг 405. Жимс, жимсгэнэ, хүнсний ногоо бага хэрэглэдэг насанд хүрэгчдийн хувь, насны бүлгээр



Зураг 406. Жимс, жимсгэнэ, ногооны зохистой хэрэглээтэй насанд хүрэгчдийн хувь, сумаар


### ГОЛ МЭДЭЭЛЭЛ

1. Өвөрхангай аймгийн насанд хүрсэн иргэдийн дөнгөж 14.6% нь жимс, жимсгэнэ, хүнсний ногоог хоногт 5 нэгж буюу 400 граммаас их хэмжээгээр хэрэглэдэг буюу зохистой хэрэглээтэй байна.
2. Эрт илрүүлэг үзлэгт хамрагдсан 18-90 насны иргэдийн 85.7% нь өдөр бүр жимс, ногоо хэрэглэдэггүй эсвэл хоногт 400 граммаас бага хэмжээгээр хэрэглэж байна. Насанд хүрсэн 10 хүн тутмын 9 нь “Эрүүл хооллолтын ГЭР зөвлөмж”-д заасан хэмжээ (Хоногт $\geq 400$ г)-ээр жимс, хүнсний ногоог хэрэглэдэггүй буюу ХБӨ-өөр өвчлөх эрсдэлтэй байв.
3. Жимс, жимсгэнэ, хүнсний ногоо бага хэрэглэдэг буюу ХБӨ-өөр өвчлөх эрсдэлтэй насанд хүрэгчдийн тархалт 19 ба түүнээс доош, 50 ба түүнээс дээш насны иргэдийн дунд харьцангуй их байна.


## ХӨДӨЛГӨӨН

Хүснэгт 240. Хөдөлгөөн хүйсээр

Насанд хүрсэн хүн амын дунд (95% ИХ)	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
7 хоногийн 5-аас доошгүй өдөр 30 минутаас дээш дасгал хөдөлгөөн хийдэггүй, эсвэл 10000 алхдаггүй хүн амын хувь	<b>60.4</b> (59.4 – 61.3)	<b>55.6</b> (54.3 – 57.0)	<b>64.3</b> (63.1 – 65.5)



Зураг 407. 7 хоногийн 5-аас доошгүй өдөр 30 минутаас дээш дасгал хөдөлгөөн хийдэггүй, эсвэл 10000 алхдаггүй хүн амын тархалт, насны бүлгээр ба хүйсээр



Зураг 408. 7 хоногийн 5-аас доошгүй өдөр 30 минутаас дээш дасгал хөдөлгөөн хийдэггүй, эсвэл 10000 алхдаггүй хүн амын тархалт, сумаар


### ГОЛ МЭДЭЭЛЭЛ

1. Өвөрхангай аймгийн “Урьдчилан сэргийлэх эрт илрүүлэгт” хамрагдсан нийт хүн амын 60.4% нь 7 хоногийн 5-аас доошгүй өдөр 30 минутаас дээш дасгал хөдөлгөөн хийдэггүй, эсвэл 10000 алхдаггүй байна.
2. Хүйсээр авч үзвэл эмэгтэйчүүд (64.3%), эрэгтэйчүүдээс (55.6%) 8.7%-иар илүү, нас ахих тусам хөдөлгөөний идэвхгүй байдал нэмэгдэж байгаа нь ажиглагдав.


## ИЛҮҮДЭЛ ЖИН БА ТАРГАЛАЛТ

Хүснэгт 241. Илүүдэл жин ба таргалалт хүйсээр

Насанд хүрсэн хүн амын дунд (95% ИХ)	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
Биеийн жингийн индекс (БЖИ)-ийн дундаж хэмжээ (кг/м <sup>2</sup> )	<b>26.0</b> (25.9-26.1)	<b>25.7</b> (25.6-25.8)	<b>26.2</b> (26.1-26.3)
Илүүдэл жин ба таргалалттай хүн амын хувь (БЖИ ≥ 25 кг/м <sup>2</sup> )	<b>52.8</b> (51.8-53.7)	<b>49.9</b> (48.5-51.3)	<b>55.1</b> (53.9-56.4)
Таргалалттай хүн амын хувь (БЖИ ≥ 30 кг/м <sup>2</sup> )	<b>17.8</b> (17.1-18.6)	<b>16.3</b> (15.3-17.3)	<b>19.1</b> (18.1-20.1)
Бүсэлхийн тойргийн дундаж хэмжээ (см)	-	<b>86.4</b> (86.0-86.8)	<b>83.8</b> (83.5-84.1)
Төвийн таргалалттай хүн амын хувь (Бүсэлхийн тойрог: эр ≥ 90 см, эм ≥ 80 см)	<b>52.5</b> (51.6-53.5)	<b>38.5</b> (37.1-39.9)	<b>64.1</b> (62.9-65.3)



Зураг 409. Илүүдэл жин ба таргалалтын тархалт, насны бүлгээр



Зураг 410. Таргалалтын тархалт (БЖИ ≥ 30 кг/м<sup>2</sup>), сумаар


### ГОЛ МЭДЭЭЛЭЛ

1. Урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдсан Өвөрхангай аймгийн 18–90 насны иргэдийн БЖИ-ийн дундаж хэмжээ 26.0 кг/м<sup>2</sup> байгаа нь ДЭМБ-аас зөвлөсөн хэвийн хязгаараас хэтэрсэн байна. Эмэгтэйчүүдийн БЖИ-ийн дундаж хэмжээ эрэгтэйчүүдийн үзүүлэлтээс их байв.
2. Өвөрхангай аймгийн насанд хүрсэн иргэдийн 52.8% нь илүүдэл жин ба таргалалттай, 17.8% нь тарган байна. Таргалалтын тархалт эмэгтэйчүүдийн дунд эрэгтэйчүүдийн үзүүлэлтээс их, аль ч хүйсийн насанд хүрэгчдийн дунд нас ахих тутам нэмэгдэх хандлага ажиглагдлаа.
3. Эрт илрүүлэгт хамрагдсан насанд хүрэгчдийн 52.5% нь төвийн таргалалттай, төвийн таргалалттай эмэгтэйчүүдийн хувь эрэгтэйчүүдээс 1.7 дахин их байна.


## АРТЕРИЙН ГИПЕРТЕНЗИ

Хүснэгт 242. Артерийн гипертензи хүйсээр

Насанд хүрсэн хүн амын дунд (95% ИХ)	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
Систолийн артерийн даралт (САД)-ын дундаж хэмжээ, мм МУБ (даралт бууруулах эм хэрэглэж байгаа хүн амыг оролцуулсан)	<b>121.5</b> (121.2-121.8)	<b>121.9</b> (121.5-122.3)	<b>121.2</b> (120.7-121.6)
Диастолын артерийн даралт (ДАД)-ын дундаж хэмжээ, мм МУБ (даралт бууруулах эм хэрэглэж байгаа хүн амыг оролцуулсан)	<b>79.5</b> (79.3-79.7)	<b>80.0</b> (79.7-80.3)	<b>79.1</b> (78.8-79.4)
Артерийн даралт ихсэлттэй хүн амын хувь (САД = 120-129 мм МУБ ба/эсвэл ДАД ≤ 80 мм МУБ)	<b>33.8</b> (32.8-34.7)	<b>39.1</b> (37.7-40.5)	<b>29.1</b> (27.-30.4)
Артерийн гипертензитэй хүн амын хувь (САД ≥ 130 ба/эсвэл ДАД ≥ 81 мм МУБ эсвэл даралт бууруулах эм хэрэглэдэг хүн амын оролцуулсан)	<b>33.2</b> (32.3-34.2)	<b>31.4</b> (30.0-32.7)	<b>34.9</b> (33.6-36.2)



Зураг 411. Артерийн гипертензийн тархалт, насны бүлгээр



Зураг 412. Артерийн гипертензийн тархалт, сумаар

## ГОЛ МЭДЭЭЛЭЛ


1. Эрт илрүүлэг үзлэгт хамрагдсан Өвөрхангай аймгийн насанд хүрэгчдийн САД-ын дундаж хэмжээ 121.5 мм МУБ, ДАД-ын дундаж үзүүлэлт 79.5 мм МУБ байна.
2. Насанд хүрэгчдийн 33.8% артерийн даралт ихсэлттэй буюу САД нь 120–129 мм ба/эсвэл ДАД ≤ 80 мм МУБ байв. Артерийн даралт ихсэлтийн тархалт эрэгтэйчүүдийн дунд статистик ач холбогдол бүхий өндөр байна.
3. Урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдсан насанд хүрсэн иргэдийн дунд САД ≥ 130 мм МУБ ба ДАД ≥ 81 мм МУБ-ээс дээш буюу Артерийн гипертензийн тархалт 33.2% байв. Артерийн гипертензийн тархалт эрт илрүүлэгт хамрагдсан эрэгтэйчүүдийн дунд эмэгтэйчүүдээс 3.4%-иар илүү байна.
4. Өвөрхангай аймгийн 50–59 насны 2 хүн тутмын 1-ээс илүү нь, 60 ба түүнээс дээш насны 10 хүн тутмын 7 орчим Артерийн гипертензтэй байв.




## ЧИХРИЙН ШИЖИН

Хүснэгт 243. Чихрийн шижин хүйсээр

Насанд хүрсэн хүн амын дунд (95% ИХ)	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
Өлөн үеийн цусны глюкозын дундаж хэмжээ (ммоль/л), глюкоз бууруулах эм хэрэглэж буй хүн амыг оруулаад	<b>5.1</b> (5.0-5.1)	<b>5.2</b> (5.1-5.3)	<b>5.0</b> (4.9-5.1)
Өлөн үеийн цусны глюкозын өөрчлөлттэй хүн амын хувь (Ийлдсийн глюкозын хэмжээ $\geq 6.1$ ммол/л ба $< 7.0$ ммол/л)	<b>5.6</b> (5.0-6.0)	<b>6.6</b> (5.7-7.5)	<b>4.9</b> (4.3-5.5)
Өлөн үеийн цусны глюкозын хэмжээ ихэссэн болон глюкоз бууруулах эм хэрэглэж буй хүн амын хувь (Ийлдсийн глюкозын хэмжээ $\geq 7.0$ ммол/л)	<b>5.1</b> (4.6-5.6)	<b>6.4</b> (5.5-7.3)	<b>4.3</b> (3.7-4.9)



Зураг 413. Өлөн үеийн цусны глюкозын өөрчлөлттэй болон ЧШ-тэй хүн амын хувь, насны бүлгээр



Зураг 414. Чихрийн шижингийн тархалт, сумаар


## ГОЛ МЭДЭЭЛЭЛ

1. Өвөрхангай аймгийн эрт ирүүлэг үзлэгт хамрагдсан насанд хүрэгчдийн өлөн үеийн цусны глюкозын дундаж хэмжээ 5.1 ммоль/л байв.
2. Насанд хүрсэн иргэдийн 5.6% нь өлөн үеийн цусны глюкозын өөрчлөлттэй, 5.1% нь цусны глюкозын хэмжээ ихэссэн буюу чихрийн шижинтэй байна.
3. Эрт илрүүлэг үзлэгт хамрагдсан эрэгтэйчүүдийн дунд өлөн үеийн цусны глюкозын өөрчлөлт болон чихрийн шижингийн тархалт эмэгтэйчүүдээс статистик ач холбогдол бүхий илүү байв.
4. Урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдсан Өвөрхангай аймгийн  $\leq 19$  насны залуучуудын дунд чихрийн шижин илрээгүй боловч, далд чихрийн шижин буюу өлөн үеийн цусны глюкозын өөрчлөлтийн тохиолдол 6.7% байна.


## ӨЛӨН ҮЕИЙН ЦУСНЫ ЛИПИДЫН ҮНЭЛГЭЭ

Хүснэгт 244. Өлөн үеийн цусны липидын үнэлгээ хүйсээр

Насанд хүрсэн хүн амын дунд (95% ИХ)	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
“Өлөн үеийн цусны холестерин хэмжээ ихэссэн” гэж оношлогдож байсан хүн амын хувь	<b>4.7</b> (4.3-5.0)	<b>4.1</b> (3.6-4.7)	<b>5.1</b> (4.5-5.6)
Цусны нийт холестерин хэмжээ ихэссэн ( $\geq 5.3$ ммоль/л) хүн амын хувь	<b>39.5</b> (38.0-40.9)	<b>40.9</b> (38.7-43.1)	<b>38.4</b> (36.4-40.3)
“Өлөн үеийн цусны триглицеридийн хэмжээ ихэссэн” гэж оношлогдож байсан хүн амын хувь	<b>2.8</b> (2.5-3.1)	<b>3.6</b> (3.1-4.1)	<b>2.1</b> (1.8-2.5)
Цусны триглицеридийн хэмжээ ихэссэн ( $\geq 1.7$ ммоль/л) хүн амын хувь	<b>7.6</b> (6.8-8.4)	<b>10.9</b> (9.5-12.4)	<b>5.1</b> (4.2-6.0)



Зураг 415. Өлөн үеийн цусны липидын хэмжээ ихэссэн хүн амын хувь, насны бүлгээр



Зураг 415. Өлөн үеийн цусны нийт холестерин хэмжээ ихэссэн хүн амын хувь сумаар


### ГОЛ МЭДЭЭЛЭЛ

1. Өвөрхангай аймгийн эрт илрүүлэг үзлэгт хамрагдсан насанд хүрсэн иргэдийн 4.7% цусны холестерин ихэссэн, харин 2.8% триглицеридын агууламж ихэссэн гэж оношлогдож байжээ.
2. Насанд хүрэгчдийн 39.5% өлөн үеийн цусны нийт холестерин, 2.8% триглицеридын агууламж ихэссэн байна. Цусны триглицеридын хэмжээ ихэссэн тохиолдол эрэгтэйчүүдийн дунд харьцангуй илүү илэрсэн болно.
3. Цусны холестерин агууламж ихэссэн насанд хүрэгчдийн тархалт тэдний наснаас шууд хамааралтайгаар нэмэгдэж байв. Өлөн үеийн цусны холестерин агууламж ихсэх байдалд хүйсийн ялгаа ажиглагдав.


## ХУВЬ ХҮНИЙ ЭРСДЭЛТ ХҮЧИН ЗҮЙЛС

Хүснэгт 245. Хувь хүний эрсдэлт хүчин зүйлс хүйсээр


Хувь хүний эрсдэлт хүчин зүйлсийн тархалт	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
АД бууруулах эм тогтмол хэрэглэдэг	<b>13.3</b> (12.7-14.0)	<b>10.2</b> (9.3-11.0)	<b>15.9</b> (15.0-16.9)
Чихрийн шижинтэй (эмээ, өвөө, нагац, авга)	<b>4.0</b> (3.4-4.6)	<b>4.7</b> (3.8-5.6)	<b>3.4</b> (2.7-4.2)
Чихрийн шижинтэй (эцэг, эх, ах, эгч, дүү, өөрийн хүүхэд)	<b>6.3</b> (5.6-7.0)	<b>5.6</b> (4.6-6.6)	<b>6.8</b> (5.8-7.7)
Жирэмсний чихрийн шижин оношлогдож байсан			<b>13.5</b> (12.5-14.4)
Гэр бүлийн гишүүд хавдраар өвчилж байсан	<b>7.4</b> (6.9-7.8)	<b>6.8</b> (6.1-7.5)	<b>7.8</b> (7.1-8.5)
Таны хөхөнд ямар нэгэн эмзэглэл, хатуурал, арьсны өнгө өөрчлөгдсөн эсэх			<b>15.4</b> (14.4-16.3)
Өөх тос бууруулах эм хэрэглэдэг	<b>11.3</b> (9.8 – 12.8)	<b>8.8</b> (7.3 – 10.3)	<b>13.3</b> (11.8 – 14.8)




Зураг 416. АД бууруулах эм тогтмол хэрэглэдэг хүн ам, хүйс, насны ангиллаар



Зураг 417. Өөх тос бууруулах эм хэрэглэдэг хүн ам, хүйс, насны ангиллаар



Зураг 418. Гэр бүлийн хэн нэгэн гишүүн нь хавдраар өвчилж байсан” гэж хариулсан насанд хүрэгчдийн хувь, сумаар



Зураг 419. Артерийн даралт бууруулах эм тогтмол хэрэглэдэг насанд хүрэгчдийн хувь, сумаар

## ГОЛ МЭДЭЭЛЭЛ

1. Өвөрхангай аймгийн “Урьдчилан сэргийлэх эрт илрүүлэгт” хамрагдсан нийт хүн амын 13.3% нь артерийн даралт бууруулах эмээ тогтмол хэрэглэдэг байна.
2. Хүйсээр нь авч үзвэл эмэгтэйчүүд (15.9%), эрэгтэйчүүдээс (10.2%) 5.7%-иар их буюу даралт ихсэлттэй эсэхдээ илүү хяналт тавьж, эмээ тогтмол хэрэглэж байна.
3. Насны бүлгээр нь авч үзэхэд <19 насны хүн ам даралтын эмийг хамгийн бага хувьтай хэрэглэдэг бол нас ахих тусам буюу 70-аас дээш настай хүмүүсийн дунд артерийн даралт ихсэлт нэмэгдэж, эмийн эмчилгээг түлхүү хэрэглэж байгаа нь ажиглагдав.
4. “Урьдчилан сэргийлэх эрт илрүүлэгт” хамрагдсан хүмүүсийн 6.3% нь гэр бүл, хамаатан садан нь чихрийн шижингээр өвдсөн байна. Жирэмсэн эхийн 13.5% нь жирэмсний чихрийн шижингээр оношлогдож байсан байна.
5. Өөх тос бууруулах эмийн хэрэглээ 11.3%-тай байна. 19-29 насныхны дунд өөх тос бууруулах эм хэрэглэх түвшин бусад насныхнаас өндөр байна. Хүйсээр авч үзвэл эмэгтэй хүмүүсийн дунд эрэгтэйчүүдээсээ өндөр, ялангуяа <19 болон 20-29 насны эмэгтэйчүүд харьцангуй өндөр байна.

## ЗӨВЛӨМЖ

- Нийт хүн амын дунд насны бүлгээр ХБӨ-ий эрсдэлт хүчин зүйлсийн тархалтад тогтмол хяналт-шинжилгээ хийх тандалтын тогтолцоог бүрдүүлэх, ЭМАШБ-ын түвшинд ХБӨ-ий эрсдэлт хүчин зүйлсийн эрт илрүүлэг, сэргийлэлтийн талаар удирдамж боловсруулж, хэрэгжүүлэх
- Иргэдийг тамхины утаанд өртөхөөс хамгаалах, ажлын байр, олон нийтийн газарт тамхи татахыг хатуу хориглох заалтыг мөрдүүлэх, тамхины эрүүл мэндэд үзүүлэх хортой нөлөөг таниулах, эерэг дадал бий болгох сургалт, сурталчилгааг тасралтгүй хийх
- Тамхины хяналтын хуульд дам тамхины хортой нөлөөллөөс иргэдийг хамгаалах зарим заалтыг нэмж оруулах, тамхийг ширхэглэн борлуулахыг хориглосон хуулийн заалтын хэрэгжилтийг хянах
- Тамхинаас гарах оролдлого хийж буй иргэдэд зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэх нэгжийг орон нутгийн эрүүл мэндийн төвүүдэд ажиллуулах
- Нийт хүн амд архины хор хөнөөл, ялангуяа согтууруулах ундааг хэтрүүлэн хэрэглэхийн сөрөг үр дагаврыг таниулах МСС-ны ажлыг эрчимжүүлэх, архины онцгой албан татварыг нэмэгдүүлэх, архины хуулийн хэрэгжилтийг эрчимжүүлэх, архинаас татгалзах олон нийтийн хөдөлгөөнийг дэмжих,
- Чихэр, давс, ханасан тос, транс тосны агууламж ихтэй эрүүл бүс хүнсний үйлдвэрлэл, худалдаа, импортыг эдийн засгийн аргаар хязгаарлах, хүүхэд, залууст чиглэсэн зар сурталчилгааг хориглох
- Жимс, хүнсний ногооны өрхийн тариаланг дэмжих замаар хангамж, хүртээмжийг сайжруулах, аминдэм, эрдсээр баялаг улаан, ногоон өнгийн ногоо, жимсийг ашиглан хоол хүнс бэлтгэх жор, технологийг хүн ам, олон нийтэд сурталчлан таниулах
- Бүх шатны боловсролын байгууллага хүүхэд, залуучуудад эрүүл хооллолт, идэвхтэй хөдөлгөөн, шинэ жимс, хүнсний ногоог өдөр бүр тогтмол хэрэглэхийн эрүүл мэндийн ач тусын талаар мэдлэг олгох
- Хүн амын нас, хүйсийн онцлог, хэрэгцээнд нийцүүлэн илүүдэл жин, таргалалтын шалтгаан, түүнд нөлөөлөх эрсдэлт хүчин зүйлс, түүнээс хэрхэн сэргийлэх, биеийн жингээ хянах талаар эрүүл мэндийн боловсрол олгох мэдээлэл, сурталчилгааг олон нийтийн мэдээллийн сувгаар тасралтгүй түгээх
- Хүн амын мэдлэг, хандлага, дадлыг дээшлүүлэх, давс багатай бүтээгдэхүүний үйлдвэрлэл, хэрэглээг нэмэгдүүлэхэд чиглэсэн үр дүнтэй арга хэмжээг авч хэрэгжүүлэх
- Нийт хүн амд чиглэсэн илүүдэл жин, таргалалтын эрсдэлт хүчин зүйл, түүнээс шалтгаалах өвчлөл, нас баралт, сэргийлэлт, идэвхтэй хөдөлгөөний талаарх эрүүл мэндийн боловсрол олгох сургалтын хөтөлбөрийг бүс нутаг, иргэдийн боловсрол, мэргэжлийн онцлогт уялдуулан судлаач, багш нартай хамтран боловсруулж, хэрэгжүүлэх
- Биеийн жингээ хянах, хэвийн хэмжээнд барих аргачилсан зөвлөмжийг ДЭМБ-ын удирдамжид тулгуурлан боловсруулж, өрх, сумын эрүүл мэндийн төвийг түшиглэн үр дүнтэй хэрэгжүүлэх
- ЗСӨ-өөс сэргийлэх эмнэлзүйн заавар, удирдамжийг боловсруулан, үндэсний хэмжээнд мөрдүүлэх, хянах
- ЗСӨ-ний эрсдэлийг тодорхойлох ДЭМБ-ын үнэлгээний хүснэгтээр эрт илрүүлэг үзлэгт хамруулахын зэрэгцээ, ард иргэдийг өөрийгөө үнэлж сургах
- Нийт хүн амын дунд залуучуудыг багтаан АД-ыг жилдээ 1 удаа заавал хэмжиж эрт илрүүлэг, урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдаж байх,
- Ард иргэдийг АД зөв хэмжиж сурах, гэрийн нөхцөлд цусны даралтаа хянахын ач холбогдлын талаарх мэдлэгийг дээшлүүлэх
- Нэгэнт АГ-тэй тохиолдолд даралт бууруулах эмийг тогтмол хэрэглэхийг зөвлөснөөр хянагддаг АГ-ийн тархалтыг нэмэгдүүлэх
- Насанд хүрсэн эрүүл хүн 4-6 жилд 1 удаа, эрсдэлтэй (илүүдэл жин, хөдөлгөөний дутагдал, архины хэтрүүлсэн хэрэглээ, холестерин түвшин ихэссэн, удамд нь зүрх судасны эмгэгийн түүхтэй) хүн эмчийн зөвлөсөн давтамжтайгаар цусны өөх тосны түвшин тогтоох шинжилгээг тогтмол хийлгэж байх
- Өрхийн эрүүл мэндийн төвд бүртгэгдсэн айл өрхийн илүүдэл жинтэй, таргалалттай хүмүүсийн судалгаа гаргаж мэдээллийн сан бүрдүүлэх, хэвийн жинтэй хүмүүсийг таргалалтаас сэргийлэх, таргалах эрсдэл бүхий хүмүүсийг эрт илрүүлэх, биеийн жингийн илүүдэлтэй, таргалалттай хүмүүст амьдралын хэв маягийг өөрчлөх зөвлөгөө өгөх ажлыг тогтмол зохион байгуулах,
- Хүн амд зохистой хооллолт, идэвхтэй хөдөлгөөний талаар мэдээлэл түгээх цогц арга хэмжээг хэрэгжүүлж, зохистой хооллолтын гарын авлага ном, товхимлыг өрх бүрд хүртээмжтэй байхаар хэвлүүлэн түгээх, иргэдэд эрүүл амьдралын талаар зөвлөгөө өгөх нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд шаардлагатай төсөв, санхүүжилт, сургалт сурталчилгаа, хүний нөөцийн асуудалд анхаарал хандуулах

**Редакцын зөвлөл:**

**Статистик боловсруулалт хийсэн:**

С.Цэгмэд, АУ-ны доктор, НЭМҮТ-ийн ЭНБД  
Н.Болормаа, АУ-ны магистр, НЭМҮТ-ийн ЭША

**Тайлан бичсэн:**

С.Цэгмэд, АУ-ны доктор, НЭМҮТ-ийн ЭНБД  
Н.Болормаа, АУ-ны магистр, НЭМҮТ-ийн ЭША  
С.Гэрэлмаа, НЭМ-ийн магистр, НЭМҮТ-ийн ЭМДМА-ны дарга  
Г.Мөнхнаран, НЭМҮТ-ийн ЭИ хариуцсан мэргэжилтэн

**Тайлан хянасан:**

С.Өнөрсайхан, ХУ-ны доктор, НЭМҮТ-ийн захирал  
О.Чимэдсүрэн, АУ-ны доктор, ЕТГ-ын ажлын албаны дарга  
Г.Ганхуяаг, ЭМЯ-ны ХБӨ-ний хэлтсийн дарга

**Хэвлэлийн эх бэлтгэсэн:**

Ж.Энхбат, НЭМҮТ-ийн ТХХ мэргэжилтэн, захирлын туслах

